



"НУТГИЙН УДИРДЛАГАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ"

Сургалтын гарын авлага

Хоёрдахь хэвлэл

5 ЖЕНДЕРИЙН ЭРХ
ТЭГШ БАЙДЛЫГ
ХАНГАХ



Улаанбаатар хот
2020 он

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээнээс боловсруулав.

Зохиогчийн эрх хамгаалагдсан болно. Энэхүү гарын авлагын аливаа хэсгийг МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран, бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дахин боловсруулах, цахим системд байршуулах, хувилах, хэвлэх зэрэг аргаар бүхлээр нь, эсвэл хэсэгчлэн хувилах, нийтлэх, цахим хэлбэрт оруулах, микрофильм хийхийг хориглоно. Аливаа хэлбэрээр ашиглах тохиолдолд эх сурвалж буюу МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн нэрийг хамтад нь заавал дурдана.

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	4
Зургийн жагсаалт.....	5
Товчилсон үгийг.....	6

ӨМНӨХ ҮГ.....	5
----------------------	----------

ТАЛАРХАЛ.....	7
----------------------	----------

Нэгдүгээр бүлэг. УДИРТГАЛ.....	9
---------------------------------------	----------

1.1. Нутгийн удирдлага дахь эмэгтэйчүүдийн манлайлал: ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж буй байдал.....	10
1.2. ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтын хэрэгцээ ба агуулга.....	11
1.3. Сургалтын зорилго, зорилт, онцлог.....	13

Хоёрдугаар бүлэг. ТӨЛӨӨЛӨЛ БА НИЙГМИЙН БҮТЦИЙН ЗУРАГЛАЛ	17
--	-----------

2.1. Төлөөллийн мөн чанар ба төлөөлөх чиг үүрэг.....	18
2.2. Ялгаатай бүлгүүд, ялангуяа эмзэг, цөөнх, дуу хоолойгоо гаргаж чадахгүй иргэдийг төлөөлөх.....	21
2.3. Эмэгтэйчүүдийн ашиг сонирхлыг төлөөлөх.....	24
2.4. Бүлгийн дүгнэлт.....	27

Гуравдугаар бүлэг. МАНЛАЙЛЛЫН ЗАГВАРУУД.....	29
---	-----------

3.1. Манлайллын талаарх ойлголт.....	30
3.2. Манлайллын загварууд.....	37
3.3. Хамтын манлайллын загвар.....	43
3.4. Бүлгийн дүгнэлт.....	48

Дөрөвдүгээр бүлэг. ХАМТЫН МАНЛАЙЛЛЫН УР ЧАДВАРУУД.....	49
---	-----------

4.1. Тулгамдсан асуудлыг шинжлэх, шийдлийн боломжит хувилбар гаргах.....	50
4.2. Оролцогч талуудыг тодорхойлох, шинжлэх.....	63
4.3. Шийдвэр гаргагчдад нөлөөлөх.....	69
4.4. Бусдыг сэдэлжүүлэх, үйл хэрэгтээ нэгтгэх.....	79
4.5. Нөлөөллийн хүрээгээ бэхжүүлэх.....	95
4.6. Бүлгийн дүгнэлт.....	100

Тавдугаар бүлэг. ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ШИНЭ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЛЭН МАНЛАЙЛЛАА БЭХЖҮҮЛЭХ НЬ.....103

- 5.1. Иргэдийн оролцоог баталгаажуулсан хуулиуд.....104
- 5.2. “Тусгай хэрэгсэл 4:6” ба анхаарах асуудлууд.....120
- 5.4. Бүлгийн дүгнэлт.....131

Зургаадугаар бүлэг. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН БОДИТ ОРОЛЦОО БА НӨЛӨӨЛӨЛ.....133

- 6.1. Төлөөлөгч эмэгтэй: давуу тал, боломжууд ба бэрхшээл,
сорилтууд.....134
- 6.2. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд тулгардаг саад
бэрхшээлийг даван туулах арга замууд.....142
- 6.3. Эмэгтэй төлөөлөгчид хамтран ажиллах, хамтын сонирхлыг
хөндсөн асуудлаар нэгдэж ажиллах арга, туршлага.....164
- 6.4. Бүлгийн дүгнэлт.....167

ХАВСРАЛТ.....169

- 1. Иргэдийн оролцоог баталгаажуулсан хуулиудын
харьцуулалт.....170
- 2. ИТХ-аас зохион байгуулах боломжтой 6 төрлийн Сонсох
ажиллагааны харьцуулалт.....174
- 3. Нийтийн сонсгол зохион байгуулах журам.....176
- 4. Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу Орон нутгийн
сонсгол явуулах ИТХ-ын хүсэлтийн жишээ.....180

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Уламжлалт ба оролцоонд суурилсан сургалтын зарчмын ялгаа.....
- Хүснэгт 2. Зохион байгуулалттай холбоотой бэрхшээлийг өөрчлөлт шаардсан асуудлаас ялгах нь.....
- Хүснэгт 3. Оролцогч талуудыг тодорхойлох.....
- Хүснэгт 4. Манлайллын цогц түүх бүтээх загвар.....
- Хүснэгт 5. Бодлогын баримт бичгүүд.....
- Хүснэгт 6. ИТХ, Төлөөлөгчийн үүрэг, гүйцэтгэх арга зам.....
- Хүснэгт 7. Сонсголын төрлүүд.....
- Хүснэгт 8. Захиргааны үйл ажиллагааны төрлүүд.....
- Хүснэгт 9. Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах.....
- Хүснэгт 10. Хувийн манлайллын төлөвлөгөөний загвар.....
- Хүснэгт 11. Төлөөлөгч эмэгтэйн давуу тал, боломжууд ба тэдэнд тулгардаг бэрхшээл/сорилтууд (Сургалтын явцад гарч ирсэн санаануудаас түүвэрлэв).....

- Зураг 1. Орон нутгийн 2016 оны сонгуулиар байгуулагдсан ИТХ-ын бүрэлдэхүүн (хүйсээр)
- Зураг 2. Цэнхэр хайрцаг, шар тойрог
- Зураг 3. Манлайллын уламжлалт загвар
- Зураг 4. Асуудлыг шинжлэх алхмууд
- Зураг 5. Тулгамдсан асуудал гэж юуг хэлэх вэ?
- Зураг 6. Тулгамдсан асуудлын жагсаалт гаргах загвар
- Зураг 7. Асуудлыг эрэмбэлэхэд харгалзах шалгуур
- Зураг 8. "Асуудлын мод" аргыг ашиглан тулгамдсан асуудлыг шинжлэх
- Зураг 9. "Асуудлын мод" зураглалын жишээ
- Зураг 10. Өнгөт чулууг хууль бусаар олборлох
- Зураг 11. Гэр бүлд хүүхэд хамгаалагдаж чадахгүй байна.
- Зураг 12. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж муу
- Зураг 13. Хог хаягдал, орчны бохирдол
- Зураг 14. "Шийдлийн мод" зураглал
- Зураг 15. Шийдлийн мод болгон хувиргасан жишээ
- Зураг 16. Байгалийн өнгөт чулууг хууль бусаар олборлохыг зогсоох
- Зураг 17. Гэр бүлд хүүхэд хамгааллыг сайжруулах
- Зураг 18. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах
- Зураг 19. Хог хаягдал, орчны бохирдлыг багасгах
- Зураг 20. Оролцогч талыг тодорхойлох алхмууд
- Зураг 21. Оролцогч талуудыг тодорхойлсон жишээ
- Зураг 22. Оролцогчдын ашиг сонирхол, нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох алхмууд
- Зураг 23. Оролцогчдыг шинжлэх зураглал
- Зураг 24. Улс төрийн оролцогч талууд "Талбар"
- Зураг 25. Манлайллын урлаг
- Зураг 26. Үнэт зүйлсийг ил гаргаж ирэх арга зам
- Зураг 27. Манлайллын түүхийн бүтэц
- Зураг 28. Манлайллын түүхийн бүрдэл
- Зураг 29. Жин дарах хүч
- Зураг 30. Сонсгол явуулах үйл явц ба дараалал
- Зураг 31. Захиргааны хэм хэмжээний акт гаргах үйл явц

ТОВЧИЛСОН ҮГС

ААН	Аж ахуйн нэгж
АН	Ардчилсан Нам
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ЗСАТХ	Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАН	Монгол Ардын Нам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
НСТХ	Нийтийн сонсголын тухай хууль
НӨУБ	Нутгийн өөрөө удирдах байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ОҮИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
СӨХ	Сууц Өмчлөгчдийн Холбоо
ТББ	Төрийн Бус Байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХБТТХ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
ШХА	Швецарийн Хөгжлийн Агентлаг



Л.ӨЛЗИЙСАЙХАН

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн үндэсний захирал

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд олон хүний нөр их хөдөлмөр, цаг хугацаа, хичээл зүтгэлийн үр дүнд бүтээсэн “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалтын гарын авлагыг Та бүхэнд өргөн барьж байна.

Монгол Улсын төр засгаас нийт хүн амын талаас илүү хувийг эзэлж байгаа эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг улс төрд болон төрийн удирдах албанд нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарсаар ирсэн. Энэхүү жендэрийн эрх тэгш байдлын биелэлтийг хэмжих гол шалгуурыг шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны түвшингээр олон улсад тодорхойлдог.

Тэгвэл орон нутгийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны түвшинг тодорхойлох гол үзүүлэлтүүд манай улсад доогуур байна. Тухайлбал, 2016 оны сонгуулиар бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нийт 8099 төлөөлөгч сонгогдсоны 2164 (26.7%), нийт 361 Хурлын даргын 50 (13.8%), 2524 Тэргүүлэгчдийн 701 (27.8%) нь эмэгтэй байна.

Тоон үзүүлэлтээс гадна төлөөллийн чанар чухал ач холбогдолтой. Ийм учраас бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч эмэгтэйчүүдийн улс төрийн бодит оролцоо, нөлөөлөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор төслийн хүрээнд “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулж, үндэсний хэмжээний сургалтыг 2014, 2018 онд тус тус зохион байгуулсан.

Энэ удаагийн сургалтын хөтөлбөр, гарын авлагыг өмнөх сургалтаас олж авсан туршлага, сургамж, сургагч багш, Төлөөлөгчдийн санал,

шинээр батлагдсан хууль тогтоомж болон олон нийтийн хүлээлтэд орсон өөрчлөлтөд үндэслэн шинэчлэн сайжруулж, Та бүхэнд толилуулж байгаадаа баяртай байна.

Уг гарын авлагад нутгийн өөрөө удирдах байгууллагад иргэдийг төлөөлж байгаа тэдний элч төлөөлөгчдөд байвал зохих манлайллын хэв шинжийг “нийтийн сайн сайхны төлөө хамтын манлайлал” хэмээн тодорхойлж, хамтын манлайллын арга барилаар төлөөлөгчийн үүргээ хэрэгжүүлэхэд шууд ашиглаж болох практик ур чадвар, арга замыг тайлбарлан, зарим жишээ, баримтаар баяжуулан тусгалаа.

Та бүхэн энэ гарын авлагаас:

- 1) Тулгамдсан асуудлыг шинжлэх, шийдлийн боломжит хувилбарыг гаргах;
- 2) Оролцогч талуудыг тодорхойлох, шинжлэх;
- 3) Шийдвэр гаргагчдад нөлөөлөх;
- 4) Бусдыг сэдэлжүүлэх, үйл хэрэгтээ нэгтгэх;
- 5) Иргэдийн оролцооны шинэ хууль тогтоомжийг хэрэглэх зэрэг хамтын манлайллын ур чадварууд болон өөрчлөлт хийх стратеги, арга замыг багтаасан агуулгыг судлах болно.

Манлайлал бол арга зам, туршлага, үйл явц байдаг. Тийм учраас манлайлагчид төрдөггүй, төлөвшиж бий болдог. Сургалтын явцад төлөөлөгчөөр сонгогдсон эмэгтэйчүүд өөрсдийн туршлага, сургамжаа хуваалцах орон зайг бий болгосон ба тэдний санаачилга, амжилтын түүхийг баримтжуулан гарын авлагад шигтгэлээ.

“Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалтын гарын авлага нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч эмэгтэйчүүд, ИТХ-ын нарийн бичгийн дарга нар, ажлын албаны ажилтнуудын үйл ажиллагаанд хөтөч болоод зогсохгүй цаашид орон нутгийн сонгуульд нэр дэвшин сонгогдохыг зорьж байгаа эмэгтэйчүүдэд иргэдийн амьдралд эерэгээр нөлөөлөх бодит өөрчлөлт хийх урам зориг, чиг баримжаа өгөх болно гэдэгт итгэж байна.

ТАЛАРХАЛ

Энэ гарын авлага нь хамтын мэдлэг бүтээх үйл явцад бий болсон тул дор нэр дурдагдсан хүмүүс, байгууллагын олон жилийн хөдөлмөр, зүтгэл, туршлага, сургамжид тулгуурлан бүтээгдсэн болно.

МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ нь эмэгтэйчүүд, төрийн албан хаагчид, хуульчид зэрэг нийгмийн янз бүрийн бүлэгт тухайн бүлгийн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр, агуулга, аргачлал, гарын авлага боловсруулж, оролцоонд тулгуурласан сургалт явуулж ирсэн баялаг туршлагаа уг гарын авлагад шингээлээ. Мөн үндэсний болон олон улсын түвшинд манлайллыг хэрхэн, ямар хүрээнд ойлгон тодорхойлж байгаа, манлайллын сургалтад ямар агуулгыг хамруулж байгааг судалсан судалгаа, дүн шинжилгээ, харьцуулалтын үр дүнг тусгасан. Үүний зэрэгцээ сонгогдон ажиллаж байгаа эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалтыг үндэсний хэмжээнд 2 удаа (2014, 2018) амжилттай зохион байгуулж, сургалтын туршлага, сургамжид үндэслэн гарын авлагыг эцэслэн Та бүхэнд толилуулж байгаадаа баяртай байна.

Сургалтын гарын авлагыг боловсруулах багийн ахлагчаар МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээний Ерөнхий зохицуулагч Д.Энхжаргал ажиллаж, “Төлөөлөл ба нийгмийн бүтцийн зураглал”, “Хамтын манлайллын ур чадварууд”, тус сүлжээний Зөвлөх Т.Ундаръяа нь “Манлайллын загварууд” бүлгүүдийг боловсрууллаа. Тус сүлжээний гишүүн байгууллагуудын төлөөлөл болох Хил хязгааргүй алхам ТББ-ын Тэргүүн Н. Баярсайхан “Иргэдийн оролцооны шинэ хууль тогтоомжийг хэрэглэн манлайллаа бэхжүүлэх нь”, Өөрчлөлтийн төлөөх ТББ-ын Тэргүүн Б. Золзаяа “Төлөөлөгч эмэгтэй: давуу тал, боломжууд ба бэрхшээл сорилтууд”, Баянзүрх дүүргийн ИТХ-ын төлөөлөгч Д.Нэргүй “Нөлөөллийн хүрээгээ бэхжүүлэх”, Бидний оролцоо, нөлөөлөл ТББ-ын Тэргүүн Ж.Чанцалдулам “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд тулгардаг саад бэрхшээлийг даван туулах арга замууд” сэдэв, бүлгүүдийг тус тус боловсруулан, сургалтаас сургалтын хооронд уйгагүй баяжуулан эцэслэсэнд гүнээ талархаж байна.

ИТХ-ын төлөөлөгчөөр удаа дараа сонгогдсон төлөөлөгчдөөс орон нутгийн сургагч багш нарыг сонгон авч, үндэсний сургагч багшаар 2014, 2017 онуудад тус тус давтан сургасан. Гарын авлагыг орон нутгийн онцлог, ИТХ-ын төлөөлөгчийн хүлээх хариуцлага, чиг үүрэгтэй уялдуулан холбоход орон нутгийн сургагч багш нарын хуримтлуулсан мэдлэг, туршлага, сургамж үнэтэй хувь нэмэр орууллаа. Г. Алтантуяа (Дархан-Уул), Ж. Ариунаа (Архангай), Б. Бадамлянхуа (Дундговь), Д. Биндэрьяа (Сүхбаатар), Н. Бүрэн (Увс), Д. Ганчимэг (Орхон), Ж. Дулмаа

(Баянхонгор), Д. Оюунгэрэл (Хэнтий), С. Саран (Булган), Д. Урансувд (Дорнод), Б. Цэвээн (Өмнөговь), Ж. Пүрэвсүрэн (Өвөрхангай), Б. Эрдэнэцэцэг (Дорноговь), Ц. Эрдэнэчимэг (Сэлэнгэ) нартаа онцгойлон талархал илэрхийлье.

Бүх шатны ИТХ-д сонгогдон ажиллаж байгаа эмэгтэй төлөөлөгчдийн хэрэгцээнд тулгуурлан гарын авлагын агуулгын бүтэц гарсан ба сургалтын явцад оролцогчид өөрсдийн туршлага, өөрчлөлтийн түүхээр баяжууллаа. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд тулгарч байгаа олон төрлийн саад бэрхшээлийг тодорхойлоход харьцангуй амархан ч тэдний давуу тал, үзүүлж буй нөлөө, гаргасан амжилтыг харагдахуйц болгон гаргаж ирэхэд бэрхшээлтэй. Үүнийг харгалзан сургалтын явцад туршлага, сургамжаа хуваалцах орон зайг төлөөлөгч эмэгтэйчүүдэд бий болгосон ба уг гарын авлагад тэдний санаачилга, амжилтын түүхийг баримтжуулан толилуулж байгаа нь харилцан суралцах шинэ өнцгийг оруулж ирж байна.

Мөн хүний эрх, ардчилал, жендэрийн тэгш байдал, иргэний оролцоо, хуулийн чиглэлээр олон жил тууштай ажиллаж, оролцооны аргаар сургалт зохион байгуулж мэргэшсэн шинжээчдийг сонгон авч, үндэсний сургагч багшаар 2014, 2017 онуудад давтан сургасан. С. Айнагуль, А. Анударь, Н. Баярсайхан, С. Дондов, Д.Должинсүрэн, Б. Золзаяа, Б.Лхамсүрэн, Д. Нэргүй, Д. Цэнд-Аюуш, Ж. Чанцалдулам, Д.Энхжаргал нарт сургагч багшаар ажиллаж, гарын авлагыг боловсруулах, агуулгыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсанд талархаж байна.

Энэ бүхэнд тус сүлжээний Хөтөлбөрийн менежер А. Саранцэцэг, Б. Лхамсүрэн, хөтөлбөрийн ажилтан Д. Должинсүрэн, Ш. Саранхөхөө, Т. Наранцэцэг нар мэдээлэл цуглуулах, судлах, нэгтгэх, харьцуулах, сургагчид болон хамтрагч талуудыг холбох, сургагч багшаар ажиллах зэрэг арын албаны өдөр тутмын нөр их ажлыг нугалсныг энд онцгойлон дурдахыг хүсч байна.

2016-2020 онд хэрэгжүүлэх “Монгол улсын төлөөллийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд төлөөлөгч эмэгтэйчүүдэд зориулсан сэдэвчилсэн сургалтыг зохион байгуулах шийдвэр гаргаж, гарын авлагыг бүтээхэд дэмжлэг, туслалцаа үзүүлсэн УИХ-ын Тамгын газар,

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлаг болон төслийн багийн хамт олон, Л.Бархас, Г.Золжаргал нарт, мөн сургалтын зохион байгуулалтыг хариуцсан бүх, аймаг, дүүргийн ИТХ-ын ажлын албаны хамт олон, нарийн бичгийн дарга нарт тусгайлан талархал илэрхийлж байна.

МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ ТББ

Нэгдүгээр бүлэг.

УДИРТГАЛ

- 1.1. Нутгийн удирдлага дахь эмэгтэйчүүдийн манлайлал: ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж буй байдал
- 1.2. ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан манлайллын сургалтын хэрэгцээ ба агуулга
- 1.3. Сургалтын зорилго, зорилт, онцлог
- 1.4. Гарын авлагын бүтэц, сургалтын хөтөлбөр

1.1. НУТГИЙН УДИРДЛАГА ДАХЬ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ: ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧӨӨР СОНГОГДОН АЖИЛЛАЖ БУЙ БАЙДАЛ

Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо дээшилж, харьцангуй олон эмэгтэйчүүд орон нутгийн түвшинд сонгогдох болон томилогдох албан тушаалд очиж байна. 2012 оны УИХ-ын сонгуулийн үр дүнгээр сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо 11 байсан бөгөөд энэ үзүүлэлтээрээ дэлхийд 95-д жагсаж байв. Харин 2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнгээр 13 эмэгтэй гишүүн сонгогдсон нь парламентын гишүүдийн 17 хувийг эзэлж байгаа ба бүс нутгийн дундаж болох 18 хувьд дөхөж очжээ.

Гэвч сүүлийн хоёр сонгууль¹ дараалан орон нутгийн ИТХ²-д сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо буурсан нь анхаарал татаж байна. Тодруулбал, 2012 оны сонгуулийн үр дүнд нийт 8000 гаруй төлөөлөгч сонгогдсоны 27.3 хувь буюу 2204 нь эмэгтэй төлөөлөгчид байсан ба өмнөх 2008 оны сонгуультай харьцуулахад буурчээ. Харин 2016 онд 2164 эмэгтэй төлөөлөгч сонгогдсон нь өмнөх сонгуулийн үр дүнтэй харьцуулахад 40-өөр цөөн буюу 1,8 хувиар буурсан үзүүлэлт гарчээ.

Түүнчлэн орон нутгийн сонгуульд нийт 15185 нэр дэвшигч бүртгэгдсэний 29.8 хувь буюу 4530 эмэгтэй нэр дэвшигч³ байгаа нь орон нутагт нэр дэвшин өрсөлдөхөд томоохон саад бэрхшээлтэй тулгардгийг илтгэж байна.

Сонгуулийн хууль болон сонгуулийн тогтолцоо нь орон нутгийн **төлөөллийн чанарт** ихээхэн нөлөөтэй байдаг. 2015 оны 12-р сарын 25-нд баталсан Сонгуулийн тухай шинэ хуулиар Ерөнхийлөгчийн, УИХ-ын болон аймаг, нийслэлийн, мөн сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийг нэгтгэн зохицуулах болсон. УИХ-ын сонгуулийн тухай 2011 оны хуульд байсан сонгууль болохоос зургаан сарын дотор ямар нэг нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглосон тухай чухал заалтыг хассан нь эмэгтэйчүүдэд учирсан улс төрийн саад бэрхшээлийн нэг болжээ. Тухайлбал, уг хуулиар УИХ-д улс төрийн намуудаас нэр дэвшигчдийн аль нэг хүйс хамгийн багадаа 20 хувь байсныг 30 хувь болгон өсгөсөн ч сонгууль болохоос 2 сарын өмнө жендэрийн уг квотыг 20 хувь болгож бууруулсан

¹ 2012 болон 2016 оны сонгууль


² Аймаг, нийслэл, сум, дүүргийн 361 ИТХ-д

³ Сум, дүүргийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийн тухай Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны Хуралдаанд хийсэн Сонгуулийн Ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэнгийн хийсэн мэдээлэл, 2016 оны 11 сар.

нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхээс ухарсан алхам болов. Мөн нийслэл болон аймгийн ИТХ-д нэр дэвших квотыг хүчингүй болгосон (дүүргийн болон сумын ИТХ-ын сонгуульд квот тогтоож байгаагүй).

2016 оны сонгуулиар бүх шатны ИТХ-д нийт 8099 төлөөлөгч сонгогдсоны 26.7 хувь нь буюу 2164 нь эмэгтэйчүүд байна. Сонгуулийн тухай хуулийн өөрчлөлт болон квот байхгүй болсон нь аймаг, нийслэлийн түвшинд эмэгтэй төлөөлөгчид цөөн сонгогдоход нөлөөлжээ. Нийт 361 Хурлын даргын 50 нь эмэгтэй ба үүний 14 нь анх удаа сонгогдсон төлөөлөгч байна. 2524 Тэргүүлэгчдийн 701 нь эмэгтэйчүүд байна.

1.2. ИТХ-ЫН ЭМЭГТЭЙ ТӨЛӨӨЛӨГЧДӨД ЗОРИУЛСАН МАНЛАЙЛЛЫН СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ БА АГУУЛГА



Зураг 1. Орон нутгийн 2016 оны сонгуулиар байгуулагдсан ИТХ-ын бүрэлдэхүүн (хүйсээр)

Нэр дэвшин өрсөлдөхөөс гадна сонгогдсоны дараа төлөөлөгчөөр ажиллахад эмэгтэйчүүдэд мөн л улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын олон саад бэрхшээл тулгарсаар байна.

Орон нутгийн төлөөллийн байгууллага нь эмэгтэйчүүд өрсөлдөх боломж хамгийн өндөртэй улс төрийн тавцан ба эмэгтэйчүүдийг улс төрийн карьерт бэлдэх хамгийн тохиромжтой бааз суурь болдог.⁴

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдтэй дүйх нь чухал боловч хүсч буй өөрчлөлтийг бий болгоход энэ нь дангаараа хангалтгүй. Тодорхой тооны

⁴ НҮБХХ. Ази, Номхон далайн орнуудын орон нутгийн захиргаанд эмэгтэйчүүдийн төлөөлөл: Нөхцөл байдлын тайлан, 2010 он.

эмэгтэйчүүд албан ёсны эрх мэдэлд хүрч байгаа ч улс төрийн үйл явцад эрх мэдлээ жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх бодит боломж бага хэвээр байна.

Эмэгтэйчүүд сонгогдох үедээ төдийгүй сонгогдсоны дараа ч олон тооны саад тогторуудтай тулгарч байна. Улс төрд хүчээ сорихыг хүссэн, улс төрд орсон эмэгтэйчүүдийн давуу тал, боломж нь хувь хүнийхээ түвшинд байгаа бол сорилт, хязгаарлалт нь тогтолцооны (улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын) шинжтэй байна. Иймээс улс төрчийн хувьд өөрийгөө хөгжүүлэхийн зэрэгцээ эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, нөлөөлөлд чөдөр тушаа болж буй одоогийн тогтолцоо, институци, тогтсон соёл, хэм хэмжээ, хандлага ба итгэл үнэмшлийг өөрчлөхөд нэгдмэл хүчин чармайлт хэрэгтэй байна.

Иймд энэ сургалтаар эмэгтэй төлөөлөгчдийн төлөөллийн болон шийдвэр гаргах, хяналт тавих үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь тулгардаг саад, бэрхшээлүүдийг тодорхойлж, тэдгээрийг даван туулах боломжит арга замуудыг санал болгоно.

Төлөөлөгч эмэгтэйчүүдийн хувьд тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх, шийдлийн боломжит хувилбаруудыг дэвшүүлэх, бодит ажил хэрэг болгохын тулд нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх хэрэгцээтэй байнга тулгардаг нь сургалтын өмнөх хэрэгцээний судалгаа болон сургалтын явц дахь хэлэлцүүлгээс харагдаж байна.

“Орон нутгийн сонгуульд нэр дэвшигч болон сонгогдсон эмэгтэйчүүдэд зориулсан сургалт нь илтгэх, сонгогчдыг татах зэрэг тодорхой ур чадварыг дээшлүүлэх, сайжруулахаас илүү өргөн хүрээг хамарч, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байдлыг хангахуйц өөрчлөлт хийх арга барил, хандлага суулгах манлайллын ур чадварт л голлон анхаарч, хөгжүүлэх нь зүйтэй”

Жендэрийн тэгш байдал: Орон нутгийн түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо ба манлайлал, НҮБХХ, 2013 (81)

Түүнчлэн оролцогч талуудыг шинжлэх, тэдний нөлөөлөх чадвар, эрх мэдэлд дүн шинжилгээ хийх, төрөл бүрийн нөхцөл байдалд эрх мэдэл олон янзын хэлбэр, арга замаар яаж хэрэгждэгийг задлан шинжлэх, эрх мэдлээ хэрхэн хэрэглэж, бодит практик болгож байгаагаа эргэн харах шаардлагатай байна. Иймд нийгмийн тогтсон хэм хэмжээ буюу одоогийн байгаа байдлыг хэвээр хадгалах бус харин улс төрийн үйл явцад илүү үр дүнтэй оролцохын тулд манлайллын шинэлэг загварыг хөгжүүлэхийн төлөө ажиллах урам зориг өгч, үүнд шаардагдах ур чадварыг олгоход анхаарна.

Төлөөлөгч эмэгтэйчүүдийн улс төр, нийгэмд, ялангуяа орон нутгийн хөгжил, иргэдийн амьдралд үзүүлэх үр нөлөөг улам сайжруулах, орон нутагтаа манлайлж ажиллах, иргэдийн өмнө тулгарч буй асуудалд нэгдсэн шийдэл олох, улмаар ИТХ-ын шийдвэрт хамтын хүчээр нөлөөлөх чадварыг дээшлүүлэхэд сургалтын агуулга чиглэгдэнэ.

1.3. СУРГАЛТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ОНЦЛОГ

Сургалтын зорилго

Төлөөлөгч эмэгтэйчүүдийн манлайллын чадавх дээшилснээр нутгийн өөрөө удирдах ёс бодит утгаараа хэрэгжих, орон нутгийн хөгжлийн бодлого тэнцвэртэй, жендэрийн мэдрэмжтэй болох, иргэдийн тэгш оролцоог хангах ач холбогдолтой.

Иймд “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалтын гол зорилго нь одоо сонгогдон ажиллаж байгаа эмэгтэй төлөөлөгчдийн улс төрийн бодит оролцоо, нөлөөллийг дээшлүүлэх, сонгуульд дахин өрсөлдөх, аймаг, нийслэлийн ИТХ-д сонгогдох чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдсэн манлайллын ур чадварыг эзэмшүүлнэ.

Сургалтын зорилт

Энэ хүрээнд дараах тодорхой зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

- ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчийн хувьд төлөөлөх, шийдвэр гаргах, хяналт тавих чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд манлайллын ямар арга, хэлбэр тохиромжтойг онол, практикт тулгуурлан хэлэлцэх;
- ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн өмнө тулгарч буй тогтолцооны шинжтэй саад бэрхшээлд дүн шинжилгээ хийх, тэгш бус байдлын суурь шалтгааныг авч үзэх, улмаар өөрчлөлт хийх стратеги, арга замыг тодорхойлох;
- Орон нутгийн хөгжил, иргэдийн амьдралд тулгамдсан асуудлыг тодорхойлох, эрэмбэлэх, шийдлийг эрэлхийлэх чадавхийг нэмэгдүүлэх;
- Манлайллаа хэрэгжүүлэх тодорхой ур чадваруудад суралцах, манлайллын түүхээ бусадтай хуваалцах;
- Иргэдийн оролцоог хангах талаарх шинэ хууль тогтоомжуудыг хэрэглэн манлайллаа бэхжүүлэх боломжийг нэмэгдүүлэх.

Сургалтын онцлог

1. Оролцоонд тулгуурлана: “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалт нь оролцоонд суурилсан сургалт бөгөөд энэ нь сургалтын оролцогч болох ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн арвин мэдлэг, амьдралын туршлага, орон нутгийн хөгжлийн онцлог, нөхцөл, практикт түшиглэнэ гэсэн үг. Сургалтын оролцогч бүр ажил, амьдралд тохиолдсон жишээ, мэдээлэл, арга барилаас хуваалцаж, харилцан суралцаж, манлайллын талаарх чиглүүлэгчийн өгөх шинэ ойлголт, өнцгийг олон талаас нь хэлэлцсэнээр сургалтын үр дүнг хамтран бий болгоно.

Доорх хүснэгтэд уламжлалт сургалт болон оролцоонд тулгуурласан сургалтын зарим зарчмын ялгааг товч тайлбарлав.

Хүснэгт 1. Уламжлалт ба оролцоонд суурилсан сургалтын зарчмын ялгаа

Уламжлалт сургалт	Оролцоонд тулгуурласан сургалт
Гол зорилго нь суралцагчдад шинэ мэдлэг, мэдээлэл өгөх.	Мэдлэг, мэдээлэл өгөхөөс гадна оролцогчдын өөртөө итгэх итгэл, шүүмжлэлтэй, бүтээлч сэтгэх, асуудалд дүн шинжилгээ хийх, тодорхойлох, хэлэлцэж шийдвэрлэх, өөрийгөө илэрхийлэх, багаар ажиллах, бусдыг сонсох зэрэг үр чадварыг хөгжүүлж, асуудалд хандах хандлага, арга барилыг хөгжүүлэхийг чухалчилдаг.
Асуулт хариулт, хэлэлцүүлэг нь “нэмэлт,” “туслах” чанартай.	Хэлэлцүүлэг нь сургалтын гол, маш чухал хэсэг.
Суралцах үйл явц нь голдуу “багшаас сурагч руу” чиглэсэн нэг чигтэй.	Суралцах нь олон чиглэлд буюу бие биеэсээ харилцан суралцах, хамтдаа хөгжих үйл явц гэж үздэг.
Сургагч багш бол “заах” буюу “зөв” мэдлэг, мэдээлэл өгөх, суралцагч нь мэдлэг, мэдлэгийг хүлээн авах үүрэгтэй гэж үздэг	Сургагч, чиглүүлэгчийн гол үүрэг бол оролцогч бүтээлчээр хандаж, өөрийн төсөөлөл, ойлголт, мэдлэг, туршлагад шинэлэг өнцгөөс харж, харилцан суралцахад нь сэдэл өгөх, туслах үүрэгтэй. Оролцогч сургалтын туршид идэвхтэй оролцохоор бодож, сургалтын хөтөлбөрийг боловсруулдаг.
Хүний оюун ухаан, логик сэтгэлгээнд түшиглэдэг.	Хүний оюун ухаан, логик сэтгэлгээнээс гадна төсөөлөн бодох, зүрх сэтгэлээрээ мэдрэх, мөрөөдөх зэрэг чадварыг чухалчилдаг.
Олон хүнд, тухайлбал, 60-100 хүнд нэгэн зэрэг явуулах боломжтой.	30-аас дээш оролцогчийг хамруулан оролцооны аргыг хэрэглэхэд бэрхшээлтэй.
Сургалтын танхимд илүү зай шаардлагагүй.	Жүжигчилсэн тоглолт, багаар ажиллах зэрэгт зориулсан талбай, дасгал бүрт зориулсан сургалтын олон төрлийн хэрэгсэл шаардана.

Ийнхүү оролцоонд тулгуурласан сургалт нь зорилго, хэлбэр, арга барилын хувьд уламжлалт маягийн сургалтаас ялгаатай бөгөөд аливаа асуултад бэлэн хариулт өгөхийг зорихгүй, харин оролцогч өөрөө асуудлыг гүнзгийрүүлэн авч үзэж, дүгнэж, хариулт эрэлхийлэхэд нь туслах зорилготой. Тиймээс оролцогч энэ төрлийн сургалтад ирэхдээ “бэлэн хариулт авах”, “багш зааж, би сонсож тогтоож авна” гэж бодож болохгүй.

2. Сургалтаар практик ур чадвар олгоход түлхүү анхаарна: “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалт нь практикт чиглэсэн сургалт юм. Хоёр өдрийн турш мэдээлэл танилцуулах, дасгал ажиллах, хэлэлцүүлэг өрнүүлэх, бүлгээр ажиллах, багаараа дүн шинжилгээ хийх зэрэг ажиллагаа тасралтгүй явагдана. Тухайлбал, ИТХ-ын эмэгтэй төлөөлөгч шийдвэр гаргахдаа хүний эрхэд суурилсан өнцгөөс ханддаг байхад чиглэсэн “эрх мэдлийн алхалт” хэмээх дасгал ажиллана. Асуудлыг өөрөө дангаараа хөөцөлдөөд байхаас илүү хамтран зүтгэгчдээ хэрхэн тодорхойлж, хамтарч ажиллахыг мөн л хийнгээ суралцана.

Сургалтын агуулгыг боловсруулахдаа тус сургалтын **зорилтот бүлэг** болох ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн онцлогт нийцүүлэхийг чармайв. Аймаг тус бүрээс ИТХ-ын төлөөлөгч нэг эмэгтэй сургагч багш/чиглүүлэгчээр бэлтгэгдсэн бөгөөд тэд дасгал ажлыг ИТХ-ын ажлын онцлог, төлөөлөгчийн чиг үүрэгтэй уялдуулж явуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Мөн шийдвэр гаргах түвшинд сонгогдон ажиллаж буй эмэгтэйчүүдийн хувьд сэтгэгдэл, байр сууриа чөлөөтэй илэрхийлэх, ялангуяа манлайлах ур чадвар, арга барилын онцлогийн талаар чөлөөтэй харилцан ярилцах боломж олгох үүднээс сургалтын танхимд зөвхөн эмэгтэй төлөөлөгчид байхаар төлөвлөв.

Оролцоонд тулгуурласан сургалтын үр дүн, амжилт зөвхөн сургагч багш, сургалтын агуулга, аргачлалаас бус оролцогч өөрөө ямар хандлагатай, хэр идэвхтэй байх, орчин хэр нээлттэй, итгэлцэл бүхий, айх санаа зовох зүйлгүй, хүндэтгэлтэй байхаас ихээхэн шалтгаална. Тиймээс энэ төрлийн сургалтын үйл явц, үр дүн нь хэзээ ямагт хамтын хариуцлага байдаг билээ.

Хоёрдугаар бүлэг. ТӨЛӨӨЛӨЛ БА НИЙГМИЙН БҮТЦИЙН ЗУРАГЛАЛ

- 2.1. Төлөөллийн мөн чанар ба төлөөлөх чиг үүрэг
- 2.2. Ялгаатай бүлгүүд, ялангуяа эмзэг, цөөнх, дуу
хоолойгоо гаргаж чадахгүй иргэдийг төлөөлөх
- 2.3. Эмэгтэйчүүдийн ашиг сонирхлыг төлөөлөх
- 2.4. Бүлгийн дүгнэлт

2.1. ТӨЛӨӨЛЛИЙН МӨН ЧАНАР БА ТӨЛӨӨЛӨХ ЧИГ ҮҮРЭГ

Ардчилал бол сонгодог утгаараа ард түмний засаглал, өөрөөр хэлбэл хамтын шийдвэр гаргахад бүх нийтийн оролцоо, хяналтыг тогтоож, тэгш боломжийг хангах амьд үйл явц ба ардчиллын гол үнэт зүйл, тулгуур нь төлөөлөл, оролцоо юм. Монгол Улсын Үндсэн хуульд “Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх ба иргэн бүр төрийн үйл хэрэгт шууд болон сонгож байгуулсан төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах эрхээ эдэлнэ” гэж заасан.⁵

Орон нутаг нь иргэдийн улс төрд оролцох, өөрийн төлөөллөө сонгох хамгийн анхан шатны нэгж юм. Иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байр, орон сууцаар хангуулах, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, газар өмчлөл зэрэг асуудлаар орон нутгийн засаг захиргаа болон төлөөллийн байгууллагатай харьцаж байдаг. Эндээс л улс төрийн сонголтын үр дүн, төрийн шийдвэрийн нөлөө бодит амьдралд өдөр тутам хэрхэн тусч байгааг иргэд олж хардаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд ч мөн адил улс төрд оролцох, төлөөлөх, төлөөлүүлэх эрхээ эдлэх эхлэл цэг нь орон нутгийн ардчилсан институци байдаг.⁶

Үндсэн хуулийн институци болох аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь тухайн орон нутгийн Засаг даргыг сонгоход чухал үүрэг гүйцэтгэж, орон нутгийн гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа буюу орон нутгийн төсвийн гүйцэтгэл, төрийн үйлчилгээнд *хяналт тавих*, нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах, иргэдээс гарсан саналыг орон нутгийн бодлого, төсөв, төлөвлөлтөд шударгаар тусгах, үйлчилгээний талаарх гомдлыг хүлээн авч шийдвэрлүүлэх, төр засаг болон нутгийн удирдлагын үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх зэргээр *иргэдийг төлөөлөх* үүрэгтэй, иргэдийн хувьд хамгийн ойр дөт байх учиртай байгууллага юм⁷.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь 4 жилийн хугацаагаар тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа иргэдээс шууд сонгогддог төлөөллийн байгууллага, харин засаг захиргааны анхан шатны нэгж болох баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь тухайн баг, хороонд

⁵ Монгол Улсын Үндсэн хууль 3.1 дэх заалт

⁶ Орон нутгийн ардчиллын төлөв байдал: үнэлгээний аргачлал, Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх Олон улсын хүрээлэн, Брехте Кэмп, Мелида Жименез, 2016

⁷ “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн хандлагын суурь түвшин тогтоох” судалгаа, 2015 он. УИХ-ын Тамгын газар, ШХА, НҮБХХ

байнга оршин сууж буй нийт иргэдийн оролцоотой үйл ажиллагаа явуулдаг шууд ардчиллын байгууллага юм. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 1) орон нутгийн иргэдийн ашиг сонирхлыг **төлөөлөх**, 2) **шийдвэр гаргах** (нутаг орныхоо асуудлаар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох), 3) **хяналт тавих** үндсэн чиг үүргийг хуулиар хүлээдэг.⁸

Төлөөлөгч нь тодорхой тойргийн иргэдийг ИТХ-д төлөөлдөг бол ИТХ нь тухайн аймаг, сумын нийт иргэдийг төлөөлөн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлж байгаа юм.⁹ Орон нутгийн иргэд өөрсдийн төлөөлөгчдийг ИТХ-д сонгох замаар нутгийн удирдлагад төлөөллөө бий болгодог. Төлөөлөгчдийн олонх нь намаас нэр дэвшигдэн сонгогддог хэдий ч нэг талаас тэдэнд санал өгсөн сонгогчдын эрх ашиг, нөгөө талаас тухайн орон нутгийн иргэдийн нийтлэг эрх ашигт үйлчлэх ёстой гэдгээ ямагт санах ёстой.

ИТХ-ын төлөөлөгч нь иргэдийг төлөөлж, тэдний эрх ашгийг хамгаалах ёстой ч бодит амьдрал дээр хангалтгүй байна. Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь ИТХ-ын талаар огт ойлголтгүй, Улаанбаатар хотын иргэдийн 30 гаруй хувь, хөдөөгийн иргэдийн 70 гаруй хувь нь ийм байгууллага байдаг эсэхийг ч мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Судалгаанд оролцсон орон нутгийн иргэдийн 50 хүрэхгүй хувь нь хурлын төлөөлөгчид иргэдийг төлөөлдөг гэдэгт итгэдэг гэсэн бол Улаанбаатар хотод энэ үзүүлэлт ердөө 1/3 байна.

Огт мэдлэг, мэдээлэлгүй байгаа хүмүүс нь нас, хүйс, ажил эрхлэлт болон сууцны нөхцөлийн хувьд онц ялгарах зүйлгүй, өөрөөр хэлбэл, хүн ам зүйн хувьд тодорхой бүлэг хүмүүс хомс мэдлэгтэй хэмээн дүгнэх үндэсгүй байна. Энэ нь иргэд нийтээрээ нутгийн өөрөө удирдах байгууллага, төлөөллийн ардчиллын талаарх мэдлэг мэдээлэл, ойлголт маш муу байгааг харуулж байна¹⁰.

Дээрх үнэлгээ нь нутгийн хүн амыг “иргэд”, “сонгогчид” хэмээн бүхэлд нь хамаатуулахаас зайлсхийж, нийгмийн бүлгүүдийн өвөрмөц, ялгаатай байдлыг харгалзах, ялангуяа дуу хоолойгоо гаргаж, өөрсдийнхөө амьдралд хамаатай шийдвэрийг гаргахад

⁸ Монгол Улсын Үндсэн хууль 62.1, 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль 8.2 дахь заалт

⁹ НҮБХХ “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн гарын авлага” УБ.2016, 20 дахь тал.

¹⁰ “Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх иргэдийн хандлагын суурь түвшин тогтоох” судалгаа, 2015 он. УИХ-ын Тамгын газар, ШХА, НҮБХХ (5 аймгийн 15 сум, Улаанбаатар хотын 7 дүүргийн 20 хорооны нийт 1200 өрх хамрагдсан)

оролцож чадахгүй байгаа бүлгийн оролцоо, төлөөллийг хангахад онцгой анхаарах шаардлагатай байгааг илтгэн харуулж байна.

Шигтгээ 1. Орон нутгийн төсвийг нөлөөллийн хувьд хамгийн олон хүн үр шимийг нь хүртэх асуудалд төвлөрүүлсэн туршлага

Манай сум нь аймгаас 75 км хол. Иргэдтэйгээ уулзаад, санал, бодлыг нь сонсоод явж байхад хүмүүс хүүхдийнхээ боловсролд их анхаардаг, сайн сургахын тулд орчин, нөхцөлийг нь бас шаарддаг болчихсон нь анзаарагддаг. Сумын хувьд сургууль бол хамгийн том төсвийн байгууллага. Сургуульд хамааралтай эцэг эх, иргэд их.

Манай сумын сургуулийн байр 120 хүүхдийн багтаамжтай. 1975 онд баригдсан. Хүн амын тоо өсөөд 600 гаруй сурагчидтой болчихоор хичээлийн байраа томруулах, орчин үеийн шаардлагад нийцсэн шинэ байртай болох хэрэгцээ гарч ирсэн.

Сумын давсан орлого нэмэгдэхээр төлөөлөгчид тойрог болгон дээрээ нэг юм хийх гээд, нөгөө мөнгө нь хий сарниад, хэсэгчилж хуваагдчих гээд байсан учраас өмнөх 4 жилд сонгогдсон эмэгтэй төлөөлөгч бид тэр мөнгийг ганц том зүйлд хөрөнгө оруулалт болгох бодлого барьсан. Бидний дотор МАН, АН-аас сонгогдсон төлөөлөгчид, бие даагчид байсан.

Бид эхлээд тус тусын намынхаа төлөөлөгчид, намын бүлэгтээ хандан “Олон жижиг сажиг зүйлд биш, хамгийн олон хүн ашиг хүртэх зүйлд хөрөнгө оруулалтаа чиглүүлье” гэсэн агуулгаар нөлөөлөл хийсэн. Бас иргэдэд сурталчилж, сургуулийн зураг, төсөв дээр тэр оныхоо төсвийг их хэмжээгээр байрлуулах шийдвэрийг ИТХ-аас гаргуулсан. Бид сургууль бариулья гэж яам, УИХ-ын гишүүд, холбогдох байгууллагууд руу хандаж л байсан. Тэгэхээр “зураг, төсөв чинь бэлэн болсон уу, экспертиз оруулсан уу” гэж асуудаг учир үүнийгээ бэлэн болгосон, одоо яаманд өгөөд хөөцөлдөөд явж байна.

**Т.Мэндсүрэн,
Баян-Өлгий аймгийн Буянт сумын ИТХ-ын төлөөлөгч,
Засаг дарга**

2.2. ЯЛГААТАЙ БҮЛГҮҮД, ЯЛАНГУЯА ЭМЗЭГ, ЦӨӨНХ, ДУУ ХООЛОЙГОО ГАРГАЖ ЧАДАХГҮЙ ИРГЭДИЙГ ТӨЛӨӨЛӨХ

Таны сонгогчид хэн бэ? Тэд хоорондоо ямар ялгаатай вэ?

“Тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлэх” нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны гол зарчим юм. ИТХ, түүний төлөөлөгч нь төр, иргэн хоёрыг холбогч гүүр учраас төлөөлж буй иргэдийнхээ өвөрмөц, олон талт байдлыг сайтар ойлгох, нийгмийн янз бүрийн бүлгийн онцлог хэрэгцээг ялгаж харах ур чадвартай байх нь төлөөлөх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөл болно.

НҮБ-аас баталсан “Тогтвортой хөгжлийн зорилт 2030” хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хэнийг ч орхигдуулахгүй, ялангуяа ядуу, эмзэг бүлгийн хүмүүсийг нэн тэргүүнд хамруулахыг зорих ба тэдний дуу хоолойг хүргэхэд онцгой анхаарал хандуулах үүргийг төр, засгийн байгууллагууд хүлээх болж байна.

Та бүхний төлөөлж буй иргэд, сонгогчид хоорондоо харилцан адилгүй. Олон янзын хэрэгцээ, ашиг сонирхол, үзэл бодол, байр суурьтай. Нийгмийн бүлэг тус бүр нас, хүйс, яс үндэс, хөгжлийн бэрхшээл, боловсрол, анги давхарга, нийгэмд эзлэх байр суурь, хэл, шашин, бэлгийн чиг баримжаа зэрэг онцлог шинж, ялгаатай байдлыг агуулдаг. Бүлэг бүр эрх мэдэл, боломж бололцоо, амьдралын нөхцөл, хүний эрх, эрх чөлөөгөө эдэлж буй байдлаараа ялгаатай. Уг ялгаатай байдал нь хувь хүний хандлага, чадвараас хамаарах нь бага, харин эрх мэдэл, эд баялгийн тэгш бус хуваарилалт, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын шударга бус тогтолцоотой илүү холбогддог. Эдгээр тогтолцоо нь өөр хоорондоо огтлолцож, нийгмийн эмзэг бүлэг, цөөнхийн төлөөлөлд давхар хамаарлыг үүсгэдэг. Жишээ нь залуу, эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй, тэгээд бас ядуу, боловсрол багатай бол тэр эмэгтэйд ирэх дарамт, ачаа, ялгаварлал улам л нэмэгдэнэ.

Эдгээр ялгаатай байдал нь зарим бүлгийг боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээг шуурхай, чанартай авах, өмчтэй байх, бизнес эрхлэх, санхүүгийн эх үүсвэр, нөөц бололцоог илүү их ашиглах, үр дүнг нь ахиу хүртэх боломжоор хангадаг. Гэвч өөр нэг хэсэгт нь ийм боломж харьцангуй хязгаарлагдмал, нөөц бололцоо муутай, өдөр хоног аргацаах төдий ядуу тарчиг нөхцөлд амьдардаг. Үнэндээ, “Эмзэг” гэгдэх хүмүүсийн өөрийнх нь ганц капитал болсон хөдөлмөр нь хүртэл үнэлэмжгүй байна. Үүнээс шалтгаалан ядуурал нь зөвхөн орлогынх биш, бас боломж, сонголтын хомсдол болж байна. Боломж, сонголт хоёр хязгаарлагдсан тохиолдолд эдлэх ёстой суурь эрхүүд зөрчигдөж, хүн шиг амьдрах наад захын нөхцөл, шаардлага хангагдахгүйд хүрдэг.

Эрх мэдэл, эд баялаг, нийгмийн статус, боломж, эрх чөлөө, чадавхийн хувьд өөр хоорондоо хол зөрүүтэй нийгмийн оршин бүлгүүд байгаа нь тэгш бус байдал үүсэх суурь нөхцөлийг бүрдүүлж байна. Ийнхүү нийгмийн харилцаанд бүрэн оролцож, дуу хоолойгоо гаргаж чадахгүй, орхигдсон, гадна үлдсэн, тусгаарлагдсан иргэд таны тойрогт байгаа ба тэд боломжоос байнга хол байдгийг харгалзаж байх зайлшгүй шаардлага гарч ирж байна.

Хамгийн түгээмэл байдаг бүлгийн гадуурхал нь хүйс, гарал үүсэл, үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл зэрэгт тулгуурладаг. Нэн ядуу байдалд амьдарч буй хүмүүсийн эдлэх эрх, оролцоо нь ихэд хязгаарлагдмал эсвэл үгүйсгэгдэж байдаг. Олон жилийн туршид нийгмээс тусгаарлагдаж, ялгаварлагдаж ирсэн эмзэг бүлгийн хүмүүс нийгэмших гэж хичээх боловч ямар ч үнэ цэнэгүй мэт байдлыг мэдэрч, давшгүй их саад бэрхшээлтэй нүүр тулах болно гэсэн таамаглал, төсөөлөлтэй байдаг.

Тэгвэл ИТХ-ын төлөөлөгчийн хувьд Та эрх нь зөрчигдсөн, тулгамдсан асуудлаа илэрхийлж, гаргаж тавьж чадахгүй, өөрт нь хамаатай шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа хүмүүсийн төлөө юу хийж болох вэ?

Төлөөлөгч танд энэ байдлыг Төлөөлөгчийн бүрэн эрхээрээ дамжуулаад засаж залруулах, нийтлэг эрх ашгийн төлөө “дуу хоолой”, төр-иргэний хооронд холбогч “гүүр” болох бодит боломж бий.

Нийгэм нэгэнт ийнхүү олон янзын бүлгээс бүрдэж байгаа тул ИТХ-ын Төлөөлөгч та энэ олонлог байдлыг зайлшгүй төлөөлөх учиртай. Ялгааг үл харгалзан, эрэгтэй эмэгтэй хүмүүс, нийгмийн эмзэг бүлэг, цөөнхийн төлөөллийн оролцоог бүрэн хангах, өөртэй нь холбоотой аливаа бодлого, шийдвэр гаргах үйл явцад хүн бүрийг хамруулахад төлөөлөл чухал үүрэгтэй.

Шигтгээ 2. Төр-иргэний хооронд холбогч гүүр болж ажилласан туршлага

Манай сумын нэг тулгамдсан асуудал бол ажилгүйдэл юм. 2004 онд ИТХ-ын дарга болсныхоо дараа ажлын байр бий болгох зорилгоор 0,5-2 га газрыг хүнсний ногооны тариалалтын зориулалтаар ажилгүй иргэдэд олгож эхэлсэн.

2012 онд энэ ажлаа эргээд дүгнэхэд, нийт 40-өөд өрхөд газар олгосноос ихэнх нь газраа ашиглахаа больсон байв. Харин 2-3 өрх л 1-2 га-д удаан хугацааны турш ногоо тарьж байсан. Шалтгааныг нь судалбал, бид тэр үедээ “өрхүүдэд газар олгочихвол тэд ногоо тариад, амьдрал нь дээшилнэ” гэж дутуу бодсонд байсан. Гэвч нэг талаас тариалалт хийх хүч, хөрөнгө хомс, нөгөө талаас тарьсны дараах борлуулалт байхгүй байсан нь асуудал болсон. Хөрөнгө, хүч шаардлагатай энэ ажлыг өрх бүр дангаараа хийх боломжгүй, мөн сумаа зах зээлээс алслагдсан гэж тооцоолоогүй байснаа олж мэдсэн. Борлуулалтад газарзүйн байршил буюу УБ-аас 432 км, аймгийн төвөөс 135 км байрладаг нь нөлөөлсөн байсан.

Ингээд, 2016 онд өмнөх сургамжаасаа суралцаж, сумын Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгчдөд хандан уриалга гаргасан. Юуны өмнө ногоо тарьж буй иргэдээ бүлэг болгоё, гарааны санхүүжилтээр дэмжье, суманд ажиллаж байгаа томоохон аж ахуйн нэгжүүдтэй хамтарч, борлуулалтыг сайжруулья”

гэсэн санаачилга гаргаж, 2 жил гаруй ярьж, нөлөөлж явсан. Нэлээд хугацааны дараа иргэд ойлгож, 2018 онд 25 өрх нэгдэж, бүлэг байгуулсан. Бүлгийн иргэдээр өөрсдөөр нь хэрэгцээт тоног төхөөрөмжийн судалгааг гаргуулан төсвийг нь Засаг даргаар дэмжүүлэн, Хуралд оруулж, Сум хөгжүүлэх сангаас 17 сая төгрөг гаргуулаад ажиллаж эхэлж байна. Хашаагаа татаад, ногоогоо тариад эхэлсэн байгаа. Иргэдийн сэдлийг төрүүлж, тэдний санаачилгыг ажилдаа шингээж ажиллаж чадвал үр дүнтэй нь харагдсан.

**Д. Баяржаргал, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын
ИТХ-ын төлөөлөгч**

Орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, холбогдох шийдвэрийг гаргахдаа эмэгтэйчүүд, залуучууд, орлого багатай болон ядуу, нийгмийн эмзэг, тусгаарлагдсан бүлэг, хүмүүсийн төлөөлөлтэй холбогдох, эдгээр хүмүүст үзүүлж буй төрийн үйлчилгээний чанарт хяналт тавих, тэдний өмнө тулгарч буй нэн тэргүүний асуудлыг тодорхойлох, ашиг сонирхол нь ямар нэг байдлаар хөндөгдөж байгаа хүмүүсийг шийдвэр гаргах үйл явцад оролцуулах шаардлагатай. Учир нь, өөрт нь юу хэрэгцээтэйг тухайн хүн өөрөө л хамгийн сайн мэддэг. Төр, засгаас гаргасан шийдвэр амьдралд хэр нийцтэйг тэд хамгийн сайн хэлж чадахаас гадна оролцож гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд маш идэвхтэй оролцдог.

Тэгш бус байдал нь хөгжлийн хамгийн том саад юм. Иргэдийг төлөөлж буй хүмүүс нь нийгмийн зарим бүлэг давуу байдалтай, зарим нь хязгаарлагдмал боломжтой байдгийг ойлгон, аливаа асуудалд нутгийн иргэдийн нийтлэг эрх ашгийг урьтал болгон хандаж сурах юм бол шийдвэр гаргах үйл явц, түүний дүрэм өөрчлөгдөж, аливаа ялгааг үл харгалзсан тэгш боломж хүн бүрт бий болох болно.

2.3. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АШИГ СОНИРХЛЫГ ТӨЛӨӨЛӨХ

Манай улс ардчиллын сонгодог хэлбэр болох төлөөллийн ардчиллыг сонгуулийн гол зарчим болгодог. Сонгуулийн үр дүнд бүрэлдсэн төлөөллийн байгууллага нь иргэдээ хэр сайн төлөөлж чадаж байгаа нь хэр ардчилсан байгааг шууд илтгэдэг нэг чухал үзүүлэлт болдог.

ИТХ буюу орон нутгийн төлөөллийн байгууллага нь боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хүргэх зэрэг иргэдийн амьдралын чанарт шууд нөлөөлөх бодлого, шийдвэрийг гаргадаг тул иргэдэд илүү ойр байгууллага юм. Иймээс эмэгтэйчүүдийн ашиг сонирхлыг тусгахын тулд ИТХ-д тэдний үзэл бодол, туршлагыг төлөөлөх төлөөлөл нэн чухал.

Манай улсын сонгогчдын 53 хувь, хүн амын 50 гаруй хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг. Хүн амын талаас доошгүй хувь нь болсон эмэгтэйчүүд шийдвэр гаргагчдын дунд тооны хувьд цөөн, шийдвэр гаргах эрх мэдлийн хувьд мөн доогуур байгаа нь харамсалтай. Энэ нөхцөлд орон нутгийн эмэгтэйчүүдээ төлөөлж байгаа тэр цөөн хүний нэг нь Төлөөлөгч эмэгтэй та билээ.

Улс төрд “эрэгтэй загвар” давамгай үйлчилж байгаагаас зарим эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй адил эрч хүчтэй, захирангуй, яг тэдэн шиг ажиллаж байж удирдах албан тушаалд ажиллаж, өөрийгөө үнэлүүлнэ гэж бодож, хичээж ажилладаг. Нийгэмд ч тийм хүлээлт тодорхой хэмжээгээр оршиж байдаг. Тиймээс эмэгтэй улс төрчдөд улс төрийн орчин зарим талаар таатай бус байдаг бөгөөд угаасаа байх ёстой газартаа, хийх ёстой ажлаа л хийж байгаа гэх сэтгэгдэл төрөхгүй байх тал бий.¹¹

Эмэгтэйчүүд бид санаачилгатай байж, өөрсдөдөө тулгамдсан асуудлуудаа тодорхойлон, түүнийхээ төлөө тэмцдэг байх хэрэгтэй. Аймгийн хурал дээр эхчүүд, эмэгтэйчүүдтэй холбоотой асуудлыг байнга ярихаар эрэгтэй төлөөлөгчдийн зүгээс үл ойлгох, дэмжихгүй байх байдал гарч ирдэг.

Эмэгтэй төлөөлөгчтэй хийсэн ярилцлагаас

Эрэгтэйчүүд давамгайлсан улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд өөрсдийн амьдралын хэрэгцээ, туршлага болон шаардлагыг хангахын төлөө ажиллах шаардлагатай. Нутгийн удирдлагын шийдвэр гаргах үйл явцад оролцохын тулд эмэгтэйчүүд заавал эрэгтэйчүүдтэй адил байх албагүй. Эмэгтэй хүн улс төрч боллоо гээд эмэгтэй хүн байхаа болино гэсэн үг биш гэдгийг хэзээд санаж явах ёстой. Шийдвэр гаргахад оролцох, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө арга хэмжээ авах зэрэг нь аль нэг хүйсийн хүнд заяасан зүйл бус харин хүн бүрт байдаг чанар, чадвар юм.

“Бид өөрийн гэсэн өөрчлөлт, ялгаа, сэтгэл хөдлөл, аливаа юманд хандах үзэл бодол, тэр ч байтугай нулимсаа ч улс төрд оруулж ирэх ёстой.”

Анна Табайжука, Профессор, Танзани

¹¹ Ардчилал, сонгуулийн тусалцааны олон улсын хүрээлэн. Парламент дахь эмэгтэйчүүд: Тоо ба агуулга. 39 дэх тал

Тэгвэл ИТХ-д эмэгтэйчүүд сонгогдсоны онцлог, давуу тал нь юу байж болох вэ?

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаа нь шийдвэр гаргах үед ямар асуудлыг чухал гэж үзэхтэй холбоотойгоор илрэн гардаг. Жишээ нь эмэгтэйчүүд нийгмийн халамж, эрүүл мэнд, хүүхдийн асуудал зэрэг нийгмийн асуудалд илүү анхаардаг ба энэ нь хувь хүний амьдралын чанарт гүнзгий нөлөөлдөг асуудлууд байдаг.

Түүнчлэн эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж байгаа онцлог хэрэгцээ, асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг чармайж байгааг эмэгтэй сонгогчид төдийгүй нийт иргэд хүлээж, ажиглаж байдгийг мартаж болохгүй. Эмэгтэй төлөөлөгчдийн хувьд орон нутгийн эмэгтэйчүүдийн өмнө тулгамдсан асуудлыг барьж авч, шийдүүлэхийн төлөө явах нь зайлшгүй. Эрэгтэйчүүдийн хөндөж ярьдаг асуудлыг чухал гэж үзээд эмэгтэйчүүдтэй холбоотой асуудлыг жижиг гэж үзэх хандлага мэдээж гарна. Энэ бүхнээс ичих, шантрах хэрэггүй. Харин ч цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байр бий болгох гэх мэт эмэгтэй хүний онцлог хэрэгцээ, шаардлагыг илэрхийлэх асуудалд эмэгтэйчүүд илүү мэдрэмжтэй хандаж, хамтран шийдвэр гаргаж буй эрэгтэй төлөөлөгчдөд асуудлыг үндэслэлтэй танилцуулж чаддаг.

Шигтгээ 3. Орон нутагт хамгаалах байр байгуулах зардлыг төсөвт тусган батлуулсан туршлага

Анхны санаачилгыг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга гаргаж, судалгаа, төсөв, саналын хамт хуульч, төлөөлөгч эмэгтэй гэдэг утгаар миний нэр дээр хаяглан, дэмжлэг хүссэн. Төсөв хэлэлцэж байхад нэмэлтээр орж ирсэн. Хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа тухай төлөөлөгч нарт шууд танилцуулсан ба ИТХ-ын төлөөлөгч бүгд дэмжсэн.

Гэр бүлийн хүчирхийлэл үнэхээр амьдралд тулгамдсан асуудал болж, өдөр бүр надад гомдол ирж байсан. Энэ талаар хохирсон хүмүүст хуулийн зөвлөгөө өгдөг тул нэн яаралтай шийдэх үндэслэлээ тодорхой тайлбарлаж, төсөвт нэмэлт оруулж санхүүжилтийг шийдэх саналыг бие даан гаргасан. Үүний үр дүнд хамгаалах байр байгуулахад шаардагдаж байсан 15,000,000 төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс гаргах шийдвэр гарсан.

Б.Урансувд, Дорнод аймгийн ИТХ-ын төлөөлөгч байсан

Хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, гарал үүсэл, анги давхарга, шашин шүтлэг зэрэг хувь хүний онцлог шинж нь хүмүүсийн

биологийн хүйстэй харилцан холбоотойгоор огтлолцож, төрөл бүрийн ялгаварлан гадуурхалтад өртөхөд хүргэдэг. Үүнээс шалтгаалан эмэгтэйчүүд өөрийнхөө амьдралд хамаатай шийдвэр гаргахад оролцож, дуу хоолойгоо гаргаж чадахгүйд хүрдэг учраас хамгийн эмзэг бүлэгт харьяалагддаг эмэгтэйчүүдийг бас төлөөлж байгаа гэдгээ байнга санаж ажиллах хэрэгтэй.

“Олон улсын туршлагаас харахад, эмэгтэйчүүд аливаа улсын парламент, орон нутгийн өөрөө удирдах байгууллагад, эсвэл хувийн салбарт ч байна уу хамаагүй, шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа бол юун түрүүнд эрүүл мэнд болон боловсрол, хүүхэд асрах асуудал, хот тосгоныг цэвэр, бохир устай холбох, түүнчлэн байгаль орчны хамгаалал зэрэг чухал асуудлуудын хүрээнд бодлогын өөрчлөлт гаргахын төлөө ажилладаг нь ажиглагдана. Харин эрэгтэй улс төрчдийн хувьд эдгээр сэдвийг төдийлөн чухалд тооцдоггүй ажээ. НҮБХХ-ийн дарга асан Хелен Кларкийн хэлсэнчлэн, хэрвээ эмэгтэйчүүд олон нийтийн амьдралд оролцохгүй байвал эдгээр сэдэв ч мөн үл үзэгдэгч болон хувирдаг байна”¹²

2.4. Бүлгийн дүгнэлт

Орон нутгийн иргэд өөрсдийн төлөөлөгчдийг ИТХ-д сонгох замаар нутгийн удирдлагад төлөөллөө бий болгодог. Төлөөлөгчид нэг талаас тэдэнд санал өгсөн сонгогчдын эрх ашиг, нөгөө талаас тухайн орон нутгийн иргэдийн нийтлэг эрх ашигт үйлчлэхээр сонгогддог.

Төлөөлж буй иргэдийнхээ олон янз байдал болон нийгмийн бүтэц, давхраажилтыг сайтар ойлгох нь төлөөлөх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөл юм. Иймд энэ бүлэгт төлөөллийн мөн чанарыг ИТХ-ын төлөөлөгчийн төлөөлөх чиг үүрэгтэй нь түлхүү холбон тайлбарлалаа.

Нутаг дэвсгэрийн хүн амаа “иргэд”, “сонгогчид” гэж бүхэлд нь харалгүйгээр нийгмийн бүлгүүдийн онцлог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалзаж үзэх, ялангуяа дуу хоолойгоо өргөж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа “эмзэг” бүлэгт хамаарагдах иргэдийн оролцоо, төлөөллийг хангахад онцгой анхаарах шаардлагыг харуулахыг зорив.

¹² НҮБ-ын болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь Суурин төлөөлөгч Беате Транкман, “Улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоогоор дамжуулан ардчиллыг бэхжүүлэх нь” Монгол-Германы XIV дүгээр чуулган дээр хэлсэн үгээс эшлэв, 2017

Түүнчлэн эмэгтэй төлөөлөгч болж сонгогдсоны онцлог, давуу тал, олон нийт болон бусад эмэгтэйчүүдийн зүгээс ирэх хүлээлт, шахалтын талаар тусгалаа.

Төлөөллийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхийн тулд өнөөг хүртэл ажиллаж ирсэн арга барилаа эргэн харах шаардлага тулгарч байгаа тул манлайллын шинэ хэв маягийг дараагийн бүлэгт танилцуулах болно.

Гуравдугаар бүлэг. МАНЛАЙЛЛЫН ЗАГВАРУУД

- 3.1. Манлайллын талаарх ойлголт
- 3.2. Манлайллын загварууд
- 3.3. Хамтын манлайллын загвар
- 3.4. Бүлгийн дүгнэлт

3.1. МАНЛАЙЛЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ нь 2008 оноос манлайллын сэдвийг эмэгтэйчүүд, залууст зориулсан сургалтынхаа агуулгад оруулснаас хойш олон улсын болон үндэсний түвшинд манлайллыг хэрхэн тодорхойлж байгааг судлан, дүн шинжилгээ хийж ирсэн билээ. Монголд явагдаж буй манлайллын тухай дийлэнх сургалт болон манай сүлжээнээс өнгөрсөн 8 жилд зохион байгуулсан сургалтад оролцогчдын эхний сэтгэгдлээс үзэхэд байгууллага, хувь хүмүүс “манлайлал” гэхээс илүү “манлайлагч”-ийн тухай ярьдаг ба “манлайлал”-ыг бусдыг “удирдан чиглүүлэх,” “араасаа дагуулах,” “хошуучлах” чадвар ба үүрэг гэж үзэж, тодорхойлж байна. Манлайлал гэхээр түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн хүмүүс, үндэсний баатар, эсвэл хэн нэгэн хүн бусдаар тодорхой зүйл хийлгэж чадаж байвал тэр манлайлагч мөн гэж үздэг ажээ.

Манлайлал гэж юу вэ, манлайллын ямар хэлбэр байдаг вэ, манлайлагч төрдөг үү, эсвэл манлайллын ур чадварт суралцах боломжтой юу, манлайлагч нь удирдагчаас ялгаатай юу зэрэг асуудлыг судлаачдын судалж дүгнэснээс тоймлон дор танилцуулъя.

3.1.1. Манлайлал гэж юу вэ?

Манлайллын талаар олон тодорхойлолт байдаг. Бүгд хүлээн зөвшөөрсөн цорын ганц тодорхойлолт байхгүй, байх ч боломжгүй гэж үздэг.

Манлайллын тодорхойлолт нь:

1. Үр дүнтэй манлайлагчийн зан чанар, дадал практикт төвлөрсөн;
2. Манлайлал нь үйл явц, нөлөөлөл гэж үздэг 2 ангилалд гол төлөв хуваагдаж байна.

Манлайллын талаар эргэцүүлэн бодож, санаа бодлоо бусадтайгаа хуваалцахад сэдэл өгөх зорилгоор хэд хэдэн тодорхойлолтыг сонгон дор дурдав.

... Манлайлал нь хүн ч биш, албан тушаал ч биш. Энэ нь итгэлцэл, хариуцлага, амлалт, сэтгэл хөдлөл болон сайн сайхны төлөө нийтлэг алсын хараанд тулгуурласан ёс суртахууны эдэрээтэй харилцаа юм. **(Жоанне Жиулла)**

... Манлайлагчийн эн тэргүүнд хийх ажил бол алсын хараагаа тодорхойлох явдал. Манлайлал гэдэг бол алсын харааг бодит шийдэл болгон хөрвүүлэх чадавх юм. **(Уоррен Беннис)**

... Манлайлал нь хамтын хүчин чармайлтад утга учиртай чиглэл өгч, зорилгодоо хүрэхэд нь нөлөөлөх үйл явц юм. **(Жейкобсба Жак)**

... Манлайлал нь тодорхойгүй нөхцөл байдалтай тулгарсан үед зорилгодоо хүрэх үүднээс бусдыг чадавхжуулах тухай асуудал юм. Тодорхой ойлгомжтой нөхцөл байдалд та юу хийхээ мэдэж байгаа тул танд манлайлал хэрэггүй. Та юу хийхээ мэдэхгүй байгаа үед манлайллын урлаг, бүтээлч чадвар чухал ач холбогдолтой. Ялангуяа тодорхойгүй нөхцөл байдалтай тулгарсан үед зорилгодоо хүрэх үүднээс бусдыг чадавхжуулахад манлайллын мөн чанар оршдог. **(Маршалл Ганз, Харвардын Их Сургуулийн харьяа Кеннедийн Засаглалын Сургуулийн төрийн бодлого судлалын профессор)**

Дээрх тодорхойлолтуудад алсын хараа, хамтын чармайлт, хоорондын харилцаа буюу нөлөөлөл гэсэн гурван утга агуулагдаж байна.

Манлайллыг гүнзгий ойлгох нь манлайлалд юу багтдаггүйг мэдэхээс эхэлнэ:

- Манлайлал нь эрх мэдэл, албан тушаал биш. Хэн ч, ямар ч нөхцөлд манлайлагч болж, эсвэл манлайллын үүрэг гүйцэтгэж болно.
- Манлайлал нь өдөр тутам хэрэглэдэг бүтээгдэхүүн, үйлчилгээ биш. Бид ямар нэг зүйлийг өөрчлөхийн тулд манлайллын чадавх, ур чадварыг бэхжүүлдэг.
- Манлайлал нь арга барил, үйл явц болохоос эцсийн зорилт биш. Хамтын ажиллагааг өрсөлдөөнөөс дээгүүр тавьж, бүлэг дотор эрх мэдэл болон нөлөөллийг хуваалцаж, улмаар оролцоонд тулгуурлан шийдвэр гаргаж байгаа нөхцөлд манлайлал нь үйл явц болно.

Манлайлал нь тодорхойгүй нөхцөл байдалд нийтлэг зорилгодоо хүрэхийн тулд бусдыг чадавхжуулах үйл явц юм. Манлайлагч нь хүмүүсийн дээр гарч, хяналтын жагсаалт бүхий цаас барьж суухын

оронд тодорхой өөрчлөлт бий болгохын тулд тэднийг сэдэлжүүлэх чадвартай байх ёстой.

... Хэрвээ үйл хөдлөл тань хүмүүсийг илүү хүсч мөрөөдөх, илүү суралцах, илүү ихийг хийх, илүү сайн сайхан болоход уриалж, урам зориг хайрлаж байвал Та манлайлагч мөн. **(Жон Күинси Адамз)**

Хэрвээ хөлөг онгоц барихыг хүсвэл, мод цуглуулахад уриалж, ажлаа хувааж, тушаал буулгасны хэрэггүй. Оронд нь харин тэдэнд зах хязгааргүй далай тэнгисийг мөрөөдөх замыг нь заа. **(Антуане дө Ст. Эксюпери)**

3.1.2. Манлайлал, менежментийн ялгаа

Та алинд нь их цаг зарцуулдаг вэ?

Манлайлал нь менежментээс тэс өөр зүйл. ИТХ-ын төлөөлөгч нь менежер биш манлайлагч юм.

Интернет холболтын өсөлт, Facebook, Twitter болон бусад нийгмийн сүлжээний тэлэлт зэрэг технологийн эрчимтэй хөгжлийн нөлөөгөөр харилцаа холбооны шинэ орон зай бий боллоо. Энэ нь нийгэм, улс төрийн амьдралд нөлөөлж иргэд болон орон нутгийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг улам л тодорхойгүй, олон талт, төвөгтэй болгож байна. Бидний амьдардаг хүрээлэн буй орчин ихэд өөрчлөгдөж байгаа энэ цаг үед тулгамдсан асуудлыг бүхэлд нь, томоор харж, нөхцөл байдлыг урьдчилан тооцоолж, сонгогчдын хэрэгцээ, хүлээлтийг мэдэрч, зөв чиглэлд хүч, бололцоогоо дайчлах, өөрийн бүтээлч орон зайг бий болгож чадах манлайллын хэрэгцээ, шаардлага улам бүр өссөөр байна.

Бидэнд замын зургаас илүүтэйгээр алсын хараа, зорьж буй газар, луужин илүү чухал байна. Бүтээмж нь дан ганц хөдөлмөрөөс биш, энэ хүч, хөдөлмөрөө зөв зүгт, зөв газарт чиглүүлж байгаа эсэхээс шалтгаална. Ийм ч учраас сүүлийн үед засаглал, үйлдвэрлэлд гарч буй өөрчлөлт нь нэгдүгээрт манлайлал, хоёрдугаарт менежментийг шаардаж байна.

Манлайлалгүй менежмент бол “Титаник хөлгийн сандлуудыг тэгшлэхтэй адил. Менежментийн ямар ч амжилт удирдлагын уналтыг нөхөж чадахгүй. Гэвч манлайлан удирдах нь маш хэцүү учраас бид менежментэд уягдчихдаг.”¹³

¹³ Стивен Ковей, Өндөр бүтээмжтэй хүний 7 дадал, 2009 он, 118, 119 дэх тал.

Менежмент буюу зохион байгуулалт бол “Тодорхой зүйлсийг хэрхэн дээд зэргээр бүтээх вэ” гэсэн эцсийн шат. Манлайлал бол “Юу бүтээх вэ” гэсэн эхний шат. Менежмент нь дэг журам, ашиглалт, гүйцэтгэл, бүтээмж байдаг бол манлайлал нь тодорхойгүй нөхцөл байдалд өөрчлөлт бий болгох үйл явц, бусдад нөлөөлөх чадвартай илүү холбогддог.

Манлайлал, менежментийн ялгааг тайлбарласан олон загвар байдаг. Энэ гарын авлагад Ральф Стэйсигийн онолд тулгуурласан “Шар тойрог, Цэнхэр хайрцаг” (Yellow circle, Blue box) загварыг танилцуулж байна.

Энэ загвар нь Ойлголцлын тэнхлэг (босоо) болон Шийдвэрийн тэнхлэгтэй (хэвтээ) бөгөөд хоёр тэнхлэгийн уулзварт Менежментийг цэнхэр хайрцаг, Манлайллыг шар тойргоор дүрсэлснийг доорх зургаас харна уу.

Ойлголцлын тэнхлэг: Ажил хэрэг, нөхцөл байдал тодорхой үед менежментийг хэрэгжүүлэхэд дөхөм байх бөгөөд харин ирээдүйн төсөөлөл тодорхой бус байх үед манлайллыг хэрэгжүүлдэг.

Шийдвэрийн тэнхлэг: Асуудлыг шийдэх боломжтой үед менежментийг хэрэгжүүлэх бөгөөд тодорхойгүй, төвөгтэй нөхцөл байдалд манлайлал шаардагдана.



Зураг 2. Цэнхэр хайрцаг, шар тойрог

Эх сурвалж: (John Atkinson, Emma Loftus, John Jarvis, 2015, p.55)

Менежментийн цэнхэр хайрцагт гомдол, саналд хариу өгөх, төлөвлөгөө, хөтөлбөр батлах; шийдвэрийг иргэдэд танилцуулах; тодорхой дэг журам, шийдвэр гаргах; хяналт хийх; хариулт, зөвлөгөө өгөх; төсөвлөх, зарцуулах зэрэг захиргааны шинжтэй өдөр тутмын үйл ажиллагаа, үйл хэрэг хамаарна.

Манлайллын шар тойрогт алсын хараа, стратегийн чиглэл тодорхойлох; харилцаа холбоо, сүлжээг хөгжүүлэх; шинэ санаа турших, нэвтрүүлэх; бусдыг үйл хэрэгт сэдэлжүүлэх, зоригжуулах, уриалах зэрэг өөрчлөлтөд чиглэсэн ажил, үйл хэрэг багтана.

Улс төрийн алсын хараа нь хүмүүс ирээдүйдээ юуны төлөө тэмүүлж байгаад тулгуурласан, иргэдийн төлөөлөгчийн хувьд таныг сонгуулийн мөчлөгт хугацаанд тойрогтоо болон орон нутагтаа юуг шийдэхээр зорьж байгааг харуулсан томоохон дүр зураг юм. Стратегийн чиглэл нь алсын хараандаа хүрэхийн тулд хэрэгжүүлэх богино хугацааны зорилтууд юм.

Тухайн асуудал нь зохион байгуулалттай холбоотой байвал шалтгаан болон шийдлийн талаар зөвшилцөхөд хялбар. Харин тухайн асуудал нь тодорхойгүй нөхцөл байдалд өөрчлөлт бий болгохтой холбоотой байвал түүний шалтгааныг оролцогч талууд өөр өөрөөр харж ойлгох тул зөвшилцөл бага байна. Түүнчлэн шийдэл олохын тулд хэрхэн ажиллах талаар оролцогч талуудын дунд зөвшилцөл бага, хүн бүр өөр өөр үзэл бодолтой байдаг. Үүнийг шар тойрогт үзүүлэв. Өөрчлөлт шаардсан асуудал нь ярвигтай бөгөөд тодорхойгүй нөхцөл байдалд байдаг тул шийдэл олохын тулд зайлшгүй хамтарч ажиллах хэрэгцээ, шаардлага үүсдэг.

Манлайлал нь тодорхойгүй нөхцөл байдалтай тулгарсан үед зорилгодоо хүрэх үүднээс бусдыг чадавхжуулах үйл явц юм. Тодорхой, ойлгомжтой нөхцөл байдалд та юу хийхээ мэдэж байгаа тул танд манлайлал хэрэггүй. Та юу хийхээ мэдэхгүй байгаа үед манлайллын урлаг, бүтээлч чадвар чухал ач холбогдолтой. Ялангуяа тодорхойгүй нөхцөл байдалтай тулгарсан үед зорилгодоо хүрэх үүднээс хүмүүст хүрч ажиллах, бусдыг чадавхжуулахад манлайллын мөн чанар оршдог.

Хууль тогтоомжид төлөөлөгчийн чиг үүргийг (цэнхэр хайрцаг дахь) заасан байдаг. Албан ёсны энэ эрх мэдлээс гадна бусад талуудад нөлөөлөх чадвараа ашиглан манлайллын (шар тойрог дахь) чиг үүргээ хэрэгжүүлэх боломж бий.

Хүснэгт 2. Зохион байгуулалттай холбоотой бэрхшээлийг өөрчлөлт шаардсан асуудлаас ялгах нь

Зохион байгуулалттай холбоотой бэрхшээл (Менежментийн цэнхэр хайрцаг)	Өөрчлөлт шаардсан асуудал/сорилт (Манлайллын шар тойрог)
Тодорхойлоход хялбар	Тодорхойлоход төвөгтэй. (эсэргүүцэх, үгүйсгэх, татгалзах магадлалтай)
Гол төлөв хурдан, хялбар шийдэгддэг, урьдчилан тооцоолж болохуйц	Үнэт зүйлс, үүрэг роль, харилцаа, уялдаа холбоо болон ажлын арга барилаа өөрчлөхийг шаарддаг.
Ихэнхдээ эрх мэдэлтэн, эсвэл мэргэшсэн мэргэжилтэн уг бэрхшээлийг шийдэж чаддаг.	Ихэвчлэн олон өөрчлөлтийг огтлолцуулан хийх шаардлага тулгардаг.
Хүмүүс гол төлөв энэ төрлийн бэрхшээлийг шийдэх шийдлийг эергээр, хялбар хүлээж авдаг.	Хүмүүс өөрчлөлт шаардсан асуудал/сорилтыг хүлээн зөвшөөрдөг хэдий ч ихэнх тохиолдолд сөрөн зогсдог.
Шийдлүүд нь ихэнхдээ шуурхай хэрэгжих боломжтой. Шийдвэр гаргагч нь өөрөө ч гардан хэрэгжүүлж болохуйц.	Шийдлүүд нь шинэ арга барил, шинэ стратегийг эрэлхийлдэг. Тэдгээр нь ажил хэрэг болж, үр дүнд хүртлээ тодорхой хугацаа шаарддаг. Шийдвэр гаргагч дангаар хэрэгжүүлэх боломжгүй.

3.1.3. Бид хэрхэн манлайлагчид болж өөрчлөгдөх вэ?

Менежер бүхэн манлайлагч болдоггүй.

Зохион байгуулалттай холбоотой бэрхшээлүүд нь менежмент болон мэргэшсэн байдалтай илүү холбоотой. Харин өөрчлөлт шаардсан асуудал/сорилт нь манлайллыг шаарддаг. Ихэнх манлайлагчдад тулгардаг нийтлэг алдаа нь энэ хоёрыг адилтгаж хандах явдал юм.

Эмэгтэй төлөөлөгчдөд ялгаагүй энэ хандлага түгээмэл ажиглагддаг ба манлайллаас илүү менежменттэй зууралдах гээд байдаг талтай. Эмэгтэй төлөөлөгчдөд хийсэн манлайллын сургалтын үеэр тэд “эрч хүч, цаг хугацааныхаа 80 гаруй хувийг менежментэд, харин 20 хүрэхгүй хувийг манлайлалд зарцуулдаг гэдгээ олж харлаа” гэж хэлж байсныг анхааралдаа авах шаардлагатай. Учир нь тэдний өдөр тутмын туршлага нь менежменттэй илүү ойр. Тухайлбал, эмэгтэй төлөөлөгчдийн үндсэн ажил нь ихэнх тохиолдолд гүйцэтгэх түвшинд байдаг. Цөөхөн нь дунд шатны менежерийн албан тушаал хашдаг. Түүнчлэн тэд эмэгтэй хүнийхээ хувьд гэр орондоо олон зүйлийг нэг дор зэрэг амжуулах үүрэг хариуцлагатай өдөр тутам тулгарч, тэр хэрээр гардан хэрэгжүүлэх дадалтай болсон байдаг. Энэ туршлага, дадал, практикаа төлөөлөгчийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ түлхүү

ашигладаг ба цаашид үүнээс зайлсхийхийн тулд тэргүүн ээлжид гүйцэтгэл, бүтээмжтэй холбоотой бэрхшээлийг өөрчлөлт шаардсан асуудал/сорилтоос ялгаж харах ур чадварт суралцах шаардлагатай.

Шигтгээ 4. Иргэдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн түүх

Манай баг 160-аад малчин өрхтэй, зуны улиралд ноосоо хадгалах газар байдаггүй, өвлийн улиралд гүний усаар дутагддаг асуудлуудтай байсан. 128 иргэдээс гарсан санал хүсэлтийн дагуу багийн хурлаар нэг, хоёрдугаарт эрэмбэлэгдсэн ноосны агуулах, гүний худгийн асуудлыг сумын ИТХ-аар хэлэлцүүлж, нийт 28 сая төгрөгийн төсвийг батлуулсан. Одоо бид ноосны агуулахаа ашиглаж байна. Мөн ундны усаа гүний худгаас авсаар байна.

**3.Цэнгэлмаа, Сэлэнгэ аймаг,
Зүүнбүрэн сумын малчин, төлөөлөгч**

Ингэснээр таны Төлөөлөгчийнхөө хувьд гүйцэтгэх үйл хэрэг нь төлөөлж буй иргэд, сонгогчдын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тэднийг сэдэлжүүлэх, хамтын үнэт зүйлийг бүтээх, хамтдаа суралцах үйл явцад түлхүү чиглэгдэх болно.

3.2. МАНЛАЙЛЛЫН ЗАГВАРУУД

Манлайллын олон загвар байгаагаас 1) манлайлагч төвтэй уламжлалт загвар, 2) нийтийн сайн сайхны төлөө хамтын манлайлал гэсэн хоёр гол хэлбэрийг энэ сургалтанд зориулан дэлгэрүүлж авч үзэв.

3.2.1. Манлайлагч төвтэй уламжлалт загвар

Манлайлагч төвтэй буюу манлайлагчийг “дээдэлсэн” гэж хэлж болох загвар хамгийн түгээмэл хэрэглэгдэж иржээ. Энэ нь босоо тэнхлэгт манлайллын загвар юм. Уламжлалт загварын хүрээнд хүмүүс манлайлагчийг ихэнхдээ “орчин үеийн” буюу хотын, костюм өмссөн, дээд боловсролтой, дундаж ба түүнээс дээш давхаргын, өөртөө итгэлтэй, бусдыг захирч чаддаг, дунд эргэм насны эрэгтэй хүн буюу дарга гэж төсөөлдөг. Орлого багатай, албан ёсны боловсрол нимгэн, залуу, эмэгтэй, орон нутгийн, үндэсний цөөнх, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг нийгэмд эрх мэдэл, нөлөө багатай хүмүүс энэ хэвшмэл ойлголтод багтаж чадахгүйгээс өөрийгөө манлайлагч байж болно гэсэн итгэлгүй байдаг. Нөгөө талаар, уг


хэвшмэл ойлголт нь нийгэмд давуу эрх эдэлж ирсэн бүлгийн эрх мэдлийг хадгалан бэхжүүлэхэд үйлчилж байж ч болох талтай.

Манлайлагч төвтэй загварт “хоршоо” буюу цөөн тооны хүний манлайлал, “түүчээ” буюу ээлжлэн цөөн хүн манлайлах хэлбэр мөн багтах бөгөөд үндсэндээ манлайлагч гэх нэг ба цөөн хүнд гол үүрэг оноож, эрх мэдэл өгдгөөрөө адил юм.

3.2.2. Манлайллын уламжлалт загварын үндсэн шинжүүд

Эрх мэдэл дээрээс доош чиглэсэн, босоо тэнхлэгтэй ба зиндаачлал үүсгэдэг.

Манлайлагч төвтэй загвар нь нэг урсгалтай ба дээрээс доошоо чиглэсэн үйл явц байдаг.



Зураг 3. Манлайллын уламжлалт загвар

Бусдаас илүү мэдлэг, чадвартай гэгдэх “манлайлагч” хүнд хамгийн их эрх мэдлийг хуваарилж, шат доошлох тусам эрх мэдлийн хэмжээ багасдаг.

Энэ загварт ихэнхдээ эцсийн шийдвэрийг манлайлагч гаргаж, эрх мэдлийн босоо тогтолцоо үйлчилдэг.

Тиймээс манлайлагч нь “дарга” болж хувирдаг. Мэдээлэл харилцаа мөн дээрээс доош чигтэй, ихэвчлэн даалгавар өгөх, сэнхрүүлэх зорилготой. Ийм загварын хүрээнд хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд олон талын, ялангуяа иргэд, эрх нь зөрчигдөж буй бүлгүүдийн бодит, тэгш, сайн дурын оролцоог хангах боломж бага.

Манлайлагч хэмээх нэг хүнд төвлөрсөн, эрх мэдлийн тэгш бус хуваарилалт.

Манлайлагч заавал эрх мэдэлтэй “дарга” байх албагүй, хэн ч манлайлагч байж болох ч бусдаас “онцгой”, мэдлэг, боловсрол, чадавхтай байх ёстой гэж үздэг. Манлайлагчийн эзэмшсэн байх ёстой шинжид ухаалаг,

харилцааны соёлтой, мэдлэг боловсролтой, зохион байгуулах чадвартай, алсыг хардаг, биеэ зөв авч явдаг, бусдыг удирдан чиглүүлэх, араасаа дагуулах чадвартай гэх мэт олон шаардлага багтдаг. Амжилттай байна гэдэг нь “нэг” номер байхын тулд үргэлж өрсөлдөх гэсэн утгатай учраас ийм бүтэц, тогтолцоонд эрх мэдэл нь бусадтай хуваалцах зүйл биш болж хувирдаг.

Манлайлагч хэмээх хувь хүнийг дөвийлгөж, түүнд өндөр шаардлага тавьдаг.

Нэгэнт манлайлагч хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн бол эрх мэдлээс гадна өндөр хариуцлага хүлээдэг. Манлайлагч тэр эрх мэдлийг хүсээгүй байсан ч хэвшмэл ойлголт, хандлагын шахалтаар энэ үүргийг хүлээхээс өөр аргагүйд хүрнэ. Харин “дагагч” түүнд гол ачааг үүрүүлээд, өөрсдийнхөө төлөө зүтгэхийн оронд “манлайлагч” бидний төлөө зүтгэх ёстой гэж бодон хувь заяагаа даатгах явдал гардаг.

Нийгэмд давуу эрхтэй хүмүүсийн өрөөсгөл мэдлэг, явцуу туршлагаар шийдвэр гардаг.

Санал солилцох, багаар ажиллах, олон нийтийг татан оролцуулах зэрэг элементүүд агуулсан ч мөн чанартаа захиран тушаах ёс давамгайлсан. Хүмүүстэй зөвлөлдөх, олон талын оролцоог хангах гэдэг нь бодит амьдрал дээр үзэл бодол, амьдралын туршлага, сонирхол, арга барил зэргийн хувьд хоорондоо ялгаатай, магадгүй зарчмын зөрүүтэй байр суурьтай хүмүүстэй харилцана гэсэн үг юм. Олон “манлайлагч” оролцоог хангая гэж бодсон ч туршлага, ур чадвар, аргазүй муутай, нөгөө талаас богино хугацаанд үр дүн харах шахалтанд орж, олон талыг татан оролцуулж, саналыг нь цуглуулж зөвлөлдсөн дүр эсгэх байдлаар оролцоог хэлбэрдэх байдалд хүрдэг.

Гадаад дүр төрх, харилцааны арга барилд хэт анхаардаг.

Хувийн хөгжил, манлайлал зэрэгт цогц, зарчимч байдлаар хандахыг чухалчилдаг нэрт зохиогч Стивен Көүви,¹⁴ “Дэлхийн I дайнаас өмнөх 150 гаруй жилийн туршид бичигдсэн бараг бүх ном зохиолд амжилтыг шударга, даруухан, зоригтой, үнэнч, тэвчээртэй, хөдөлмөрч, энгийн, тууштай байх зэрэг зарчим болон хүмүүний мөн чанартай холбож үзэж байжээ. Түүнээс хойш өнөөг хүртэл бичигдсэн бүтээлийн дийлэнх нь олон нийтэд таалагдах, олон нийтийн хандлагыг “зохицуулахад” түлхүү анхаарч, хүмүүс хоорондын харилцааг “тосолж” байдаг зан авир, хувь хүний дүр төрх, хандлага, биеэ авч явах байдал, харилцааны арга барил,

¹⁴ Stephen R. Covey, *The Seven Habits of Highly Effective People* (New York: Free Press, 2004).

ур чадвар зэрэгтэй холбон тайлбарлах болсон байна.

Өмнө нь амьдралын үндэс болох суурь, түгээмэл зарчмуудыг хувь хүн баримталж, түүнд нийцсэн шинж чанарыг өөртөө төлөвшүүлж чадваас амжилтанд хүрнэ гэж үздэг байсан бол сүүлийн үед түр зуурын шийдлээр цаг, хөдөлмөр шаардсан ул суурьтай, тогтвортой шийдлийг орлуулахыг оролдож, хуурамч дүр сурталчилж байна. Тухайлбал, тодорхой арга техник хэрэглэж хүмүүст таалагдах, хүсч буй зүйлээ авахын тулд хүмүүсийн хобби зэргийг сонирхож буй дүр эсгэх эсвэл “нөлөө бүхий хүн” шиг харагдан хүмүүсийг сүрдүүлэх замаар хүссэн зорилгодоо хэрхэн хүрэхийг зааж байна” гэжээ.

“Сүүлийн үеийн” өнгөц хандлага Монголд ч нэвтэрч, дээр нь хариуцлага, ёс зүй суларсны улмаас амжилт олохыг хүссэн олон хүн “имидж” буюу гадаад дүр төрхөндөө түлхүү анхаарах болсон. Манлайлагч байх гэдэг нь “манлайлагчийн төрх бүрдүүлэх”-тэй утга нэгэн болж хувирчээ. Мэдээллийн эрин зуунд “дүр төрх”-өө зөв бүрдүүлэх нь чухал. Гэхдээ энэ нь тухайн хүний зарчим, үнэт зүйлс, мөн чанарт суурилагагүй бол “амжилт” түр зуурынх байхаас гадна хүмүүсийн амьдралд сөргөөр нөлөөлнө. Улмаар бусдад таалагдахуйц байдлаар биеэ авч явдаг, ямар ч асуудлаар өөртөө итгэлтэй ярьчихдаг, ямар ч хамаагүй аргаар богино хугацаанд “үр дүн” гаргачихдаг, хувийн амбицдаа хөтлөгдсөн, бусдыг ашиглан дээш мацахаас буцахгүй, “соёлтой” харагддаг ёс зүйгүй “манлайлагч” олшроход нөлөөлж байна.

3.2.3. Манлайллын босоо тэнхлэгт уламжлалт загварын сул тал, эрсдлүүд

Цөөн хүн, эсвэл нэг хүний гарт эрх мэдэл төвлөрдөг болохоор:

- о Үйл явц, үр дүн нь эрх мэдэл бүхий нэг эсвэл цөөн хүнээс хэт хамааралтай, тогтолцооны хувьд суурь муутай, эмзэг, тогтворгүй.
- о Манлайлагч солигдоход нийтэд чиглэсэн бодлого, шийдвэрийн залгамж чанар алдагдах эрсдэлтэй.
- о Нийтлэг ашиг сонирхлыг хангах зорилгоо хөсөрдүүлж, хувийн буюу эрх мэдэлтэй цөөнхийн эрх ашигт үйлчлэх эрсдэл өндөр.

Эрх мэдэл босоо тэнхлэгт, зиндаачилсан, угтаа захиран тушаах ёсонд суурилсан тул:

- о Эрх мэдэл ихтэй нь эрх мэдэл багатайгаа үл хүндэтгэх, үл тоомсорлох, эрхийг нь зөрчих, дарамтлах эрсдэлтэй.

- Энгийн иргэдийн, ялангуяа эрх нь зөрчигдөөд буй бүлгүүдийн бодит, тэгш оролцоог хангахдаа муу.

Мэдээлэл харилцаа дээрээс доош чигтэй тул:

- Өрөөсгөл, амьдралаас хол шийдвэр гаргах магадлал өндөр.
- Энгийн иргэд, ялангуяа хамгийн эмзэг, эрх мэдэл багатай хүмүүст гаргасан шийдвэр нь хэрхэн тусч буйг мэдрэхдээ удаан, хойрго.
- Буруу шийдвэр нь удаан хугацаанд хэрэгжиж, ихээхэн сөрөг үр дагавар дагуулах эрсдэл өндөр.

Үйл явц, тогтолцооноос илүү үр дүн, хувь хүний хүчин зүйлийг илүүтэй анхаардаг тул:

- Манлайлагч хэмээх цөөн хүн чадавхжиж, дийлэнх нь хэвээрээ хоцордог.
- Эргээд иргэдийн “мэдлэггүй, чадавхгүй” байдал нь асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх үйл явцад тэднийг оролцуулахгүй байх үндэслэл болсоор байх магадлалтай.
- Манлайлагч гэсэн хэвшмэл ойлголт, дүрийг бүтээхдээ ихэвчлэн эрэгтэй, орчин үеийн хэв маягтай, мөнгөтэй, өндөр боловсролтой гэх мэтээр төсөөлдөг тул эмэгтэй, хөдөөний, боловсрол багатай, хэтэвч нимгэн хүмүүсийн манлайлал, оролцоог хязгаарлаж, манлайлагч мөн эсвэл байж чадна гэж өөртөө итгэх итгэлгүй болгож байдаг.

Эрх мэдэл, нөлөөтэй хүмүүсийн үзэмж, өрөөсгөл мэдлэг, явцуу туршлагаар шийдвэр гарах нь түгээмэл тул:

- Нийгэмд давуу эрх эдэлж буй бүлгүүдийн нүдээр харсан, тэдний эрх ашигт илүү үйлчилсэн, асуудлын суурь шалтгаанд хандаагүй, өнгөц, үр дүн муутай төдийгүй сөрөг үр дагавар бүхий бодлого, шийдвэр гарах өндөр эрсдэлтэй.
- Шаардлагатай шинэтгэлийг хийх хүсэл эрмэлзэл сул, эхлүүлсэн ч тууштай, цогцоор нь хэрэгжүүлэх магадлал бага, ерөнхийдөө статус кво буюу байгаа байдлыг хамгаалан хадгалахад үйлчлэх өндөр магадлалтай.

Эрх мэдлийн хуваарилалтыг дагаад хариуцлагын хуваарилалт тэгш бус, шийтгэл оноохдоо туйлширдаг:

- Ихэнхдээ шийдвэр гаргахад бүрэн эрхтэй оролцоогүй эрх мэдэл багатай хүмүүст нялзааж, хэлмэгдүүлдэг.

- о Эсвэл зөвхөн шийдвэр гаргагч/манлайлагчид оноож, түүнийг зайлуулж, өөр манлайлагчаар сольдог.
- о Энэ байдал хүн бүхэнд - эрх мэдэл ихтэйд ч, багатайд ч хариуцлагаас бултах сэдэл төрүүлж, хариуцлагагүй, хяналтгүй байдлыг өөгшүүлэхээс гадна хувь хүмүүст буруу өгч, тогтолцоог өөрчлөх шаардлагыг үл огоорч, дорвитой өөрчлөлт хийх боломжийг хааж байдаг.

Дээрх сул талуудын улмаас хувь хүнийг дөвийлгөсөн, манлайлагч төвтэй загвар шүүмжлэлд өртөж, энэ загвар манлайлагчдыг нийгмийн сайн сайхны төлөө зөв зүйлд хандуулж тэр бүр чадахгүй, орчин үеийн нийгмийн болон бизнесийн хөгжлийн эрэлт хэрэгцээг хангахгүй байна гэж үзэх болжээ.

Манлайлал судлаач Жэксон, Парри нарын ангилснаар¹⁵ “манлайлагч төвтэй загвар” Монгол Улсад давамгайлж байна гэж үзэж болно. Түүнээс гадна энэ загвар нь “эрчүүдийн хэв маяг” зонхилсон улс төрийн загварын суурь нь болдог ба эмэгтэйчүүдэд ээлгүй байдаг.

“Парламент дахь эмэгтэйчүүд: тоо ба агуулга” номд “Эрэгтэйчүүд улс төрийн тавцанд давамгайлж, улс төрийн тоглоомын дүрмийг тогтоож байна. Түүнчлэн улс төрийн амьдрал нь эрэгтэйчүүдийн хэм хэмжээ, үнэт зүйлсийн хүрээнд бүрдэж, зарим тохиолдолд бүр эрэгтэйчүүдийн амьдралын хэв маягт нийцэн зохицсон байдаг. Жишээ нь улс төр нь системчилсэн хамтын ажиллагаа болон зөвшилцөл бус харин нам хоорондын хэмжээнд “ялагч”, “ялагдагч”, “өрсөлдөөн-сөргөлдөөн” гэсэн зарчим дээр голлон суурилдаг. Үүнээс үүдээд эмэгтэйчүүд улс төрөөс татгалзах, зүгээр нэг улс төрөөс ч биш, эрчүүд давамгайлсан улс төрөөс татгалзах хандлагатай болдог. Энэ тохиолдолд эмэгтэйчүүд улс төрд оролцсон ч гэсэн хязгаарлагдмал хэмжээтэй байх тохиолдол элбэг байдаг” талаар онцолсон ба энэ нь орон нутгийн төлөөлөгч эмэгтэйчүүдэд ч мөн хамаатай юм.

Бидний дотоод ертөнцөд ч ялгаагүй манлайллын уламжлалт загвар, практик гүн гүнзгий, нэвт шингэсэн байдаг. Иймд эрх мэдлийг төвлөрүүлсэн, босоо тэнхлэгт манлайллын загварт баригдалгүйгээр манлайлал, хамтын ажиллагааны шинэ загварыг хөгжүүлэх, хамтын эрх мэдлийг бэхжүүлэх шаардлага тулгарч байна.

¹⁵ Brad Jackson and Ken Parry, *Very Short, Fairly Interesting and Reasonably Cheap Book about Leadership* (London: Sage Publications Ltd., 2008)

Манлайлал нь заавал нэг мундаг хүний чадамж, түүний удирдлага хошуучлалын тухай ойлголт байх албагүй.

Манлайлал гэдгийг бид зорилго, зарчим, үнэт зүйлсдээ нийцүүлэн дахин тодорхойлох боломжтой.

Эмэгтэйчүүдийн манлайллын ахиц дэвшлийг тэдний улс төрийн оролцоо, нөлөөллөөр хэмжих болж байна.

3.3. ХАМТЫН МАНЛАЙЛЛЫН ЗАГВАР

Манлайллын уламжлалт загварт манлайлагч нь “од”-ын дүрд (бүхнийг манлайлж, дарга болж) тоглож, бусад бүх хүн туслах эсвэл орлогч дүр бүтээж, манлайллын театрыг бий болгодог. Харин хамтын манлайлал нь уламжлалт манлайлалтай харьцуулахад илүү дугуй хэлбэртэй, доороосоо дээшээ чиглэлтэй манлайлал юм.

Хэн ч, ямар ч нөхцөлд манлайлагч болж, эсвэл манлайллын үүрэг гүйцэтгэж болно. Оролцогч бүр манлайллыг зэрэгцэн хэрэгжүүлдэг ХАМТЫН манлайллын загвар нь “манлайлал бол мэдээлэл, эрх мэдэл шиг хүмүүс хооронд шилжиж байдаг, хуваалцах боломжтой зүйл” гэсэн үзэлд суурилдаг. Хамтын ажиллагааг өрсөлдөөнөөс дээгүүр тавьж, бүлэг дотор эрх мэдэл болон нөлөөллийг хуваалцаж, улмаар оролцоонд тулгуурлан шийдвэр гаргаж байгаа нөхцөлд манлайлал нь үйл явц юм.

“Ирэх зуун руу өнгийн харвал, бусдыг эрх мэдэлжүүлж чаддаг хүмүүс манлайлагчид байх болно.”

Билл Гейтс

Хүмүүс рүү оч. Тэднээс сур. Тэдэнтэй амьдар. Тэдний мэддэг зүйлээс эхэл. Тэдэнд байгаа зүйлээр бүтээн байгуул. Ажил дуусч, зорилго биелэгдсэний дараа хүмүүс “бид үүнийг өөрсдөө хийж чадлаа” гэж хэлж байвал та өөрийгөө сайн манлайллаа гэж бодоорой.

Лао Цзу

Хамтын манлайллын явцад харилцан суралцаж, хамтдаа хөгжих боломжтой учраас хүн бүрийн чадавх бэхжинэ. Ингэснээр хүн болгон зөвхөн манлайлагчийг дагаж хөгжих бус харин өөрсдөө манлайлагч болохын төлөө хичээцгээх болно.

3.3.1. Хамтын манлайллын үндсэн шинжүүд

Пэрри, Браймэн, Манц, Симс, Каузес, Познер, Шамир, Проктор-Томпсон, Синха, Хоскинг, Найтс, Уилмотт, Гордон¹⁶ болон эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллыг хөгжүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулдаг “Эмэгтэйчүүдийн суралцах түншлэл” олон улсын байгууллагын үндэслэгчдийн нэг Махназ зэрэг онолчдын дэвшүүлсэн онолын гол санааг нэгтгэн хамтын манлайллын онцлогийг дор дурдав. Үүнд:

Хамтын манлайлал нь зэрэг зиндаанд тулгуурласан тогтолцоог илүү тэгш эрхэд суурилсан хэвтээ тэнхлэг болгон өөрчилдөг.

Захиран тушаах ёс, аливаа албадлага, захиргаадлаас эрс татгалзаж, эрх мэдэл, үүрэг хариуцлагыг тархаан хуваарилахыг хичээдэг. Хариуцлагыг хүн бүр хуваалцдаг.

Нийтлэг зорилгын төлөө ажиллаж байгаа хүмүүстэй хамтрах хэрэгтэй. Хамгийн чухал зүйл бол хүмүүсийг санаачилгынхаа нэгэн хэсэг болгосноор тэд бүгд хариуцлагын мэдрэмжтэй болно. Хэрвээ та аливааг хөгжүүлж, бусадтай үр дүнгээ хуваалцахын тулд хамтран ажиллаж байвал тэр зүйл нь өөрийн гэсэн амьтай болж ирнэ. Тиймээс манлайлал нь удаан үргэлжлэх тогтвортой санаачилгыг үүсгэх боломжтой холбоотой гэдгийг би ойлгож байна. Ажил дууссан ч бүтэц, тогтолцоо болон та бүхний хийсэн, бүтээсэн бүхэн цааш үргэлжлэх болно (Жакелин Питанги)

Хүн бүр нэгэн зэрэг манлайлагч, бас оролцогч

Манлайлагчид төрж гарах орон зай, боломжийг нээдэг. Уян хатан зохион байгуулалттай. Эрх мэдэл оролцогч бүрт тэгш, цэгцтэй хуваарилагдсан. Эрх мэдлийн шатлалгүй байна гэдэг нь эмх замбараагүй байна гэсэн үг биш. Харин тус бүрдээ хувь нэмрээ оруулж буй оролцогчдын дунд харилцан яриа өрнүүлэх, нийтлэг ашиг сонирхлын төлөө нэгэн бүлэг үүсэх явцыг дэмжсэн харилцаа үүсгэнэ гэсэн үг. Оролцооны чанарыг чухалчилж, аль болох олон хүний үзэл санаа, ур чадварыг гол капиталаа болгодог. Тухайн манлайлагчийн ур чадвараас гадна бусад хүмүүсийн ур чадварыг үнэлдэг. Хариуцлагыг хүн бүр хуваалцдаг.

Харилцан сонсох, харилцан хүндэтгэх, бие биенээсээ суралцах, сайн дурын үндсэн дээр зөвшөөрөх зарчимд суурилсан.

¹⁶ Jackson and Parry (2008)

Хамтын манлайллын орчинд эрх мэдэл гэнэт алга болохгүй, харилцаанд оршсоор, нийтлэг зорилгод хүрэх явцад чухал үүрэг гүйцэтгэсээр байдаг. Гэхдээ эрх мэдэл нь албан тушаал, эсвэл албадлагад бус харин сайн дураар хүлээн зөвшөөрөх явдалд тулгуурладаг. Оролцогчид бие биеэ харилцан хүндэтгэж, тэгш эрхтэй харилцах чадвар чухал, санал зөрж байсан ч бие биенийхээ үзэл бодлыг хүндэлж харилцана. Хамтын манлайлал нь харилцан

Хамтын манлайллыг бэхжүүлнэ гэдэг өөрөө үйл явц гэдгийг мартаж болохгүй.

ярилцах, харилцан буулт хийх, харилцан ойлголцож, зөвшилцөх зарчимд тулгуурлах тул нийтлэг төсөөлөл, зорилгыг хуваалцах бүлэг, хамтлаг бүрдэж байж манлайллын зорилго биелнэ.

Үйл явцыг түлхүү анхаардаг.

Манлайлал нь нөлөөллийн үйл явц, аль нэг тийш чиглэсэн үйл явц юм. Чиглэл байхгүй бол манлайлал байхгүй. Чухам хаашаа явах вэ гэдгээ тодорхойлохын тулд зорилго, хүсч буй ирээдүйн тухай төсөөлөл хэрэгтэй. Зорилго нь ч, зорилгод хүрэх арга зам нь ч ёс зүйтэй, хэзээд уян хатан байж, өөрчлөгдөн хувьсах боломжтой. Ямар нэгэн зүйл буруудвал “ХЭН буруутай вэ?” гэж асуудаггүй, харин “Бидний тогтолцоонд ямар доголдол байна вэ, түүнийг яаж засах вэ?” гэж асуудаг.

Манлайлал хэр үр дүнтэй байгааг шагнал, манлайлагчийн хувийн амжилтаар бус нийтийн сайн сайхан болон хамт олны эрх ашигт хэр сайн үйлчилж байгаагаар үнэлнэ.

Хамтын манлайлал нь нэг хүн бусдад нөлөөлөхөөс илүү өргөн зорилготой. Хамтын манлайллыг хэрэгжүүлэхийн тулд “Бид хэн бэ? Бид юуны төлөө, юуг, яаж хийх вэ? Энэ ажил хэнд, яагаад чухал байх вэ? Бид яагаад энэ үйл явцад оролцох ёстой вэ? Үр дүнг бид юу гэж ойлгож, хэрхэн хэмжих вэ?” зэрэг асуултыг байнга өөртөө тавих хэрэгтэй болдог.

Ололт амжилтыг үр дүн, бүтээгдэхүүнээс илүүтэй оролцооны чанар, харилцан суралцаж хөгжих, чадавхжих зэрэг хамтын үйл явцаар үнэлдэг.

3.3.2. Хамтын манлайллын хэмжүүр

Манлайллын талаарх сургалт, хөтөлбөрт манлайлагч байхын тулд хувь хүн ямар шинж чанар, ур чадварыг эзэмшсэн байх ёстой вэ гэдэг асуудал хөндөгдсөөр ирсэн. Хувь хүнд төрөхөөс заяасан зарим шинж

чанар манлайлагч болоход тодорхой хэмжээгээр нөлөөлж болох ч манлайллын ур чадварыг хөгжүүлж бий болгодог.

Манлайллыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд туслах зарим нэг ур чадварыг сургалтаар сайжруулж болох ч сургалтаар манлайлагчийг бүрэн бэлтгэх боломжгүй. Түүнчлэн хүмүүстэй харилцах, илтгэл тавих, яриа хэлэлцүүлэг чиглүүлэх зэрэг ур чадвар манлайлалд тус болох ч нөгөө талаас эдгээр нь зорилгод хүрэхэд ашиглах хэрэгсэл юм. Ийм ур чадвар сайн эзэмшээгүй олон хүн улс орондоо нэртэй сайн манлайлагч болсон байдаг.

Хамтын манлайлал нь үйл явц учраас хүмүүс манлайлах явцдаа, өөрийн туршлагаар хувийн онцлог чанар болон чадавхиа хөгжүүлж байдаг. Тэгвэл хамтын манлайллыг хэрэгжүүлэхэд манлайлагч өөртөө хувийн ямар шинж чанарыг хөгжүүлэх ёстой вэ?

Хамтын манлайллын хүрээнд хувь хүний зүгээс хөгжүүлэх манлайллын ур чадвар нь босоо тогтолцооны үед бүрдүүлэх ур чадвараас **ялгаатай** бөгөөд тэдгээрээс заримыг дор жишээ болгон дурдав. Үүнд:

- **Бусдад хандах хандлага:** Бусдыг сайн зүйл хийхийг хүсч, сурч боловсрохыг эрмэлздэг, нэр алдрын төлөө бус сайн сайхан нийгэм бүтээлцэхийн төлөө зүтгэж буй хүмүүс гэж харж сурах;
- **Үнэт зүйлсдээ үнэнч байх:** Үнэт зүйлсдээ үнэнч байх буюу нийгмийн сайн сайхны төлөө тууштай байх, үйлдлээ эрхэм зорилготойгоо байнга холбож сурах;
- **Бусдын хэрэгцээнд мэдрэмжтэй хандах:** Бусдад үйлчилж, тэдний хэрэгцээнд мэдрэмжтэй хандаж сурах хэрэгтэй. Өөрийгөө бусдын оронд тавьж төсөөлөх, хатуу дүгнэлт хийхээс зайлсхийх, саналаа тулгахгүй байж сурах, хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, эерэг талыг нь олж харах чадвараа хөгжүүлэх;
- **Багаар ажиллах:** Багаар ажиллахын тулд бусдыг хүндлэх, зөрчлийг эерэг аргаар шийдвэрлэх, шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд бусдыг оролцуулдаг байх зэрэг чадвар шаардагдана.

Хамтын манлайллыг бид зөвхөн улс төр, олон нийтийн талбар дээр төдийгүй гэр бүл, ажил, хамт олон зэрэг өөрсдийн амьдралын бүхий л хүрээнд хэрэгжүүлэх боломжтой. Энэ загварыг хэрэгжүүлнэ гэдэг нь энэ танилцуулгад дурдсан бүх шинжийг агуулсан байдлаар гэнэт ажиллаад эхэлнэ гэсэн үг биш.

Манлайллын энэ загвар нь тэмүүлэх зорилго, хүрэх цэгийг тодорхой,

харагдахуйц болгож өгч, үйл ажиллагаагаа явуулахад өдөр тутмын баримжаатай, бас үнэлэх шалгууруудтай болгоход тусална. Тиймээс энэ загвар та бүхэнд өөрийн гэсэн өвөрмөц манлайллаа хөгжүүлэхэд чиг, баримжаа л өгч байна гэсэн үг.

Аливаа зүйлийг өөрчлөхөд бидний мэдлэг, хандлага, хүсэл зориг болон хүчин чармайлтаас гадна цаг хугацаа шаардагддаг. Манлайллын тогтсон ойлголт, хандлага, арга барил, үйл явцыг нэг өдөр шийдээд өөрчлөх боломжгүй. Учир нь энэ өөрчлөлтийн үйл явц зөвхөн хэлбэрийн тухай асуудал биш, харин бидний дотор болон нийгэмд гүн нэвчсэн захиран тушаах, хүмүүсийг ялган зиндаачлах сэтгэлгээг үндсээр нь өөрчлөх, амьдралын бүхий л хүрээнд эрх мэдлийг тэгш бус хуваарилах, ёс зүйгүй хэрэглэх практикийг халахыг шаардаж байгаа юм. Энэ өөрчлөлтийг бид өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд явах боломжтой.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Эрх мэдлийг төвлөрүүлсэн, босоо тэнхлэгт манлайллын загварт баригдалгүйгээр манлайлал, хамтын ажиллагааны шинэ загварыг хөгжүүлэх, хамтын эрх мэдлийг бэхжүүлэх шаардлага тулгарч байна.

Манлайлагч төвтэй буюу манлайлагчийг “дээдэлсэн” гэж хэлж болох босоо тэнхлэгт манлайлал нь “эрчүүдийн хэв маяг” зонхилсон улс төрийн загварын суурь нь болдог ба эмэгтэйчүүдэд ээлгүй байдаг.

Иймд манлайллын уламжлалт загварын сул тал, эрсдлүүдэд дүн шинжилгээ хийж, манлайллын талаар тогтсон ойлголт, хандлагыг шинэ өнцгөөс харах, дахин тодорхойлох боломжийг олгохыг зорилоо.

Улс төрийн бодит оролцоо, нөлөөллөө бүрэн хэрэгжүүлэхэд нь чөдөр тушаа болж буй саад бэрхшээл, түүний шалтгааныг арилган, улс төрийн орчноо эмэгтэйчүүдэд ээлтэйгээр хувирган өөрчлөхөд нь тохирсон манлайллын шинэлэг загвар, хэв маягийг сонгон танилцууллаа.

Хамтын ажиллагааг өрсөлдөөнөөс дээгүүр тавьж, эрх мэдэл, нөлөөллөө хуваалцаж, түншлэл, харилцаагаа бэхжүүлэх зэрэгт анхаарлаа хандуулснаар эмэгтэйчүүд өөрсдийн өвөрмөц манлайллыг бий болгож чадна гэж үзэж байна.

Манлайллын ур чадварыг хэн бүхнээс дээгүүр гэж тооцогдох цөөн хэдэн хүнд л байдаг зүйл мэтээр жинхэнэ мөн чанарыг нь бүрхэгдүүлсээр ирсэн. Гэвч манлайлал нь зөвхөн нэг хүнийг бусдаас дээгүүр тавихын тулд байдаггүй, манлайллын ур чадвар нь өөр өөр хэлбэрээр олон хүнд байдаг гэж үзвэл манлайллыг бид өөр нүдээр харах боломжтой болно.

Шарлотт Бүнч

Дөрөвдүгээр бүлэг. ХАМТЫН МАНЛАЙЛЛЫН УР ЧАДВАРУУД

- 4.1. Тулгамдсан асуудлыг шинжлэх, шийдлийн боломжит хувилбар гаргах
- 4.2. Оролцогч талуудыг тодорхойлох, шинжлэх
- 4.3. Шийдвэр гаргагчдад нөлөөлөх
- 4.4. Бусдыг сэдэлжүүлэх, үйл хэрэгтээ татан оруулах
- 4.5. Нөлөөллийн хүрээгээ бэхжүүлэх
- 4.6. Бүлгийн дүгнэлт

4.1. ТУЛГАМДСАН АСУУДЛЫГ ШИНЖЛЭХ, ШИЙДЛИЙН БОЛОМЖИТ ХУВИЛБАР ГАРГАХ

- Та тодорхой асуудал санаачлан Хурлаар хэлэлцүүлж байсан уу?
- Та тодорхой асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллага, албан тушаалтанд асуулга тавьж байсан уу?
- Та бусад төлөөлөгч эмэгтэйчүүдтэйгээ хамтран тодорхой асуудал санаачлан Хурлаар хэлэлцүүлж байсан уу?

Та иргэдийг төлөөлж сонгогдсоны хувьд Хуралдаанд оролцож, санал өгөх төдийгөөр үүргээ хязгаарлалгүй нутгийн иргэдийн өмнө тулгамдсан тодорхой асуудлыг олж харж, барьж авах нь манлайллаа хэрэгжүүлэх эхний алхам юм.

Тулгамдсан асуудлыг хөндөхгүйгээр, түүнийг бодлогын түвшинд үндэслэлтэй гаргаж тавихгүйгээр, шийдэхийн төлөө тууштай явахгүйгээр олонд танигдаж, хүлээн зөвшөөрөгдөж чадахгүй. Нөгөө талаар, дуу хоолойгоо гаргаж, эрх ашгаа хамгаалж чадахгүй байгаа бүлгийг оролцуулахгүйгээр, тэдний өмнө тулгамдсан асуудлыг төр, засаг, орон нутгийн засаг захиргаа, холбогдох газарт нь хүргэхгүйгээр иргэдээ жинхэнэ утгаар нь төлөөлөх боломжгүй.

Хурлын Тэргүүлэгчид, хороо болон Төлөөлөгчид нь асуудал санаачлан Хуралд хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй. Мөн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд, сум, баг, хорооны Хурал зохих дээд шатны хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.¹⁷

Түүнчлэн хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг иргэдэд таниулах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан холбогдох албан тушаалтанд асуулга, асуулт тавьж, хариуг авах эрхтэй байдаг.

Шигтгээ 5. ИТХ болон Төлөөлөгч, Тэргүүлэгчдийн бүрэн эрх

12 дугаар зүйл. Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх

12.1.3. Хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах;

12.1.7. хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг

¹⁷ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйл

дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад асуулга тавьж хариуг нь авах;

18 дугаар зүйл. Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх

18.1. Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ:

18.1.1. Хурлын зохион байгуулалт, хяналт шалгалтын талаар:
е/тухайн Хурлын төлөөлөгчөөс Засаг даргад тавьсан асуулгын хариуг хэлэлцэж, шаардлагатай бол зохих шийдвэр гаргах;

20 дугаар зүйл. Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрх

20.1.13. нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн болон иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбогдсон асуудлаар Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга, төсвийн байгууллагын удирдлагад асуулга тавих, түүний хариуг хэлэлцэж санал, дүгнэлт өгөх;

Энэ нь нутгийн өөрөө удирдах байгууллага болох ИТХ, түүний төлөөлөгчийн хувьд иргэдтэйгээ ойр ажиллаж, сонгогчдынхоо санаа бодлыг сонссоны үндсэн дээр тодорхой асуудлыг шийдвэрлэх санаачилга гаргаж, Хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах эрх, өргөн боломж олгож буй чухал зохицуулалт юм. Ийм өргөн эрх мэдэл, бас боломж байгаа ч түүнийг хэр зэрэг бүрэн дүүрэн ашиглах нь тухайн Төлөөлөгчийн идэвх, санаачилгаас шалтгаалдаг билээ.

Хурлын Төлөөлөгч нь иргэдтэйгээ уулзаж, семинар, сургалт, хяналт шалгалтын ажилд оролцдог. Хуралдаанаар ИТХ-ын ажлын албанаас бэлтгэсэн, түүнчлэн Засаг даргын өргөн мэдүүлсэн асуудлыг л голдуу хэлэлцдэг. Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар санал хэлэх, асуулт асуух, хэлэлцэх, батлах эсэхийг шийдвэрлэхийн тулд таслах эрхтэйгээр оролцох нь хангалтгүй. Орон нутгийн хөгжилд түлхэц болж, иргэдийн амьдралд нөлөөлөхүйц бодлогын шинж чанартай асуудлыг шийдэх санаачилга гаргаж, бодит шийдэл болгохын төлөө тууштай зүтгэх нь сонгуульт үүргээ биелүүлэхэд хамгийн чухал нь гэдгийг мартаж болохгүй.

Тулгараад буй асуудлыг шийдвэрлэх арга замыг дэвшүүлэхээсээ өмнө тухайн асуудал гарах болсон учир шалтгаан, түүнээс үүдсэн сөрөг

үр дагаврыг сайтар судалж, эрх ашиг нь зөрчигдөн хөндөгдөж байгаа иргэдийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

Асуудлыг шинжлэх нь дараах 4 алхамтай.



Зураг 4. Асуудлыг шинжлэх алхмууд

Одоо асуудлыг шинжлэх алхмуудыг нэг бүрчлэн танилцуулъя:

■ Алхам 1. Тулгамдсан асуудлуудыг тодорхойлох

Тулгамдсан асуудал гэж юу вэ?

- Тухайн орон нутгийн иргэдийн эрх ашиг, сонирхлыг хөндсөн;
- Бодлогын шийдэл шаардсан;
- Иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн хувьд таны санааг зовоосон;
- Энэ сонгууль хугацаанд уг асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах юмсан гэж хүсч байгаа;
- Нэн тэргүүнд шийдвэрлэвэл зохих асуудал.

Зураг 5. Тулгамдсан асуудал гэж юуг хэлэх вэ?

“Та нутгийн иргэдийн болон орон нутгийн хөгжлийн өмнө тулгамдсан ямар асуудлыг шийдвэрлэхийг хүсч байна вэ? ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчийн хувьд Та түүнийг хэрхэн шийдвэрлэх вэ? Бодлогын шийдэл шаардсан асуудлыг аль өнцгөөс, ямар үндэслэлтэйгээр гаргаж тавих вэ? Үүнийг шийдвэрлэхэд хэн, хэнийг татан оролцуулах вэ” хэмээн олон талаас нь эргэцүүлж, иргэд,


сонгогчдынхоо санаа бодлыг сонсож, бэрхшээлтэй асуудлыг нь шийдвэрлэхийн төлөө ажиллах шаардлагатай.

Тулгамдсан асуудлыг сонгохдоо давхар бодолцох хүчин зүйлс:

- Иргэдийн, эсвэл хүн амын тодорхой бүлгийн (эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гэртээ хүүхдээ асарч байгаа ээжүүд зэрэг) **нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн**,
- Эмэгтэй төлөөлөгчийн хувьд дуу хоолойгоо гаргах, шийдвэрлэхийн төлөө зүтгэх байх гэсэн **олон нийтийн хүлээлт үүсгэсэн**,
- Тухайн асуудлыг эмэгтэй төлөөлөгчийн хувьд гаргаж тавих, анхаарлын төвд авчрах, Хурлаар асуудал дэвшүүлж, санал гаргаж шийдвэрлүүлэх **зайлшгүй шаардлага** тулгарсан.

Иргэд өөрт болон нутаг орондоо тулгамдаж буй асуудлаар ИТХ-ын төлөөлөгчдөө хандах нь нэмэгдэж байна. Ялангуяа эмэгтэй хүн өөрийнх нь асуудал, бэрхшээлийг арай сайн ойлгох болов уу гэсэндээ ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчтэй ирж уулзах, хандах нь элбэг. Иймээс тулгамдсан асуудлаа сонгон авахдаа иргэдээс ямар асуудлаар, хүн амын ямар бүлгээс өргөдөл, гомдол их ирж байгааг мөн харгалзан үзэх шаардлагатай.

Тулгамдсан асуудлыг тодорхойлохдоо иргэдийн оролцоог хангах нь нэн чухал. Оролцогчдод санаа бодлоо чөлөөтэй хэлэх боломж олгох, мөн олон хүний саналыг нэг дор цуглуулахын тулд дараах аргыг ашиглаж болно¹⁸.



Зураг 6. Тулгамдсан асуудлын жагсаалт гаргах загвар

Тулгамдсан асуудал нь орон нутгийн онцлогоос шалтгаалан янз бүр байж болно. Тухайлбал, цөлжилт, элсний нүүдэл, усны хомсдол, малчин тариаланчдын асуудал гэх мэт.

¹⁸ Иргэний танхимын хөтөч, Ж.Чанцалдулам, 2013 он

Шигтгээ 6. Тулгамдсан асуудлын жагсаалт¹⁹

ИТХ-ын төлөөлөгчийн хувьд Таны санааг зовоож буй ямар асуудлууд байна вэ?

- цэцэрлэг хүртээмжгүй
- уул уурхайн ашиглалтаас үүдэлтэй экологийн тэнцвэр алдагдалт
- гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалт муу
- сумын дэд бүтэц хөгжөөгүй
- цэвэрлэх байгууламжгүй
- гэр хороолол цэвэр, бохирын шугамд холбогдоогүй
- нөөцийн өвсний байргүй
- гүний худаг хүртээмжгүй
- усжуулалтын системгүй
- хог тээвэрлэлтийн менежмент сул
- засмал замын босоо тэнхлэгтэй холбогдоогүй
- гэр бүлийн хүчирхийлэл
- хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажлын байргүй
- СӨХ, оршин суугчдын холбоо муу
- байрны дээврийн засвар
- хогийг дахин боловсруулах цэг байхгүй
- эргэлтийн эмийн сангийн ханган нийлүүлэлт, татан авалт муу
- гэр хорооллын хашаа, гудамжны эмх цэгцгүй байдал
- сургуулийн байрны хүртээмж, стандарт хангалт муу
- цэвэр усны хомсдол
- үлийн цагаан оготны нүүдэл
- малын гоц халдварт өвчний тархалт
- багийн эмчгүй
- нийгмийн халамж үйлчилгээ зорилтот бүлэгтээ хүрдэггүй
- сум хөгжүүлэх сангийн зээл эргэлтгүй болсон
- бэлчээрийн даац хэтрэлт
- цөлжилт
- эмнэлгийн лабораторийн урвалж бодис дутмаг
- оношилгооны тоног төхөөрөмж хангалтгүй
- боловсон хүчин дутмаг
- малчид, тариаланчдын зөрчил
- хүүхэд хамгаалал сул
- эхчүүдийн амрах байр тохижилт муу
- эрчим хүч, цахилгаан хүртээмж тогтвортой бус
- сумын ИТХ төлөөлөгчид үйл ажиллагааны зардал олгогддоггүй
- эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар дутмаг
- тэтгэврийн зээлийн хүү өндөр
- ундны усны чанар муу
- хог хаягдал, орчны бохирдол
- ажилгүйдэл/ядуурал
- шударга үнэлэгдэх, тогтвортой ажлын байр хомс
- архидалт
- малын хулгай
- хүнсний аюулгүй байдал алдагдсан
- аймгийн төвтэй холбосон засмал замгүй
- хүүхдийн шүдний өвчлөл
- агаарын бохирдол
- СӨБ-ын сургалтын стандарт сул
- гэр бүл салалт
- РС тоглоомын донтолт
- дэд бүтэц хөгжөөгүй
- халуун усны газаргүй
- бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт
- банкны зээлийн хүү өндөр
- намчирхал
- газрын маргаан
- бодлого, төлөвлөлтөд иргэдийн оролцоо бага
- малчдын 6 настай хүүхдийн асуудал
- өнгөт чулууг хууль бусаар олборлолт

■ Алхам 2. Эрэмбэлэх

- Тулгамдсан асуудлуудын жагсаалтыг гаргасныхаа дараа давхацсан болон ижил утгатай санаануудыг ангилж, бүлэглэнэ.
- Шийдвэрлэх асуудал мэдээж олон. Тэдгээр асуудлын цар хүрээ, санхүүгийн нөөц зэргээс шалтгаалан сонгуулийн мөчлөг буюу 4 жилийн хугацаанд нэгэн зэрэг шийдвэрлэх боломжгүй учраас сонголт хийнэ. Хамгийн чухал, зайлшгүй шийдвэрлэвэл зохих, нэн тулгамдсан асуудлыг сонгож авахын тулд эрэмбэлнэ.

- Эрэмбэлэхийн тулд санал хураалт явуулна. Хүн бүр хамгийн чухал, эн тэргүүнд шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж буй асуудлынхаа ард нэмэх тэмдэг (+) юмуу босоо зураас (/) тавьж тэмдэглэнэ. Тэмдэглэгээнүүдийг тоолж, хамгийн их санал авсан асуудлаас хамгийн бага санал авсан хүртэл эрэмбэлээд, хамгийн олон хүний дэмжлэг авсан 3-4 асуудлыг сонгон авна.

Асуудлыг эрэмбэлэхэд харгалзах шалгуур

- Нутгийн иргэдийн буюу тодорхой бүлгийн эрх, ашиг сонирхлыг хэр их хөндөж байна вэ?
- Бодлогын тодорхой шийдэл буюу шийдвэр гаргахыг шаардаж байна уу?
- Цаг хугацааны хувьд шийдвэрлэх боломж нь ямар байна вэ?
- ИТХ-ын эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэгдэх асуудал мөн үү?

Зураг 7. Асуудлыг эрэмбэлэхэд харгалзах шалгуур

Анхаарах зүйл: Тухайн асуудал нь ямар нэг бүлэгт хамаарагддаг хүмүүсийн дийлэнх буюу олон хүний эрх ашгийг хөндөж байгаа бол тэр бүлгийн хүмүүсийн тоо нь тухайн орон нутагт амьдарч байгаа хүмүүстэй харьцуулахад цөөн байсан ч нийтийн эрх ашгийг хөндсөн гэж үзнэ. Жишээ нь: малчдад тулгамдаж байгаа асуудал нь тухайн аймгийн нийт иргэдийн хувьд олонхийн эрх ашгийг хөндсөн асуудал биш байж болно. Гэхдээ орон нутгийн нийт малчдын эрх ашгийг хөндөж байгаа бол нийтийн эрх ашиг гэж үзнэ.

Шигтгээ 8. Асуудлыг эрэмбэлсэн жишээ²⁰

Дархан уул аймаг	Увс аймаг	Ховд аймаг
1. Сургуулийн өмнөх насны хүүхдийн 60% нь цэцэрлэгт хамрагдахгүй байна.	1. Жижиг, дунд үйлдвэрлэлийн төсөл хэрэгжихгүй байна.	1. Хүрээлэн буй орчны бохирдол
2. СӨХ ба иргэд оршин суугчдын уялдаа муу	2. Нийгмийн халамжийн үйлчилгээ зорилтот бүлэгт тэгш хүрч чадахгүй байна\	2. Хүнсний аюулгүй байдал
3. Хог хаягдал	3. Ажилгүйдэл	3. Халуун усны газар байхгүй

■ Алхам 3. Сонгосон асуудлаа шинжлэх

Сонгон авсан асуудлынхаа шалтгаан, үр дагаврыг “Асуудлын мод” аргыг ашиглан тодорхойлно.

¹⁹ “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалтын үеэр 3 аймгийн эмэгтэй төлөөлөгчдийн гаргасан эрэмбэлсэн жагсаалтыг жишээ болгон оруулав. 2018

Тулгамдсан асуудлыг шинжлэх “Асуудлын мод” арга



- Модны **их бие** нь тухайн тулгамдсан асуудлыг илэрхийлнэ.
- Модны **мөчир** нь тухайн тулгамдсан асуудлаас шалтгаалж үүссэн сөрөг үр дагаврыг илэрхийлнэ.
- Модны **үндэс** нь тухайн тулгамдсан асуудлыг үүсгэгч суурь шалтгааныг илэрхийлнэ.
- **Нар**, ус, хөрс нь нөлөөлөгч хүчин зүйлсийг илэрхийлнэ.

Зураг 7. “Асуудлын мод” аргыг ашиглан тулгамдсан асуудлыг шинжлэх

Энэ арга нь нөхцөл байдлыг шинжлэхэд түгээмэл хэрэглэгддэг. Энэ нь асуудлын шалтгаан, үр дагавар, нөлөөлөгч хүчин зүйлсийг бүхэлд нь, томоор харах боломж олгодог. Асуудлыг үүсгэгч шалтгаан болон үр дагаврын харилцан хамаарлыг гаргаж ирснээр асуудлыг зөв тодорхойлох боломжийг бүрдүүлдэг.

Уг аргыг ашиглан дараах дараалал, зааварчилгааны дагуу асуудлыг шинжилнэ үү:

1. Асуудлаа томъёолох: Асуудлын зөв томъёолол нь тухайн асуудал ямар учраас чухал болохыг шууд харуулах, үндэслэлээ зөв гаргах, улмаар олон нийт, шийдвэр гаргагчдын дэмжлэгийг хүлээх эхлэл болно. Жишээлбэл, ажилгүйдэл ихсэж байна гэснээс “баталгаатай, амьдралд хүрэлцэхүйц цалинтай ажлын байр хомс байна” гэж асуудлыг томъёолох нь хүчтэй, тодорхой байр суурийг илэрхийлнэ.


2. Суурь шалтгааныг тодорхойлох: Асуудлын суурь шалтгааныг тодорхойлоогүй цагт шийдэл оновчтой гарахгүй. Оновчтой шийдэл гаргаж чадаагүй бол уг асуудал арилахгүй. Суурь шалтгаанаа буруу тодорхойлсон тохиолдолд дүн шинжилгээ өөр тийшээ эргэж, мөн л уг асуудал хэвээр үлдэх буюу үр дагавар нь даамжрахад хүрнэ.

Суурь шалтгаан нь тухайн асуудлыг үүсгэгч үндэс нь юм. Жишээлбэл, архидалтын шалтгаан нь ажилгүйдэл, ядуурал аль аль нь биш, харин тухайн хүний хандлага, зан үйл гэж үздэг. Хэрэв архидалтын шалтгаан нь ажилгүйдэл гэж үзэх юм бол ажилгүй хүн бүр архи уудаг байх ёстой. Гэтэл бодит амьдрал дээр ажилтай хэрнээ

Бид хогийн ургамлыг устгая гэвэл дээрээс нь хэсэг хэсгээр зулгаагаад нэмэргүй, дахиад ургана, харин үндсээр нь сугалсан цагт л дахин ургахгүйтэй адил тухайн асуудлын үндэс болсон суурь шалтгаан руу анхаарлаа хандуулах шаардлагатай. *Модоор зүйрлэвэл тухайн асуудал нь модны их бие, харин суурь шалтгаан нь модны үндэс юм.*

4. **Тухайн асуудлын сөрөг үр дагаврыг зураглах:** Шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлын шалтгааныг тухайн асуудлын илрэх шинжээс нь ялгаж харах шаардлагатай. Ил харагдаж байгаа энэ шинж нь тухайн асуудлаас бий болж байгаа үр дагавар юм. Жишээлбэл, асуудал нь шилжилт хөдөлгөөн бөгөөд түүний сөрөг үр дагаврын нэг нь хөдөөгийн эзгүйрэл юм. Үр дагавар бүр өөр хоорондоо холбоотой, харилцан нөхцөлдөж байдаг. Үр дагаврыг модны жишээн дээр зүйрлэвэл мөчир нь юм.

Асуудлын дүн шинжилгээний загвар болгож, ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн сургалтын үеэр гарсан зарим жишээг харна уу.²⁰



Зураг 8. "Асуудлын мод" зураглалын жишээ

²⁰ “Нутгийн удирдлагад эмэгтэйчүүдийн манлайлал” сургалтын үеэр эмэгтэй төлөөлөгчдийн гаргасан асуудлын шинжилгээг жишээ болгон оруулав. 2018

АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Жишээ 1. Тулгамдсан асуудал:

“Өнгөт чулууны хууль бус олборлолт”

Асуудлын суурь шалтгаан:


- Хуулийн зохицуулалт оновчгүй.
- Чулуу олборлож байгаа иргэдэд хяналт тавихад төсөв хөрөнгө дутагдалтай.

Үр дагавар:


- Иргэдийн амгалан тайван байдал алдагдсан.
- Бэлчээр талхлагдсан.
- Нөхөн сэргээлт хийдэггүй.

Нөлөөлөгч хүчин зүйлс:

- Хялбар аргаар мөнгө олох бэлэнчлэх сэтгэлгээ
- Өнгөт чулууг өндөр үнээр худалдаж авах болсон.



Зураг 9. Өнгөт чулууг хууль бусаар олборлох



Жишээ 2. Тулгамдсан асуудал:

“Гэр бүлд хүүхэд хамгаалагдаж чадахгүй байна”

Асуудлын суурь шалтгаан:

- Хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүд ажлаа сайн хийхгүй байна.
- Хүмүүсийн харилцаа хандлага, ёс зүй, зан үйл

Үр дагавар:

Зураг 10. Гэр бүлд хүүхэд хамгаалагдаж чадахгүй байна.

- Хүүхдийн хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Хүүхэд халдлагад өртөнө, гэмтэнэ.
- Сэтгэл санааны дарамтад орно.

Нөлөөлөгч хүчин зүйлс:

- Хамтын ажиллагаа хангалтгүй.
- Эцэг эх, асран хамгаалагчдын ёс бус үйлдэл.
- Эцэг, эхийн хариуцлага, оролцоо сул.

Жишээ 3. Тулгамдсан асуудал:

“Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж муу”

Асуудлын суурь шалтгаан:

- о Төсөв, хөрөнгө хүрэлцээгүй
- о Мал эмнэлэг, үржлийн тасаг, хувийн эмнэлэг уялдаа холбоогүй

Үр дагавар:


- о Чанар муу мал ихэссэн.
- о Эдийн засгийн хохирол (малчид, орон нутагт)
- о Хүнсний аюулгүй байдал алдагдсан.

Нөлөөлөгч хүчин зүйлс:

- о Иргэдийн оролцоо, мэдээлэл дутмаг
- о Мэргэжлийн байгууллагын үйлчилгээний чанар, хяналт муу (ашгийн төлөө байдаг)



Зураг 11. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж муу



Зураг 12. Хог хаягдал, орчны бохирдол

Жишээ 4. Тулгамдсан асуудал:

“Хог хаягдал, орчны бохирдол”

Асуудлын суурь шалтгаан:

- о Хоёрдогч түүхий эд авах цэггүй
- о Хогийн менежмент, төлөвлөлт байхгүй

Үр дагавар:

- о Хүн, малын өвчлөл их.
- о Хөрс, ус, агаарын бохирдол нэмэгдсэн.
- о Бэлчээрийн доройтол

Нөлөөлөгч хүчин зүйлс:

- о Иргэд, малчдын унаа, техник их.
- о Иргэдэд олгох сургалт, мэдээлэл дутмаг.
- о Иргэдийн ухамсар, хандлага

- Асуудлын дүн шинжилгээг ганцаараа биш, тухайн асуудалд холбоотой талуудыг оролцуулан хамтдаа хэлэлцэж хийвэл илүү үр дүнтэйг анхаарна уу.
- Анхны оролдлогоор асуудлаа, нөхцөл байдлаа бүрэн дүүрэн гаргаж ирнэ гэж бүү бодоорой, ялангуяа өмнө нь ийм шинжилгээ хийж байгаагүй бол эхэндээ хэцүү санагдаж магадгүй.
- Бүү шантар. Дүн шинжилгээний чадавх бол булчин шиг ажиллуулаад л байвал улам хөгжиж хүчирхэг болоод байдаг зүйл тул та холбогдох талууд болон иргэдтэйгээ хэд хэдэн удаа уулзаж, дүн шинжилгээгээ хамтдаа хийхэд бэлэн байгаарай.

■ Алхам 4. Шийдлийн боломжит хувилбарыг гаргах

“Асуудлын мод” аргачлалаар асуудлын уг шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлс, үр дагаврыг шинжилсэн. Харин одоо шийдлийн боломжит хувилбаруудыг гаргана.

Өөрчлөлт бий болгох гарц, арга замыг зураглахдаа асуудлын модноос шийдлийн модыг ургуулж зураглана. Ингэхдээ хүссэн өөрчлөлтийг бий болгохуйц боломжит хувилбаруудыг тодорхойлоход анхаарна.

Асуудлын шийдлийг оновчтой томъёолох нь маш чухал. Асуудлыг шийдэл болгон хувиргасан жишээг доор үзүүлээ.



Зураг 13. "Шийдлийн мод" зураглал



Зураг 14. Шийдлийн мод болгон хувиргасан жишээ

Жишээ 1. Зорилго: “Байгалийн өнгөт чулууг хууль бусаар олборлохыг зогсоох”

Шийдэл:

- Холбогдох хуульд өөрчлөлт оруулахад нөлөөлөх (Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу орон нутагт сонсгол хийх)
- Өнгөт чулуутай газрыг бичил уурхайн зориулалтаар нөхөрлөлд өгөх
- Пост ажиллуулах



Зураг 15. Байгалийн өнгөт чулууг хууль бусаар олборлохыг зогсоох


Үр дүн:

- Нөхөн сэргээлт хийдэг болно.
- Засгийн газар, УИХ-аас газар дээр нь ирж, орон нутгийн нөхцөл байдалд тохирсон шийдвэр гаргана.
- Холбогдох хуульд өөрчлөлт орно.

Сайнаар нөлөөлөгч хүчин зүйлс:

- Тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүнтэй хамтарна.
- Аймгийн ИТХ-аас энэ асуудлаар тогтоол гаргасан. (дээд шатныхаа байгууллагад өмнө нь хандчихсан)

Жишээ 2. Зорилго: “Гэр бүлд хүүхэд хамгааллыг сайжруулах”



Зураг 16. Гэр бүлд хүүхэд хамгааллыг сайжруулах

Шийдэл:

- Засаг даргын тайланг сонсох
- Хөтөлбөр боловсруулж, ИТХ-аар батлуулах
- Хамтарсан багт орон нутгийн төсвөөс санхүүжилт батлуулах

Үр дүн:

- Сурч, амьдрах орчин аюулгүй болно.
- Хуулийн мэдлэг дээшилж үүргээ ухамсарлана.
- Хүмүүсийн хандлага, ёс зүй, зан үйл эерэг хандлагатай болно.

Сайнаар нөлөөлөгч хүчин зүйлс:

- о Эмэгтэй төлөөлөгчид нөлөөлсөн.
- о Хамтын ажиллагаа сайжирсан.

Жишээ 3. Зорилго: “Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах”

Шийдэл:

- о Оролцогч талуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлэх журам батлуулж мөрдүүлэх
- о Дараа жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд оруулах, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажилд тусгах

Үр дүн:

- о Мал эрүүлжиж, хүнсний аюулгүй байдал сайжирна.
- о Малын чанар сайжирч, малчдын орлого нэмэгдэнэ.



Зураг 17. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах

Сайнаар нөлөөлөгч хүчин зүйлс:

- о Мал эмнэлэг, үржлийн албаны уялдаа холбоо сайжирсан.
- о Мал эмнэлгийн үйлчилгээ чанартай, хяналттай болсон.


Жишээ 4. Зорилго: “Хог хаягдал, орчны бохирдлыг багасгах”

Шийдэл:

- о Хог хаягдал тээвэрлэх тусгай унаатай болох санхүүжилтийг ОНХС-ийн хөрөнгөөс гаргуулах
- о Хог хаягдлын менежментийн талаар журам батлуулах

Үр дүн:

- о Хүн малын өвчлөл багасна.
- о Ажлын байр нэмэгдэнэ.
- о Хөрс, ус, агаар, бэлчээрийн бохирдол багасна.



Зураг 18. Хог хаягдал, орчны бохирдлыг багасгах

Сайнаар нөлөөлөгч хүчин зүйлс:

- о Иргэдийн хог хаягдлын талаарх мэдлэг, мэдээлэл, хандлага сайжирсан.
- о Эмэгтэй төлөөлөгчид хамтарсан.

4.2.ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ, ШИНЖЛЭХ

Бид өмнө нь нутгийн иргэдийн өмнө тулгамдсан асуудлуудыг гарган ирж, эрэмбэлсний үндсэн дээр нэн чухалчилж үзсэн асуудлаа сонгон шинжилсэн. Тухайн асуудлын шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлс, үр дагаврыг тодорхойлж, шийдлийн боломжит хувилбаруудыг гаргасан. Нөхцөл байдлын дүн шинжилгээгээ ийнхүү хийсэн учраас одоо Та цааш алхаж, Төлөөлөгчийн хувьд тухайн асуудлыг шийдвэрлүүлэхийн төлөө ажиллах шатанд орж ирж байна.

Тулгамдсан асуудлыг эрх ашиг нь хөндөгдөж буй хүмүүс, бүлгийг оролцуулалгүй өмнөөс нь шийдвэрлэх нь сөрөг нөлөөтэй. Тэднийг оролцуулаагүй байж, өмнөөс нь хэлж ярьж буй тохиолдолд олон нийт итгэдэггүй, дургүйцдэгийн жишээг бид эргэн тойрноосоо зөндөө харж байна. Иргэдийн оролцоог хангаагүй хийсэн нөлөөллийн ажил бодлогын түвшинд амжилт олж болох ч хэрэгжих шатанд бэрхшээл, эсэргүүцэлтэй тулгардаг, эсвэл хэсэг хугацааны дараа няцаагдан богино наслах эрсдэлтэй.

Олон хүн, байгууллага, ялангуяа мэдээллийн асар их зөрүүтэй, өөр, өөр ашиг сонирхол, олон янзын туршлагатай талуудыг өөрийнхөө үйл хэрэгт татан оролцуулна гэдэг амаргүй. Гэвч өөр сонголт байхгүй, асуудлыг өөрөөр шийдэх боломжгүй тул зайлшгүй энэ олон талыг, бүгдийг нь биш гэхэд ихэнхийг, ялангуяа эрх нь зөрчигдөөд буй бүлгүүд, шийдвэр гаргагчдыг оролцуулахаас өөр замгүй.

Эдгээр бүлэг, байгууллага хоорондоо ихээхэн ялгаатай тул тэдэнтэй харьцахдаа тухайн бүлэг бүрт тохирсон арга барилаар ашиглах хэрэгтэй болно. Олон талын оролцоог хангаж ажиллахад өөр, өөр бүлэгт тохирсон мэдээлэл, харилцааны оновчтой стратеги зохиох чадавхаа дээшлүүлэх шаардлага тулгарна.


Эмэгтэй төлөөлөгчдийн ихэнх нь одоогийн улс төрийн орчинд нөлөө, эрх мэдэл багатай байгаа. Гэхдээ нутгийн иргэдийн өмнө нэн тулгамдсан асуудлыг бодитой шийдвэрлэхийн тулд сонгогчидтойгоо ойр байж, олон талт хамтын ажиллагааг бэхжүүлж явбал нөлөөллийн хүрээгээ тэлж чадна. Хүмүүсийн оролцоог нэмэгдүүлснээр хамтын эрх мэдэл бий болдог.

Асуудлыг шийдвэрлэхэд холбогдох талуудыг татан оролцуулахын ач холбогдол:

- Хүмүүсийг санаачилгынхаа нэгэн хэсэг болгосноор таны үйл хэрэг өөрийн гэсэн амьтай болж ирнэ. Энэ нь тогтвортой үргэлжлэх нөхцөл болно.
- Тэд өөрсдийн санаачилсан, хувь нэмрээ оруулсан санааг хэрэгжүүлэхдээ илүү өөриймсөг байдаг учир тууштай дэмжих хандлагатай байдаг.
- Хэн, ямар ашиг сонирхлоор дэмжиж, бас эсэргүүцэж байна, нөлөөлөх чадамж нь ямар болохыг тодорхойлсноор хаанаас эхэлж, хэн дээр хамгийн түрүүнд очих, хэрхэн хамтрах нь тодорхой болно.

Энэ бүхнийг харгалзан шийдвэрлэхийг хүсч буй асуудлынхаа хүрээнд оролцогч талууд болон эмзэг бүлэгт хамаарагдах төлөөллийг тодорхойлж шинжилнэ. Дараа нь оролцогч тал бүрийг (албан тушаалтан, байгууллага, нийгмийн бүлэг зэргийг) тухайн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд татан оролцуулах, тэдний дэмжлэгийг авах, хандлага, шийдвэрт нь эергээр нөлөөлөх, асуудлыг олон нийтийн анхаарлын төвд оруулахад чиглэгдсэн арга замаа боловсруулна.

Дараах 3 алхмаар оролцогч талуудын зураглалыг гаргана:



Зураг 19. Оролцогч талыг тодорхойлох алхмууд

■ Алхам 1. Оролцогч талуудаа тодорхойлох

Эхлээд хэнд нөлөөлөх шаардлагатайгаа мэдэх нь чухал. Оролцогч тал бүрт өөр өөр арга замаар нөлөөлөл хийх шаардлага гарна. Иймээс:

- Тухайн тулгамдсан асуудлын сөрөг үр дагаварт хэн өртөж байна?
- Хэний эрх, ашиг сонирхол хөндөгдөж байна?
- Энэ асуудлыг шийдвэрлүүлэх нийтлэг сонирхол өөр хэнд байна?
- Хэн хамтрагч байж чадах вэ?
- Хэнд шийдвэр гаргах гол эрх мэдэл байна вэ? гэж өөрөөсөө асуух хэрэгтэй.

Хариулт тус бүрт оролцогчдын жагсаалт гаргаж, тэдний чадавх, хамтран ажиллах сонирхлыг тогтооно. Оролцогч талуудыг тодорхойлох загварыг харна уу:

Хүснэгт 3. Оролцогч талуудыг тодорхойлох

Оролцогч талууд	Хамтран ажиллах сонирхол	Хувь хүн	Бүлэг	Байгууллага
Үндсэн оролцогч	Тухайн асуудалд өртсөн, эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн хүмүүс			
Дам оролцогч	Үндсэн оролцогчтой шууд хамааралтай хүмүүс			
	Ажил, амьдралд нь нөлөө үзүүлэх нийтлэг сонирхолтой хүмүүс			
Гол оролцогч талууд	Шийдвэр гаргах гол эрх мэдэлтэн			
	Нөлөө бүхий хүмүүс, байгууллага			
	Хийх ажлаас бий болох үр нөлөөг сонирхож буй хүмүүс			

Оролцогч талуудыг тодорхойлсон жишээг нарийвчлан тайлбарласныг доорх зургаас үзнэ үү:

Зураг 20. Оролцогч талуудыг тодорхойлсон жишээ

“Цэцэрлэг хүртээмжгүй” асуудлын жишээгээр

Үндсэн оролцогч: а) Цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхэд, б) Хүүхдээ цэцэрлэгт өгч чадахгүй байгаа эцэг, эх

Дам оролцогч:

1. **Үндсэн оролцогчтой шууд хамааралтай:** Цэцэрлэгт хамрагдаж чадаагүй ач, зээгээ харж байгаа эмээ, өвөө, ах, эгч, гэр бүлийн бусад гишүүд
2. **Ажил амьдралд нь нөлөө үзүүлэх нийтлэг сонирхолтой:** а) Хүүхэдтэй болоод удаагүй байгаа залуу эцэг эх, тэдний эцэг эх, гэр бүлийн гишүүд, б) Гэрлээд удаагүй байгаа залуу хос, тэдний эцэг эх, гэр бүлийн гишүүд, в) Цэцэрлэгийн багш, ажилтнууд

Гол оролцогч талууд:

1. *Шийдвэр гаргах гол эрх мэдэлтэн:* а) Цэцэрлэг өргөтгөх болон шинээр барихад гол шийдвэр гаргагчид (шийдлээс шалтгаалж янз бүр байна. ИТХ-аар тогтоол гаргуулах тохиолдолд ИТХ-ын төлөөлөгчид гэх мэт), б) Уг асуудлыг шийдвэрлэх үүрэг хүлээсэн албан тушаалтан, байгууллага
2. *Нөлөө бүхий талууд:* а) Шийдвэр гаргах эрх мэдэлгүй ч тухайн шийдвэрийг гаргахад нөлөө үзүүлэх боломж, чадамжтай талууд: а) Хэвлэл мэдээлэл (үндэсний болон орон нутгийн телевиз, өдөр тутмын сонин, FM радио, сайтууд г.м) б) Нийгмийн сүлжээ (Facebook, Twitter г.м) в) Шийдвэр гаргагчийн итгэлийг хүлээсэн, ойр ажилладаг хүмүүс, г) Намын бүлэг ...
3. *Хийх ажлаас бий болох үр нөлөөг онирхож буй талууд:* а) Цэцэрлэгт бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлдэг аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүс, тухайлбал, мах, сүү нийлүүлэгч г.м, б) Уг асуудлыг шийдвэрлүүлэхийн төлөө ажиллаж байгаа хүмүүс, бүлэг, байгууллага

■ **Алхам 2. Эрх ашиг нь хөндөгдсөн хүмүүсийн оролцоог тодруулах**

Тухайн асуудлыг ул суурьтай, үндэслэлтэй шийдвэрлэх хамгийн их хүсэл сонирхолтой бүлэг, хүмүүсийг тодорхойлж, тэд уг асуудлыг шийдвэрлэхэд оролцож байгаа эсэхийг тодруулна. Иргэд, сонгогчид, ялангуяа эрх ашиг нь зөрчигдөж буй бүлэг өөрт хамаатай шийдвэр гаргах үйл явцад ихэнхдээ оролцож чаддаггүй.

Тиймээс ИТХ-ын төлөөлөгч нь иргэд, сонгогчид, ялангуяа эрх ашиг нь хөндөгдөж буй хүмүүсийн хэрэгцээ, үзэл бодол, байр суурийг сонсож, мэдэрч, түүнийг шийдвэрт тусгуулах замаар төлөөллийг хангахад анхаарах шаардлагатай. Ингэж чадвал тухайн асуудлыг шийдвэрлэгдэж дуусах хүртэл тууштай дэмжих дэмжлэгийн хүчээ оллоо гэсэн үг.

Шигтгээ 9. Эрх ашиг нь хөндөгдсөн хүмүүсийг оролцуулсан туршлага

2012-2016 оны сонгуульт жилийн хугацаанд төлөөлөгчөөр ажилласан 6 эмэгтэй хамтран, цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хамгийн их хүүхэтэй гэр хорооллыг сонгож, цэцэрлэг барих аяныг санаачилсан. Нийт 390 сая төгрөгийн санхүүжилт хэрэгтэй болсон. Үүнээс 120 сая төгрөгийг иргэд, байгууллагын хандиваар цуглуулж чадсан.

Энэ аянд цэцэрлэг баригдсан 5-р багийн иргэд гудамж, хорооллоороо нэгдсэн. Тэд гудамж болгондоо идэвхтэн томилоод айл бүр доод тал нь мянга, дээд тал нь арван мянган төгрөг хандивлах санаачилга гарган, хандивын аяныг амжилттай өрнүүлсэн. 23 гудамжинд 18 идэвхтэн ажилласны 17 нь эмэгтэйчүүд байсан ба тэд айл, өрх бүрт хүрч ажилласан. Цэцэрлэгийн газраа аваад шав тавьж байхад сургуулийн хүүхдүүд халаасандаа байсан тавь, зуун төгрөгөө хүртэл хандивлаж байсан. Өндөр настнууд тэтгэврээсээ илүүчлэн хандив өргөсөн.

Үлдэгдэл 270 сая төгрөгийн санхүүжилтийг жил, жилийн орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт суулгуулсан. (2014 онд 100 сая, 2015 онд 80 сая, 2016 онд 90 сая төгрөгийг тус тус батлуулж, гурван жилийн хугацаанд цэцэрлэгийг барьж ашиглалтад оруулсан. Одоо 125 хүүхэд энэ цэцэрлэгт явж байна.

Энэ сонгуульт жилийн хугацаанд 50 ортой хүүхдийн эмнэлэг барих ажлыг эхлүүлэх зорилготой тооцоо, зураглал гаргасан байгаа.

**Ж.Дулмаа, Баянхонгор аймгийн ИТХ-ын төлөөлөгч
(2004 оноос одоог хүртэл төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж
байгаа)**

■ Алхам 3. Оролцогч талын сонирхол, нөлөөллийг шинжлэх

Нөлөөлөл нь ямар нэг өөрчлөлт бий болгохын төлөө, эсвэл ямар нэг зүйлийг хэвээр авч үлдэхийн төлөөх үйл явц юм.

Оролцогч талуудаа тодорхойлсны дараа тэдний ашиг сонирхолд нөлөөлөх дүн шинжилгээ хийнэ. Түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлан, нөөц, боломжоо ихэсгэж, нөлөөллийн хүрээгээ тэлэхэд энэ алхам тусална. Хэн, ямар үндэслэлээр дэмжиж байна, хэн сонирхож байна, хэн ямар шалтгаан, үндэслэлээр эсэргүүцэж байна вэ гэдгийг тодорхойлсноор оролцогч бүртэй хамтран ажиллах, нөлөөлөх арга замаа мэдэж авна. Мөн хаанаас эхэлж, хэн дээр хамгийн түрүүнд очих нь тодорхой болно.

Оролцогч талуудаас хэн нь бодлого, шийдвэрт хамгийн сайн, эсвэл хамгийн их сөрөг нөлөөлөл үзүүлэхийг мэдэх, өөр өөр сонирхол, нөлөөлөх байдал нь ялгаатай оролцогчидтой хэрхэн ажиллавал зохистойг тодорхойлохдоо “оролцогч талуудын зураглал” арга хэрэгслийг ашиглана.²¹

Оролцогчдын ашиг сонирхол, нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох алхмууд:

Нөлөөлөх чадамжаар нь
оролцогчдыг эрэмбэлэх



Оролцогч талуудыг зураглах
хавтгайд оноож байршуулах

Зураг 21. Оролцогчдын ашиг сонирхол, нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох алхмууд

²¹ Төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний гарын авлага, Sarthi Acharya, Г. Ганзориг, Н. Одмаа, 2016 он, 110-112 дахь тал

Тайлбар: Хаалтанд байгаа нэрс нь оролцогч талуудын сонирхол болон нөлөөллийг тодорхойлно.

■ **Дэмжигч:** тухайн асуудлыг шийдэх сонирхолтой, нөлөө ихтэй, эрх мэдэлтэй. Тэдэнтэй хамтран ажиллах нь чухал.

■ **Хамгаалагч:** тухайн асуудлыг шийдвэрлүүлэх, бодлого, шийдвэрийг гаргуулах амин сонирхолтой ч нөлөөлөх эрх мэдэл бага. Тэдэнд явцыг байнга танилцуулж, үйл ажиллагаандаа татан оролцуулж, дэмжлэгийн сууриа бүрдүүлэх хэрэгтэй.

■ **Нуугдмал этгээд:** Чиглэсэн сонирхол, эсвэл асуудлын шийдэлд оролцоо байхгүй хэрнээ сонирхол нь төрвөл бодлогод нөлөөлөх эрх мэдэл бүхий хүмүүс. Тэдэнд нөлөөлөх нь чухал.

■ **Нөлөө багатай хүмүүс:** тухайн асуудлыг шийдүүлэх, бодлого шийдвэр гаргуулах сонирхол ч, эрх мэдэл ч байхгүй, тухайн асуудлын талаар мэддэггүй. Тэдний хандлага, төлөв байдлыг ажиглаж байхад л болно.


Оролцогчдын сонирхол, нөлөөллийг харгалзан үзэж, тэдний дэмжлэгийг авахын тулд юу хийх хэрэгтэйгээ төлөвлөх нь асуудлыг шийдэх боломжийг нэмэгдүүлнэ.

4.3. ШИЙДВЭР ГАРГАГЧДАД НӨЛӨӨЛӨХ

Эрх мэдлийн тухай ойлголтыг эргэн харах нь

*Тоглоомыг дүрмийг мэдэж ав.
Шийдвэр хэрхэн гардгийг мэдэхгүй бол их юм алдана.*

Оролцогч талын эрх мэдлийг шинжлэхийн тулд нэн тэргүүнд эрх мэдлийн тухай ойлголтоо эргэж харах шаардлагатай. Ил (албан



Зураг 22. Оролцогчдыг шинжлэх зураглал

ёсны) эрх мэдлээс гадна нуугдмал болон үл үзэгдэх эрх мэдлийг таньж мэдэх нь нөлөөллийг үр дүнтэй явуулах урьдач нөхцөл юм.

Эрх мэдэл гэхээр хүмүүс улс төр, санхүүгийн эрх мэдэл, албан тушаал гэж голдуу хардаг, мөн ихэнхдээ сөрөг утгаар ойлгодог. Зарим хүмүүс угаасаа л эрх мэдэлтэй, зарим нь эрх мэдэлгүй байж ирсэн, тийм байх ч ёстой мэт боддог. Тухайлбал, иргэд, сонгогчдын зарим нь өөрсдийгөө эрх мэдэлгүй гэж үздэг, эрх мэдэл бол дарга, улс төрчдөд л байдаг; эрх мэдлийн төлөө зүтгэх нь зохимжгүй гэж үзэх хандлагатай байдаг. Ингэж ойлговол “улс төр бол тодорхой хэсэг, бүлэг хүмүүсийн л хийдэг зүйл” гэсэн нийгэмд тархаад байгаа ойлголтыг хүлээн зөвшөөрч, улс төрд оролцох зүй ёсны эрхээ эдлэхээс зайлсхийж, ашиг сонирхлоо илэрхийлж чадахгүй хэвээр үлдэнэ.

Эрх мэдлийн илэрхийлэл нь эерэг ч байж болно, сөрөг ч байж болно. Бид дотоод хүч чадлаа нээн, бусадтай хүчээ нэгтгэн, эргэн тойрноо өөрчлөх эрх мэдлээ мэдэрч байгаа бол энэ нь эерэг эрх мэдлийн илрэл. Харин бусдын эрх, эрх чөлөөг хязгаарлаж, үгүйсгэж, хянаж байгаа бол энэ нь сөрөг эрх мэдлийн илрэл. Эрх мэдлийн сөрөг илэрхийлэл нь маш түгээмэл байдаг тул бид түүнд дасал болж, энэ талаар эргэцүүлж боддог ч үгүй байна.

Мөн эрх мэдлийг хязгаарлагдмал зүйл, бусадтай хуваалцвал хасагдах мэт төсөөлөх нь элбэг. Амжилттай байна гэдэг нь “нэг номер” байхын тулд үргэлж өрсөлдөх гэсэн утгатай учраас эрх мэдэл нь ийм бүтэц тогтолцоонд бусадтай хуваалцах зүйл биш болж хувирдаг. Эрх мэдэл хязгааргүй учир хэн нэгэнтэй эрх мэдлээ хуваалцсанаар алга болохгүй, хорохгүй, харин ч тэлнэ.

Асуудлаа үр дүнтэй шийдвэрлэж, амжилтанд хүрэхийн тулд бусадтай хамтран “хамтын хүч, эрх мэдэл” бий болгох зайлшгүй шаардлагатай. Буруугаар ашиглаагүй тохиолдолд эрх мэдэл нь муу муухай, ичгүүртэй зүйл биш юм. Өөрчлөлт хийхийг хүссэн хэнд ч эрх мэдэл чухал. Ганц, ганцаараа хийж чадахгүй зүйлээ хоёр буюу түүнээс дээш хүмүүс нийлж хийх нь хамтын эрх мэдэл ба энэ нь эв нэгдэл, хамтын ажиллагаанд суурилдаг. Хамтын эрх мэдэл нь эерэг өөрчлөлт авчрахын тулд хувь хүмүүсийн авьяас, чадвар болон мэдлэгийг нэгтгэдэг. Ингэснээр ашиг сонирхлоор ялгаатай бүлгүүдэд нийтлэг байр суурь олгодог.

Монтгомери хотод автобусны эсэргүүцлийн хөдөлгөөн 1955, 1956 онд өрнөсөн нь хувь хүмүүсийн хөрөнгө нөөцийг хамтын эрх мэдэл болгосон жишээ юм. Арьс өнгөөр ялгаж тусдаа тээвэрлэх

нийтийн тээврийн автобусуудыг эсэргүүцэхийн тулд өнгөт арьстнууд автобусны компанид автобусны тасалбар төлөхөөс татгалзсан ба тэд ганц нэгээрээ биш, нийтээрээ нэгдэж эсэргүүцлээ илэрхийлсэн. Монтгомери хотын төсөвт орох санхүүжилтийн эх үүсвэрийг хааж чадсанаар арьс өнгөөр ялгаварлан тусдаа тээвэрлэхээ больж, тэд салангид байсан хүч, нөөцөө хамтын эрх мэдэл (хүч чадал) болгож чадсан. (*Маршалл Ганз, Манлайлагчийн хүүрнэл түүх*)

Манлайлал бол эцсийн эцэст эрх мэдлийн тухай ойлголт юм. **Эрх мэдэл нь өөрт болон эргэн тойрондоо нөлөөлж, өөрчлөлт бий болгох чадамж** юм. Энэ утгаар нь авч үзвэл, эрх мэдэл бол биднээс ангид, салангид орших зүйл огт биш, харин ч хүн бүрт байдаг зүйл. Эерэг өөрчлөлт авчрах эрх мэдэл хүн бүрт бий.

Иргэдийг төлөөлөн ажиллаж байгаа эмэгтэй төлөөлөгчдөд ч ялгаагүй эрх мэдэл чухал, учир нь эрх мэдлийг ашиглан нийтийн сайн сайхны төлөө өөрчлөлт хийнэ.

Эрх мэдлийн харагдах байдал (илрэх хэлбэр)

Эрх мэдэл нь ил, нуугдмал, үл үзэгдэх зэрэг хэлбэрээр оршин байдаг ба эдгээрийг ялгаж ойлгох нь чухал. Ингэснээр хөшигний ард юу өрнөдгийг мэдэж, амьдрал дээр хэн хэн гол шийдвэрийг гаргаж байгааг олж харснаар эрх мэдэл бүхий хүмүүс, гол шийдвэр гаргагчидтай харилцах арга, нөлөөллийн стратегиа сонгох боломж бүрдэнэ.

Ил эрх мэдлийн хувьд хуульчлагдсан байдаг учраас танихад амар. Нуугдмал эрх мэдлийг ялгахад амаргүй ч олж харж болно, харин үл үзэгдэгч эрх мэдлийн хувьд танихад төвөгтэй. Учир нь нийгмийн хэм хэмжээ, улс төрийн соёл, уламжлал, зан заншлаар дамжин бидний нэг хэсэг болтлоо нэвчин шингэсэн байдаг.

Тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөхийн тулд эрх мэдлийн төрлүүд, тэдгээрийн илрэх хэлбэрийг ялгаж таньдаг байх шаардлагатай.

Ил эрх мэдэл. Хууль, дүрэм, журам тогтоох, шийдвэр гаргах эрх мэдэл

Энэ нь бидний хамгийн сайн мэддэг эрх мэдэл юм. Үүнд улс төрийн эрх мэдлийн бидэнд “харагддаг” албан ёсны бүтэц, тогтолцоо бүхий байгууллагуудын шийдвэр гаргаж буй үйл явц багтана.

Хууль тогтоомжоор бүрэн эрх, эрх мэдлийг нь тодорхойлсон байгууллага, албан тушаалтнууд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шийдвэр гарган, бусдад нөлөө үзүүлэх замаар уг эрх мэдэл хэрэгжинэ. Жишээлбэл: сонгуулийн үр дүнд Засгийн газар байгуулагдах, УИХ-аас хууль батлах, Засгийн газраас үндэсний хөтөлбөр боловсруулж батлах, ИТХ-аас орон нутгийн төсвийг батлах гэх мэт.

Энэ нь нийтэд чиглэсэн шийдвэр гаргах явцад хэнийг оролцуулж, хэнийг оролцуулахгүйгээ өөрийн эрх мэдэл, давуу эрх болон нөөц боломжийг хэрхэн хуваарилснаар тодорхойлогддог. Хэн шийдвэр гаргах явцад оролцож болох, болохгүйг болон ямар шийдвэр гарч, хэн нөлөөлөв, хэнд ашигтай эсвэл хохиролтой шийдвэр болсон зэргийг харах боломжтой. Нэгэнт ил явагдаж буй тул тухайн гарсан шийдвэрт хүмүүс албан ёсны хууль, журмыг үндэслэн гомдол гаргах боломжтой гэж тооцогддог.

Нуугдмал эрх мэдэл. Хэлэлцэх асуудлыг тодорхойлох, шийдвэр гаргахад нөлөөлөх эрх мэдэл

Энэ нь хэн нэгэн **шууд захиран тушаахгүйгээр** бусдын үйл хөдлөл, зан үйл болон боломжид **нөлөө үзүүлж буй эрх мэдэл** юм. Өөрөөр хэлбэл, **хөшигний цаанаас хэн нөлөөлж, тоглоомын дүрмийг хэн тогтоож** байгааг харуулна. Ямар сэдвээр ярих, ямар асуудлуудыг бодлогын түвшинд авч үзэх, хэний дуу хоолойг сонсож, тодорхой асуудлын хүрээнд хэнтэй зөвлөлдөх вэ гэдгийг орон нутгийн түвшинд хэн тодорхойлж байна вэ?

Тэгвэл тодорхой ашиг сонирхол бүхий бүлэг хүмүүс, байгууллага нөлөөгөө ашиглан, олон нийтэд ач холбогдолтой чухал асуудлыг хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахгүй байх, уг асуудлыг чухал биш байдлаар томъёолох эсвэл бусад бүлгийнхэн асуудлаа илэрхийлэх боломжийг хаах зэргээр шийдвэр гаргах үйл явцад далдуур нөлөөлж, өөрийн ашиг сонирхолд нийцүүлэх замаар илэрдэг.

Энэ тохиолдолд нийгэмд өөрийгөө чөлөөтэй илэрхийлж чадахгүй байгаа “эмзэг” бүлгийн хүмүүс шийдвэр гаргалтад оролцож чаддаггүй. Нөгөө талаар тухайн нөлөө бүхий тодорхой ашиг сонирхлын бүлгүүд шийдвэр гаргах үйл явцыг хяналтандаа авч, болж байгаа үйл явцыг мэдэж байдаг бол бусад бүлэг энэ талаар мэдэлгүй өнгөрдөг.

Хэдий далд явагддаг ч тухайн нөхцөл байдал хэнд хохиролтой, хэнд ашигтай тусч, ямар асуудал шийдэгдэхгүй хэвээр үлдэж байгааг нарийвчлан анхааралтай ажигласны үндсэн дээр нуугдмал эрх мэдлийг хэн хэрэгжүүлж байгааг олж харах боломж бий. Жишээлбэл: зарим хүмүүс, бүлгийн дуу хоолойг оролцуулахгүйгээр зөвшилцөх, хэлэлцэх асуудлыг хаалттай хаалганы цаана шийдвэрлэх зэрэг.

Үл үзэгдэх эрх мэдэл. Итгэл үнэмшил, үнэт зүйлс, зан үйлд нөлөөлөх эрх мэдэл

Энэ нь хэн нэгэн, эсвэл зарим институци, байгууллага нь хүмүүсийн зан үйл, сонголт, шийдвэрт **үл үзэгдэх байдлаар нөлөө үзүүлдэг эрх мэдэл юм.**

Илэрхий үүрэг роль гүйцэтгэж байгаа мэт харагдахгүй хэрнээ хүмүүсийн биеэ авч явах байдал, өөртөө итгэх итгэл, үнэлэмж, нийгмийн хандлага, хэвшмэл ойлголт зэргийг нөхцөлдүүлэн бий болгох чадвартай. Хэвлэл мэдээлэл болон маркетинг, зар сурталчилгааны компаниуд үл үзэгдэх эрх мэдлийн сонгодог жишээ юм.

Хэвлэл мэдээлэл нь ямар асуудлыг онцолж, эсвэл үл ойшоох вэ гэсэн сонголтыг байнга тулгаж, хүний ой тойнд удаан хугацаагаар үлдэхүйц дүр төрх, үнэлэмжийг бий болгох зэргээр үл үзэгдэх эрх мэдлээ хэрэгжүүлдэг. Тухайлбал, телевизийн мэдээ нь өдөр бүр ямар үйл явдал хамгийн чухал вэ гэдгийг бидний ой санамжид хоногшуулдаг. Хэвлэл мэдээллийн үл үзэгдэх эрх мэдлийг ойлгохын тулд улс төрд нэр дэвшсэн болон шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн талаар ямар сөрөг имиж, ойлголтыг тэд бүрдүүлж чадсаныг бодоход л хангалттай. Жишээлбэл: шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэй хүнийг өөрийн чадлаар бус хэн нэгний татаас, дэмжлэгээр гарч ирсэн гэж харах зэрэг.

ИТХ-ын эмэгтэй төлөөлөгч эрх мэдлийн илрэн гарах дээрх хэлбэрүүдийг ялгадаг байхын зэрэгцээ эрх мэдлээ ёс зүйгүй ашиглаж байгаа тохиолдлыг мөн таньж мэддэг байх шаардлагатай.


Зөвхөн ил эрх мэдэлд чиглэн ажиллах нь үр дүн муутай. Нуугдмал эрх мэдлийг харгалзахын зэрэгцээ үл үзэгдэгч эрх мэдлийг өөрчлөхийн төлөө ажиллах ёстой. Ингэж чадвал нийтийн сайн сайхны төлөө эерэг өөрчлөлт хийх чадамж, нөлөөгөө нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Улс төрийн оролцогч талуудыг шинжлэх

Оролцогч талуудын ашиг сонирхол, нөлөөлөлд дүн шинжилгээ хийсний дараа тухайн тулгамдсан асуудлыг шийдэхэд шууд нөлөө үзүүлэх, гол шийдвэр гаргах хүмүүсийн эрх мэдэл, байр суурийг нь шинжилнэ. Энэ дүн шинжилгээ нь асуудлыг шийдвэрлэхийн төлөө хийгдэх нөлөөллийн ажлын стратеги, тактик боловсруулах суурь болно. Мөн асуудлаа шийдвэрлүүлэх, хүсч байгаа өөрчлөлтөө хийхийн тулд нөлөөллийн хүчин чармайлтаа хаана төвлөрүүлбэл үр дүнтэйг ойлгоход тусална.

Тогтоол шийдвэр гаргуулах, төсөв хөрөнгө батлуулах зэрэг өөрчлөлт авчрахад гол түлхэц үзүүлэх шийдвэр голдуу улс төрийн хүрээнд гарна. Иймээс улс төрийн орчинд шийдвэр гаргах эрх мэдэл бүхий оролцогч талуудыг мэдэж, холбоотон, дэмжигч, эсэргүүцэгчийг тодорхойлох, улмаар хамтран ажиллахад тохиромжтой аргыг сонгохын тулд энэ шинжилгээг хийдэг.

Улс төрийн оролцогч талуудын шинжилгээ буюу “Талбар” нь Петер Блоксын загварчлалд суурилсан бөгөөд шийдвэр гаргах хүмүүс болон тухайн шийдвэрт хамааралтай улс төрийн нөхцөл байдлыг задлан шинжилдэг арга юм.²²



Зураг 23. Улс төрийн оролцогч талууд “Талбар”

Улс төрийн оролцогч талуудын “Талбар” нь Итгэлцэл, Зөвшилцөл гэсэн 2 тэнхлэг болон оролцогчдын төрлийг бичсэн 4 хэсгээс бүрдэнэ.

²² Эх сурвалж: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн манлайлал 2017 оны гарын авлага, Улс төрийн оролцогч талуудын шинжилгээ “Талбар” сэдэв, 33-36 дахь тал

Тэнхлэгийн голын босоо шугам нь итгэлцлийг, хэвтээ шугам нь зөвшилцлийг илэрхийлнэ.

Итгэлцэл, зөвшилцлийн тэнхлэгээс дээшээ талуудын хооронд итгэлцэл их байх бөгөөд доошоо итгэлцэл буурна. Харин тэнхлэгийн баруун гар тал руугаа талуудын дунд зөвшилцөл байх магадлал өндөр, зүүн тал руугаа зөвшилцөлд хүрэхэд хэцүү болно.

- *Холбоотон:* Таны итгэдэг, мөн тэр хүн таныг хэрхэн үнэлдгийг мэддэг хүмүүс (итгэлцэл их, зөвшилцөл их)
- *Сөргөлдөгч:* Та тэдэнтэй хэл амаа ололцоход бэрх хүмүүс. (итгэлцэл бага, зөвшилцөл бага)
- *Шударга эсэргүүцэгч:* Эсэргүүцэж байгаагаа шулуухан хэлчихдэг. Та тэдэнд итгэдэг, гэвч өөртэй тань санаа нийлэхгүй зүйл дээрээ тэд ямар хариу үйлдэл үзүүлдэг болохыг та мэддэг (итгэлцэл их, зөвшилцөл бага)
- *Түр зуурын найз:* Ганц, нэг тохиолдолд тэдэнд итгэж болох ч тэд таныг бус бусдыг сонгож, өөрийг тань дэмжихгүй байх магадлалтай хүмүүс. Өнөөдөр найз хэрнээ маргааш яаж ч мэдэх хүн. Мөн тодорхой асуудлыг ойлгуулаад өгчихвөл хэсэг хугацаанд найз байж болох хүмүүс (итгэлцэл бага, зөвшилцөл бага)
- *Хашаан дээр суугчид:* Эргэлзэгчид, эсвэл дундыг баригчид. Тэд таныг дэмждэг эсэхэд та бүрэн итгэлтэй бус, учир нь танд тэдний тухай хангалттай мэдээлэл байхгүй, эсвэл сайн мэдэхгүй. Эсвэл дээрх 4 талын алинд ч багтахгүй, үйл явдлыг хөндлөнгөөс харж буй хүмүүс. (итгэлцэл, зөвшилцөл тодорхой бус)

Петер Блокийн²³ аргыг улс төрийн дэмжлэг хаана байж болохыг харахын тулд хэрэглэж харилцааны хүрээнд хүссэн өөрчлөлтөө хийж болдог. Түүнчлэн уг арга нь таны бүлгийн гишүүд буюу улс төрийн намын бусад гишүүд, ажлын хамтрагчид, найз нөхөд тус бүр хаана байгааг, мөн хашаа хэлбийж болохыг харж болох хамгийн сайн арга юм.

“Талбар”-ыг ашиглан улс төрийн оролцогч талууд болон шийдвэр гаргагчдын байр суурь, эрх мэдлийг шинжлэхийн ач холбогдол:

- 1) Улс төрийн орчин, нөхцөлийг тодорхойлох

²³ Peter Block – The Empowered Manager: Positive Political Skills at Work (Jossey Bass Management) 22 Feb 1991

- 2) Тодорхой асуудлын хүрээнд дэмжигч, эсэргүүцэгч, холбоотноо тодорхойлох
- 3) Тухайн өөрчлөлтийг хэн дэмжиж, хэн эсэргүүцэж байгааг ойлгох
- 4) Улс төрийн нам, бүлэглэл болон төр, орон нутгийн дэмжлэгийг үнэлэх
- 5) Шийдвэр, үйлдлийн улс төрийн эрсдэлийг тооцох
- 6) Цаашдын алхмаа тооцоолох, нөлөөллийн стратеги, тактикаа тодорхойлох зэрэг ач холбогдолтой.

Улс төрийн оролцогч талуудын “Талбар” шинжилгээг хэрхэн хийх вэ?

Улс төрийн оролцогч талуудын шинжилгээ “Талбар” арга хэрэгслийг ашиглан сонгосон асуудлын хүрээнд шийдвэр гаргагчдын **байр суурь, эрх мэдлийг** шинжилнэ.

Таны өөрчлөлтийн үйл хэргийг дэмжих дэмжлэг хаана байгааг **“Талбар”** хэрэглэж шинжлэхдээ улс төрийн хүрээнээс эхлэн тодорхойлох ба голлох шийдвэр гаргагчид болон нөлөө бүхий хүмүүсийг заавал багтааж бичнэ. Өмнө хийсэн оролцогчдын дүн шинжилгээг ашиглана. Оролцогч талуудаас **гол шийдвэр гаргагчид** ба **нөлөө бүхий талуудыг** сонгон авна.

Дараа нь хамтрагч талууд, хамтарч болох талуудыг авч үзнэ.

- Нэг нам, бүлгийнхэн
- Улс төрийн бусад нам, бүлгүүд
- Бие даагч
- Засаг захиргааны ажилтнууд
- ИТХ-аас гадуурх улс төрийн сонирхогч
- Түншлэгчид
- Өргөн хүрээний оролцогч талууд

Гаргасан жагсаалтаа ашиглан, холбоотон, сөргөлдөгч, түр зуурын найзууд, шударга эсэргүүцэгч, хашаан дээр суугчийн алин болохыг хэлэлцэж, тохирох талбайд байршуулна.

Хувь хүний нэрийг эхний үсгээр нь тэмдэглэвэл тохиромжтой байдаг. Нэрийг бичсэний дараа дараах байдлаар хэлэлцэж цэгцэлнэ:

- Бүхэлд нь том зургаар харж, өөрчлөлт хийх явцад ямар эрсдэл гарч болзошгүйг тодорхойлох
- Хэн нь тухайн асуудал буюу таны гаргасан саналын тухайд ямар байр суурьтай байгааг мэдэх
- Хүмүүсийг хэрхэн “Холбоотон” болгох тухай авч үзэх
- Үзэл бодлыг нь сайн мэдэхгүй хүмүүсийг тодорхойлох, цаашид тэдэнтэй харилцаа тогтоох шаардлагатай гэж бодож байвал “Хашаан дээр суугчид” ангилалд оруулах
- Холбоотны байрлал өөрчлөгдөх бүрд шинжилгээг дахин хийнэ.
- Нөхцөл байдал өөрчлөгдөх бүрд шинжилгээг эргэн харж дахин хийнэ.

Улс төрийн талбарт оролцогч талууд болон шийдвэр гаргагчдад нөлөөлөх арга

Холбоотноо тэлэх: Эхний шатанд дэмжих хүмүүс, бүлгээ сонгож бүрдүүлнэ. Таны саналыг дэмжих, үзэл бодлоор нэгдэх магадлалтай хүмүүсийг сонгон, мэдээлэл өгч, тухайн асуудлаар тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарна. Үйлдэл, үйл ажиллагаандаа шууд татан оролцуулж, хамтран ажиллана. Холбоотон олон байвал нөлөөлөл амжилттай болох боломж нэмэгдэнэ.

Хашаан дээр суугчдыг буюу эргэлзэгч/төвийг сахигчдыг татах: Ихэнх хүмүүс тухайн асуудлаар тодорхой шийдвэр гаргаж амжаагүй байдаг. Тэдний ашиг сонирхлыг татах хүчин зүйлсийг тооцоолж, байгаа боломжоо ашиглан холбоотны эгнээнд оруулахыг эрмэлзэнэ.

Түр зуурын найзтай хамтран ажиллахыг хичээх: Тухайн асуудлаар нэгдмэл байр суурьтай байгаагаа баталгаажуулна. Тухайн асуудлаар хамтран ажилласан тохиолдолд түүнээс яг юу хүсч байгаагаа тодорхой болгоно. Өөртэйгөө ижил байр суурьтай байхыг санал болгож, аль болох үр дүнтэй хамтран ажиллахыг хүснэ.

Шударга эсэргүүцэгчдэд нөлөөлөх: Юуны өмнө, тэдний эсэргүүцэж байгаа шалтгааныг олж мэдэх хэрэгтэй. Зарим хүмүүс ташаа мэдээлэл, буруу ойлголтын улмаас эсэргүүцэж байдаг. Манай ард түмэн “хүн мэдэхгүй юмныхаа дайсан” гэж хэлэлцдэгийг энэ үед эргэн санахад илүүдэхгүй. Ийм тохиолдолд эхлээд тэдэнд тухайн асуудлаар бодит мэдээлэл хүргэхийг хичээнэ. Мөн эсэргүүцэж байгаа үндэслэлийг сайн сонсож авах нь зүйтэй. Тэдний үндэслэл бодит байдалтай нийцэхгүй байгааг илтгэсэн баримт, нотолгоог үзүүлж болно.

Тэднийг буруутгах, шүүмжлэхийг урьтал болголгүйгээр байр суурийг нь ойлгож байгаагаа төвийг сахисан байдлаар хэлэх ба тухайн нөхцөл байдалд тохируулан асуудлын шийдлийг эрэлхийлнэ.

Сөргөлдөгчдөд нөлөөл, болохгүй бол орхи: Зөвхөн эсэргүүцэхийн тулд эсэргүүцэж, шүүмжлэхийн тулд шүүмжилж байгаа хэсэг байгаа бол тэднийг орхин, цаг хүчээ нөлөөллийн хүрээгээ тэлэх бусад аргад зарцуулсан нь дээр.

Та энэ талбарыг хэрэглэснээр өөрийн хүрээлэл, хамтрагчидтайгаа хэрхэн харилцах, хэрхэн ажиллах тухай тодорхой ойлголттой болохоос гадна хүсч буй өөрчлөлтөө хийхийн тулд нөлөөллийн стратеги, тактикаа боловсруулж, түүнийгээ зорилготойгоор ашиглаж сурна.

4.4. БУСДЫГ СЭДЭЛЖҮҮЛЭХ, ҮЙЛ ХЭРЭГТЭЭ НЭГТГЭХ

“Манлайллын түүх” бүтээх, ярих

Манлайллын түүх гэж юу вэ?

ИТХ-ын төлөөлөгч нь тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд иргэд, сонгогчдын нөөц боломжийг дайчлах, тэдний дэмжлэгийг бий болгох шаардлагатай зайлшгүй тулгарна. Иймд иргэдийг үйл хэрэгтээ татан оролцуулахын тулд тэднийг сэдэлжүүлэхүйц түүх бүтээх, ярих ур чадварт Төлөөлөгч суралцах шаардлагатай.

Олон нийтэд яриа хийхдээ Манлайлагч өөрийн бодит түүхээс сэдэвлэж, тэдэнд сэдэл, итгэл төрүүлж, үйл хэрэгтээ татан оролцуулах энэ загварыг Харвардын Их Сургуулийн харъяа Кеннедийн Засаглалын сургуулийн төрийн бодлого судлалын профессор Маршал Ганз²⁴ бүтээжээ.

Манлайллын түүх нь өөрийн түүхээр дамжуулан *үнэт зүйлсийг үйл хэрэг болгоход* чиглэсэн манлайллын урлаг бөгөөд бусдыг сэдэлжүүлж, өөрчлөлтийн үйл хэрэгтээ татан оролцуулахад ашигладаг улс төрийн ур чадвар юм.

²⁴ УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд олон улсын зөвлөх Мари Дэйвис Харвардын их сургуулийн профессор Маршал Ганзын бүтээлд тулгуурлан боловсруулсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн манлайлал” сургалтад ашиглагдсан гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнээс товчлон оруулав. 2017 он.


Манлайлал нь стратегийн ба сэдэлжүүлэх ур чадваруудын аль алиныг шаарддаг. Стратегийн ур чадвар нь зорилго, зорилтдоо хүрэхийн тулд бид хэрхэн хөрөнгө нөөцөө дайчлан хүч чадал болгохыг илтгэнэ. Сэдэлжүүлэх ур чадвар нь (манлайлагчийн түүх) тодорхойгүй нөхцөл байдлаас үл хамааран бусдыг зоригжуулах болон өөрийн үйл хэрэгт сэдэлжүүлж оролцуулахын тулд бидний зорилго, зорилт яагаад чухал байх ёстойг илэрхийлнэ.

Үр дүнтэй манлайлал гэдэг нь хүмүүсийг *гар* нийлэн ажиллуулахын тулд тэдний *тархи*, *зүрхэнд* хүрч холбогдохыг илэрхийлнэ. Асуудалд бид ийм үзэл бодлоор хандаж байна гэхээсээ илүүтэй тухайн асуудал бидэнд ийм мэдрэмж төрүүлж байна гэсэн мессеж өгч, хүмүүсийн мэдрэмжийг холбож өгдөгт түүх ярихын давуу тал оршдог. Хүмүүсийн туулж өнгөрүүлсэн зам, мэдрэсэн амьд туршлагыг өгүүлэгч түүх нь хүмүүст өөрчлөлт хийх сэдэл, хүч тэнхээ, урам зориг өгдөг.

Манлайллын түүхээр дамжуулан бид *үзэл бодлоо* бус харин бидэнд ямар зүйл үнэ цэнэтэй, чухал болох тухай *мэдрэмжээ* хуваалцдаг тул хийсвэр зарчмыг биш, үнэт зүйлийг хөндсөн туршлага, үйл явдлыг илэрхийлэх боломжтой. Хүн бүр үнэт зүйлсийг мэдэрч амьдралаараа туулсан байдаг тул тэдний өгүүлэх түүх нь бусдын сэтгэлийг хөндөх хүч чадалтай байдаг.


Үнэт зүйлсээр бусадтай нэгдэж, үйл хэргээ тууштай үргэлжлүүлэх

Манлайллын түүх – манлайллын урлаг



Зураг 24. Манлайллын урлаг

Тодорхой түүх, үйл явдал сонсох, эсвэл зүрх, сэтгэлийг эмзэглүүлсэн шударга бус явдлын гэрч болж, бидний дотор орших сэтгэл хөдлөл хөндөгдөх хүртэл амьдралдаа ямар зүйлсийг үнэлж дээдэлдгээ бид тэр бүр ухаардаггүй. Уг сэтгэл хөдлөл нь бидний үнэт зүйлсийг ил болгож, ямар нэг үйлдэл хийх, арга хэмжээ авахад сэдэлжүүлж өгдөг.



Зураг 25. Үнэт зүйлсийг ил гаргаж ирэх арга зам


Манлайллын түүх нь сэтгэл хөдөлгөсөн уран зохиомж ухаалгаар ашиглах, бусдыг хуурах арга хэрэгсэл биш юм. Сэтгэл хөдлөл нь бидний үнэт зүйлсийг ил гаргаж ирэх арга зам болж өгдөг. Сэтгэл хөдлөл нь дангаараа аливаа арга хэмжээг тухайн цаг хугацаанд үргэлжлэх төдий багахан суурь тавьж өгөхөөр хязгаарлагддаг. Сэтгэл хөдлөл хурдан хугацаанд бий

болоод буурч сарнидаг. Харин үнэт зүйлс ил гарч ирэн удаан хугацаанд тогтвортой оршдог. Бид сэтгэл хөдлөлөөр биш, харин **үнэт зүйлсийн түвшинд** нэгдэж холбогддог.

Манлайллын түүх бүтээж сурснаар бид өөрийнхөө үнэт зүйлийг илэрхийлэхээс гадна энэ түүхээрээ дамжуулан бусдын сэтгэл хөдлөлийг хөндөх замаар нийтлэг үнэт зүйлсээр холбогдож нэгдэх чадварт суралцана.

Манлайллын түүхийн бүтэц

Манлайллын цогц түүх нь “Миний түүх”, “Бидний түүх”, “Одоогийн алхам” гэсэн гурван хэсгээс бүрдэнэ.



• МИНИЙ түүх - Та хэн болох, та яагаад энэ үйл хэргийг хийхээр сэдэлжсэн болохыг хэлж өгнө. - холбоо харилцаа

• БИДНИЙ түүх - Хүмүүсийг нэгтгэж нэг хамт олон болгодог түүх - сэдэлжүүлэх

Таны үйл хэрэгтээ нэгтгэхийг хүсч байгаа талуудыг “Бид” гэж нэрлэнэ.

Бидний түүх нь Та болон таны сэдэлжүүлэхийг хүсч буй хүмүүсийн нийтлэг үнэт зүйл, туулж буй нийтлэг туршлагыг хөндөхөд чиглэгдэнэ.

• ОДОО-гийн алхам - өөрчлөлтийг хамтдаа бий болгох үйл хэрэгтээ уриалах дуудлага - стратеги, тодорхой алхмууд.

Зураг 26. Манлайллын түүхийн бүтэц


1. **Миний түүх:** Манлайллын түүх нь миний түүхээр эхэлнэ. Та ямар учраас манлайлагч болох урам зориг, сэдэлтэй болсон шалтгааны тухай өгүүлнэ.

2. **Бидний түүх:** Манлайллын түүхийн хоёр дахь хэсэг нь “Бидний түүх” юм. Энэ түүх нь “Бид яагаад манлайллын үйл хэрэгт оролцох шаардлагатай тухай асуултад хариулт өгнө. Үйл хэрэгтээ татан оруулахаар уриалж буй хүмүүс, нийгмийн бүлэг, иргэдийн бүлэг, хамт олон, байгууллагыг нэгтгэгч нийтлэг үйл явдал буюу үнэт зүйлс, хамтдаа туулж буй нийтлэг туршлагыг илэрхийлнэ.

3. **Одоогийн алхам:** Манлайллын түүхийн гурав дахь хэсэг болох “Одоогийн алхам” нь алсын харааг харуулдаг ба иргэдийг сэдэлжүүлэн өөрчлөлт бий болгоход уриалах дуудлага юм. Энэ түүхээр нэн шаардлагатай хэрэгцээний талаар өгүүлж, өөрчлөлтийг хамтдаа бий болгох стратеги, арга хэмжээг тодорхойлно.

Манлайллын түүхийн бүрдэл

Манлайллын түүх нь **Тулгамдсан асуудал, Сонголт, Үр дүнг** өөртөө агуулдаг. Энэ бүрдэл “Миний түүх, “Бидний түүх”, “Одоогийн алхам” бүгдэд нь хамаарна.



Зураг 27. Манлайллын түүхийн бүрдэл

“Миний түүх” нь сэдэлжүүлж уриалах үнэт зүйлсийг илэрхийлнэ.

“Миний түүх” нь та хэн болох, яагаад энэ үйл хэргийг хийхээр сэдэлжсэн, юунд хүрэхээр итгэж найдаж байгаа болохыг хэлж өгдөг. Та өөрт тохиолдсон бодит үйл явдал, үнэн түүхээс бусдыг сэдэлжүүлэх, уриалж чадах хэсгийг бусдад товч тодорхой ярина.

Шигтгээ 10. Байгалмаагийн түүх

Би уул уурхайн салбарт 27 жил ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан. Тэтгэвэрт гарахаас өмнө мэргэжлээс шалтгаалах өвчний групптэй 18 жил болсон.

Надтай адил Бор-өндрийн уурхай, үйлдвэрт ажиллаж байгаад мэргэжлээс шалтгаалах өвчний группт орсон маш олон хүнд тус

дэм болох зорилготой “Боржигон тал” ТББ-аа 2007 онд байгуулсан. Мэргэжлээс шалтгаалах өвчний группт орсон хүмүүст нийгмээс үзүүлэх үйлчилгээг ойлгуулах, тэдэнд нөхөн олговор, буцалтгүй тусламж олгуулах, ар гэрийнхэнд нь орон сууцыг өмчлүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд ажилласан. Би хоёр жилийн хугацаанд Бор-өндөр сумынхаа 480-аад хүн, Монгол Росцветмент нэгдлийн 1600 гаруй ажилтны нөхөн олговрыг олгуулж, Бор-өндрийн уулын үйлдвэрийн 180-аад айл өрхийн байрыг хүмүүст нь хувьчлуулж өгсөн.

Эдгээр ажлыг хийх явцад надад олон бэрхшээл тохиолдсон. Удирдах түвшний хүмүүстэй уулзаж, асуудлыг ойлгуулах, шийдвэр гаргуулах нь хамгийн бэрхшээлтэй асуудал байсан. Гэхдээ би шантраагүй, 2 жилийн хугацаанд уйгагүй хөөцөлдөж, олон хүний асуудлыг шийдэж өгч чадсанаараа өөрөөрөө бахархдаг. Орон нутагтаа шударга үнэний төлөө тэмцэж явдаг гэдгээрээ олонд танигдаж, хүмүүсийн хүндлэл хүлээсэн хүн болсноороо бас бахархдаг. Тиймээс ч хүмүүс надад итгэл хүлээлгэж 2016 онд сумын хурлын төлөөлөгчөөр сонгосон.

Миний бие нийгмийн сайн сайхны төлөөх олон ч ажилд одоо хүртэл оролцсоор явна, цаашид ч хийх ажил ч их байна даа.

**С.Байгалмаа, Хэнтий аймаг,
Бор-өндөр сумын ИТХ-ын төлөөлөгч**

Бид бүгдэд бусадтай хуваалцахуйц хүчирхэг түүх бий. Бидний амьдралын замналыг тодорхойлсон сонголтуудыг бид хийж ирсэн. Хэний ч амьдралд сорилт бэрхшээл, саад тотгор, хямрал тулгардаг ба тэдгээрийг даван туулахад суралцах шаардлага гардаг. Энэ явцад хуримтлуулсан туршлага нь бидний сургамжит түүхийг бий болгодог. Бидний бусдыг сэдэлжүүлэх сургамжит түүх нь “Миний түүх”-ийг бүтээнэ.

Зарим хүмүүс “Би өөрийнхөө тухай ярих дургүй” хэмээн хэлдэг. Гэвч та өөрийн сэтгэлийн дуудлага, урам сэдлийнхээ шалтгааныг бусдад ярьж өгөхгүй бол өөр бусад хүмүүс таны оронд тухайн асуудлыг ярьж тайлбарлана. Мөн өөр хэн нэгэн түүх бичих болно. Гэхдээ таны хүссэн шиг хүмүүст хэлэхгүй буюу биднийг бусдаас онцгой болгож буй үнэн болон гүн мэдрэмжийг илэрхийлэхгүй байж болзошгүй. Иймд та манлайлагч болохыг, өөрчлөлт хийхийг зорьж байгаа бол үүнийхээ учир шалтгааныг үйл хэрэгтээ татан оруулахыг хүсч байгаа хүмүүст ярьж өгөхөөс өөр сонголт байхгүй.

Шигтгээ 11. Ганжаргалын түүх

Би бага ангийн багш мэргэжилтэй. Анх удаагаа төлөөлөгчөөр сонгогдсон. 2012-2014 онд би Тамгын газрын нийгмийн бодлогын мэргэжилтнээр ажиллаж байсан. Миний бага хүү шарлалт нь удаж арилснаасаа болоод эмнэлэгт ойр ойрхон хэвтдэг байсан. Жаахан л ханиад хүрчихвэл цээж нь шуугиад хатгаа болчихно, тэгээд л эмнэлэгт хэвтчихнэ, 2 нас хүртлээ ийм байдалтай байсан. Надад маш хэцүү байсан. “Энэ их ажлын хажуугаар хүүгээ яаж эрүүл байлгах вэ, эмнэлэгт хэвтэхгүй юмсан” гэж бодож байсан чинь гэнэт телевизээр нялх хүүхдүүдийг сүү, шар усанд оруулах, давсан дээгүүр алхуулах тухай нэвтрүүлэг гарсан. Хүүтэйгээ эмнэлэгт хэвтэж байхад зөгийн балны татлага гэж хийлгээд цэр ховхолдог байсныг гэнэт санасан.

Би эрүүл мэнд, боловсрол гээд бүх салбартай хамтарч ажилладаг байсан учир эмчдээ нялх хүүхдүүдийг сүү, шар усанд оруулаад, бариа хийгээд, давсан дээгүүр явуулъя гэж хэлсэн. Эмч зөвшөөрсөн. Та орчноо тохижуулчих, би багийн Засаг дарга нартайгаа уулзаж байгаад сүү, шар ус, өөр юу хэрэгтэй байна, цуглуулъя гэж хэлсэн. Хавар дулаараад ирэнгүүт багийн Засаг дарга нартаа хэлсэн чинь бүгд дэмжсэн. Тэр жилүүдэд цаг их сайхан байсан. Багийн Засаг дарга нар 10, 10 л-ээр нь сүү, шар ус, ээдэм авчирч өгөөд, эмч маань орчноо гоё тохижуулчихсан, сумынхаа зорилтот бүлгийн болон эмнэлэгт тэр өвөл хэвтсэн нялх хүүхдүүдийг цуглуулсан. Эхний 10 хүүхэд 10 хоног, дараагийн 10 нь бас 10 хоногийн хугацаатай гэх мэтээр ээлжлээд хамруулаад байсан.

Би ажилтай учир ээж хүүхдийг маань зөөгөөд, нэг цагийн хугацаанд шар усанд оруулаад, сүүгээр угаагаад, давсан дээгүүр явуулаад байсан чинь харьцангуй гайгүй болсон. Түүнээс хойш манай хүүхэд ханиад хүрээгүй, эмнэлэгт дахиад хэвтээгүй. Тэр жил манай эмнэлгийн нийгмийн ажилтан надад “Ганаа эгчээ, та бид 2-ын санаачилсан ажил чинь аймагтаа тэргүүн туршлага болсон” гэж хэлж байсан.

Би сүүлдээ бага ангийн багшаа хийсэн. Ингээд 3 жил энэ ажил явсан, жилээс жилд ирж эмчлүүлэх хүүхдийн тоо олон болсон. Одоо үйл ажиллагаа нь зогсчихсон чинь эцэг эхчүүд нөгөө сувиллаа явуулахгүй юм уу, тэр чинь их үр дүнтэй байсан гэж санал тавиад байгаа дуулдсан.

**Ганжаргал, Булган аймаг,
Гурвансайхан сумын ИТХ-ын төлөөлөгч**

Та өөрийнхөө түүхийн бүтээгч нь байх ёстой бөгөөд өөрийнхөө үнэт зүйлийг бусдад ойлгуулах замаар тэднийг сэдэлжүүлж, хамтдаа манлайлахыг уриалах чадварт суралцах шаардлагатай. Танд манлайлагч болох урам, сэдэл төрсөн шалтгаан болохуйц хэдэн ч сорилт бэрхшээл тулгарсан байж болно. Бид амьдралдаа хийсэн сонголт бүрээрээ өөрийн түүх, амьдралын замналаа бүтээсэн байдаг.

Шигтгээ 12. Мөнхцэцэгийн түүх

Би 2016 онд анх удаа сонгуульд нэр дэвшин сонгогдсон. Манай сум уул нь ус мод тэгш мөртлөө миний дэвшсэн Хөөр баг хамгийн их усны хомсдолтой, хэдхэн худагтай, 2-3 булагтай, мод байхгүй газар байсан. Булгийн эхээс мод ихээр бэлтгэсэн учраас булгууд хатаад эхэлчихсэн байсан. Энэ асуудлыг шийдэх ёстой юм байна аа л гэж бодсон. Энэ багтаа нэг юм хийх ёстой нь энэ л юм байна гэж бодсон.

Ингээд шийдэл хайгаад явж байгаад Хашаат суманд хүмүүс булгийн эхээ хашдагийг олж мэдсэн. Ноднин өвөл Хашаатад булаг хашсан хүмүүс дээр очиж хаашаа, хэнд хандаж энэ асуудлаа шийдэж байгааг судлахад заримыг нь өөрсдийн хөрөнгөөр, заримыг нь НҮБ-ын Байгаль орчныг хамгаалах санд хандаж хашаагаа барьсан байсан. Хашаатад НҮБ-ээс дахиад 3 булаг хашиж өгнө гэхэд нь манай сум орж болох уу гэж асуусан. Намайг хүсэлтээ өгөөрэй гэсний дагуу би саналаа бичиж өгсөн ба энэ хавар надад хашааг хүргэж ирсэн. Зориулалтын, нүх ухалгүй (нүх ухах нь булгийн усыг татах, улмаар ширгээх аюултай) баригддаг хашаа бэлэн хүргэгдээд ирсэн тул барих л үлдсэн. Хашаа хэдийгээр бэлэн ирсэн ч босгоход хөрөнгө мөнгө хэрэгтэй байсан учир малчидтайгаа очиж уулзсан. Тойрсон хориод айл, тэр булгаас ундаалдаг арваад мянган мал байсан. Намайг учраа хэлээд очиход "өөр хүмүүсийг гуйгаад яах вэ бид өөрсдөө очоод барья" гэсэн.

Анх хашаагүй байхад булгийн эх ямар ч хамгаалалтгүй, мал амьтан орж туучдаг, хүмүүс бохирдуулдаг байсан. Булаг ингэж гадны нөлөөгөөр татрахаар малчид хол явж нуураас малаа усалдаг болсон. Эхийг хашсанаас хойш булаг сэргэж чөлөөтэй урсаж байгаа. Малчид үүнд маш их сайшаалтай хандаж, үлдсэн хоёр булгийн эхээ ийм байдлаар хашъя гээд санаачилга гаргачихсан явж байгаа.

**Т.Мөнхцэцэг, Архангай аймаг,
Хотонт сумын ИТХ-ын төлөөлөгч**

Миний түүхийг ярихдаа Таны амьдралын замналыг бүрэлдүүлэхэд нөлөөлсөн чухал, эгзэгтэй мөчүүд, ямар нэгэн томоохон шийдвэр гаргах, өөрчлөлт хийхэд эрч хүч, урам зориг өгсөн, хөшүүрэг болсон үйл явдлыг үнэт зүйлтэйгээ холбон ярина. Таныг сонголт хийхэд болон өнөөгийн таныг бий болгоход нөлөөлсөн тэр цаг мөч буюу чухал эргэлтийн цэгийг түүхээрээ илэрхийлнэ.

Таны түүх нь сонсогчдыг өөрсдийнхөө үнэт зүйл болон тулгамдсан асуудлын тухай бодохыг уриалж, тэд амьдралдаа өөрчлөлт хийх талаар бодох шинэ арга замуудыг төрүүлж, түүнийг нь дэмжихэд чиглэгдсэн байх ёстой.

Түүх болохуйц үйл явдлыг сонгон авахын тулд дараах асуулыг өөрөөсөө асууна уу:

- Таны боломжит “Миний түүх”-үүдээс аль нь манлайллын арга хэмжээнд тань хамгийн тохиромжтой байна вэ?
- Таны аль сонголт нь өөрчлөлт хийхэд түлхэц болсон таны сэдлийг тодорхой харуулж байна вэ?

Миний түүхийн бүтэц: асуудал – сонголт – үр дүн

Та нэгэнт чухал эргэлтийн цэг буюу анх удаа сорилт бэрхшээлтэй тулгарч, түүний талаар ямар нэг алхам/үйлдэл хийх сонголт хийсэн тохиолдлыг тодорхойлсон бол цааш үргэлжлүүлэн боловсруулна.

Сорилт/ тулгамдсан асуудал

- Та хэзээ шударга бус явдалтай учирсан бэ?
- Та яагаад үүнийг тулгамдсан асуудал гэж бодсон бэ?
- Тэр үед танд ямар нэг зүйл хийх хэрэгтэй гэсэн мэдрэмж төрсөн үү?

Сонголт

- Та яагаад өөрийгөө ямар нэг зүйл хийж чадна гэж бодсон бэ?
- Та ямар шийдвэр гаргасан бэ?
- Та яагаад тэр сонголтыг хийсэн бэ?

Үр дүн

- Сонголтын үр дүнд юу болсон бэ?
- Ямар өөрчлөлт гарсан бэ?
- Та түүхээрээ дамжуулан юуг хэлэхийг хүсч байна вэ?
- Та хүмүүст ямар сэтгэгдэл, бодол, мэдрэмж төрөөсэй гэж хүсч байна вэ?

Миний түүхээр дамжуулан өөрчлөлт хийхэд сэдэлжүүлсэн үнэт зүйлсээ үр дүнтэй хуваалцсанаар хүмүүстэй итгэлцэл, ойлголцлын бат бэх суурийг тавьж чадна.

Миний түүхийг тохиромжтой үед ашиглана, дандаа биш. “Миний түүх” нь дангаараа бусдыг үйл хэрэгт татан оролцуулж чадахгүй. Иймээс хүмүүсийг тантай нэгдэж, хамтдаа өөрчлөлт хийхийг уриалах шаардлагатай болно.

“Миний түүх” нь хүмүүст та хэн болох, яагаад энэ ажлыг хийж

байгааг хэлж өгдөг. Гэхдээ “Миний түүх” нь дангаараа хүмүүсийг үйлдэл, арга хэмжээнд татан оруулахад хангалтгүй. Таны дараагийн анхаарах асуулт бол “бидний нийтлэг үнэт зүйлс юу вэ?” юм. Иймээс хүмүүсийг тантай нэгдэж, хамтдаа өөрчлөлт хийхийг уриалах шаардлагатай болно. “Миний түүх”-ээ боловсруулсны дараа нийтлэг үнэт зүйлс, “нэг хамт олон” болгож буй онцлог шинжүүдийг тодорхойлох зорилгоор “Бидний түүх”-ээ бүтээнэ.

“Бидний түүх” нь бусдыг өөртөө нэгтгэж хамтдаа үйлдэл хийх, арга хэмжээ авахыг уриалж буй нийтлэг үнэт зүйлийг илэрхийлнэ.

Манлайллын түүхийн хоёр дахь хэсэг нь “Бидний түүх” ба хүмүүсийг өөртөө татаж, нэгтгэх зорилготой тул та болон таны сэдэлжүүлэхийг хүсч байгаа хүмүүсийн үнэт зүйлсийг илэрхийлэх ёстой. Тодорхойгүй нөхцөл байдалд өөрчлөлт хийх, үр дүн гаргахын тулд та хүмүүсийг өөртэйгөө нэгдэж, үйлдэл/алхам хийхийг уриалахад суралцах шаардлагатай.

Таны үйл хэрэгтээ нэгтгэхийг хүсч байгаа талуудыг “Бид” гэж нэрлэнэ. Хүмүүсийг үнэт зүйлээр нэгтгэж нэг хамт олон болгодог. Тэдэнд шинэ хамт олны нэг хэсэг болох мэдрэмж төрүүлэх, өөрчлөлт хийх бүлэгт нэгдэхийг уриалахын тулд нийтлэг үнэт зүйлсийг нь ил гаргаж ирэхүйц түүх бүтээх шаардлагатай. Иймээс дараах асуултыг өөртөө тавьж, биднийг нэг хамт олон болгож буй нийтлэг үнэт зүйл, онцлог шинжүүдийг тодорхойлно:

- Та чухам ямар “бид” хэмээгч “хамт олон”-той нэгдэхийг хүсч байна вэ?
- Ямар нийтлэг үйл явдал буюу үнэт зүйлс биднийг (таныг ба үйл хэрэгтээ оролцуулахыг хүсч буй иргэд) нэгтгэж байна вэ?
- Бидний хамтдаа туулж буй нийтлэг туршлага юу вэ?
- Биднийг ямар нийтлэг ирээдүй хүлээж байна вэ?
- Тантай адил сонголтыг тэд хийнэ гэдэгт та хэр зэрэг итгэж байна вэ?

Бидний түүхийн бүтэц: асуудал – сонголт – үр дүн

“Миний түүх” дээрээ “Бидний түүх”-ийг нэмж ярина. “Бидний түүх” нь “Миний түүх”-тэй адил тодорхой тулгамдсан асуудал, сонголт, үр дүнгээс бүрдсэн бүтэцтэй.

Сорилт/ тулгамдсан асуудал

- Сэдэлжүүлэн, үйл хэрэгтээ татан оролцуулах гэж байгаа хүмүүс чинь хэн бэ?
- Бидэнд ямар тулгамдсан асуудал/сорилт бэрхшээл тулгарсан вэ?

Сонголт

- Та ямар нийтлэг үнэт зүйлсийг илэрхийлэх вэ?
- Бид ямар нийтлэг туршлага туулж, ямар нийтлэг ирээдүйг хуваалцаж байгаа вэ?
- Та тулгамдсан асуудлыг шийдэх ямар тодорхой сонголтуудыг санал болгох вэ?

Үр дүн

- Сонголтоос ямар үр дүн гарна гэж санал болгох вэ?
- Хамт олон болж нэгдэн, хамтдаа арга хэмжээ авснаар ямар өөрчлөлт гарах вэ?
- Та бидний түүхээр дамжуулан юуг хэлэхийг хүсч байна вэ?
- Та хүмүүст ямар сэтгэгдэл, бодол, мэдрэмж төрөөсэй гэж хүсч байна вэ?

Асуудлыг шийдэж, эерэг өөрчлөлт бий болгох үйл хэрэгт тань нэгдэх хүсэл төрүүлэх түүхийг хүмүүст ярьж өгөөрэй. Таны түүхийг сонссоны дараа хүмүүс бие биетэйгээ нэгдэж чадаж байгаа эсэхээс “Бидний түүх”-ийн чанар чансаа шалтгаална.

Шигтгээ 13. Лхамдулам ба багийн иргэдийн түүх

Сумынхаа хүн, малын тоо ихтэй багаас сонгогдсон төлөөлөгч юм би. Манай багийн Нарийн хад гэдэг газар амьдардаг 18 өрх ундны усны хомсдолд орсон нь нэн тэргүүнд шийдэх тулгамдсан асуудал болсон байсан. Энэ айлууд усгүйн улмаас долоо хоногт 2-3 удаа 25 км-ийн зайтай багийн төвөөс ундны усаа зөөдөг байсан. Би иргэдийн ундны усны асуудлыг шийдвэрлэж өгье гэж шийдсэн.

Ингээд Нарийн хад гүний өрмийн худгийн асуудлыг шийдүүлэхээр 2018 оны 3-р сарын 22-ны хурлаар оруулсан. Ингэхдээ төлөөлөгч нартаа тайлбарлан нөлөөлж уг асуудлыг дэмжүүлсэн. Хурлаас зөвхөн хайгуулын 100,000 төгрөгийг л санхүүжүүлэх боломжтой, яг худаг байгуулах санхүүг дэмжих боломжгүй гэсэн.

Хайгуулын зардлаараа усны сувгаа гаргуулаад худаг байгуулах хөрөнгөө тухайн багт оршин суугч иргэдийг дайчлан, тэдний оролцоотойгоор босгож, худгаа гаргаж чадсан. Ингэснээр Нарийн хадны өрхүүд өнөөдөр ундны устай болж, эрүүл мэнд, эдийн засгийн хувьд олон эерэг үр нөлөөг биеэр мэдрээд амьдарч байна.

**Н.Лхамдулам, Баянхонгор аймаг,
Баянцагаан сумын ИТХ-ын төлөөлөгч**

“Бидний түүх”-ээр дамжуулан нийтлэг зорилгодоо хүрэхийн тулд бусад хүмүүсийг үйлдэл/арга хэмжээнд хэрхэн уриалах талаар сайн бодож тунгаах хэрэгтэй. Энэ түүхийн зорилго нь хүмүүсийг шинэ хамт олны нэг хэсэг болох мэдрэмж төрүүлэх, тэднийг өөрчлөлт хийх бүлэгт нэгдэхийг уриалахад оршино.

“Бидний түүх”-ийн зорилго бол:

- Хүмүүсийг нэгтгэх нийтлэг үнэт зүйлсийг хөндөж ил гаргах
- Тулгамдсан асуудал болон түүнийг шийдэх арга хэмжээний зайлшгүй шаардлагыг илэрхийлэх
- Бид тодорхой өөрчлөлт хийж чадна гэсэн итгэл хүмүүст өгөхөд чиглэгдэх ёстой.

Шигтгээ 14. Мөнхболор ба оршин суугчдын түүх

Манай суманд байдаг орон сууцуудын Сууц өмчлөгчдийн холбооны (СӨХ)-ны үйл ажиллагаа зогсонги байдалтай олон жил болсон. Орон сууцууд эзэнгүйдэж, хүн амьдрах наад захын баталгаа алдагдаж, хүний эрүүл мэндэд сөрөг үр дагавар үзүүлж эхэлсэн.

Сумын ИТХ-д энэ талаар санал оруулж шийдвэрлүүлснээс гадна иргэдийг уриалан, тэдний дэмжлэгээр СӨХ-г шинэчлэн байгуулсан ба одоо Удирдах зөвлөл нь шийдвэр гарган ажиллаж байна. СӨХ-ны үйл ажиллагаа хэвийн явагдаж, санхүүгийн эх үүсвэртэй болсноор эвдрэлд орж муудаж байсан орон сууцнуудын нөхцөл сайжирч, хүмүүс ая тухтай амьдрах боломжоор хангагдаж, шинээр ирж ажиллаж буй эмч, багш нар орон байргүйн зовлон байхгүй болсон нь том дэвшил гэж манай сумынхан болон сонгогчид маань сэтгэл хангалуун байгаа.

**Ю.Мөнхболор, Дорноговь аймаг,
Их хэт сумын ИТХ-ын төлөөлөгч**

“Одоогийн алхам” нь бусдыг сэдэлжүүлэн өөрчлөлтийг хамтдаа бий болгох, үйл хэрэгтээ уриалах дуудлага юм.

Манлайллын түүхийн гурав дахь хэсэг нь **“Одоогийн алхам”** бөгөөд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд хийгдэх өөрчлөлт болон тухайн өөрчлөлтийг авчрах стратеги, нэн чухал алхмуудыг өгүүлдэг. Түүнчлэн бид ямар үйлдэл хийх, эсвэл хийхгүй байх талаар сонголт хийх зайлшгүй шаардлагыг илэрхийлнэ. Зайлшгүй сонголт хийхийг шаардсан одоогийн нөхцөл байдал, хэрэв арга хэмжээ авахгүй бол улам дордож даамжрах төлөв байдал, арга хэмжээ авсан тохиолдолд итгэл найдвар бүхий алсын хараа байгаа болох, түүний төлөө бүгдээрээ хамтран ажиллах хэрэгцээ шаардлагын тухай өгүүлнэ.

Бидний хүсэл тэмүүлэл, нийтлэг үнэт зүйл болон одоо байгаа нөхцөл байдлын хооронд ялгаа байгаа нь тулгамдсан асуудал болоод байна. Энэ ялгаа, зөрчлөөс бухимдал үүсдэг. Энэ нь бидэнд сонголт хийх шахалт үзүүлдэг. Иймээс бид өөрчлөлтийг авчрах цаашдын стратеги болон оновчтой арга хэмжээ/үйлдлүүдийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд бусдыг уриална. Миний түүхийн эцсийн бүрдэл болсон “Одоогийн алхам”-ыг үр дүнтэй илэрхийлж чадсан эсэхийг хүмүүс үйлдэл/арга хэмжээнд нэгдсэн эсэхээр хялбархан дүгнэх боломжтой.

Шигтгээ 15. Лхамсүрэнгийн түүх ба тусгай зөвшөөрөл, лицензийг цуцлуулах шаардлага

Дорноговь аймгийн Аргалийн уул маань 300 гаруй аргальтай байгалийн үзэсгэлэнт газар төдийгүй Их говийн зоригтон гээд түүх дурсгал агуулсан үнэт нандин газар юмаа, бид бүгдийн хувьд. Энэ газарт маань нэгэн уул уурхайн компани ирээд хүрэн нүүрсний хайгуулаа хийж эхлээд байсан. Улмаар хайгуултай холбоотой том оврын машин тэрэг олноор ирж арваадхан хоногийн дотор бэлчээр, ус гээд маш их байгаль орчны хохирол учруулсан.

Нүдэн дээр байгаль орчныг доройтуулж байсан ч энэ компани улсаас лиценз, зөвшөөрлөө авчихсан байсан нь бидний хувьд нутаг усаа хамгаалах, эрх ашиг сонирхлоо хамгаалуулах боломжийг хумьсан. Бид нутгийн иргэдтэйгээ хамтран нутгийнхаа энэ дурсгал газрыг авч үлдэхээр эхлээд Фэйсбүүк дээр мэдээлэл түгээж аян өрнүүлсэн. Мөн 3 телевиз урьж мэдээлэл хийсэн. Бид багийн өдөрлөг дээр энэ асуудлыг хэлэлцэж нийт 1000 хүний гарын үсэг цуглуулж Өргөдлийн байнгын хороонд хандсан. Энэ аянд маань зөвхөн Өргөн сумынхан бус Дорноговь аймгийн, цаашлаад Их говийн зоригтонг

шүтэж байсан олон хүмүүс дэмжиж нэгдсэн. Тухайн уул уурхайн компани нь лиценз зөвшөөрөлтэй байсан тул бидний авсан арга хэмжээ уулаа тусгай хамгаалалтанд авах байсан. Энэ Аргалийн уул Тусгай хамгаалалтын газарт багтаж чадаагүй байсан бөгөөд 4-5 удаа өргөдөл илгээсэн ч дандаа татгалзсан хариу авч байсан юм билээ. Бид саяхан энэ газраа объектын тусгай хамгаалалтанд, дараа нь аймгийн тусгай хамгаалалтанд авсан. Одоо бид ингээд санаа амарч болохгүй, байгалийн үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт энэ газар өгөгдсөн тусгай лизенз, зөвшөөрөл Ашигт малтмалын газраас цуцлагдтал бид зогсч болохгүй, хамтдаа дуу хоолойгоо илэрхийлэх нь чухал гэж үзэж хөдөлгөөнөө үргэлжлүүлсээр байна. Ингэж байж Аргалийн уул маань 100 хувь аврагдаж, сүйтгэгдэх аюулаас хамгаалагдана.

**Б.Лхамсүрэн, Дорноговь аймаг,
Өргөн сумын ИТХ-ын төлөөлөгч**

Одоогийн алхмын бүтэц: асуудал – сонголт – үр дүн

Сорилт/ тулгамдсан асуудал

- Одоо бидэнд тулгамдаж буй сорилт бэрхшээл
- Хамтдаа юуг, нэн тэргүүнд зайлшгүй хийх шаардлагатай байна вэ?

Сонголт

- Та шинээр бүрдүүлэх “бид – хамт олон”-оос хамтдаа хийх боломжтой ямар тодорхой сонголтуудыг хүсч байна вэ?
- Тэдний шийдвэр, хүчин чармайлт ямар байх вэ?
- Тэр сонголтууд нь хамтын үнэт зүйлсэд нийцэж байгаа юу?

Үр дүн

- Тулгамдсан асуудлыг шийдэх зайлшгүй шаардлага, одоо арга хэмжээ авахгүй бол улам дордох төлөв байдал, учрах муу үр дагавар нь юу вэ?
- Арга хэмжээ авсан тохиолдолд ямар тодорхой үр дүн, өөрчлөлт бий болох вэ?
- Тодорхой үр дүн, өөрчлөлт бий болгохын тулд та хүмүүст хандаж ямар уриалга хэлэх вэ?

Манлайллын түүхийн дэд хэсгүүдийг холбох

Хамтын үнэт зүйлсийг хамт олны үйл хэрэг болгох

Та тулгамдсан асуудлыг шийдэхийн төлөө хичээж зүтгэх нь анхны алхам боловч энэ нь дангаараа хангалтгүй. Та бусадтай нэгдэж, бүлэг, хамт олон бүрдүүлж, “олны хүч оломгүй далай” гэдгийн адил тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хүчин чармайлтыг хамтын үйл хэрэг болгох шаардлагатай.

“Миний түүх”, “Бидний түүх”, “Одоогийн алхам”-ыг нэгтгэхийн тулд энэ үйл хэрэгт би болон бид яагаад нэгдэх сэдэлтэй болсон, бидний үйл хэрэг одоо цааш хэрхэх талаар уялдаа холбоог бүрдүүлэх хэрэгтэй.

Манлайллын цогц түүх бүтээхийн тулд доторх бүрдлүүдийг холбох загварыг доорх хүснэгтээс харна уу:

Хүснэгт 3. Манлайллын цогц түүх бүтээх загвар

МИНИЙ ТҮҮХ		БИДНИЙ ТҮҮХ		ОДООГИЙН АЛХАМ	
Энэ өөрчлөлт/үйлдэлд бусдыг уриалахын тулд та ямар түүх ярих вэ? (Та хэн болох, яагаад энэ үйл хэргийг хийхээр сэдэлжсэн болох, ямар сонголт хийсэн, тэр нь ямар өөрчлөлт/үр дүнг бий болгосон тухай)		Тэд яагаад энэ өөрчлөлт/үйлдэл хийхэд оролцох ёстой талаар та ямар түүх ярих вэ? (Хамтдаа амсаж, туулж буй нийтлэг туршлага, хамтдаа хуваалцах ирээдүй, энэ бүхэнд хөндөгдөж буй бидний нийтлэг үнэт зүйлс, түүнтэй холбоотой тулгамдсан асуудлыг хамтдаа шийдэхээр санал болгож буй сонголтууд)		Биднийг ямар үйлдэл/арга хэмжээнд уриалж байгаа вэ? (Зайлшгүй хэрэгцээ шаардлага, арга хэмжээ авахгүй бол ямар үр дагаварт хүрэх, арга хэмжээ авснаар ямар үр дүн гарах, энэ өөрчлөлтийг хамтдаа бий болгохын тулд нэн тэргүүнд ямар үйлдэл хийх)	
Тулгамдсан асуудал	2.	Тулгамдсан асуудал	5.	Тулгамдсан асуудал	8.
Сонголт	3.	Сонголт	6.	Сонголт	9.
Үр дүн	4.	Үр дүн	7.	Үр дүн	1.Эндээс эхэлнэ: Тодорхой хүчин чармайлт хүсч уриалахыг анхаарна уу.

Манлайлагчийн цогц түүх бүтээж сурснаар бид өөрсдийн үнэт зүйлсээ илэрхийлэхийн зэрэгцээ бусдын сэтгэл хөдлөлийг хөндөх замаар хүмүүстэй нийтлэг үнэт зүйлсээр холбогдож нэгдэх, улмаар үйл хэрэгтээ тэдний дэмжлэгийг авах чадварт суралцана.

Манлайллын түүх ярихад анхаарах зүйлс:

Түүх хүүрнэх нь тоочих үйл явц биш, харин эрч хүчтэй үйл явц юм.

Манлайллын цогц түүх бүтээх нь ур чадвар бөгөөд таны намтар, ажлын танилцуулга биш гэдгийг анхаарах шаардлагатай. Бусдыг сэдэлжүүлэхийн тулд олон нийтийн өмнө түүхээ ярих бүртээ “Миний түүх” болон “Бидний түүх” ямар байвал зохистой вэ? гэж өөрөөсөө байнга асуух нь зүйтэй.

Манлайллын түүхээ олон нийтийн өмнө ярих бүрт өөрийгөө тодорхой илэрхийлэх, сонсогч хүмүүстэйгээ нийцүүлэх, орчин нөхцөлөөс хамаарах зэрэг шалтгаанаар бага зэрэг өөрчлөх шаардлага гарна. “Миний түүх”, “Бидний түүх”-ийн уялдаа холбоог тодорхой харж ойлгодог болмогц, “Бидний түүх”-ээ боловсруулах явцад “Миний түүх”-ээ өөрчилмөөр санагдаж болно.

Түүхийн үг, өгүүлбэр бүрийг амьсгалж мэдэртэл ярина.

Түүх нь тодорхой, мэдрэмжтэй, тодорхой цаг хугацаа, газар, орчин, нөхцөл, сэтгэлийн хөдлөл, өнгө, дуу чимээ, бүтэц, амттай байна. Энэ мэдрэмжийг та түүхээрээ аль болохоор тодорхой өгүүлбэл, таны түүхийн бусдыг татах, сэдэлжүүлэх, нэгтгэх хүч улам илүү болно. Түүхээ үнэн бодит болгох тод томруун дүрслэл, онцлог сэтгэгдэл төрүүлэхүйц байдлаар өгүүлэн нэн шаардлагатайг ойлгуулж, итгэл найдвар төрүүлнэ. Гэхдээ статистик аль болох ашиглахгүй байхыг хичээгээрэй. Зайлшгүй ашиглах шаардлагатай тохиолдолд хүн амын тал нь, 3 хүн тутмын нэг нь гэх мэт анхаарал татахуйц хэллэг ашиглах нь зүйтэй.

Түүх ярихад дадлага хэрэгтэй.

Баялаг, олон талт үйл явдлаар дүүрэн цаг үед амьдарч байгаа тул бидэнд олон янзын тулгамдсан асуудал, сонголт, амжилттай үр дүн, амжилтгүй үр дагаврууд ээлжлэн оршдог. Энэ нь бид бүх амьдралынхаа түүхийг богино хугацаанд шууд ярих боломжгүй гэсэн үг юм.

Манлайллын цогц түүх бүтээх нь тодорхой цаг хугацаа зарцуулж суралцах боломжтой ур чадвар бөгөөд нэг удаа бичээд, дахин дахин

ашиглах бүтээл биш юм. Түүхийг хамгийн ихдээ 4 минутад багтаан ярих хэрэгтэй. Үүнээс урт түүх яривал оролцогчдын сонирхол буурах тул 4 минутын хугацааг сайн баримтлах нь зүйтэй.

Харин манлайллын цогц түүхийг ярих, хөгжүүлэхэд байнга суралцах шаардлагатай ба уг тасралтгүй үйл явцын үр дүнд бусдыг сэдэлжүүлэхийн тулд хэзээ, хаана, хэрхэн түүхээ ярих талаар тодорхой туршлага хуримтлуулах болно. Энэ хэрээр тухайн нөхцөл байдлаас хамааран өөрийн амьдралын аль түүхийг ярихаа сонгож сурна. Манлайллын цогц түүх бүтээх нь ахисан шатны ур чадвар бөгөөд бүрэн сурч эзэмштэл дадлага, туршлага хуримтлуулах хангалттай цаг хугацаа шаардлагатай.

4.5. НӨЛӨӨЛЛИЙН ХҮРЭЭГЭЭ БЭХЖҮҮЛЭХ

Нөлөөлөл ба Төлөөлөл

Нөлөөллийг бусдын санаа бодлыг хувирган өөрчлөхөд чиглэсэн ятгалга гэж нэг талаас хэлж болно. Бид хүмүүсийн нөлөөлөл дунд амьдарч, бас өөрсдийн нөлөөллөөр дамжуулж бусдын санаа бодлыг өөрчилж байдаг. Үр дүн хэрхэн гарах нь бид нөлөөллийн үйл ажиллагааг хэрхэн явуулснаас шууд хамаарна.

Төлөөлөгч эмэгтэй танд төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад ганцаардах, мухардах явдал элбэг тохиолддог уу? Тийм бол тойрог болон төлөөлж буй иргэдийнхээ өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд нөлөөллийн хүрээгээ тэлэх шаардлагатай. Энэ үйл явцад дэмжлэг болохуйц **Экологийн загварыг** танилцуулж байна. Энэ загвар нь эргэн тойрон дахь хүрээллээ илүү системтэй, өргөн хүрээгээр харахад та бүхэнд тусална. Ингэснээр бусдын бодол санаа, итгэл үнэмшил хүмүүсийн шийдвэр болон сонголтод хэрхэн нөлөөлдөг талаар эргэцүүлж, нөхцөл байдлыг шинжлэн, нөлөөллийн тойрог бүр дээр хэрхэн ажиллахаа тодорхойлоход дөхөм болно.

Аль тойрогт, хэнд илүү нөлөөлөх нь шийдвэрлэх гэж буй асуудал, хамрах хүрээнээс шалтгаалж харилцан адилгүй байдаг. Тухайлбал, зарим төлөөлөгч харилцааны тойрогтоо буюу гэр бүлдээ илүү нөлөөлснөөр сонгогдсон тойрогтоо цаг гаргаж ажиллах боломж гаргахад ашиглаж болно. Зарим төлөөлөгч хамт олны тойрог буюу ажлын хамт олон, хамтран ажилладаг хүмүүстээ илүү нөлөөлж, ажил үүргийн зохион байгуулалт хийснээр төлөөлөгчийнхөө чиг үүрэгт илүү анхаарах нөхцөлийг бүрдүүлж болно.

Экологийн загварыг ашиглахад анхаарах хамгийн чухал зүйл нь бид зөвхөн нэг тойргийн хүмүүст анхааран ажиллах нь хангалтгүй, нөлөөллийн тойрог тус бүрээс тодорхой тооны хүмүүсийг өөрийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг дэмжихэд татан оролцуулах замаар **жин дарах хүчийг** нэмэгдүүлж, нөлөөллийн хүрээгээ бэхжүүлнэ гэдгийг ойлгох явдал юм.

Экологийн загварыг дараах дөрвөн түвшинд авч үзэж байна:

1. Хувь хүний тойрог: Энэ бол таны тойрог. Бусдын бодол санаа итгэл үнэмшил, хандлага нь таны шийдвэр, сонголтод тодорхой байдлаар нөлөөлж байдаг. Бидний хүйс, нас, амьдралын туршлага, нийгмийн гарал, ажил зэрэг нь иргэдийг төлөөлөх эсэх, эргэн тойрны хүмүүсийн дэмжлэгийг авах эсэхэд нөлөөлдөг. Тухайлбал, бүх шатны дарга нарын дунд эрэгтэйчүүд давамгайл байснаар “шийдвэр гаргах түвшинд ихэвчлэн эрэгтэйчүүд байх ёстой” гэсэн итгэл үнэмшил олон нийтэд хэвшин тогтоход нөлөөлж магадгүй. Тиймээс төлөөлөгч эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд та өөртөө болон бусдад амьдралынхаа туршлага, ажил, нийгмийн нөхцөл байдал зэргээ тунгаан бодох орон зай бий болгох нь чухал юм.

2. Харилцааны тойрог: Энэ тойрогт гэр бүлийн гишүүд, хамаатан садан, найз нөхөд гээд өдөр тутамдаа харилцдаг хүмүүсийг хамааруулан ойлгож болно. Эмэгтэй төлөөлөгчийн хувьд харилцааны тойрог нь тэдний шийдвэр, сонголтод шууд хүчтэй нөлөөлөхүйц байдаг. Иймд гаргасан шийдвэр, таньд итгэл хүлээлгэсэн сонгогчдын төлөө хийж буй ажлынхаа сайн талыг бусдад ойлгуулж ажиллахад анхаарах нь чухал.

Эмэгтэй хүн гэр бүлдээ цаг зарцуулах, үр хүүхдээ өсгөх үүрэг хариуцлагаа ажилтайгаа хослуулах ёстой гэж үздэг тогтсон хандлага нийгэмд хүчтэй байдаг. Гэр бүлээ асрамжлах, үр хүүхдээ зөв хүмүүжүүлэх нь ямар ч гэр бүлийн хувьд хамгийн чухал гэдэгтэй гэр бүлийн гишүүд санал нийлдэг ч эмэгтэйчүүдэд ихэвчлэн ачаалал ирдэг. Энэ нь төлөөлөгчийн үүргээ гүйцэтгэхэд тулгардаг томоохон бэрхшээлүүдийн нэг болдог. Иймд хүүхэдтэйгээ хамт цагийг өнгөрөөж, гэр бүлдээ анхаарах нь хамтын хариуцлага гэдгийг харилцааны тойргийн хүмүүс ухамсарлахад нөлөөлж, гэр бүлийн ачааллаа оновчтой хуваарилахад анхаарч чадвал танд итгэл өгсөн хүмүүсийн төлөө цаг гарган ажиллах боломж, бололцоо бүрдэх сайн талтай.

3. Хамт олны тойрог: Ажлын хамт олон, намын үүрийн гишүүд, дэмжигчид нь энэ тойргийг бүрдүүлдэг бөгөөд эмэгтэй төлөөлөгчийн хувьд энэ тойрог нь ихэвчлэн таныг дэмждэг. Иймд энэ тойргийн хүрээг тэлж, хийх гэж буй ажилдаа дэмжлэг авч, хийсэн ажлаа тайлагнаж, итгэлийг нь батжуулахад анхаараарай.

4. Нийгмийн тойрог: Төлөөлж буй тойргийн иргэд, сонгогчид болон нийт иргэдийг ойлгоно. Хэдийгээр та дэмжсэн хүмүүсийнхээ сонголтоор төлөөлөгч болсон ч сонгогдсоны дараа нийт тойргийн иргэдийн эрх ашгийн төлөө ажиллах үүрэг хүлээдэг. Иймд тойргийнхоо нийт хүмүүсийн төлөөлөл, дуу хоолой болж байгаагаа цаг ямагт ойлгож ажиллавал эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоо бэхжиж, хүн амын 51 хувь нь болсон эмэгтэйчүүдэд сонгогдох болон томилогдох албан тушаалд ажиллах боломж нэмэгдэнэ. Гэр бүлд зөвхөн эмэгтэйчүүд л олж хардаг, бидний оролцоогүйгээр бүтдэггүй олон асуудал байдаг. Түүн шиг орон нутаг, улс оронд ч ялгаагүй эмэгтэй төлөөлөгч таны оролцоо, шийдлийг хүлээсэн олон асуудал бий. Жишээ нь: хүчирхийлэлд өртөж буй хүмүүсийн 90 гаруй хувь нь хүүхэд, эмэгтэйчүүд. Энэ талаар эмэгтэй төлөөлөгч нар л илүү хүчтэй дуугарч, тэдний дуу хоолой болохгүй бол уг асуудал хэзээ ч бодлогын тэргүүлэх чиглэл болж чадахгүй. Мөн ногоон байгууламж, экологийн тэнцвэр, эрүүл амьдрал, гэр бүл салалт, хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах зэрэг эмэгтэй хүний амьдралын туршлага, нарийн мэдрэмж шаардсан олон асуудал орхигдсоор л байна.

Төлөөлөгч эмэгтэйчүүдийн дуу хоолой, оролцоо ийнхүү нийгэмд дутагдсаар байгаа тул нөлөөллийн тойрог тус бүртэй ажиллахдаа өөртөө итгэлтэй, тууштай, зоригтой байж, хамтын манлайллыг хэрэгжүүлж ажиллаарай. Дахин сануулахад тогтсон сөрөг хандлагыг эвдэхэд таны оролцоо хамгийн чухал юм шүү.

Нийгэм, хамт олны дунд өөрчлөлт бий болго.

Нийгэм, хамт олны зүгээс “хэвийн”, “байх ёстой зүйл” гэж үздэг хэвшмэл ойлголт, тогтсон хандлага, зан үйлээс нийгэм, хамт олны хэм хэмжээ бүтдэг. Шийдвэр гаргах түвшинд нийгмийн бүхий л бүлгүүдийн тэгш оролцоо бүрэн хангагдсан, эрх мэдэл тэнцвэртэй хуваарилагдсан байхын төлөө дэлхий нийт зорьж байна. Нийгэм, хамт олны дунд ийм хэм хэмжээ тогтвоос бид аливаа асуудлыг зөвхөн нэг талаас нь бус өөр өөр өнцгөөс харж, шийдвэрлэх олон талт арга замыг эрэлхийлж чадна.

Нийгэм, хамт олны хэм хэмжээг өөрчлөхөд урт удаан цаг хугацаа шаардагддаг ч үүнийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Нийгэм, хамт олны дунд өөрчлөлт бий болгохын тулд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, гэр бүлийн гишүүд, мөн хөрш, үсчин, бизнес эрхлэгч, эрүүл мэндийн ажилтан, хуульч, орон нутгийн удирдагч, цагдаа, төрийн албан хаагч нар гээд нийгэмд оролцогч бүх талуудад хүрч, ялгаатай арга замаар нөлөөлөх шаардлагатай.

Эрэгтэйчүүд бодлого шийдвэр гаргагч, удирдагч байх ёстой гэсэн хандлагад баригдсанаар иргэдийг төлөөлөх төлөөлөгчдийн дийлэнх нь нэг хүйсийн төлөөлөл байхад хүргэдэг. Ингэснээр нийгэм дэх бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг харгалзаагүй, тэдний амьдралд тулгарч буй ялгаатай хүчин зүйлсийг тооцоогүй бодлого, шийдвэр гарахад нөлөөлдөг болохыг тэдний бодит амьдралд тулгарч байгаа асуудлын үр дагаврыг хэлэлцэх замаар ойлгуулж болно.


Нөлөөллийн хүрээгээ тэлэх, жин дарах хүчийг бүрдүүлэх;

Иргэд төрөөс авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны гадна үлдэж, хоцрох ёсгүй. Иргэд төлөөлөх эрхээ шилжүүлж таныг сонгосон тул хоорондоо ялгаатай олон бүлэг, хүмүүст хүрч ажиллаж чадах эсэхээс төлөөлөгчийн ажлын амжилт шууд хамаарна.

Эмэгтэй төлөөлөгчийн хувьд иргэдийн дуу хоолой болж, тэдний өмнө тулгамдаж буй асуудлыг дэвшүүлэх, түүнийг шийдвэрлэх, орон нутгийн төсвийг зөв зүйтэй зүйлд зарцуулахад нөлөөлөх нь та бүхний эргэн тойрны хүрээллийн хандлага, итгэл үнэмшил, хүлээн зөвшөөрөл

зэрэг олон хүчин зүйлсээс хамаардаг тул нөлөөллийн хүрээгээ тэлж, жин дарах хүчийг бүрдүүлэхийн төлөө ажиллах хэрэгтэй.

Нийгмийн өөрчлөлтийн төлөө ажиллахдаа нөлөөллийн бүх тойргуудыг хамруулах зайлшгүй шаардлагатай. Өндөр настнууд, залуус, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд зэрэг олон бүлэгт хүрч очихгүйгээр,



Зураг 28. Жин дарах хүч ²⁵

²⁵ SASA! аргачлалын манилцуулга, МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ, 2011 он

тэдний ялгаатай хэрэгцээ, тэдний амьдралд нөлөөлж буй ялгаатай хүчин зүйлсийг мэдэрч чадахгүй.

Нөлөөллийн хүрээгээ тэлэхдээ өөрчлөлтийн давуу талыг чухалчилж үз. Хүмүүсийг албадаж, тулгах нь тэднийг өөрчлөгдөхөд хүргэдэггүй гэдгийг бид сайн мэднэ. Өөрчлөлт нь ээлтэй, ашигтай болохыг харсан тохиолдолд л хүмүүс өөрчлөгддөг. Иймээс ИТХ-д хүйсийн харьцаа тэнцвэртэй байх, аливаа асуудлыг шийдвэрлэхэд төлөөлөгч эмэгтэйчүүд оролцоотой байх нь бодит амьдралд ямар өөрчлөлт авчирч байгааг үлгэрлэн харуулж байж л нөлөөллийн хүрээ тэлнэ.

Таны санаачилга, хийж буй ажлыг олон янзын, хангалттай тооны, хүн, бүлэг, байгууллага дэмжсэн тохиолдолд өөрчлөлт хийх оролдлогууд амжилтанд хүрч чадна. Өөрөөр хэлбэл, тодорхой тулгамдсан асуудлыг шийдэхийн төлөө хамтдаа зүтгэж чадахуйц, нөлөөллийн бүх тойргийн оролцогчдоос бүрдсэн, хангалттай тооны, олон янзын хүн, бүлэг, байгууллага нь шийдвэр гаргахад нөлөөлөх **“жин дарах хүч”** болно.

Таны шийдэхийг хүсч буй тэр асуудлын улмаас шууд буюу шууд бусаар хохирч буй хувь хүн, гэр бүл, найз нөхөд, нийгмийн бүлгүүд болон уг асуудлыг шийдэх үүрэг хүлээсэн төрийн байгууллагууд, мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, мөн хэвлэл мэдээллийнхэн, бодлого тодорхойлогч нарт хүрч чадсанаар жин дарах хүч бүрдэнэ. Энэ нь нэг дор хийгдэхгүй, шат шатаар ахиж явна гэдгийг анхаарна уу.

4.6. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Манлайлал нь үйл явц учраас манлайллаа хэрэгжүүлэх ур чадварт суралцах зайлшгүй шаардлагатай. Ялангуяа хамтын манлайллыг хэрэгжүүлэхэд ахисан түвшний, шинэ ур чадвар шаардагдана.

Иймд энэ гарын авлагад хамтын манлайллаа хэрэгжүүлэхэд шаардагдах дараах ур чадваруудыг төлөөлөгчийн чиг үүрэг, орон нутгийн онцлогт нийцүүлэн, тодорхой жишээтэйгээр дэлгэрэнгүй тайлбарлалаа.

1. Тулгамдсан асуудлыг шинжлэх, шийдлийн боломжит хувилбарыг гаргах
2. Оролцогч талуудыг тодорхойлох, шинжлэх
3. Шийдвэр гаргагчдад нөлөөлөх

4. Бусдыг сэдэлжүүлэх, үйл хэрэгтээ нэгтгэх

Тулгамдсан асуудлыг шинжлэх, шийдлийн боломжит хувилбарыг гаргах чадварыг эзэмшсэнээр нөхцөл байдлыг том зургаар, өргөн хүрээтэй харж, нэг асуудалд олон шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйл байж болохыг ойлгон, гарц, шийдлийг олон хувилбартайгаар гарган хэрэгжүүлж сурна.

Улс төрийн хүрээнд нөхцөл байдлыг тухайн бүтэц, тогтолцоонд эсвэл орон нутагт ил болон далд, үл үзэгдэх эрх мэдлийг хэн, хаана, ямар үндэслэл, шалтгаанаар барьж байгааг ойлгох, улс төрийн шийдвэрүүдийг хаана, хэрхэн гаргадгийг мэдэх, өөрчлөлт бий болгохтой холбоотой хэн, ямар байр суурьтай байгааг тодорхойлох, улмаар тэдэнд нөлөөлөх стратеги тактикаа боловсруулах чадварыг олгоно.

Улс төрийн орчин, нөхцөлийг тодорхойлох, холбоотнуудаа бүрдүүлэх, улмаар тэлэхийн тулд хэнд хандах хэрэгтэйг олж мэдэхэд оролцогч талуудын дүн шинжилгээ болон “Талбар” арга хэрэгслийг ашиглах ур чадварыг мөн олгоно. Ихэнх өөрчлөлтөд улс төр оролцсон байдаг тул тухайн өөрчлөлтийг хэн дэмжиж, хэн эсэргүүцэж байгааг ойлгох нь чухал ач холбогдолтой.

ИТХ-ын төлөөлөгч нь хүмүүст хүрч ажиллах, тэднийг үйл хэрэгтээ татан оруулах, сэдэлжүүлэх шаардлагатай байнга тулгардаг. Манлайлагчийн хувьд өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэхийн тулд хүмүүстэй харилцаа холбоо тогтоох, улмаар тэдний амьдралын туршлагаас үүдэлтэй нийтлэг үнэт зүйлсийг ил гаргах, тэднийг үйлдэл/арга хэмжээнд уриалан сэдэлжүүлэх ур чадварт суралцана.

Эхлээд “Миний түүх” боловсруулж, хүмүүстэй харилцаа холбоо тогтоох ур чадварт суралцана. Дараа нь бусдыг сэдэлжүүлэх ур чадвар буюу “Бидний түүх” боловсруулж сурна. Тэгээд цаашдын стратегиа боловсруулж, өөрчлөлт бий болгох бодитой ажил, алхам хэрэгжүүлэх ур чадвараа дээшлүүлнэ.

Хамтын манлайллыг хэрэгжүүлснээр эмэгтэй төлөөлөгчид нь тулгамдсан асуудлуудыг ул суурьтай шийдвэрлэхэд бодит хувь нэмэр оруулж чаддаг, иргэддээ ойр, итгэл даахуйц хүмүүс гэдгээ харуулах боломжтой болно.

Тавдугаар бүлэг.

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ШИНЭ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЛЭН МАНЛАЙЛЛАА БЭХЖҮҮЛЭХ НЬ

- 5.1. Иргэдийн оролцоог баталгаажуулсан хуулиуд
- 5.2. “4:6 тусгай хэрэгсэл” ба анхаарах асуудлууд
- 5.3. “4:6 тусгай хэрэгсэл”-д суурилсан “4 шатлалт
16 алхамт зөвлөмж”
- 5.4. Бүлгийн дүгнэлт

5.1 ИРГЭДИЙН ОРОЛЦООГ БАТАЛГААЖУУЛСАН ХУУЛИУД

Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах нь ардчиллын тулгуур зарчмуудын нэг. Нийтийн эрх ашигт нийцсэн, удаан хугацаанд тогтвортой хэрэгжиж чадахуйц бодлого шийдвэр гаргахад иргэдийн оролцоо чухал үндэс суурь болдог. Тиймээс энэ зарчмыг Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулж “засгийн бүх эрх ард түмний гарт” хэмээн заасан. Иймд ИТХ-аас гаргахаар боловсруулж буй бодлого, шийдвэрийн талаар сонгогчид, иргэдээс санал шүүмж гаргах, байр сууриа илэрхийлэн оролцох үр дүнтэй арга замын нэг нь иргэдтэйгээ зөвлөлдөх ажиллагаа юм.

Гэхдээ иргэдийн оролцоо нь тасралтгүй үйл явц бөгөөд тодорхой төлөвлөж хэрэгжүүлдэг арга хэмжээ биш юм. Тиймээс иргэдийн оролцоо нь хөгжилд оролцогчдын байр суурь, үзэл бодлыг сонсож, шийдвэр гаргахдаа харгалзан үзэж, хамгийн зохистой нийтийн эрх ашигт нийцэх шийдвэр гаргаж, улмаар олон талуудын оролцоотой хэрэгжүүлэн, хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж дахин сайжруулах цикл/мөчлөг бүхий үйл явц юм.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын хувьд иргэдийн оролцоо нь гүйцэтгэх засаглалын иргэдийн оролцоог хангах асуудлаас мөн чанар, агуулгын хувьд эрс ялгаатай ойлголт гэдгийг онцгойлон ойлгох ёстой юм. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиудад өөрөө өөрийгөө удирдах болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын талаар хуульчилсан байдаг. Үндсэн хуульд заасан “Засгийн эрх мэдэл ард түмний гарт байна” гэсэн заалтыг шууд хэрэгжүүлэх нь баг, хорооны ИНХ, харин төлөөллөөр дамжин хэрэгжих нь УИХ, ИТХ гэдгийг гүнзгий ойлгосон цагт ИТХ иргэдийн оролцоонд суурилсан байгууллага, иргэд сонгогчдоо төлөөлдөг ИТХ-ын төлөөлөгч гэдэг мөн чанараа ойлгох юм. Өөрөөр хэлбэл ИТХ-ын төлөөлөгч та аливаа нам улс төрийн хүчний төлөөлөгч биш, засгийн бүх эрх мэдэл ард түмэнд хадгалагдаж буй эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх итгэл хүлээлгэсэн түмний төлөөлөгч юм. Энэ утгаараа ИТХ нь төлөөллийн байгууллага болдог онцлог шинж чанартай.

НҮБ-ын гишүүн орнууд 2015 онд Тогтвортой хөгжлийн зорилт-2030²⁶ урт хугацааны стратегийн бодлого тодорхойлон, хэрэгжилтийг хангахад хамтын хүчин чармайлт гаргаж байна.

²⁶ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоол

Зөвхөн манай улс төдийгүй дэлхийн бүх улс орон хөгжлөө хамтдаа бий болгохыг зорьж буй энэ цаг үед Монгол Улсад хөгжлийг бий болгохдоо иргэдийн оролцоог хангахыг чармайж, түүнийг нэр төдий бус бодит оролцоо болгохоо баталгаажуулсан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”(2016), “Нийтийн сонсголын тухай хууль”(2016), “Захиргааны ерөнхий хууль”(2017), “Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль”(2017)-иудыг шинээр мөрдөж эхлээд байна. Эдгээр нь нутгийн өөрөө удирдах төлөөллийн байгууллага болох ИТХ-д болон ЗДТГ-т аливаа бодлого шийдвэр гаргахын өмнө болон түүний хэрэгжилтийн үр нөлөөнд үнэлгээ хийхэд иргэдийн санал, байр суурийг сонсож зөвлөлдөх замаар оролцоог хангах харилцааг зохицуулсан ихээхэн ач холбогдолтой хуулиуд юм. *(Хавсралт 1. Иргэдийн оролцоог баталгаажуулсан хуулиудын харьцуулалтыг харна уу.)*

ИТХ-ын төлөөлөгч нь засгийн эрх барих эрхийг иргэдийг төлөөлөн хэрэгжүүлэх онцгой чиг үүрэгтэй. Тийм ч учраас ИТХ нь иргэдийн байгууллага, зарим тохиолдолд иргэний нийгмийн байгууллага гэж нэрлэгдэх ч бий. Иймд ИТХ-ын төлөөлөгч нь улс, орон нутгийн хөгжлөөс хувь хүний хөгжлийг өргөн хүрээнд авч үзэж, сонгогчид, иргэдтэйгээ ойр байж тэдний хүсэл санаа, эрэлт хэрэгцээ, нөхцөл байдлын талаар тогтмол мэдээлэлтэй байх үүрэгтэй. Ийм тохиолдолд л иргэдээ төлөөлж сонгуульт болон төлөөлөгчийн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж чадна. Харин иргэд, сонгогчдоо сонсож, тэдэнтэй зөвлөлдөхгүйгээр, тэдний өмнөөс шийдвэр гаргах нь даацтай бодлого, шийдвэр байж чадахгүй төдийгүй асуудлын мөн чанарын талаар өргөн хүрээний мэдээлэл гарахгүй, олон ургальч үзэл сонсогдохгүй тул шийдлийн цөөн эсвэл цорын ганц хувилбар харах, гаргасан шийдвэр зорилгоо хангаж чадахгүйд хүрэх, хүний эрхийг зөрчих, цөөн хүний эрх ашгийг хангах зэрэг сөрөг нөлөөтэй шийдвэр гарахад хүргэдэг.

МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээний гишүүн байгууллага болох “Хил хязгааргүй алхам” ТББ-аас 2018 онд дээрх дөрвөн хуулийн хэрэгжилтийн талаар 10 аймгийн бүх сумдын ИТХ-ын 920 орчим төлөөлөгчдийг хамруулсан судалгаа хийсэн. Уг судалгаанаас харахад эдгээр хуулийн талаарх ИТХ-ын төлөөлөгчдийн ойлголт мэдлэг, хэрэглээ бий болгох мэдээлэл хандлага хангалтгүй байгаа нь тогтоогдсон ба хуулийг хэрэгжүүлэх арга зүй, удирдамж дутагдалтай байгааг тэмдэглэсэн байсан нь энэ дөрвөн хуулийг дэлгэрүүлэн тайлбарлах, таниулах шаардлагыг бий болгож байна.

ИТХ-ын төлөөлөгчид эдгээр хууль тогтоомжийг хэрэглэх замаар тулгамдаж байгаа тодорхой асуудлаар иргэд сонгогчидтойгоо зөвлөлдөх, талуудын байр суурь, оновчтой шийдэл гарцын талаар өргөн мэдээллээр хангагдах боломжийг олгоно. Энэ нь сонгогч иргэдийн оролцоог бүтээлчээр хангах, тухайн асуудлаар хамгийн сайн мэдээлэл бүхий иргэд, эрдэмтэд, ТББ, судлаачидтай зөвлөлдөх, шийдэхээр зорьсон асуудлаа хамгийн сайнаар шийдвэрлэх боломж олгосон ач холбогдолтой эрх зүйн зохицуулалтууд юм.

Иргэдийн оролцоог баталгаажуулсан эдгээр хууль тогтоомжийг мөрдөж хэрэгжүүлэхгүй бол ИТХ-аас гаргасан аливаа бодлого шийдвэр нь өөрөө илт хууль бус болохыг эдгээр хуульд зааж өгсөн байна. Иймд ИТХ-аар тогтмол хэлэлцэн баталдаг дараах бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжилтийг үнэлэхэд иргэдийн оролцоог хангах 4:6 тусгай хэрэгсэл болсон дээрх хуулиудыг хэрэгжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Энэ нь:

1. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр үнэлж дүгнэхэд
2. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих “Дэд хөтөлбөр”-үүдийн төсөлд санал дүгнэлт гаргах, батлах, хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгөхөд
3. Жил бүрийн “Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд санал дүгнэлт гаргах, батлах, хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгөхөд
4. Жил бүрийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, тайлан”-г хэлэлцэж, дүгнэлт гаргахдаа энд дурдах арга, аргачлалыг боломж болгон ашиглахыг санал болгож байгаа юм.

Иргэдээ сонсох ажиллагааны үндсэн зорилго нь ИТХ-ын хуралдаанаар болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх бодлогын асуудлаар иргэд, байгууллагаас санал, шүүмжлэл, зөвлөмж хүлээн авч, тэдгээрийг нэгтгэн бодлого, шийдвэрийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах, асуудал шийдвэрлэхэд ашиглах явдал юм.

Сонсгол нь иргэдийн нээлттэй цуглаан, хурал, хэлэлцүүлэг биш тул ялгаатай зохион байгуулалт шаарддаг. Сонсох ажиллагаа нь оролцогчид болон зохион байгуулагч тал тодорхой журам, дэгийн дагуу эрэмбэ дараалал, эмх цэгцтэйгээр байр сууриа илэрхийлэх хэлбэрээр явагддаг. Энэ талаар хууль тус бүрт нарийвчлан зааж, УИХ-ын тогтоолоор Нийтийн сонсгол явуулах жишиг журам гаргасан бол Захиргааны ерөнхий хуулиар сонсох ажиллагааг хэрхэн зохион байгуулахыг нарийвчлан хуульчилж заасан байна.

Иргэдийн оролцоог баталгаажуулсан хуулиудын ИТХ-тай холбогдох гол заалтууд:

1. “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-ийн (ХБТТХ) 15-р зүйл. 15.4 болон 15.7 дахь хэсэг; 16-р зүйл.16.2; 16.3; 16.5 дахь хэсэг, 19-р зүйл. 19.2.1 болон 19.2.4 дэх хэсэг;
2. “Нийтийн сонсголын тухай хууль”-ийн (НСТХ) 5-р зүйл. 5.1.1 дэх хэсэг. 6-р зүйл. 6.2.3; 6.2.5;6.2.6 дахь хэсэг;
3. “Захиргааны ерөнхий хууль”-ийн (ЗЕХ) 26-р зүйл. 26.1 болон 26.2 дахь хэсэг;
4. “Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль”-ийн (ЗСАТХ) 6-р зүйл 6.1.2, 6.4 дэх хэсэг;

ИТХ-аас зохион байгуулах боломжтой зургаан төрлийн сонсох ажиллагааг дөрвөн хуулиар баталгаажуулсан ба хэрхэн хэрэглэх тухай харьцуулалтыг Хавсралт 2-оос үзнэ үү.

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль (ХБТТХ)

а. Нээлттэй хэлэлцүүлэг

2. Нийтийн сонсголын тухай хууль (НСТХ)

а. Ерөнхий хяналтын сонсгол

б. Төсвийн хяналтын сонсгол

в. Орон нутгийн сонсгол

3. Захиргааны ерөнхий хууль (ЗЕХ)

а. Сонсох ажиллагаа

4. Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль (ЗСАТХ)

а. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтаар санал асуулга

б. Зөвлөлдөх санал асуулга

5.1.1 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль

2016 оны 1 дүгээр сарын 1-ээс мөрдөж эхэлсэн энэ хуулиар 1) аймаг, нийслэл, сум, дүүргийг хөгжүүлэх хэтийн зорилт; 2) аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр; 3) дэд хөтөлбөр; 4) эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлахдаа иргэдийн оролцоог хангах тухай заалтуудыг тусгаж өгсөн.

Уг хуулиар Монгол Улсын хэмжээнд ердөө 11 төрлийн бодлогын баримт бичиг байхаар зохицуулж өгсөн бөгөөд эдгээр нь ямар нэртэй, ямар хугацаатай, хэн батлах, хэрхэн хяналт үнэлгээ хийх, ямар бодлогын баримт бичгийг баримтлан боловсруулж батлан гаргахыг зааж өгсөн. Энэ хуулийг гарахын өмнө (2016.01.01-ээс өмнө) аймаг, нийслэл, сум,

дүүрэг бүр өөр өөрийн үзэмж, арга барил, хандлагаар янз бүрийн хугацаа, нэртэй бодлогууд батлан гаргаж түүнийгээ тогтмол үнэлдэггүй, төсвийн эх үүсвэргүй, уялдаа муутай байсан. Жишээ нь, Баян-Өлгий аймгийн нэг сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, Дорноговь аймгийн нэг сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр арга зүй, загварын хувьд янз бүрээр боловсрогдож байсан. Мөн нэг аймгийн сум 2021 он хүртэлх мастер төлөвлөгөө, нөгөө сум нь 2020 хүртэлх стратеги төлөвлөгөө гэх мэт нэршил, хугацаа нь өөр өөр байдлаар боловсруулсан бодлогын баримт бичгүүд гарган хэрэгжүүлж байсан. Гэтэл үндэсний хэмжээний бүсчилсэн хөгжлийн бодлого, аймгийнх нь хэтийн зорилго стратегитай уялдаа муутай, зарим тохиолдолд аймаг нь урт хугацааны бодлогоо тодорхойлоогүй байтал сумд нь урт хугацааны бодлого боловсруулсан байх зэрэг янз бүр байсан. Энэ нь тухайн нэгжид ажиллаж байсан удирдлагууд, ИТХ болон ЗДТГ-ын буруу биш юм. Харин төрөөс нэгдсэн зохицуулалт, хууль тогтоомж байхгүй байсантай холбоотой.

Хэдийгээр хууль мөрдөгдөж эхлээд 2 жил болж байгаа ч хуулийг ойлгож хэрэглэх байдал туйлын хангалтгүй байна. Иймд иргэдийн оролцоог баталгаажуулсан хуулиудыг хэрэглэх нь ИТХ-ын төлөөлөгчийн заавал эзэмших чадвар юм.

Уг хуулийн 4-р зүйлд бодлогын баримт бичгүүдийг дараах байдлаар хуульчлан зааж өгсөн ач холбогдолтой юм.

Хүснэгт 5. Бодлогын баримт бичгүүд

	Бодлогын баримт бичгийн нэр	Хугацаа (жилээр)	Уялдуулах баримт бичиг	Үнэлгээ, хяналтын хугацаа	Батлах байгууллага
1	Хөгжлийн үзэл баримтлал	Урт: 15-20		2 жилд хяналт үнэлгээ	УИХ
2	Төрөөс баримтлах бодлого	Дунд: 8-10	Хөгжлийн үзэл баримтлал		ЗГ
3	Бүсчилсэн хөгжлийн бодлого	Дунд: 8-10	Хөгжлийн үзэл баримтлал		ЗГ
4	Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт	Дунд: 8-10	Бүсчилсэн хөгжлийн бодлого	4 жилд хөндлөнгийн үнэлгээ	ИТХ
5	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	Дунд: 4 жил	Хөгжлийн үзэл баримтлал; Бүсчилсэн хөгжлийн бодлого		УИХ
6	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	Дунд: 4 жил	Бүсчилсэн хөгжлийн бодлого; Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт	2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	ИТХ

7	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	Дунд: 4 жил	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр; Үндэсний хөтөлбөр	2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	ЗГ
8	Үндэсний хөтөлбөр	Дунд: 3-5	Төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	Жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийх	ЗГ
9	Дэд хөтөлбөр	Дунд: 3-5	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр; Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт		ИТХ
10	Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	Богино: 1 жил	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр; Үндэсний хөтөлбөр; Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	Жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	УИХ
11	Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	Богино: 1 жил	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр; Дэд хөтөлбөр	Жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	ИТХ

Эндээс харахад ИТХ нь хэд хэдэн төрлийн бодлогын баримт бичгүүдийг батлах, хяналт-шинжилгээ үнэлгээ хийхээр заасан байна. ИТХ-ын төлөөлөгчид үр дүнтэй хяналт-шинжилгээ, үнэлгээ дүгнэлт хийхийн тулд тухайн батлах гэж буй бодлогын баримт бичгийн төсөлд санал дүгнэлт сайтар гаргаж хэлэлцэх мэдлэг, ур чадвартай байх ёстой. ИТХ нэгэнт хэлэлцэн баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх, улмаар үнэлгээ дүгнэлт өгөхийн тулд гүйцэтгэх засаглалын баримталж буй хяналт-шинжилгээний аргачлалд суралцах, түүнийг мэдэх хэрэгтэй.

Үүний тулд төлөөлөгч та бүхэн ИТХ-ын ажлын хороодын зохион байгуулалтаа идэвхжүүлж, хороод өөрсдийн хариуцсан салбарын асуудлаар мэргэшин ажиллах мэдлэг, ур чадварыг эзэмших шаардлагатай байна.

Энэ нь тийм ч хэцүү биш. Төлөөлөх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа шаардагдаж буй мэдлэг, ур чадварыг эзэмших боломжтой. Тухайлбал хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15-р зүйлийн 15.4 болон 15.7 дахь хэсэг; 16-р зүйлийн 16.2; 16.3; 16.5

дахь хэсэг; 19-р зүйлийн 19.2.1 болон 19.2.4 дэх хэсгийн заалтуудыг хэрэгжүүлэх санал санаачилга гарган ажиллах шаардлагатай.

Хүснэгт 6. ИТХ, Төлөөлөгчийн үүрэг, гүйцэтгэх арга зам

Хуулийн заалт	ИТХ, Төлөөлөгчийн үүрэг, гүйцэтгэх ажил, арга зам
Хэзээ: Аливаа бодлого, шийдвэр гаргахын өмнө нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулна.	
Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19-р зүйл. Олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах, нээлттэй хэлэлцүүлэг явуулах бөгөөд хэлэлцүүлэгт а/ хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд; б/ эрдэмтэн судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд; в/ тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд; г/ төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг хөгжлийн бодлогын баримт бичигт тусган боловсруулж, төслийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ.	
15.4. Тухайн шатны ИТХ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ.	ИТХ хэлэлцэн дүгнэнэ гэдэг нь ИТХ нэгдсэн хуралдаан хийнэ гэсэн үг. Тэгэхээр хуралдааны хэлэлцэх асуудлаар төлөөлөгч болон хороод санал, дүгнэлт гаргах үүрэгтэй. Засаг даргын мөрийн хөтөлбөр дунд хугацааны бодлогын баримт бичиг бөгөөд жил бүр Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгалаа олж хэрэгждэг. Иймд Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолын дагуу дүгнэлт гаргана. Үүний өмнө Нийтийн сонсгол зохион байгуулах журмын дагуу Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтийг ИТХ-ын Тэргүүлэгчдэд гаргаж иргэдээс санал авах, хэрэгжилтийн явцыг ил тод нээлттэй мэдээлэх арга хэмжээг зохион байгуулна.
15.7. Нутгийн захиргааны байгууллага Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг ИТХ-д танилцуулж, 2 дугаар сарын 20-ны дотор ЗГХЭГ-т хүргүүлнэ.	
16.2. Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор ИТХ-д өргөн мэдүүлж, тухайн шатны ИТХ батална.	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг 10 сарын 05-аас өмнө ИТХ-д өргөн барьдаг. Үүний дараа 12 сарын 20-нд батлах хүртэлх 2 сарын хугацаанд төлөөлөгчид бие дааж болон хороодоор тус баримт бичигт бодлогын шинжилгээ хийж санал дүгнэлт гаргана. Харин нэмэлтээр ХБТТХ-ийн дагуу ИТХ өөрөө нээлттэй хэлэлцүүлэг хийх болон ЗДТГ-ыг ЗЕХ-ийн дагуу сонсох ажиллагаа зохион байгуулахыг зөвлөж, хэрэгжүүлэхэд хяналт тавьж оролцоно.
16.3. ИТХ эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлт, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэж дүгнэнэ.	Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу хийсэн Ерөнхий, төсвийн хяналтын сонсголын тэмдэглэл, дүгнэлт, ХБТТХ-ийн дагуу хийсэн нээлттэй хэлэлцүүлгийн тэмдэглэл, ЗЕХ-ийн дагуу хийсэн сонсох ажиллагааны тэмдэглэл тайлангуудыг ИТХ-ын төлөөлөгч, хороод авч үзээд, хуралдаанаар хэлэлцэх асуудлын санал дүгнэлт боловсруулж, шийдвэрийн төсөлд санал бэлтгэсэн байна.

16.5. Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ИТХ-д танилцуулж, 2 дугаар сарын 20-ны дотор ЗГХЭГ-т хүргүүлнэ.	Жил бүрийн 2 сарын 20-нд ЗДТГ нь ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолын дагуу хийсэн хяналт-шинжилгээний дүгнэлт тайлангаа танилцуулж ЗГХЭГ-т хүргүүлэх тул ИТХ-ын төлөөлөгчид, хороод дээрх 3 төрлийн хэлэлцүүлгийн санал дүгнэлттэй нийцүүлэн ЗДТГ-ын үнэлгээ бодитой эсэхэд санал дүгнэлт гаргана. Хэрэв ЗДТГ нь ИТХ-ын төлөөлөгчийн болон хороодын санал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг ИТХ санаачлан зохион байгуулах үүрэг хүлээнэ.
--	---

5.1.2 Нийтийн сонсголын тухай хууль

2016 оны 1 дүгээр сарын 1-ээс мөрдөж эхэлсэн энэ хуулиар төрийн шийдвэр гаргах бүхий л шатны байгууллага, албан тушаалтан батлан гаргаж байгаа хууль тогтоомжийн төсөл, хяналтын, төсвийн болон төрийн албан тушаалтныг томилоход иргэдийг мэдээллээр хангах, тэдний санаа бодлыг сонсох эрх зүйн баталгааг бий болгож, хэрэгцээ, шаардлагад нийцсэн шийдвэр гаргах боломж бүрдүүлж өгсөн чухал ач холбогдолтой хууль юм.


“Нийтийн сонсгол” гэж хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг тогтоох, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, түүнчлэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэх, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахын өмнө төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээчээс санал сонсох, мэдээлэл авах үйл ажиллагааг хэлнэ.

Нийтийн сонсгол нь гарах гэж буй бодлого, шийдвэрийн төсөлд иргэдийн санал авах, сонсох төдийгүй тэдгээрийн хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгөх, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, ингэхдээ төсөв санхүүжилтийн зарцуулалттай хамтад нь үнэлэлт өгөх, төрийн бодлого хэрэгжсэнээр орон нутагт үүсэх үр дагаврыг газар дээр нь үзэж хэлэлцэх зорилгоор сонсгол зохион байгуулах өргөн хүрээтэй байна.

Тэрчлэн шийдвэр гаргагч гаргасан шийдвэрийнхээ биелэлтийг хянахдаа тухайн шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний нийтийн удирдах албан тушаалтны үйл ажиллагааг хянах зорилгоор мөн шийдвэр гаргагч сонсгол зохион байгуулж болох ба үүнийг **хяналтын сонсгол** хийх гэнэ.

Нийтийн сонсгол хийх зарыг тараахдаа ИТХ дараах зүйлийг анхаарна:

Товыг олон нийтийн телевиз, радио болон сонсгол зохион байгуулагчийн цахим хуудас, өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сонсгол эхлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө олон нийтэд мэдээлнэ. Сонсголын үйл явцад үр бүтээлтэй оролцох боломж нээх үүднээс иргэдэд сонсголын зар, мэдэгдэл, урилгад сонсгол болох огноо, цаг, байрлалыг тодорхой дурдах хэрэгтэй. Түүнчлэн оролцогчдыг хэрхэн бүртгэх, бүртгэл дуусах хугацаа, сонсгол хийх асуудал буюу шийдвэрийн төсөл, үндэслэл, сонсголын журам, дэг, бусад шаардлагатай мэдээллийг хавсаргах, эсвэл хаанаас олж үзэх боломжтойг тодорхой дурдсан байх шаардлагатай.



Зураг 29. Сонсгол явуулах үйл явц ба дараалал

Төлөөллийн байгууллагад хамаарах сонсголын төрөл, зохион байгуулах тохиолдол

Хүснэгт 7. Сонсголын төрлүүд

Сонсголын төрөл	Зохион байгуулах тохиолдол	Хэзээ зохион байгуулах	Тайлбар
Хэзээ: Аливаа бодлого, шийдвэр гаргахын өмнө болон дараа нь буюу хэрэгжилтийн явцад, түүний үр нөлөөг дүгнэхэд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулна.			
Ерөнхий хяналтын сонсгол	Заавал зохион байгуулах тохиолдол: ИТХ-ын дөрөвний нэгээс доошгүй төлөөлөгч хүсэлт гаргасан бол; Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй иргэн, хуулийн этгээдийн ³ гаргасан хүсэлтийг ИТХ-ын тэргүүлэгчид хэлэлцэн хүлээн авсан бол;	Тухай бүрт	ИТХ-ын дөрөвний нэгээс доошгүй төлөөлөгчид эсвэл 4 хүртэл хороотой бол нэг хороо хүсэлт гаргаж ЗД-ын мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дэд хөтөлбөрийн хэрэгжилтээр төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулах хүсэлтийг ИТХ-ын тэргүүлэгчдэд гаргах замаар сонсгол хийх боломжтой.
Төсвийн хяналтын сонсгол	ИТХ болон ЗДТГ зохион байгуулна. -Орон нутгийн төсөв -Орон нутгийн хөгжлийн сан -Төсөл хөтөлбөр -Орон нутаг баталгаа гаргаж өр авлага үүсэх асуудлаар	Жил бүр заавал	
Захиргааны хэм хэмжээний болон төлөвлөлтийн сонсгол	Захиргааны хэм хэмжээний актыг батлах, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргахын өмнө зохион байгуулна.	ЗЕХ-д заасан	Захиргааны ерөнхий хуулиар зохицуулсан бөгөөд тус хуулийн сонсох ажиллагаа юм.
Орон нутгийн сонсгол	Тухайн орон нутагт үүссэн асуудалтай холбоотой газар нутагт УИХ, ЗГ-аас зохион байгуулах сонсгол. Тухайн ИТХ нь УИХ-ын холбогдох байнгын хороонд хүсэлт гаргаж, байнгын хороо шийдвэр гаргасан бол зохион байгуулна.	Хүсэлт гаргасан тохиолдол бүрт	ИТХ өөрөө эсвэл тухайн үүссэн асуудалд хамаарах хороо зохион байгуулах замаар албан хүсэлтийн үндэслэлээ гаргаж дэмжүүлэн УИХ-ын хороонд хүргэх замаар зохион байгуулж болно.

Ерөнхий болон төсвийн хяналтын сонсгол явуулах журмыг УИХ-ын 2017 оны 12 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу зохион байгуулна. (Хавсралт 3: Нийтийн сонсгол зохион байгуулах журмыг үзнэ үү.)

Нийтийн сонсголын тухай хуульд заасан орон нутгийн сонсгол явуулах тухай хүсэлт гаргахдаа Төв аймгийн Заамар сумын ИТХ-аас УИХ-ын Өргөдлийн байнгын хороонд илгээсэн албан хүсэлтийг жишээ, загвар болгон ашиглаарай. (Хавсралт 4: Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу Орон нутгийн сонсгол явуулах ИТХ-ын хүсэлтийн жишээг үзнэ үү.)

5.1.3 Захиргааны ерөнхий хууль

2017 оны 7 дугаар сарын 1-ээс мөрдөж эхэлсэн энэ хууль нь нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлсэн.

Уг хуулийн 5.1.5-д бүх шатны ИТХ нь захиргааны байгууллага²⁷ бөгөөд ИТХ-ын тогтоолоор байгуулсан ажлын хэсэг²⁸ ч мөн захиргааны байгууллага болно гэдгийг заасан байна. Захиргааны байгууллагаас буюу ИТХ түүний байгуулсан ажлын хэсгээс гаргасан аливаа шийдвэр нь захиргааны үйл ажиллагаа болно. Тус хуулийн 11-р зүйлд Захиргааны үйл ажиллагааг а/ захиргааны акт; б/ захиргааны гэрээ; в/ захиргааны хэм хэмжээний актын 3 хэлбэртэй байхаар заажээ. Бидний ярьж заншсан ойлголт болох ИТХ-ын тогтоолууд, нийтээр дагаж мөрдөх журам, бусад этгээдтэй байгуулдаг гэрээ, ЗД-ын талуудтай байгуулах гэрээг батлах үйл ажиллагаа зэрэг нь ЗЕХ-иар захиргааны үйл ажиллагаа болсон гэж ойлгоно.

Хүснэгт 8. Захиргааны үйл ажиллагааны төрлүүд

Захиргааны үйл ажиллагааны төрөл	Тайлбар
Захиргааны акт	Захиргааны байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.

²⁷ Захиргааны ерөнхий хуулийн 5-р зүйлийн 5.1.5.нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага

²⁸ Захиргааны ерөнхий хуулийн 5-р зүйлийн 5.2.Захиргааны байгууллага байнгын бус, нэг удаагийн шинжтэй асуудлыг шийдвэрлэж зохицуулахаар байгуулагдаж болох бөгөөд татан буугдсан тохиолдолд түүнийг байгуулсан, томилсон эрх бүхий этгээд эрх зүйн үр дагаврыг хариуцна.

Захиргааны гэрээ	Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, эсхүл дуусгавар болгохоор захиргааны гэрээг эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгуулж болно. 52.2.Дараах харилцаанд захиргааны гэрээг хэрэглэж болно: 52.2.1.төрийн алба, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах болон бусад захиргааны эрх зүйн харилцаанд; 52.2.2.захиргааны байгууллага өөрийн зарим чиг үүрэг, эрх мэдлийг бусад этгээдэд шилжүүлэх харилцаанд; 52.2.3.дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг бий болгох, тогтвортой ашиглахтай холбогдсон харилцаанд; 52.2.4.концессын харилцаанд; 52.25.хуульд өөрөөр заасан бусад харилцаанд
Захиргааны хэм хэмжээний акт	59.1.Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно. 59.2.Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд захиргааны хэм хэмжээний акт гаргах эрхээ бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

ИТХ-ын үндсэн чиг үүргийн нэг нь өөрийн нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах, тэр нь тухайн нутаг дэвсгэртээ заавал мөрдөгдөхөөр журамласан байдаг. Харин Захиргааны ерөнхий хуулиар ИТХ-аас нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан шийдвэр нь гадагшаа чиглэсэн захиргааны хэм хэмжээний акт болохыг заажээ. Энэ нь нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан, эрх зүйн үр дагавар бүхий болгосон шинжийг хадгалах тул захиргааны үйл ажиллагаа болно.



Зураг 30. Захиргааны хэм хэмжээний акт гаргах үйл явц

ИТХ-аас гаргах тогтоол шийдвэр, нийтээр дагаж мөрдөх журам нь захиргааны үйл ажиллагаа болох тул шийдвэр гаргахын өмнө **сонсох ажиллагаа, хэлэлцүүлэг** явуулна. (Хавсралт 5. Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулах зарын жишээг үзнэ үү)

Сонсох ажиллагаа гэж захиргааны акт, захиргааны гэрээг батлан

гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгож оролцогчоос тайлбар, санал авах ажиллагааг хэлнэ²⁹.

Захиргааны шийдвэр гаргах захиргааны байгууллага эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлохоор заасан. Сонсох ажиллагааг дараах арга хэлбэрээр явуулна. Үүнд:

- о сонсгол зохион байгуулах;
- о саналыг бичгээр авах;
- о биечлэн уулзах;
- о утсаар санал авах;
- о цахим хэлбэрээр санал авах;
- о төлөөлөгчөөр дамжуулж санал авах;
- о бусад гэсэн хэлбэртэй байна.

Хэлэлцүүлэг зохион байгуулах ажиллагааг нийтийн ашиг сонирхол, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын төсөлд нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцох боломжоор хангах бөгөөд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг заавал хийнэ.

Хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр зохион байгуулж болно:

- о уулзалт, ярилцлага;
- о өдөр тутмын сонин хэвлэлд төслийг нийтэлж санал авах
- о цахим хуудас, харилцаа холбооны хэрэгслээр санал авах
- о бусад хэлбэрээр

Хэлэлцүүлгийн явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж, гарсан саналыг захиргааны хэм хэмжээний актын төсөлд хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэж танилцуулна.

Сонсох ажиллагаа, хэлэлцүүлэг явуулах загваруудыг хавсралт 6-аас үзнэ үү.

5.1.4 Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль

2017 оны 3 дугаар сарын 12-оос мөрдөж эхэлсэн энэ хууль нь нийтийн эрх зүйн хүрээнд зөвлөлдөх санал асуулгыг энэ хуульд

²⁹ ЗЕХ-ийн 26-р зүйлийн 26.1-26.2 дахь хэсэг

заасан асуудлаар зохион байгуулж төрийн үйл хэрэгт зөвлөлдөх арга хэлбэрээр иргэдийн оролцоог хангахад оршино.

Зөвлөлдөх санал асуулга гэдэг нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахын өмнө болон түүнийг хэрэгжүүлж, сахин мөрдөж байгаа байдлын талаар тохиолдлын зарчмаар түүвэрлэн сонгосон иргэдээс тусгай бэлтгэсэн асуултаар санал авах замаар иргэдийг төрийн үйл хэрэгт оролцуулах цогц үйл ажиллагааг хэлнэ.

Зөвлөлдөх санал асуулгыг дараах үндсэн зорилгоор зохион байгуулна:

- о Нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатай олж илрүүлэх;
- о Тухайн асуудлын эрэмбэ, түүнийг шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх;
- о Иргэд, олон нийтэд тулгамдсан асуудлын талаар мэдлэг, мэдээлэл өгөх;
- о Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд заасан төрийн үйл хэрэгт оролцох иргэдийн оролцоог хангах зорилгоор зохион байгуулна.

Зөвлөлдөх санал асуулгыг дараах **гурван** тохиолдолд **заавал** зохион байгуулна. Зөвлөлдөх санал асуулгыг улсын хэмжээнд, эсхүл засаг захиргааны тодорхой нэгжийн хэмжээнд зохион байгуулна.

Хүснэгт 9. Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах

Зохион байгуулах байгууллага	Зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах тохиолдол
Бүх шатны ИТХ	Орон нутгийг хөгжүүлэх сангаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тогтооход заавал зохион байгуулна.
6.3.Шийдвэр гаргах эрх бүхий этгээд энэ хуулийн заавал зохион байгуулахаар зааснаас бусад асуудлаар зөвлөлдөх санал асуулгыг санаачлан явуулж болно.	ИТХ-ыг энэ хуульд зааснаар “Шийдвэр гаргах эрх бүхий этгээд” гэжээ. Тэгэхээр эмэгтэй төлөөлөгч та нийтийн эрх ашигтай холбоотой тодорхой асуудлаар зөвлөлдөх санал асуулга санаачлан явуулах боломжтой. Энэ нь иргэд, сонгогчидтойгоо ойртох тодорхой асуудлыг анхаарлын төвд хүргэх боломжийг олгож байна.

6.4.Нийтийн ашиг сонирхолд хамааралтай тодорхой асуудлаар зөвлөлдөх санал асуулга явуулах талаар нийслэлийн хэмжээнд 500-аас дээш, дүүрэгт 300-аас дээш, аймагт 100-аас дээш, суманд 50-иас дээш тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугч иргэдийн гаргасан санал, хүсэлтийг шийдвэр гаргах эрх бүхий этгээд хэлэлцэн шийдвэрлэх үүрэгтэй.	Өөрийн тойргийн эсвэл нутаг дэвсгэрийн нийтийн эрх ашигтай холбоотой шийгдэхгүй байгаа асуудлаар иргэдээр санал хүсэлт гаргуулах замаар тодорхой асуудлыг шийдэх, анхаарлын төвд асуудлыг хүргэх замаар төлөөллөө хэрэгжүүлэх боломжтой.
--	--

5.2 “ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ 4:6” БА АНХААРАХ АСУУДЛУУД

ИТХ нь хөгжлийн бодлого боловсруулж, баталдаг, түүний хэрэгжилтэд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх, улмаар дүгнэлт хийх, тайлагнаж мэдээлэх үүргийг хэрэгжүүлдэг иргэдийн төлөөллийн байгууллага. Иймд хуралдаанаараа хэлэлцэн батлах бодлого, шийдвэрийн төсөлд иргэд, сонгогчдоосоо саналыг нь заавал авч тусгадаг байх үүрэгтэй.

ИТХ түүний төлөөлөгчид, хороод нь ардчилсан зарчмын дагуу ил тод, нээлттэй, иргэдээ сонсож ажиллаж чадахгүй, тийм хүсэлгүй бол төлөөллийн чиг үүргээ хариуцлагатай биелүүлж байна гэж үзэх боломжгүй. Ялангуяа, энэ нь НӨУБ-д хамгийн илүү хамааралтай. Учир нь аливаа хэлэлцэх асуудал нь олон нийтийн амьдралаас урган гарсан, иргэдэд хамгийн ойр байж тэдний төлөө үйлчилдэг байх явдал бөгөөд бодлого, шийдвэр гаргахад ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэдийг заавал сонсох ёстой.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн олон нийтийн хэлэлцүүлэг нь бодлого шийдвэр гаргахын өмнө зохион байгуулагдах ёстой.

Зөвлөмж 1.

Энэ хуулийн 19-р зүйлийн 19.2 дахь хэсэгт зааснаар хэлэлцүүлэг явуулж **БОЛНО** гэж заасан байгааг анхаарах хэрэгтэй. Олон нийтийн хэлэлцүүлэг явуулахгүй байж бас болох хэдий ч аль болох ИТХ нь гүйцэтгэх засаглалд энэ хуулийн хэрэгжилтийг хангахыг шаардаж, зөвлөж байх хэрэгтэй бөгөөд тус хэлэлцүүлэгт та ИТХ төлөөлөгчийн хувиар оролцож, хамтран зохион байгуулж ажиллах хэрэгтэй. **Болно** гэсэн нь ИТХ болон төлөөлөгчид хүсэлт санал гаргахад Засаг дарга татгалзах эрхгүй, сонсгол зохион байгуулах үүрэгтэй гэсэн ойлголт юм.

Зөвлөмж 2.

Энэ хуулийн 19-р зүйлийн 19.1 дэх хэсэгт зааснаар үндэсний болон аймаг, нийслэлийн хөгжлийн бодлогод олон нийтийн оролцоог хангахаар зааж, харин сум, дүүрэгт энэ хуулийн заалтыг **баримтлахааргүй заасан** байгааг анхаарах хэрэгтэй.

Нийслэлийн нэгэн дүүргийн ИТХ-аас 19.1 дэх хэсэгт заасны дагуу “2018 онд Дүүргийн Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл”-өөр нээлттэй хэлэлцүүлэг явуулахыг шаардахад ЗДТГ нь тус хуулийн 19-р зүйлийн 19.1 дэх хэсэгт сум, дүүрэг гэж заагаагүй тул нээлттэй хэлэлцүүлэг явуулах боломжгүй гэсэн хариу өгч нээлттэй хэлэлцүүлэг хийж чадаагүй байна.

Ийм тохиолдолд ИТХ юу хийж болох вэ?

Захиргааны ерөнхий хуулийн 5-р зүйлийн 5.1.5 дахь хэсэгт нутгийн өөрөө удирдах байгууллага нь захиргааны байгууллага болохыг заасан тул мөн хуулийн 24-р зүйлд заасны дагуу сонсох ажиллагаа явуулах, 62 дугаар зүйлд хэлэлцүүлэг зохион байгуулах чиг үүргийг ЗДТГ-т өгч иргэд, эрх ашиг нь хөндөгдөж болох иргэд байгууллагын саналыг авах **боломжтой** юм. **Сонсох, хэлэлцүүлэг хийж санал авах ажиллагааг** аливаа **шийдвэр гаргахын өмнө** зохион байгуулна.

Зөвлөмж 3.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19-р зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан хэлэлцүүлгээс ялгаатай нь ЗЕХ-иар заасан **сонсох ажиллагааг заавал** явуулна. Ингэхдээ эхлээд тухайн бодлого шийдвэр гарснаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлсон байх бөгөөд тэдгээрийг заавал сонсох ажиллагаанд оролцуулна гэж зааснаараа онцлог ялгаатай юм. Дээрх хоёр хуульд зааснаар ИТХ нь аливаа бодлого шийдвэр батлахын өмнө иргэдээс тэр дундаа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдүүдээс бодлого шийдвэрийн төслийн талаар асуух, үзэл бодол байр суурийг сонсох, улмаар түүнд харгалзан эцсийн шийдвэр гаргах үүрэгтэйг заасан.

Харин аймаг, нийслэлийн түвшинд гүйцэтгэх засаглал буюу ЗДТГ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг баримтлан зохион байгуулах, ИТХ нь түүний тэмдэглэл, дүгнэлттэй танилцах замаар иргэдийн санал, байр суурийг шийдвэрт туссан эсэхийг харах **боломжтой** юм.

Зөвлөмж 4.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15-р зүйл. 15.4 дэх хэсэгт ИТХ нь Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр хэлэлцэн дүгнэлт гаргана гэсэн бол 16-р зүйл. 16.3 дахь хэсэгт ИТХ нь тухайн жилийн “Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг хэлэлцэн дүгнэлт гаргана гэж заажээ.

Хэрэв сум, дүүргийн хувьд ЗДТГ нь энэ хуульд заасан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах эрх зүйн үндэс байхгүй гэсэн тайлбар хийсэн тохиолдолд ИТХ нь бодитой үнэлэлт дүгнэлт өгөх, хэлэлцэх асуудлаар санал дүгнэлт гаргахын тулд **нээлттэй хэлэлцүүлэг эсвэл сонсох ажиллагаа зохион байгуулах санал гаргаж** иргэд, сонсгогчдоо сонсож, тэднээр үнэлгээ дүгнэлт гаргуулах сонсгол зохион байгуулах **боломжтой** юм.

Сум, дүүргийн хувьд ИТХ өөрөө захиргааны байгууллага болохын хувьд Захиргааны ерөнхий хуулийг баримтлан Сонсох ажиллагаа явуулах **боломжтой**.

Зөвлөмж 5.

ИТХ нь Үндсэн хуулийн 62-р зүйл. 62.1. НӨУБ тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний **эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэнэ**. 63-р зүйл. 63.2. Хурлын тогтоол нь харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тухайн **нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө** гэж заасан. Иймд ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэх аливаа бодлого, шийдвэрийг хэлэлцэхийн өмнө заавал иргэд, сонсгогчдын саналыг авах, хэлэлцүүлэг, сонсох ажиллагаа явуулах журам гаргаж мөрдүүлэх хүртэл **боломжтой**.

Шигтгээ 16. Сонсох ажиллагаа явуулах талаар журам гаргахад анхаарах зүйл

ЗЕХ-ийн сонсох ажиллагаа явуулах асуудлаар журам гаргана гэсэн тусгайлсан заалт тус хуульд байхгүй. Энэ нь олборлох салбарт орон нутагт үүсч буй харилцааг зохицуулсан захиргааны гэрээ байгуулахад зайлшгүй журамлах шаардлагыг үүсгэж байна. ИТХ-аас гаргасан журмыг заавал хууль зүйн мэдээллийн санд бүртгүүлэх тухай заалт бий. Иймд баримт бичгийн дагалдах хуудас, хувийн хэргийг бүрдүүлж Хуулийн мэдээллийн санд бүртгүүлэх эсвэл зөвхөн ЗДТГ-г гэрээ байгуулахдаа баримтлах дотооддоо чиглэсэн журам болгож мөрдөх 2 боломж байгааг анхаарах хэрэгтэй. Дорноговь аймгийн Айраг сумын ИТХ-аас “Олборлох салбарт гэрээ

байгуулахад сонсох ажиллагаа явуулах журам” батлан мөрдөж эхлээд байна. Энэ нь аймгийн Засаг дарга компаниудтай 2 талт гэрээ шууд байгуулж байгаа тохиолдолд зайлшгүй сумын иргэдийг сонсох ажиллагаа явуулах, мөрдөх журам болж байгаа сайн талтай.

Одоогийн байдлаар ИТХ, түүний төлөөлөгчид, хороод, тэргүүлэгчид эдгээр хуулиар өгөгдсөн чиг үүргийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхгүй³⁰, нөгөө талаар эрх зүйн дээрх боломжуудыг ашиглаж иргэддээ хүрч, сонгогчиддоо очих боломж гэж харахгүй байна.

ИТХ-ын төлөөлөгч та хуралдаа аль нэг хорооны гишүүнээр ажиллаж байгаа. ИТХ-ын хороод нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэж боловсруулах, санал дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулахаар хороод ажиллах үүрэгтэй. ИТХ-ын төлөөлөгч та нутаг дэвсгэрийн хэмжээнд тулгамдаж байгаа шийдэл хүлээсэн нийгэм, эдийн засаг, байгаль орчны (тогтвортой хөгжлийн) асуудлыг шийдэхийн тулд иргэд сонгогчдоо, мэдлэг мэдээлэл бүхий талууд, шинжээч/экспертүүдийг сонсох замаар тэдний дэмжлэгтэйгээр асуудлыг үр дүнтэй шийдэх олон боломжуудыг ашиглах шаардлагатай.

Шигтгээ 17. Хуулийг ашиглан лицензийг цуцлах шийдвэр гаргуулсан туршлага

Төв аймгийн Заамар суманд сум, аймгийн оролцоогүйгээр 280 га газрыг Ашигт малтмал, газрын тосны газраас олгосон. Иймд ИТХ-аас Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу Заамар суманд ирж, орон нутгийн сонсгол явуулах хүсэлтийг УИХ-ын Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороо, Өргөдлийн байнгын хороонд илгээж байсан. Заамар сумын ИТХ-ын энэ хуулийг хэрэглэсэн нөлөөлөл, иргэний нийгмийн хөдөлгөөний үйл ажиллагааны үр дүнд тус лицензийг цуцлах шийдвэрийг гаргуулаад байна.

Эдгээр хууль нь шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах төдийгүй ИТХ-ын төлөөлөгчид, улс төрчдөд, нийгмийн амьдралд илүү орж бодит мэдээлэл авах, бодлогын шийдлийн олон хувилбар сонсох боломжуудыг олгосон төдийгүй гаргасан шийдвэрийн

³⁰ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, 8-р зүйлийн 1 дэх заалт: "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална".

хэрэгжилт, үр нөлөөг үнэлж дүгнэхэд ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл зөвхөн иргэдийн оролцоог шийдвэр гаргахад хангахын төлөө биш харин эмэгтэй төлөөлөгчдөд тодорхой асуудал хариуцаад нийгмийн дэмжлэг авах, хүлээн зөвшөөрөгдөх хүртэл нөлөөллөө тэлж манлайллаа бэхжүүлэх боломжуудыг танилцууллаа.

5.3 “4 : 6 тусгай хэрэгсэл” –д суурилсан “4 шатлалт 16 алхамт зөвлөмж”

ИТХ-ын төлөөлөгч та энэхүү сэдвийн агуулгатай танилцсаны дараа сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд төлөөлөгчийн чиг үүрэг, манлайллаа хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүд хэрэгжүүлэхээр шийдсэн бол **“4 шатлалт 16 алхамт зөвлөмж”**-ийг санал болгоё. Цаашид **“4:16”** гэж нэрлэж занших нь зүйтэй байж болох юм.

Энэхүү зөвлөмжийг яагаад анхаарах ёстой вэ?

Монгол улс 1992 оноос хойш дөрвөн удаагийн улс төрийн сонгууль явуулжээ. Энэ нь төлөөллийн байгууллагаараа дамжуулан ард түмэн засгийн эрх барих эрх мэдлээ тав дах удаагаа хэн нэгэнд итгэл өгч төлөөллөө сонгоод байна гэсэн үг. Гэтэл ИТХ-ын төлөөлөгч нь иргэд, сонгогчдын эрхийг төлөөлж буй гэхээсээ илүүтэйгээр намын төлөөлөл гэж буруу ташаа ойлгон, сонгуульт ажилдаа хайнга хандаж ирсэн бодит гажуудлыг бид хүлээн зөвшөөрөх учиртай. 14 аймгийн 60 гаруй сумын ИТХ-ын төлөөлөгчдөөс тойрогтоо ажиллах төлөвлөгөө, сонгогчдын хавтас бүхий баримт бичгийн сантай юу? гэхэд тун цөөхөн эмэгтэй төлөөлөгч л байгаа гэж байсан. Гэхдээ үүний ихэнх нь зөвхөн хуралдааны тэмдэглэл материалуудаас бүрдсэн байдаг талаар хариулж байсан.

ИТХ-д нэг намын төлөөлөгчид хэт давамгай олноор сонгогдсон эсвэл сөрөг хүчин болсон, бие даагч цөөнх байгаа ИТХ-ын хуралдааны хэлэлцэх асуудалд төлөөлөгч хувь хүний үүднээс, сонгогдсон тойргийн эрх ашгийн үүднээс санал, дүгнэлтээ илэрхийлэхэд бэрхшээл, дарамттай мөн хүч муутай, зөвшөөрөгдөхгүй байх нь элбэг байдаг.

Ийм тохиолдолд “4:6 тусгай хэрэгсэл”-ийг хэрэглэсний үр дүн нь төлөөлөгч **Танд** иргэдийн дүгнэлт, иргэдийн гаргасан саналд үндэслэн төлөөлөгчийн хувийн байр сууриа илэрхийлэх, энэ нь үндэслэлтэй, хүчтэй байх боломжийг олгоно.

Энэ “4 шатлалт 16 алхамт зөвлөмж” нь бүрэн эрхийн хугацаандаа төлөөлөгч та ганцаараа биш бусад төлөөлөгчид, оролцогч талуудын

хүч дэмжлэгийг авах замаар одоогийн сонгуульт ажлаа илүү үр дүнтэй хэрэгжүүлэх, ИТХ-ын төлөөлөгчөөр дахин сонгогдох, 2020, 2024 онд эмэгтэй төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх замаар шийдвэр гаргах түвшинд хүйсийн тэгш байдлыг хангах, мөн түүнчлэн мэдлэг, туршлага, чадвартай олон эмэгтэйчүүдийг сонгогдоход нь хувь нэмрээ оруулахад ач холбогдол, үр нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Нэг. ИТХ-ын Төлөөлөгч та өөрийн чиг үүргээ тодорхойлно уу.

1. *Та өөрөө ИТХ-ын аль хороонд харьяалагдаж байна вэ?* Танай хороонд жил, улирлын үйл ажиллагааны төлөвлөгөө байгаа юу? Түүнийг хэрэгжүүлэхэд та хэрхэн оролцож байна вэ? Танай тойрогтой холбоотой ямар ямар асуудлууд тусгагдсан бэ? Энэ талаар та дүгнэлт хийнэ үү?
2. *Таны тойрогт хэдэн өрх айл, ААН, бизнесийн үйл ажиллагаа явагдаж байна вэ?* Тойргийн тань хүн амын хэд нь тааруу нөхцөлд амьдарч байна вэ? Тэдэнд ямар бэрхшээлтэй асуудлууд байна вэ? Энэ нь Төлөөлөгч танаас ямар үйлдэл хийхийг шаардаж байна? Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, ажилгүй иргэд, ядуу өрх хэд байна вэ? Энэ тоо өнгөрсөн 4 жилээс өссөн буурсан эсэх, танай тойрогт ямар давуу тал боломжууд байна вэ? Танай тойргийн иргэдийн эдийн засгийн гол эх үүсвэр юу вэ? Түүнийг хэрхэн хөгжүүлэх боломжтой вэ? Эрсдэл бэрхшээл байна уу? Иргэдийн дунд түншлэл нөхөрлөл байна уу? Байхгүй бол ямар чиглэлээр зохион байгуулагдах боломжтой вэ? гэх зэрэг олон талын судалгаа дүгнэлтүүд гаргаж “алган дээрээ” тавьж харна уу? Ингээд та Төлөөлөгчийн хувьд юу хийх ёстой, хэнтэй хамтрах, ИТХ-д ямар асуудал оруулах зэрэг төлөвлөгөөний төсөл гаргаж цаасан дээр буулгана уу.
3. *Нийт сонгогчдын нарийвчилсан дэлгэрэнгүй судалгааг Засаг даргын Тамгын газраас авна уу?* Та судалгааны материалууд хийх хавтас нээнэ үү. Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, байгаль орчны төлөв байдлын судалгааг Засгийн газраас хөрөнгө хүч гаргаж 2 жил тутамд хийдэг бөгөөд танай сум, тойргийн мэдээлэл ЗДТГ-т бүрэн байгаа. Зарим мэдээллийг www.1212.mn цахим сайтаас авч болно.
4. *Танай тойрогт, баг хороо, нутаг дэвсгэрт хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн өмнө тулгамдаж байгаа, нийтийн ашиг сонирхлыг хөндөж байгаа ямар асуудлууд байна вэ?* Өөрийн

тойрогт бий болоод буй шийдэл, зохион байгуулалт шаардаж буй асуудлуудын талаар төрөлжүүлсэн жагсаалт гаргаж, эдгээр асуудлыг эрэмбэлж нэн түрүүнд шийдэх асуудлаа хамгийн эхэнд жагсаан бичнэ үү? Ингэж төрөлжүүлэн жагсаахдаа: а) **нийгмийн асуудал:** ядуурал, ажлын байр, эрүүл мэнд, боловсрол, архидалт, мал аж ахуй болон тусгайлан анхаарах ёстой нийгмийн бүлгүүд болох хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчид, ахмад, эмэгтэйчүүд тэднийг үл хайхрах, гэр бүлийн хүчирхийлэл гэх мэт б) **эдийн засгийн асуудал:** уул уурхай түүнээс үүссэн үр дагавар, жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, малын түүхий эд, ажилгүйдэл, өргөн хэрэглээний бараа болон тээврийн үйлчилгээний чанар үнэ, хууль бус орлогын эх үүсвэр болох малын хулгай, бичил уурхай гэх мэт в) **хүрээлэн буй орчны асуудал:** агаарын бохирдол, хог хаягдал, гол булаг шандын хамгаалал, уул уурхайн нөхөн сэргээлт, хуулийн хэрэгжилт, бэлчээрийн даац, хадлан отрын талбай, хилийн цэсийн маргаан, газар өмчлөл болон эзэмшил гэх мэтээр төрөлжүүлж хараарай.

Хоёр. Бодлогын баримт бичгийн судалгаа хийнэ үү.

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийнхээ Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөртэй сайтар танилцаж дээрх шийдэл хүлээсэн асуудлуудыг шийдэх зорилтууд байгаа эсэхийг харна уу.
2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд дээрх асуудлууд хэрхэн тусгагдсан, хэрэгжилт ямар үнэлгээтэй байгааг харна уу.
3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд гарсан Дэд хөтөлбөрүүд байна уу.
4. Эдгээр баримт бичгүүдээс та дараах дүгнэлт хийх шаардлагатай.
 - о Тойргийн болон нутаг дэвсгэрийн хэмжээнд тулгамдаж байгаа, ИТХ-аас шийдэл, зохицуулалт хүлээсэн асуудлууд бодлогын баримт бичигт хэрхэн тусгагдсан болон тэдгээрийн хэрэгжилт ямар байгаа, Засаг дарга, ИТХ эдгээр асуудлуудад хэр их анхаарал хандуулж ажиллаж байна вэ?
 - о Бодлогын баримт бичгүүдэд огт тусгагдаагүй орхигдсон эсвэл дутуу тусгагдсан ямар ямар асуудлууд байна вэ? Үүнээс үүдэн байгаль орчин, нийгэм, эдийн засагт ямар үр дагавар нөлөө үүсээд байгааг тодорхойлон дүгнэлт хийгээрэй.

Гурав. Хэлэлцэх асуудлын төсөл боловсруулж, шийдлийн хувилбарууд гаргана уу.

1. Тухайн асуудал нь ИТХ-аар хэлэлцэж шийдвэр гаргах асуудал мөн үү? Хэрэв энэ нь ИТХ-ын бүрэн эрхэд хамаарахгүй асуудал бол орон нутгийн гүйцэтгэх засаглал буюу Засаг даргад үүрэг даалгавар өгч болно. Харин ИТХ-аас шийдэл хүлээсэн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн баримт бичигт тусгах асуудал мөн эсэхийг сайтар ялгаж хараарай.
2. ИТХ-ын чиг үүрэгт хамаарах асуудлуудаа ИТХ-ын холбогдох хороодод хүргэх. Ингэхдээ Төлөөлөгч та өөрийн үнэт зүйл, мэргэжил туршлагад үндэслэн өөрийн барьж ажиллах асуудлыг сонгож авбал илүү сайн. Тухайн асуудал тань харин нийтийн эрх ашигтай холбогдох асуудал байх хэрэгтэй. Ингээд тухайн асуудлаараа нэмэлт судалгаа хийж Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулиудад заасан сонсох ажиллагаануудыг хийх санал санаачилгыг идэвхийлэн гаргаарай. Та зөвхөн асуудал барьж ав, санаачилга гарга, уриалахад болно. Учир нь танд хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн “эрх бүхий зам” байна, дэмжигч оролцогч талуудыг хуулиар үүрэгжүүлсэн байгаа.
3. Тухайн сонгосон асуудал тань бодлогын баримт бичигт тусгагдан хэрэгжиж байгаа бол Нийтийн сонсголын тухай хуулиар **ерөнхий хяналтын сонсгол** явуулж асуудал шийдэгдэхгүй байгаа учир шалтгаан, бэрхшээл, дутагдаж байгаа нөөц, үүрэг хүлээгч талуудын хариуцлагыг харах боломжийг олгох ач холбогдолтой. Үүний дараа бодлогын баримт бичигт асуудлыг хэрхэн сайжруулан тусгах, ИТХ-ын хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргахад бодитой санал, хувилбарууд олох боломжтойг ашиглаарай.
4. Тухайн сонгосон асуудал тань бодлогын баримт бичигт тусгагдаагүй эсвэл дутуу тусгагдсан бол та шинэ шийдлийн хувилбар хайна гэсэн үг. Тиймээс иргэд, сонгогчдод тухайн асуудлаас үзүүлж буй нөлөөллийг, тэдний санал болгож буй шийдлийг Захиргааны ерөнхий хуулийн сонсох ажиллагаа, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан нээлттэй хэлэлцүүлэг, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд заасан санал асуулга зэргийг явуулах замаар мэдээлэл авах, ярилцах аргаар тухайн асуудалд анхаарал хандуулан ажиллаж байгаагаа ойлгуулах боломжтой. Харин тухайн асуудлаар зөв, үр дүнтэй хэрэгжих бодлого тодорхойлох,

тогтвортой хэрэгжих шийдвэр гаргахын тулд нийтийн сонсгол зохион байгуулж тухайн асуудлаар мэргэшсэн, мэдээлэл судалгаа сайтай, бодлогын шийдэл хувилбар бүхий талуудыг сонсох замаар мэдээлэл аваарай.

Дөрөв. ИТХ-ын Төлөөлөгч та хамтрагчдаа тодорхойлж, зохион байгуулалт хийнэ үү.

1. Таны барьж ажиллах, шийдэхийг зорьсон асуудал ИТХ-ын аль хорооны чиг үүрэгт хамаарах вэ? Тэр хороонд та өөрөө байгаа юу? Хэрэв байхгүй бол тантай ижил сонирхол, зорилготой хамтрагч ИТХ-ын төлөөлөгч хэн байж болох, эмэгтэй төлөөлөгчдийн бүлэг байгуулах эсвэл тухайн асуудлаар ажиллах бүлэг байгуулах талаар төлөвлөнө үү. Та ямар ч тохиолдолд асуудлыг дангаараа шийдэж чадахгүй тул заавал бүлэг зохион байгуулалт хийх ёстой болно. Гэхдээ та асуудлыг санаачилсан тул манлайлан ажиллах ёстой.
2. Таны барьж ажиллах, шийдэхийг зорьсон асуудлаар ямар судалгаа баримтууд байж болох вэ? Зэргэлдээ аймаг, сум эсвэл нийслэл, дүүрэг хэрхэн шийдсэн байна гэдгийг судалж, баримт мэдээлэл цуглуулаарай. Тэдгээрийг хэн, ямар байгууллага, ямар эрдэмтэн мэргэжилтнүүд гүйцэтгэсэн болохыг анхаарч үзээрэй. Өөрөөр хэлбэл хамгийн сайн мэдээлэл бүхий талуудтай холбоо тогтоохыг эрмэлзээрэй. Тэдэнтэй холбогдож зарим нэгийг Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу хийх нийтийн сонсголд урьж оролцуулах талаар төлөвлөөрэй.
3. Таны барьж ажиллах, шийдэхийг зорьсон асуудал хэний эрх ашиг, ямар бүлэгт, аль нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжилд сөрөг нөлөөлөл үүсгэж байна, мөн хэн ашиг хүртэж байгаа зэрэг хамаарал бүхий оролцогчдыг тогтоож, тэдэнтэй уулзалтууд хийх, сонсох ажиллагаануудад урьд оролцуулах нь үр дүнтэй. Шийдвэрийн төсөл боловсруулахаас гадна иргэдийн дэмжлэгийг авах, тэдэнд асуудлаар танигдах боломжтой.
4. Төрийн төв байгууллага, төлөөллийн байгууллага, УИХ-ын гишүүн, аймаг нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагатай холбогдож болно. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14-р зүйлд. Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны баталгааг зааж, 14.2 дахь хэсэгт Төлөөлөгчдийн Хурлын ажилд оролцсон байдлыг харгалзан Тэргүүлэгчид урамшуулал олгож болох бөгөөд хэмжээ, олгох журмыг нь аймаг,

нийслэлийн Хурал баталж, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгана гэсэнд үндэслэн аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөд жилд дунджаар 4-8 сая төгрөг, нийслэлийн төлөөлөгчдөд улирал тутамд 5 сая төгрөг жилдээ 20 сая төгрөгийг урамшуулал нэрээр олгодог. Гэхдээ энэ нь хурлын төлөөлөгчийн үйл ажиллагааны баталгаа, тойрогтоо төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардал тул эмэгтэй төлөөлөгчид аймаг, нийслэлийн төлөөлөгчидтэй хамтран ажиллаж зарим үйл ажиллагааны зардал гаргуулах боломж бас байна.

5. Мөн танай тойргийн сонгогчдыг УИХ-д төлөөлж буй УИХ-ын гишүүн тань мөн тойрогтоо үйл ажиллагаа хэрэгжүүлэх зорилгоор жилд нэг тэрбум төгрөг улсын төсвөөс авч захиран зарцуулж байгаатай уялдуулан төлөвлөсөн үйл ажиллагаагаа хамтран хэрэгжүүлэх боломж бий.

ИТХ-ын төлөөлөгч та санал болгож буй **"4 шатлал бүхий 16 алхамт зөвлөмж"**-ийн дагуу тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр хамтын манлайллыг бий болгон хөгжүүлж чадна.

Та тогтмол санаачил, тасралтгүй урагшаа тэмүүл, бодит үйлдэл хий.

ИТХ-ын төлөөлөгч та дараах загварын дагуу жил бүрийн эхэнд хувийн манлайллын төлөвлөгөө гаргаж байгаарай.

Хүснэгт 10. Хувийн манлайллын төлөвлөгөөний загвар

	ИТХ-ын төлөөлөгчийн хувьд	ИТХ-ын хамаарах хорооны төлөөлөгчийн хувьд
Төлөөлөх чиг үүрэг: сонгогчдынхоо засгийн эрх барих эрх мэдлийг төлөөлөх хүрээнд		
Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт: сонгогчдоо төлөөлж захиргааны ямар ямар акт гаргах		

Тавдугаар бүлэг. Иргэдийн оролцооны шинэ хууль тогтоомжийг хэрэглэн манлайллаа бэхжүүлэх нь

Хяналтын чиг үүрэг: Засаг даргын мөрийн хөтөлбөр, Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, хууль тогтоомжийн хэрэгжилт, нийтийн эрх ашгийг хангах хүрээнд		
Дээрх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөгжилд оролцогч бусад талуудтай хэрхэн хамтран ажиллах талаар		

5.4 БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Хуулийг заавал биелүүлэх нийгмийн стандарт гэж ойлгож ирсэн бол энэ удаад хууль тогтоомжийг ойлгож, ажил амьдралдаа хэрэглэх нь амжилтад хүрэх, бусдаас дэмжлэг авах, хүмүүст танигдах боломжийг олгодог гэдгийг мэдүүлж, хууль тогтоомжид хандах та бүхний хандлагыг өөрчлөхийг зорилоо.

Төлөөлөгч бүрийн мэдлэг, ур чадвар, нөөц боломж харилцан адилгүй байхын зэрэгцээ нөөц хязгаарлагдмал тул аль болох энгийн, ойлгомжтой байдлаар хуулиудыг хялбаршуулан тайлбарлаж “4:6 тусгай хэрэгсэл”-ийг ашиглах, “4 шатлалт 16 алхамт зөвлөмж”-ийг эхлүүлэх дараалал, алхмуудыг санал болгов.

Шинэ гэж болох энэ арга хэрэгсэл нь хуулиар хүлээн зөвшөөрөгдөж баталгаажсан гэдгээрээ эмэгтэйчүүдэд онцлог “багаж” болох юм. Улс төрийн намаар талцаж намчирхахгүй, лоббидож хуйвалдах бус, хөрөнгө шаардахгүй арга хэрэгсэл тул төлөөлөгч дангаар болон эмэгтэйчүүд нэгдэх замаар өөрийн харьяалах хороогоор дамжуулан хүсэлт албан бичиг гаргаж хэрэглэх боломжтой.

Зургаадугаар бүлэг.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН БОДИТ ОРОЛЦОО БА НӨЛӨӨЛӨЛ

- 6.1. Төлөөлөгч эмэгтэй: Давуу тал, боломжууд ба бэрхшээл, сорилтууд
- 6.2. Эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөлөл, оролцоонд тулгардаг саад бэрхшээлийг даван туулах арга замууд
- 6.3. Эмэгтэйчүүдийн улс төрийн бодит оролцоо, нөлөөллийг дээшлүүлэх стратегиуд ба туршлага

6.1. ТӨЛӨӨЛӨГЧ ЭМЭГТЭЙ: ДАВУУ ТАЛ, БОЛОМЖУУД БА БЭРХШЭЭЛ, СОРИЛТУУД

Шийдвэр гаргах түвшинд оролцох, төлөөлөн сонгогдох, төлөөллөө хэрэгжүүлэх эрх бол ардчилсан нийгмийн салшгүй нэг үнэт зүйл юм. Тиймээс шийдвэр гаргах, бодлого боловсруулахад эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, нийгмийн бүлгүүдийн оролцоог хангах нь тэнцвэртэй бодлогын суурь болж, нийгмийг илүү хүмүүнлэг замаар хөгжүүлэх амин чухал ач холбогдолтой.

Эмэгтэйчүүд бүх шатны ИТХ-д сонгогдон ажиллахад дараах нийтлэг боломж, давуу тал байна:

1. Хувь хүний түвшинд: Эмэгтэйчүүд дээд боловсролд эзлэх тоогоороо жин дарж байгааг бид 2012-2017 оны хичээлийн жилүүдэд суралцагчдын 58,2³¹ хувь нь эмэгтэйчүүд байгаагаас харах боломжтой. Түүнчлэн аливаа албан бус сургалт, лекц, хэлэлцүүлэгт ч эмэгтэйчүүд олонх байж, идэвхтэй оролцож байгаа нь тэд боловсрол эзэмших, өөрийгөө хөгжүүлэх, насан туршдаа суралцахын тулд эрэл хайгуул хийж, идэвх зүтгэлтэй байгааг харж болно. Мөн эмэгтэйчүүдэд нийгмээс өгөгддөг жендэрийн дүр, үнэлэмж, үүрэг, хариуцлагаас шалтгаалан бий болдог уян хатан, хөрвөх чадвар зэрэг нь хувь манлайлагчийн давуу тал болох талтай.

Хамт олон, орон нутгийн орчинд: Эмэгтэйчүүдийг илүү итгэл хүлээхүйц, хариуцлагатай, бодит ажил хийдэг сайн төлөөлөгч гэж хардаг. Мөн орон нутгийн болон үндэсний түвшний ТББ-уудтай хамтарч ажиллах, асуудлыг шийдвэрлэхэд дуу хоолойгоо нэгтгэх боломжууд байдаг. Бас хүний амьдралын чанарыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгаалалд тулгамдаж буй асуудлыг шийдэхэд анхаарлаа илүү хандуулдаг.

Нөгөө талаас бүтэц, тогтолцооноос шалтгаалсан буюу соёл уламжлал, хууль эрх зүй, улс төр, эдийн засагтай холбоотой **бэрхшээл, сорилтууд** эмэгтэй төлөөлөгчдөд тулгардаг. Эдгээрийг дараах үндсэн 3 бүлэгт ангилан авч үзлээ.

Нэг. Улс төрийн саад бэрхшээл

Хоёр. Нийгэм, эдийн засгийн саад тотгорууд

³¹ Дээд боловсролын салбарын 2016-2017 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн танилцуулга, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яам

Гурав. Хандлага, сэтгэлзүйн саад бэрхшээл

Нэг. Улс төрийн саад бэрхшээл

- *Эрчүүд давамгайлах улс төрийн загвар*

Эрэгтэйчүүд улс төрийн тавцанд давамгайлж, улс төрийн тоглоомын дүрэм, үнэлэх стандартуудыг тогтоодог. Түүнчлэн улс төрийн амьдрал нь эрэгтэйчүүдийн хэм хэмжээ, үнэт зүйлсийн хүрээнд бүрдэж, зарим тохиолдолд бүр эрэгтэйчүүдийн амьдралын хэв маягт нийцэн зохицсон байдаг.³²

- *Намын дэмжлэг дутмаг*

Эмэгтэйчүүд өөрийн харьяалагдах улс төрийн намуудад сонгуулийн кампанит ажил явуулах, тусламж, дэмжлэг олоход чухал үүрэгтэй байдаг хэдий ч шийдвэр гаргах албан тушаалуудын өчүүхэн хувийг эзэлдэг.³³

Намын өдөр тутмын болон сонгуулийн арын албаны ажлыг гардан хийдэг ч эмэгтэйчүүд нам дотроо стратегийн байр суурь эзэлж чадаагүй нь тэдний нэр дэвших эсэхийг нам доторх эрэгтэйчүүд ихэвчлэн шийдэж байгаагаас харагдаж байна.

Түүнчлэн иргэн хүн шийдвэр гаргах үйл явцад оролцох нь өөрөө өндөр үнэтэй, өртөг ихтэй болж байгаа нь эрх мэдэл, мөнгө, холбоо сүлжээтэй цөөн хүнд л боломжийг нээж өгч байна. Энэ нь бодлогын гарц, нийгмийг өөрчлөх эрмэлзэлтэй, иргэдийг төлөөлөх зорилготой ч эрх мэдэл, мөнгө, холбоо сүлжээгүй иргэд, нэн ялангуяа эмэгтэйчүүд, залуучууд болон бусад эрх мэдлээс алслагдсан бүлгүүдийн оролцоог ноцтойгоор хязгаарлах үндэс болж байна. Мөн хэрээс хэтэрсэн намчирхал нь эмэгтэйчүүдийг хамтран ажиллах, дуу хоолойгоо нэгтгэн өөрчлөлт авчрах боломжуудыг хязгаарласаар байна.

- *Сонгуулийн систем таатай бус*

Эмэгтэйчүүд эрх тэгш өрсөлдөх шударга сонгуулийн орчин бүрдэхгүй байна. 2012 оны сонгуулийн өмнө бүхий л шат дахь нэр дэвшигчдийн 30 хувийг эмэгтэй байлгах квот гэнэт цуцлагдсан³⁴. 2016 оны Сонгуулийн хуулийн өөрчлөлтөөр УИХ-д улс төрийн намуудаас

³² Парламент дахь эмэгтэйчүүд: Тоо ба агуулга Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн (IDEA)

³³ Парламент дахь эмэгтэйчүүд: Тоо ба агуулга Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн (IDEA)

³⁴ Улс төрд монгол эмэгтэйчүүдийн оролцоо: Бэрхшээлийг даван туулах нь, Бүгд Найрамдахчуудын Олон Улсын хүрээлэн, 2016 оны 3 сар

нэр дэвшигчдийн аль нэг хүйс хамгийн багадаа 20 хувь байсныг 30 хувь болгон өсгөсөн ч сонгууль болохоос 2 сарын өмнө дахин өөрчлөлт оруулж, 20 хувь болгон бууруулсан ба нийслэл болон аймгийн ИТХ-ын квотыг хүчингүй болгосон.

Уг гарын авлагын 4-р хуудсанд сонгуулийн тогтолцоо орон нутгаас нэр дэвшигч эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлсөн талаар дэлгэрүүлж уншина уу. (1.1. Нутгийн удирдлага дахь эмэгтэйчүүдийн манлайлал: ИТХ-ын сонгуульд албан тушаалд ажиллаж буй байдал)

Түүнчлэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар (2011) сонгогдох болон томилогдох албан тушаалд квот тогтоохоор тусгагдсан ч хэрэгжилт хангалтгүй байна. Эмэгтэйчүүд гүйцэтгэх түвшинд олонх буюу 70 хувь, удирдлагын түвшинд цөөнх буюу 30 хувийг эзэлж байна. Энэ нь засаглалын бүтцэд эрэгтэй манлайллын хэв маяг давамгайлсан байгааг харуулж байна.

Хоёр. Нийгэм, эдийн засгийн саад тотгорууд

- *Соёл, уламжлалын сөрөг нөлөө*

Уламжлал, түүх нэрийн дор эмэгтэйчүүдийн улс төр, нийгмийн оролцоог үгүйсгэх хандлага амь бөхтэй оршиж байна. Энэ нь хэлц үгээс эхлээд хэвшмэл ойлголт, хандлага, улмаар зан үйл болтлоо нийгэмд гүн нэвчсэн. Улс төрийн манлайллыг эрэгтэй хүнтэй илүү холбож ойлгодог уламжлалт хандлага нь үүний нэг тод жишээ юм. “Эмэгтэйчүүд гэр бүлийн орчинд байх ёстой, нийгэм, улс төрийн асуудалд оролцох шаардлагагүй” хэмээх хандлага нь эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоо, манлайллыг далдуур хязгаарлаж байна.

- *Давхар ачаалал*

Эмэгтэйчүүдийн нийгэм, улс төрийн идэвхтэй оролцоо нь гэр бүлийн гишүүдийн дэмжлэгээс ихээхэн шалтгаалдаг. ИТХ-ын төлөөлөгчийн ажлын онцлог, ачаалал зэргийг ойлгож дэмждэг гэр бүлтэй байх нь төлөөлөгч эмэгтэйд давуу тал болдог. Эрэгтэй төлөөлөгч, улс төрчтэй харьцуулахад эмэгтэй төлөөлөгч нь ажил болон гэр бүлийн үүрэг хариуцлагын тэнцвэрийг олох хүндхэн сорилттой нүүр тулдаг.

- *Санхүүгийн хувьд хараат байдал*

Эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд санхүүгийн бие даасан байдлын хувьд эмзэг, ижил ажил хөдөлмөрт өөр өөрөөр үнэлүүлж байгаа нь эргээд эмэгтэй төлөөлөгч улс төрийн үйл явцад

шаардлагатай хөрөнгө, санхүү босгох боломжид нөлөөлсөөр байна. Мөн гэр бүлийн болон хамт олны хөрөнгөөс зарцуулах эрх мэдэл эмэгтэйчүүдэд бага байдаг.

Гурав. Хандлага, сэтгэлзүйн саад бэрхшээл

• Уламжлалын үр дагавар

Та эрэгтэйчүүдийн улс төрийн манлайллын сургалт, хөтөлбөргөж сонсож байсан уу, үгүй л болов уу? Тэгвэл яагаад Эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллын тухай бид байнга ярилцдаг юм бол? Эдгээр асуултанд “угаасаа...” гэсэн хариулт мундахгүй олон. Угаасаа улс төр “эрчүүдийн тоглоом”, угаасаа улс төр эмэгтэйчүүд орохооргүй “бохир муухай”, эсхүл угаасаа улс төрд эрэгтэйчүүд л байсаар ирсэн... ингэхэд энэ “Угаасаа” гэгч нь хаанаас гарав?

Нийгэм, улс төрийн манлайлал нь түүхэн нөхцөл байдлаас үүдэн илүү “эрэгтэйлэг” шинж чанараар танигдан, төсөөлөгдөж иржээ. Энэ нь түүхийн удаан хугацаанд аливаа хүн эсхүл бүлгийн нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг нь бие махбодийн функцтай нь илүү уялдан тодорхойлогддог байсантай холбоотой. Хэдхэн зууны өмнөхийг эргээд харвал эмэгтэйчүүд амьдралынхаа ихэнх идэвхт цаг хугацааг хүүхэд төрүүлэн, өсгөн торниулж ахуйн орчинд өнгөрүүлдэг байсан бол эрэгтэйчүүд ан ав, дайн байлдаанд мордож, олз хоол авчирдаг байсан байна. Энэ амьдралын хэв маяг нь бидэнд эмэгтэйчүүд илүү ахуй гэр доторх асуудлыг, эрэгтэйчүүд харин гэрээс гадуурх олон нийт, нийгмийн асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх, хийж гүйцэтгэх үүрэг функцтай хэмээсэн тогтсон хүлээлт, ойлголтыг бий болгожээ.

Харин өнөөгийн нийгэмд шинжлэх ухааны ололт амжилт, технологийн хөгжлийн ачаар хүмүүс бие махбодын функцдээ шууд сонголтгүйгээр захирагдах бус өөрсдийн шийдвэрээр амьдралаа зохиох, төлөвлөх, бүтээх боломжтой болсон. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөрийн сонголтоор гэр ахуйн орчинд эсхүл нийгмийн орчинд, мөн эдгээрийг хослуулан ажил, амьдралаа цогцлуулан бүтээх боломжууд нээгдсэн.

Гэсэн хэдий ч нийгэм тогтсон хэвшмэл хандлагаар гэрээс гаднах буюу олон нийтийн шийдвэр гаргах орон зайг, нэн ялангуяа улс төрийг эрэгтэйчүүдийн орон зай гэж, улс төрийн манлайллыг “маскулини” буюу эрэгтэйлэг шинжтэй манлайллын хэлбэрээр төсөөлж, түүгээр хэмжиж үнэлж дүгнэсээр байгааг шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооноос харагдаж байна.

- Итгэл дутагдах

Өөртөө итгэх итгэл дутагдах нь улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байх нэг шалтгаан юм. Энэ нь эмэгтэйчүүдийг улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг хязгаарладаг итгэл үнэмшил, хандлагаас шалтгаалдаг.

Намын удирдах албан тушаалыг дийлэнхдээ эрэгтэй гишүүд хашиж, харин захиргааны, орлогч даргын албыг эмэгтэй гишүүд хашиж байгаа нь нийгэмд эрэгтэйчүүдийн удирдах буюу улс төрд манлайлах чадварыг илүү гэж үзэх үзэл давамгайлж буйг илтгэж байна. Энэ хандлага эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэлийг бууруулж, сонгуульд өрсөлдөхөд бэлэн эсэхдээ эргэлзэхэд хүргэдэг хэмээн эмэгтэйчүүд хэлжээ.³⁵

“Эмэгтэйчүүд бусад эмэгтэйчүүдээ дэмждэггүй, тэдний төлөө саналаа өгдөггүй” гэж ярих нь бий. Үүнийг эмэгтэйчүүдийн эв нэгдэл болон атаархуу зан чанартай холбон тайлбарлах нь түгээмэл, гэвч энэ нь ташаа ойлголт юм. Үнэн хэрэгтээ энэ нь эмэгтэйчүүдийн өөртөө итгэх итгэлтэй холбоотой. Улс төрийн орчинд, шийдвэр гаргах түвшинд өөрийгөө ажиллаж чадна гэж үзэх итгэл сул байх тусам бусад эмэгтэйчүүдээ итгэдэггүй.

³⁵ Улс төрд монгол эмэгтэйчүүдийн оролцоо: Бэрхшээлийг даван туулах нь, Бүгд Найрамдахчуудын Олон Улсын хүрээлэн, 2016 оны 3 сар

Хүснэгт 10. Төлөөлөгч эмэгтэйн давуу тал, боломжууд ба тэдэнд тулгардаг бэрхшээл/сорилтууд (Сургалтын явцад гарч ирсэн санаануудаас түүвэрлэв)

Нийгмийн орчин, хүрээ	БОЛОМЖ (ДАВУУ ТАЛ)	СОРИЛТ (БЭРХШЭЭЛ)
Соёл, уламжлал	- Эмэгтэйчүүдийн уян хатан, өрөвч зөөлөн сэтгэл улс төрд хэрэгтэй гэж үзэж, улс төрийн уур амьсгалыг тэнцвэржүүлэх үүднээс эмэгтэйчүүдийг дэмжих хандлага - Монгол хатдын тухай түүх, домгууд	- Эмэгтэй хүнийг нийгэмд манлайлагч, шийдвэр гаргагч гэж харах нь бага. - Эмэгтэй төлөөлөгчийг эрэгтэй төлөөлөгчөөс илүү давхар шүүлтүүрээр шүүдэг, шүүмжилж ханддаг. - Эмэгтэйчүүд нийгмийн тодорхой асуудлыг л шийдвэрлэх ёстой гэсэн тогтсон ойлголт, хүлээлттэй, түүгээр хязгаарладаг. - Эмэгтэй төлөөлөгчдийг бодлого, ажил үйлсээр нь бус худал, үнэн хувийн хов живээр өрсөлдөгч нь дарж унагаах, эсвэл хэвлэл мэдээлэл гоочлох нь их, нэр гутаах эрсдэл өндөр. - Эмэгтэйчүүдийг манлайлагчийнх нь хувьд хүлээн зөвшөөрөх нь бага.
Эрхзүйн орчин	Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль батлагдсан. (2011 он)	- Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль, бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангалтгүй - УИХ-д нэр дэвшихэд л аль нэг хүйсийн төлөөлөл 20-иос доошгүй байна гэж жендэрийн квот зааж өгсөн. Аймаг, нийслэлд нэр дэвшихэд тавигдах квотыг хуулиас хассан. - УИХ-ын сонгуульд нэр дэвших квотын доод хязгаар 20 хувийг дээд хязгаар мэт ойлгон сөргөөр ашигладаг. - Улс төрийн намын санхүүжилт, сонгуулийн тогтолцоо нь мөнгө их зарцуулсан нь ялах магадлалтай болгож буй нь эмэгтэйчүүдэд ээлгүй. - Ажил, амьдралын тэнцвэрийг хангасан жендэрийн бодлого хэрэгждэггүй тул эмэгтэйчүүд нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаас шалтгаалан өсөж дэвших боломж нь хязгаарлагддаг. (ажлын байран дахь ёс зүй, соёл, ажилд авах шалгуур, тэтгэврийн нас, ажлын цагийн зохицуулалт зэрэг нь эмэгтэйчүүдэд ээлгүй)

Олон улс	■ Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг усгах тухай Конвенц, Тогтвортой хөгжлийн зорилго -2030 болон бусад бодлогын хүрээнд жендэрийн тэгш байдлыг бий болгох гэж зорьж буй санаачилгууд ■ ИТХ-ын төлөөлөгч эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжихэд чиглэсэн ОУ-ын төсөл, хөтөлбөрийн дэмжлэг	■ ОУ-ын хэмжээнд мөрдөгдөж байгаа бодлого, хөтөлбөрийн талаарх мэдээлэл хангалтгүй тул өөрсдийнхөө ажилд хэрэглээ болгож чаддаггүй. ■ Жендэрийн тэгш эрхийн тухай ойлголт “гадны” эсвэл “барууны” юм шиг ойлгогддог.
Төр, засаглал	■ Сонгох, сонгогдох эрх хуулиар олгогдсон ■ Сонгогдож, төлөөлөх эрхээ олж авсан. ■ Төлөөлөгчдийг, ялангуяа төлөөлөгч эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих сэдэвчилсэн сургалт явагддаг.	■ Төр, засаглалын бүтэц уламжлалт (эрэгтэйчүүд давамгайлсан) манлайллын шинжид суурилсан. ■ Засаглалын түвшинд өмнөх эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага, үр дүн харагдахуйц байж чадаагүй. ■ Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн сонгогдох болон томилогдох албан тушаалын квоттой холбоотой зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй
Эдийн засаг, санхүү	■ Эмэгтэйчүүд эдийн засгийн хувьд хараат ■ Жижиг зээл дээр эргэн төлөлт сайтай, найдвартай зээлдэгч	■ Эмэгтэйчүүдийг том санхүүжилт, хөрөнгө оруулалтын ашигтай, баталгаатай түншлэгч гэж үзэхгүй байх нь элбэг, түүнээс шалтгаалан санхүүгийн чадавхаа нэмэгдүүлэх боломж бага. ■ Эрэгтэй нэр дэвшигчид илүү хандив өгдөг. ■ Улс төрд идэвхтэй оролцох, төлөөлөгчөөр сонгогдон ажиллахад албан бус элдэв татаас, хураамж нь ачаа дараа болдог.
Нам, эвсэл	■ Намын дэргэд эмэгтэйчүүдийн холбоо, клубууд байдаг. ■ Төлөөлөгч эмэгтэйчүүд хамтран хэрэгжүүлсэн сайн туршлагууд бий.	■ Намчирхал, нам доторх фракцлал, талцал нь эмэгтэйчүүд хамтарч ажиллахад сөргөөр нөлөөлдөг. ■ Фракцалж, талцаж байж шат ахих боломж бий болдог шударга бус тогтолцоо ■ Үнэт зүйлд бус мөнгөнд суурилсан намын санхүүжилтийн тогтолцоо (нэр дэвших дэнчин, сонгуулийн кампанит ажлын сурталчилгааны зардал гэх мэт) ■ Улс төрийн соёл эмэгтэйчүүдэд ээлгүй (жишээ нь ууж идэж наргиж байж фракцын, шийдвэр гаргагчдын “бүлэг”-т орох гэх мэт) ■ Эмэгтэйчүүдэд ээлгүй улс төрийн соёл ■ Нам дотор эмэгтэй төлөөлөгчдийг дэмжих тогтолцоо, механизм сул.

Хамт олон, орон нутаг	■ Үндэсний ТББ-уудын дэмжлэг ■ Сум, багийн түвшинд хийсэн бүтээсэн ажлаараа эмэгтэйчүүд илүү танигдсан. ■ Хамт олон, орон нутагт нэр хүндтэй, хүндлэгддэг. ■ Төлөөлөгчийн бүрэн эрхийн хүрээнд тодорхой асуудлуудыг шийдвэрлэх боломж байдаг.	■ Орон нутаг дахь асуудлыг гаргаж ирэхэд, мөн шийдвэрлүүлэхэд олон нийтийн дэмжлэг дутагдах ■ Асуудлыг шийдвэрлэхэд хүн хүч, нөөц бололцоо, сүлжээ, харилцаа холбоо дутагдах ■ Намчирхал их тул асуудлыг шийдвэрлэхэд аль намын, хэн байхаас шалтгаалж хандах ■ Төлөөлөгчийг бүх асуудлыг шийдвэрлэнэ гэж хардаг, төлөөлөгчийн бүрэн эрхэд хамаарахгүй зүйл санаачилж хийж, хэрэгжүүлэхийг хүсч шаарддаг.
Гэр бүл	■ Давхар ачаалал үүрдэг. ■ Гэр бүлийнхэн дэмжиж ойлгосон үед улс төрийн идэвхтэй байх боломж бий болдог.	■ Улс төрд идэвхтэй орох, нэр дэвших үед гэр бүлийнхэндээ ойлгуулах амаргүй даваа байдаг. ■ Гэр бүлд гүйцэтгэх үүрэг, давхар ачаалал их. ■ Ажил, ар гэрийн тэнцвэрийн тухай асуудал үргэлж өрнөдөг. ■ Гэр бүлийн асуудлыг орхигдуулахаас өөр аргагүйд хүрсэн. ■ Гэр бүлийн хүрээндээ ойлголцсон ч бусад хүмүүс төдийлөн ойлгодоггүй. ■ Сонгуулийн үеэр илүүтэй яригддаг хувийн сэдэвтэй худал хов живээс болж гэр бүлийн харилцаанд асуудал үүсэх эрсдэлтэй.
Хувь хүн	■ Боловсролтой ■ Итгэл хүлээсэн ■ Уян хатан, дасан зохицох, хөрвөх чадвартай ■ Хөдөлмөрч, хариуцлагатай ■ Олон ажлыг зэрэг амжуулдаг ■ Бүтээлч, шинийг санаачлагч ■ Асуудлын нарийн учгийг олж хардаг, жижиг асуудлыг ч шийдэж өгдөг ■ Өндөр ачаалал дор ажиллах чадвартай гэх мэт	■ Өөртөө итгэлгүй ■ Өөрт байгаа хүч, боломжоо мэдэхгүй байх ■ Хууль, эрх зүй, төсөв санхүүгийн мэдлэг дутмаг ■ Үргэлж цагийн хомсдолд байдаг.

Сургалтын явцад төлөөлөгч эмэгтэйчүүдийн гаргаж ирсэн дээрх санаануудаас харахад эмэгтэй төлөөлөгчдийн **боломж, давуу талууд** нь хувь хүн, гэр бүл, хамт олон, орон нутгийн хүрээнд илүүтэй жин дарж байна. Харин сорилт, бэрхшээлүүд нь бүтэц, тогтолцоо, итгэл үнэмшил, хандлагын түвшинд байна.

6.2. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦООНД ТУЛГАРДАГ СААД БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ЗАМУУД

Сонгуулийн хууль эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд нөлөөлсөн үү?

Монгол улс сонгуулийн тухай хэд хэдэн хуулийг нэгтгэн, сонгуулийн тухай шинэ хуулийг 2015 оны 12-р сарын 25-нд баталсан. Уг хууль нь УИХ-ын сонгуульд холимог тогтолцоог ашиглахаар төлөвлөж, пропорциональ болон мажоритар тогтолцооны зарим бүрэлдэхүүн хэсгийг нэгтгэсэн байсан. 2016 оны 4-р сарын 22-ны өдөр Үндсэн хуулийн цэц хоёр өргөдөлд шуурхай шийдвэр гаргаж “сонгуулийн хувь тэнцүүлэх буюу пропорциональ тогтолцоо нь иргэний “шууд” сонгох Үндсэн хуулиар олгогдсон эрхийг зөрчиж байна” хэмээн хүчингүй болгосон. Үндсэн хуулиар УИХ нь Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байх эрхтэй хэдий ч дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, 5-р сарын 5-ны өдөр Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан бүрэн мажоритар тогтолцоог тогтоон батлав. Түүнчлэн УИХ олон мандат бүхий сонгуулийн тойргийн тогтолцоог нэг мандат бүхий тойргийн систем болгон өөрчилж, мажоритар тойргийн тоог 26-аас 76 болгон нэмэгдүүлж, сонгуулийн тойргийн тоог тогтоох эцсийн хугацааг сонгуулийн өдрөөс 150 хоногийн өмнө байсныг 45 болгож багасгасан.

Ингэснээр УИХ-ын гишүүд нь нэг мандаттай 76 тойрог дээр хамгийн олон санал авсан нь ялдаг системээр сонгогдох болсон юм. Түүнчлэн сонгуулийн шинэ хуульд нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэй байхаар заасан квотыг 20 хувь болж бууруулсан. Сонгууль болохоос зургаан сарын өмнө сонгуулийн хуулийг баталсан, мөн хоёрхон сарын өмнө сүүлийн суурь нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан зэрэг нь ноцтой асуудлыг үүсгэсэн юм.

СЕХ-ноос гаргасан дүнг харахад 2016 оны УИХ-ын сонгуульд 12 нам, гурван эвслээс нийт 498 нэр дэвшигч өрсөлдсөний ердөө 129 нь эмэгтэй нэр дэвшигчид байсан. Үүний талаар олон улсын ажиглагч нар өөрсдийн дүгнэлтээ гаргаж байлаа. Жишээ нь, ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар (ЕАБХАБ/АИХЭГ) болон Европын парламент (ЕП)-ийн хамтарсан сонгуулийн ажиглагч нар “Сонгуулийн шинэ хуульд нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэй байхаар заасан жендэрийн квот³⁶ 20 хувь болж буурсан нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхээс

³⁶ Квот гэхээр эмэгтэйчүүдэд илүү эрх олгож эрэгтэйчүүдийн эрхийг зөрчих гэж байна гэсэн ойлголт түгээмэл. Квот нь эрх нь зөрчигдөж, хоцрогдож байгаа хэсэгт давуу байдал олгох гэсэн үг биш. Аль аль талыг нэг гараанаас эхлүүлэх аргыг хэлдэг.

ухарсан алхам болов. Бүх улс төрийн нам, эвсэл хуулиар зааж өгсөн 20 хувийн жендэрийн квотыг мөрдсөн бөгөөд нэр дэвшигчдийн 26 хувь нь эмэгтэйчүүд байв. Гэвч сонгуулийн тойргийн гуравны нэгээс илүү хувь дээр эмэгтэй нэр дэвшигч байсангүй” гэж дүгнэсэн.

УИХ-ын болон ИТХ-ын сонгуульд нэр дэвшсэн эмэгтэйчүүд сонгуулийн тогтолцооноос шалтгаалан тойрог олох, намаасаа тойрогт хуваарилагдахаас өгсүүлээд кампанит ажлаа явуулах хөрөнгө, санхүү дутах, олон нийтийн жендэрийн талаарх хэвшмэл ойлголт зэрэг нь тэдний сонгуулийн сурталчилгаанд хэрхэн сөрөг нөлөө үзүүлсэн талаар өөрсдийн санал бодлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сонгогчдод хүргэж байсан. Тухайлбал, УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл: “Би Хөвсгөл аймагт нэр дэвшсэн. Миний хувьд сонгуулийн кампанит ажлыг явуулахад энэ жил хүнд байлаа. Хандивын мөнгөө босгох гэж их сандарсан. Хөвсгөлийн иргэд миний сонгуулийн кампанит ажлын хандивын 20 хувийг босгосон бол, Улаанбаатар хотын иргэд 142 сая төгрөгийг хандивласан. Сэтгүүлчдэд мөнгө өгч, сонгуулийн кампанит ажлынхаа талаар телевизээр гурван удаагийн давтамжтай мэдээлүүлэхээс эхлээд мөнгөний хэрэгцээ их гарч, таньдаг бүх хүмүүс рүүгээ утасдаж, мөнгө гуйсан. Харин 2008 онд намайг улс төрд орох гэж зүтгэж явахад нэр хүндийг минь унагасан гол шалтгаан бол нөхрийн асуудал байсан. Гэвч одоо бол эмэгтэй нэр дэвшигчдийн талаарх хэвшмэл ойлголт, бусдын гүтгэлэг, доромжлолоос өөрийгөө хамгаалах дархлаатай болсон” гэж өөрийн санал бодлоо хуваалцаж байлаа. Мөн Сонгогчдын Боловсролын Төвийн захирал С.Оюунтуяа: “Сонгуулийн тогтолцоо нь эмэгтэй нэр дэвшигчдэд мэдээж нөлөө үзүүлсэн. Өмнөх хуулиар сонгууль холимог системээр явсан. Харин шинэ сонгуулийн хуулинд олонхийн /мажоритар/ тогтолцоотой байна гэж тусгагдсан нь сонгуулийн тойрог жижгэрсэн гэсэн үг юм. Ингэснээр сонгуульд мөнгөний нөлөө их болж, тэр утгаараа эмэгтэй нэр дэвшигчдэд ээлгүй болж байгаа юм” гэж дүгнэжээ.

“Энэ жил аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулийг УИХ-тай зэрэг явуулсан нь сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн ач холбогдлыг бүр бууруулсан. Сонгуулийн өмнөхөн төвийн 4 аймаг, Улаанбаатар хотын 6 дүүрэгт хийсэн олон нийтийн санаа бодлын судалгааны дүнгээс харахад хөдөөгийн сонгогчидтой харьцуулахад нийслэлийн сонгогчид, ялангуяа 18-35 насны залуу сонгогчид УИХ-ын сонгуулийн үеэрх намуудын ухуулга сурталчилгаанаас залхсан байдалтай, орон нутгийн сонгуульд төдийлөн ач холбогдол өгөхгүй байгаа нь харагдсан” гэж Улс төрийн коммуникацийн хүрээлэн дүгнэжээ. Сонгогчдын энэ идэвхгүй байдал нь орон нутагт нэр дэвшсэн хүмүүст, ялангуяа эмэгтэй нэр дэвшигчдэд

олонхийн санал авахад нь сөрөг нөлөө үзүүлсэн гэдэгтэй орон нутагт нэр дэвшсэн эмэгтэйчүүд, судлаачид санал нийлж байлаа.

Шигтгээ 16. Орон нутгийн сонгуульд өрсөлдсөн эмэгтэйчүүдэд тулгамдсан сорилт бэрхшээл

- Өрсөлдөгчийн зүгээс гүтгэлэг явуулж байсан.
- Хөдөө орон нутгийн нөхцөлд ах дүү, хамаатан цөөн байсан нь бэрхшээл болсон.
- Хэрвээ сонгогдвол юу хийх вэ, юу өгөх вэ гэх мэт хуулиар хориотой, хэрээс хэтэрсэн. зүйлийг нэхдэг, шаарддаг. Жишээ нь эд материал, тусламж гэх мэт.
- Намчирхал
- Нэр дэвшигчийн нэр төр, хувийн амьдрал руу дайрч давшилсан.
- Нутгархах явдал
- Сонгогчдын боловсрол дутмаг.
- Тухайн ажиллаж буй байгууллагын дарамт шахалт
- Санхүүгийн бэрхшээл
- Нэр дэвших эрх хязгаарлагдмал
- Эмэгтэй учраас дэмжих, сонгох талдаа иргэд муу байсан.
- Гэрийнхэн дэмждэггүй
- Ажил хийж байгаа үед сурталчилгаа явуулахад хүндрэлтэй
- Эмэгтэйчүүдийн улс төрийн мэдлэг дутмаг
- Нийгмийн хүрээнд эмэгтэй хүнийг үнэлэх үнэлэмж дутмаг
- Эмэгтэй улс төрчдийг төрийн түшээ болох талаас нь бэлтгэдэггүй

Аймаг, сумын эмэгтэй төлөөлөгчдийн ярилцлагаас...

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх арга зам

Улс орон бүр шийдвэр гаргах бүхий л түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл, оролцоог нэмэгдүүлэхийн тулд олон тактик боловсруулж, амьдрал дээр туршсаар ирсэн. Мөн улс орнууд өөрийн онцлог бүхий засаглалын бүтэцтэй, улс төрийн нам бүр өөрийн удирдлага болгодог дүрэм, журам, практиктай. Тиймээс арга, тактик бүрийг өөрийн улс орны ардчиллын онцлог нөхцөл, олон улсын өмнө хүлээсэн амлалт, үндэсний тогтолцоо, сонгуулийн болон улс төрийн намын тогтолцоо, нийгэм-соёлын уламжлал, өнөө үед тулгарч буй улс төрийн сорилт зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр хэрэгжүүлэх нь зүйтэй. Гэхдээ тухайн тогтолцооноос үл хамааран улс төрийн намын дотор

жендэрийн тэгш байдлыг сайжруулах, эмэгтэйчүүдийн улс төрийн дэвшлийг хангахад үр дүнтэй гэдэг нь нотлогдсон хэд хэдэн арга байдаг. Үүнд:

- Улс төрийн намын удирдлагаас намын дотоод дүрэм, журам, бодлого, практикаа ил тод, шударга, тэгш болгох (энэ бүгд нь намын дотоод ардчиллыг бэхжүүлэхэд чиглэнэ);
- Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих сайн дурын арга хэмжээ болох намын квот нэвтрүүлэх;
- Эмэгтэйчүүдэд зориулсан чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах: улс төрийн намуудын эмэгтэй гишүүдийн чадавхийг дээшлүүлэх, улс төрийн оролцоо, манлайлал, түншлэл, нөлөөлөл зэрэг сэдвийн хүрээнд үе шаттай сургалтад хамруулж, зөвлөгөө өгөх;
- Эмэгтэйчүүдэд намын хөрөнгө нөөцөөс ашиглах боломж олгох тусгай санаачилгыг хэрэгжүүлэх;
- Намын үйл явц, бодлого, ялангуяа намын үндсэн дүрэмд жендэрийн тэгш байдлыг институцлэн тусгах;
- Нам дотроо эмэгтэйчүүдийн бүлэг байгуулах;
- Намын эрэгтэй, эмэгтэй гишүүдийн хамтын ажиллагааг дээшлүүлэх;
- Үндэсний болон орон нутгийн түвшинд сонгогдсон эмэгтэй улс төрчид эмэгтэйчүүдийн бүлэг, сүлжээ байгуулж, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх, хууль, тогтоомжид өөрчлөлт оруулахын тулд нөлөөллийн ажлуудыг үе шаттай зохион байгуулах;
- Улс төрийн нам өөр хоорондоо болон иргэний нийгмийн байгууллага зэрэг бусад талуудтай хамтран ажиллах;
- Сонгогч иргэдийн дэмжлэгийг авахын тулд тэдний дунд хэлэлцүүлэг, ярилцлага, сургалтыг тогтмол зохион байгуулах зэрэг юм.

Шигтгээ 17. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх арга зам

- Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах
- Намын дүрэмд квотын асуудлаар нэмэлт заалт оруулах
- Эмэгтэйчүүдийн чадавхийг дээшлүүлэх сургалтууд тогтмол зохион байгуулах
- Эмэгтэй төлөөлөгчид нам харгалзахгүй хамтран ажиллах, бүлэг байгуулах
- Манлайлагч эмэгтэйчүүдийг салбар бүрээс тодруулж, тэднийг олон нийтэд танилцуулах, идэвхжүүлэх
- Иргэдийн хэрэгцээ, саналд тулгуурлан үйл ажиллагаа зохион байгуулах
- Тойрог харгалзахгүй олон нийтэд тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх саналыг Хуралд хамтран оруулж, нөлөөллийн ажил хийх
- Эмэгтэй төлөөлөгчид Хурлын Тэргүүлэгчээр сонгогдох боломжийг алдахгүй байх
- Сонгогчидтой тогтмол уулзаж, тэдний асуудлыг зохих албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлэхэд туслах
- Хууль, эрхзүйн мэдлэгээ дээшлүүлэх
- Эмэгтэй төлөөлөгчдийн бүлэг байгуулж, багаа бүрдүүлэх
- Төрийн байгууллагатай хамтран иргэдэд зориулсан сургалт, арга хэмжээ зохион байгуулах
- Залуу эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх
- Сумын ИТХ-д нам харгалзахгүйгээр эмэгтэйчүүдийн лобби бүлэг байгуулах
- Тулгамдсан асуудлыг барьж авч, шийдвэр гаргаж хэрэгжиж дуустал бүх үйл явцад оролцох
- Залгамж халаагаа бэлтгэх
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ИНБ-уудтай хамтран ажиллах
- Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо яагаад байх шаардлагатайг иргэдэд ойлгуулах сурталчилгааны ажлууд зохион байгуулах
- Бусад улс орнуудын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх арга, туршлагаас суралцах
- УИХ, ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдож байсан бусад эмэгтэйчүүдийн сайн туршлагыг түгээх, таниулах
- Эмэгтэй улс төрчдийн давуу болон сул талыг шинжилж, улс төрийн оролцоогоо дээшлүүлэх шийдлийн модыг гаргах

Аймаг, сумын эмэгтэй төлөөлөгчдийн ярилцлагаас...

Улс төрийн нам эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэхийн тулд юу хийх вэ?

Орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн, сонгогдсон төлөөлөгчдийн дийлэнх нь улс төрийн намын гишүүд байдаг. Гэвч улс төрийн намын албан ба албан бус практик, тухайн улс төрийн намд давамгайл үйлчилж буй соёл, жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголт зэрэг нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд бэрхшээл учруулдаг. Тиймээс эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх, тэдний оролцоог дээшлүүлэх нь улс төрийн намаас эхлэлтэй байх ёстой. Улс төрийн намууд, ялангуяа намын удирдлагууд намын бодлого, практик, дүрэм журмаа жендэрийн тэгш байдлыг дэмжсэн болгоход гол үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь намын эрэгтэй, эмэгтэй гишүүдэд адил тэгш нөхцөл бүрдүүлэхэд эхний чухал алхам болно.

Улс төрийн намууд эмэгтэйчүүдийн улс төрийн мэдлийг дээшлүүлэхэд илүү ихийг хийх шаардлагатай. Улс төрийн намуудад нам дотроо, мөн сонгуульт албан тушаалд эмэгтэйчүүдийг дэмжих олон боломж, арга бий. Үүнд нам дотроо жендэрийн тэгш байдлын сан байгуулж, холбогдох журмыг батлах; намаас нэр дэвшигч, гишүүд, дэмжигч, сонгогчидтой жендэрийн мэдрэмжтэй харьцах; улс төрийн намын санхүүгийн хөрөнгө нөөц, сурталчилгааны хөрөнгөнөөс хүртэх жендэрийн тэгш боломжоор хангах; эмэгтэй гишүүдийг сургах, намын сонгуулийн сурталчилгаандаа жендэрийг нэг арга болгон тусгах; мөн үндэсний түвшинд жендэрийн мэдрэмжтэй засаглалыг дэмжин нэвтрүүлэх зэрэг багтана.

■ *Сайн дурын квот тогтоох*

Намын удирдлагаас намын засаглалын гол тогтолцоо, үйл явцад сайн дурын квот тогтоох замаар шийдвэр гаргах дотоод бүтэцдээ эмэгтэйчүүдийн төлөөллийг дээшлүүлэх боломж бий. Намын хурлууд, нэр дэвшигч сонгон шалгаруулах хороо, намын гүйцэтгэх зөвлөл зэрэг удирдлагын тогтолцоонд байх эмэгтэйчүүдийн төлөөллийн доод хязгаарыг зааж болдог.

Шигтгээ 18. *Польш улсын туршлага*

Коммунизм задарсны дараа, 1989 онд болсон чөлөөт сонгуулийн дараа парламент дахь эмэгтэй төлөөлөгчдийн тоо 1985 онд 23 хувь байсантай харьцуулахад 1991 онд 10% болж эрс доошилжээ. Ардчилсан зүүний альянс, Хөдөлмөрийн эвлэл, төвийг сахигч Чөлөөт эвлэл хэмээх гурван нам 30 хувийн сайн дурын квот тогтоосны үр дүнд дөрөв дэх удаагийн парламентын үед л эмэгтэйчүүдийн төлөөлөл 20 болж өсчээ.

Энэ үр дүнд хүрэхэд намын удирдлагад нөлөөлсөн хоёр гол хүчин бол эдгээр намын эмэгтэй гишүүд болон Парламентын Эмэгтэйчүүдийн бүлгийн дэмжлэгтэй Эмэгтэйчүүдийн сонгуулийн өмнөх эвсэл гэж үздэг. Хэдийгээр албан ёсоор квотыг эсэргүүцэж байсан ч барууны буюу консерватив намууд нэр дэвшигчдийн жагсаалтаа илүү олон эмэгтэйг оруулжээ. Тухайлбал, эрх барьж буй Иргэний платформ нам жагсаалтын эхний гурван байранд эмэгтэй нэр дэвшигчдийн 15 хувийг бичсэн бөгөөд 2001 онд сонгогдсон эмэгтэйчүүдийн 20 хувийг бүрдүүлжээ. Иргэний Платформ Намын гишүүн Iwona Ledzińska-Katarasińska-гийн гаргасан саналын дагуу жагсаалт бүрийн эхний гурван байрын аль нэгт эмэгтэй нэр дэвшигч бичих тогтоолыг 2007 оны сонгуулиас өмнө баталжээ. Энэ журмыг зөрчвөл хүлээлгэх хариуцлага байхгүй боловч үүнийг хэрэгжүүлэхийг намын удирдлагаас шаардах боломжтой болсон. 41 тойргийн 34 нь энэ журмыг баримталсан бол 3 тойрогт эмэгтэйчүүдийг жагсаалтын 4 дүгээрт бичжээ. Үүний үр дүнд эмэгтэйчүүд жагсаалтын 21 хувийг эзэлж, 23 хувь сонгогдсон байна.

■ *Жендэрийн тэгш байдлыг институтчилэх*

Улс төрийн нам дотроо жендэрийн тэгш байдлыг институтчилнэ гэдэг нь намын баталсан бодлого журмыг гишүүд бодит амьдрал дээр даган мөрддөг, ялангуяа орон нутаг, бүс, үндэсний түвшинд намын удирдлага, сонгогдсон төлөөлөгчид хэрэгжүүлдэг байхыг хэлнэ. Улс төрийн намууд тус бүртээ жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, нийтэлж, хэрэгжүүлж, түүндээ хяналт тавьдаг байх хэрэгтэй бөгөөд түүнд тодорхой хэмжигдэхүйц, цаг хугацаатай зорилго тавьсан байх нь зүйтэй.

Ингэснээр намын бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх, түүний дотор тусгай хороод байгуулах, чадавхийг нь бэхжүүлэх, эсвэл эмэгтэйчүүдийн бүлэг, парламентын эмэгтэйчүүдийн нэгж, намын эмэгтэй гишүүдийн гаргасан шийдвэр, зөвлөмж намын бодлого боловсруулах үйл явцад хэлэлцэгдэж, тусгагддаг байх үүднээс энэ асуудлыг хариуцсан ажилтан томилох зэрэг арга хэмжээ авахыг шаардаж болно. Намын үйл ажиллагаа, бодлого, журмын талаар жендэрийн шинжилгээ хийх чадавхийг намын эрэгтэй, эмэгтэй гишүүдэд бий болгох шаардлагатай.

Гэвч бодлогын амлалт авах, тэр ч байтугай тодорхой зорилго тавьсан ч нам дотроо эмэгтэй, эрэгтэй гишүүд харилцан уялдаатай арга хэмжээ авахгүй бол тэдгээр нь олигтой үр дүнд хүрэхгүй. Намын удирдлагын бүтцэд эрэгтэйчүүд давамгайл байдаг, ихэнх парламентад ч эрэгтэй гишүүд давамгайл байгаа тул өөрчлөлт хийхэд эрэгтэйчүүд чухал түнш юм. Эмэгтэйчүүдийн байр суурь, тэргүүлэх чиглэл,

тэдний санааг эрэгтэй гишүүд нухацтай авч үздэг болгоход намын удирдлагын эрмэлзэл, улс төрийн хүсэл зориг нэн чухал. Түүнчлэн намын гишүүдэд жендэрийн тэгш байдал, тэгш боломжийн талаар байнга мэдлэг ойлголт өгөх, ялангуяа хоосон үг, амлалтаар бус үйлдлээрээ дэмжихэд намын удирдлага маш чухал үүрэг гүйцэтгэнэ.

Шигтгээ 19. Намын бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгоход нөлөөлсөн туршлага

Жэйн Доу өөрийгөө ИТХ-ын төлөөлөгч болно гэж хэзээ ч бодож байсангүй. Гэрийнх нь ойролцоо том үйлдвэр нээгдсэнээс хойш замын хөдөлгөөн ихсэж, улмаар зам дээр осол их гарч байгааг тэр анзаарчээ. Жэйн багш мэргэжилтэй бөгөөд сургуулиа тараад харьж яваа эсвэл тоглох газаргүйгээс гудамжинд тоглож буй хүүхдүүд ихэвчлэн осолд өртөж байгааг олж мэджээ. Жэйн үүнд санаа нь зовж, үйлдвэрийн орчмын замыг аюулгүй болгохоор иргэдийн бүлэг байгуулж, ИТХ-д нөлөөлөх ажил хийж эхэлсэн байна. Хүүхдүүд сургуулиа тараад гэртээ хэрхэн харьдаг, хаана тоглож нааддаг талаар үйлдвэр барих зөвшөөрөл олгосон ИТХ-ын төлөөлөгчид (дийлэнх нь эрэгтэйчүүд) мэддэг ч үгүй, анхааран судалж үзээ ч үгүй байсан ажээ.

Ингээд ИТХ-ын сонгууль дөхөхөд Жэйн боловсрол, нийгмийн шударга ёсны асуудлаар сурталчилгааны ажлынхаа гол анхаарлыг хандуулж байсан улс төрийн намд элсэж, мэргэжлийн ур чадвар, эрмэлзэл, хүүхэдтэй ажилласан туршлагатай тул нэр дэвшвэл амжилт гаргах боломжтой гэдгээ танилцуулав. Намын удирдлага, сонгон шалгаруулах хорооныхон хэнийг нэр дэвшүүлэх талаар нэлээд маргалдаж байв. Харин Жэйн орон нутгийн боловсрол, замын аюулгүй байдал зэрэг шинэ асуудлыг намын бодлого, сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгах санаачилга гаргаж ирснээрээ намдаа итгэл олж, нэр дэвших дэмжлэг авсан байна.

Сонгуулийн сурталчилгааны явцад тэрээр замын аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулж, цэцэрлэгт хүрээлэнд хүүхдийн тоглоомын газар барих асуудлыг дэвшүүлсэн нь нутгийн иргэдэд таалагджээ. Жэйн Доу сонгуульд ялж, ИТХ-ын төлөөлөгч болсон бөгөөд замын аюулгүй байдлыг сайжруулах талаар шийдвэр гаргагчдад нөлөөлөх ажлаа үргэлжлүүлж, орон нутгийн нийгэм-эдийн засгийн асуудалд анхаардаг гэсэн нэр хүндийг намдаа авчирчээ.

■ **Намын үйл ажиллагааны мэдээлэл ил тод байх**

Намын үйл ажиллагаа ил тод бус, мөн намын дотоодод өрнөж буй соёл, бодит дүрмийг мэдэхгүйгээс намын эмэгтэй гишүүд улс төрийн карьераа ахиулахдаа саад бэрхшээлтэй тулгарах нь элбэг. Ялангуяа намын үйл явцыг бичгээр тодорхой, ил тод баримтжуулаагүй эсвэл

бичгээр гаргасан журмаа амьдралд мөрддөггүй тохиолдолд ийм байдал үүсдэг. Нам хэрхэн ажилладаг, практик дээр юуг удирдлага болгодгийг мэдэж авснаар эмэгтэйчүүд сонгуулийн сурталчилгааны ажлын хөрөнгө нөөц, хандивлагч, сүлжээ, хэвлэлийн эх сурвалж, намын өмч зэргийг ашиглах боломжийг олж харах бөгөөд эдгээр нь нэр дэвшигч, сонгуулийн сурталчилгааны менежер, намын шийдвэр гаргагч болж карьераа хөгжүүлэхэд нэн чухал юм.

Шигтгээ 20. Улс төрийн нам жендэрт ээлтэй эсэхийг тодорхойлох шалгуур үзүүлэлт

- ✓ Намын шийдвэр гаргах бүх байгууллага, сонгуульд нэр дэвшигчдийн жагсаалт, сонгуульт болон томилогдох бүх албан тушаалд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэнцвэртэй оролцоог хангах талаар намын дүрэмд заасан байх
- ✓ Намын дүрэм, бодлого, хөтөлбөрүүдэд жендэрийн эрх тэгш байдал бол намын баримтлах суурь үнэт зүйл, зарчмын нэг гэдгийг дурдсан байх
- ✓ Намын орон нутаг, бүс, төв буюу улсын түвшний байгууллага, түүний дотор Удирдах зөвлөлийн гишүүдийн бүртгэлийг тогтмол шинэчлэн хөтөлж, уг мэдээллийг хүйсээр ангилдаг байх
- ✓ Намын хүрээнд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан бодлого, практик байгаа эсэхийг илрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар ямар ахиц дэвшил гарч байгааг үнэлэх зорилгоор жендэрийн аудитыг тогтмол хугацаанд хийдэг байх
- ✓ Жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлыг тодорхойлж, холбогдох арга хэмжээг сонгуулийн сурталчилгааны ажлын санаа, намын амлалт болгодог байх
- ✓ Нам дотроо бие даасан, идэвхтэй, олонд танигдсан жендэрийн эрх тэгш байдлын механизм/байгууллагатай (эмэгтэйчүүдийн жигүүр, хэсэг гэх мэт) болох, нам дотроо уг байгууллагад хүндэтгэлтэй ханддаг байх
- ✓ Жендэрийн эрх тэгш байдлын механизм/байгууллага нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлаар нам дотроо болон олон нийтэд чиглэсэн хэлэлцүүлэг зохион байгуулдаг байх
- ✓ Нам нь иргэний нийгмийн эмэгтэйчүүдийн ТББ, парламент, засгийн газрыг холбогч суваг болж ажилладаг байх
- ✓ Намын хөрөнгө нөөцийг эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчдэд шударгаар хуваарилдаг байх
- ✓ Намын жендэрийн эрх тэгш байдлын механизм/байгууллага болон энэ чиглэлийн бодлого, хөтөлбөрт намын төсвөөс санхүүжилт хуваарилдаг байх
- ✓ Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алийг нь жендэрээр ялгаварлан гадуурхсан, зүй бус харилцсан тухай асуудлыг намын анхааралд хүргэх гомдол шийдвэрлэх механизм, журамтай болсон байх

■ Улс төрийн чадавх дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар тогтмол зохион байгуулах

Ирээдүйтэй эмэгтэйчүүдийн улс төрийн чадавхийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах нь олон эмэгтэй улс төрд хөл тавих, улс төрийн удирдах албан тушаалд хүрэхэд тус дэм болдог. Энэ арга нь эмэгтэйчүүдийн улс төрийн сонирхлыг өдөөж, улс төрд нэн чухал ур чадвар, мэдлэгийг нь хөгжүүлэн, түүнийгээ улс төрийн карьертаа ашиглах бололцоо олгох зорилготой.

Эмэгтэйчүүд улс төрийн албан тушаал хашихад шаардлагатай мэргэжил, боловсрол, туршлагаар эрэгтэйчүүдээс дутахгүй боловч шууд, шууд бус ялгаварлан гадуурхалтын улмаас улс төрийн карьераа эхлүүлэх мэдээлэл, боломж нь эрэгтэйчүүдээс дутуу байх явдал гардаг. Иймд улс төрд хөл тавьсан эмэгтэйчүүдэд улс төрийн удирдагчийн албан тушаалд хүрэх, улс төрийн зорилгоо таниулан ойлгуулахад нь тулгарч буй жендэрээс үүдэлтэй бэрхшээлийг хэрхэн даван гарах талаар нэмэлт дэмжлэг, сургалт хэрэгтэй байдаг. Улс төрийн намын гишүүн эмэгтэйчүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх нь эмэгтэй удирдагчийн шинэ үеийг өсгөж өндийлгөх чухал арга зам тул аливаа улс төрийн намын зүгээс эмэгтэйчүүдийн улс төрийн төлөөллийг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээнийх нь нэг чухал хэсэг болж байдаг.

Шигтгээ 21. Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан сургалтын хэрэгцээ

“Намын зүгээс эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан төрөл бүрийн сургалт ер нь явуулж байгаагүй. Би мэдлэг, чадвараа дээшлүүлэх, боловсролын түвшингээ ахиулахын тулд Удирдлагын академийн менежерийн түвшний сургалтад хамрагдахад туслалцаа үзүүлэхийг хүсч намд өргөдлөө явуулсан ч одоо хүртэл хариу ирээгүй. Нэг удаагийн арга хэмжээ болох намын болон эмэгтэйчүүдийн чуулганд л оролцдог.”

“Ер нь нэр дэвших сонирхолтой байгаа эмэгтэйчүүддээ сонгуулийн өмнө ИТХ, төлөөлөгчийн үүрэг, хариуцлага, хууль зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах хэрэгтэй. Намайг сумын хуралд төлөөлөгч байх үед намын өмнөөс санал өгөх ёстой гэсэн үүрэг өгдөг болохоос эмэгтэй төлөөлөгчдийг сургах, мэдээллээр хангах ажил ерөөсөө хийж байгаагүй. Анх төлөөлөгч болох үед Засгийн газраас л нэг удаагийн сургалт хийж байсан.”

Хэнтий, Дорнод аймгийн сумын хурлын төлөөлөгчдийн ярианаас...

■ **Намын улс төрийн мэдээлэл, харилцаанд жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг тусгах**

“Зуу сонсохоор нэг үз” гэдэг үг бий. Намын болон сонгуульт албан тушаалд ажиллах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нэг үр дүнтэй арга бол илтгэж яриад зогсохгүй эмэгтэйчүүдийг олон нийтэд таниулах, харагдуулах арга билээ. Сонгуулийн сурталчилгааны ажлын үеэр эмэгтэй нэр дэвшигч, сурталчилгааны ажлын менежер, идэвхтэн гишүүд ихэвчлэн хөшигний цаана үлдэж, харин намын удирдлага (ихэвчлэн эрэгтэй) хэвлэл мэдээллээр гардаг.

Намын цахим хуудас, зурагт хуудас, телевиз, радиогийн болон видео мессеж, сонин хэвлэл, олон нийтийн цахим сүлжээ зэрэг сувгаар эмэгтэй нэр дэвшигч, эмэгтэйчүүдийг олон нийтэд идэвхтэй танилцуулснаар тэднийг байгаа гэдгийг мэдрүүлэх, нэрийг нь олны танил болгох боломжтой. Түүнчлэн улс төрийн уулзалт цуглаан, сонгуулийн сурталчилгааны ажлын хүрээнд зохион байгуулж буй бусад үйл ажиллагаа, телевизийн мэтгэлцээн, намын өргөн нэвтрүүлэгт эмэгтэйчүүдийг оролцуулах боломж бий.

Шигтгээ 22. Эмэгтэй улс төрчдийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэхийн тулд юу хийх вэ?

- ✓ Бүтээлч, хөдөлмөрч, манлайлагч эмэгтэйчүүдийг бодлогоор олон нийтэд таниулах
- ✓ Улс төрч эмэгтэйчүүдийн хөгжил, дэвшилд оруулж буй хувь нэмрийг жендэрийн мэдрэмжтэй, бүтээлч гэсэн талаас нь үзүүлэх
- ✓ Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн амжилтад адилхан ач холбогдол өгөх
- ✓ Эмэгтэйчүүдийг олон талт дүрээр харуулах
- ✓ Жендэрийн хэвшмэл ойлголтыг эвдсэн агуулга бэлтгэх
- ✓ Улс төрд оролцож буй эмэгтэйчүүдийг хөгжлийг бүтээгч талаас нь харуулах
- ✓ Улс төрийн аливаа асуудлаарх эмэгтэйчүүдийн санаа бодлыг гаргаж ирэх
- ✓ Эмэгтэй, эрэгтэй улс төрчдөд асуултад хариулах адилхан боломж өгөх

■ **Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нээлттэй, албан ёсоор, байнга дэмжих**

Ингэснээр улс төрийн нам дэмжигчдийн хүрээгээ өргөжүүлж, шинэ гишүүдийг өөртөө татан, мөн нийтийн санхүүжилтээ нэмнэ. Түүнчлэн олон нийтийн байр суурийг өөрчилж, олон улсад ч өөрсдийн нэр хүндийг дээшлүүлэх боломжтой.

Эмэгтэйчүүд нам дотроо дуу хоолойгоо бодитой илэрхийлэх боломжтой байж л олон нийтийн хэлэлцүүлэгт эрэгтэйчүүдтэй тэгш оролцож, тэдний болон гэр бүл, нутаг орон, улс орныхоо ирээдүйг шийдэх шийдвэрт нөлөө үзүүлж чадна. Тиймээс эмэгтэйчүүдийн оролцооны саад бэрхшээлийг арилгах нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алиных нь хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн ажилладаг жендэрийн мэдрэмжтэй улс төрийн нам, парламент, ИТХ бий болгоход чухал ач холбогдолтой.

Жендэрийн тэгш байдлын төлөөх санаачилгад эрэгтэйчүүдийн дэмжлэг чухал ч эмэгтэйчүүд өөрсдөө ч идэвхтэй байр сууринаас хандаж, жендэрийн тэгш байдлын асуудал улс төрийн намын журамд тусгагдан, бүх намын бүх түвшинд хэлэлцэгддэг байхад анхаарах нь зүйтэй.

Шигтгээ 23. Хяналтын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлсэн туршлага

2012-2016 оны сонгуульт жилийн хугацаанд Хэрлэн сумын хуралд АН, МАН-ын нийт 15 эмэгтэй төлөөлөгч байсан бөгөөд бид эмэгтэйчүүдийн албан бус бүлэг байгуулсан. Эмэгтэйчүүдийн төлөөллийг ИТХ-ын бүх хороодод хангахын тулд хороо тус бүр дээр хуваагдаж гишүүнээр орж ажилласан. Манай бүлэг төсвийн хэлэлцүүлэг явагдахаас өмнө шийдвэрлэх ёстой асуудлуудын жагсаалтын дагуу тухайн газар дээр нь очиж, үнэхээр тулгамдсан асуудал эсэхийг нь нягталдаг байлаа. Бүтээн байгуулалтын ажлуудын ихэнх нь үр дүн муутай байдаг байсан учраас Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтэд хяналт, үнэлгээ хийсэн.

Хэрлэн сум 10 багтай, хурлын эмэгтэй төлөөлөгч, иргэд, ИНБ-ын төлөөллөөс бүрдсэн Орон нутгийн хяналтын зөвлөлийг баг тус бүр дээр байгуулж, бүтээн байгуулалтын бүхий л үйл явцад өөрсдөө оролцож мөн хяналт тавих үүрэгтэй ажилласан юм. Сумын ИТХ-аас Орон нутгийн хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлан, үйл ажиллагааг нь дэмжиж ажилласан.

Би төлөөлөгчөөр сонгогдоод 9 жил ажиллаж байна. Ер нь бол эмэгтэй, эрэгтэй гэлтгүй дахин сонгогдоход нөлөөлдөг зүйл бол иргэдийнхээ өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн төлөө уйгагүй л ажиллах ёстой гэж би үздэг.

Б.Оюун-Эрдэнэ, Дорнод аймгийн Хэрлэн сумын хурлын төлөөлөгч (2008-2016)

Эмэгтэй төлөөлөгчид оролцоогоо нэмэгдүүлэхийн тулд юу хийх вэ?

Орон нутгийн түвшинд нэр дэвших хүсэл сонирхолтой, эсвэл одоо ИТХ-д сонгогдон ажиллаж байгаа төлөөлөгч хэн нь ч ялгаагүй улс төрийн намтайгаа ажиллах, нөлөөлөх, хяналт үнэлгээ хийх хэрэгтэй.

■ *Хяналт, үнэлгээ хийх*

Эмэгтэйчүүд сонгогдсоныхоо дараа ч эрэгтэйчүүд давамгайлсан орчинд орох бөгөөд тэнд даган мөрдөх дүрэм, журам нь эрэгтэйчүүдийн тэргүүлэх чиглэл, байр суурь, хэрэгцээ, сонирхолд тулгуурлан боловсруулагдсан байдаг.

Тиймээс сонгуульт байгууллагын дүрэм журамд жендэрийн аудит, үнэлгээ хийх нь эмэгтэйчүүд карьераа ахиулахад тулгарч буй тодорхой бэрхшээлийг илрүүлэх, уг төлөөллийн байгууллагыг жендэрийн мэдрэмжтэй болгоход юу хийх хэрэгтэйг тодорхойлоход тусална. Иргэдийн төлөөлөл болохын хувьд эмэгтэйчүүд (мөн эрэгтэйчүүд) төлөөллийн байгууллагын тогтсон улс төрийн соёлыг өөрчлөхийн төлөө ажиллах боломжтой юм.

Шигтгээ 24. Сонгогдох болон томилогдох албан тушаалын квотын хэрэгжилт

Улс төрд эмэгтэйчүүдийн оролцоогоор Увс, Баян-Өлгий аймаг доогуур үзүүлэлттэй байна. Ховд аймаг ч ялгаагүй. Баруун аймгаас эмэгтэйчүүдийн төлөөлөл сайтай нь Завхан аймаг. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуульд аймгийн Засаг даргын тамгын газрын хэлтэс, газрын дарга нарын дунд квот байх ёстой юм байна. Тэр квотыг хуульд 40 хувь гэж заачихсан. Гэтэл Баян-Өлгий, Увс аймагт ганцхан эмэгтэй байх жишээний. Эдгээрт хэн ч хяналт тавьдаггүй.

Үндэсний аудитын газар шалгалт хийхдээ Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн биелэлт хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаггүй. Хуулийн дагуу томилгоо хийгдсэн эсэхийг хянахгүй байгаа учраас эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд оролцох боломж орон нутагт хомс байгаа юм.

Нарантуяа Ховд аймгийн ИТХ-ын төлөөлөгч

■ *Иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах*

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэхэд тулгарч буй бэрхшээл, орхигдсон асуудлыг шийдвэрлэх тодорхой арга, ажлын төлөвлөгөө боловсруулах ёстой. Жендэрийн тэгш байдлыг бодлогын

асуудал болгон анхаарлын төвд хүргэх үр дүнтэй аргуудын нэг нь улс төрийн намууд ба иргэний нийгмийн хамтын ажиллагаа юм.

Тиймээс жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны дэвшлийн төлөө улс төрийн хүчнүүдэд шахалт үзүүлэх чадвартай иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгтэй. Ялангуяа эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх зорилгоор хуульд өөрчлөлт оруулах, эсвэл хууль тогтоомжийг хэлэлцэх үед санал өгөх зэрэг асуудалд улс төрийн намууд нь иргэний нийгмийн байгууллагатай ойр хамтран ажилласан тохиолдолд үр дүнтэй байдаг.

Шигтгээ 25. Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажилласан туршлага

2012-2016 онд аймгийн ИТХ-д АН, МАН, МАХН-аас төлөөлөл бүхий 10 эмэгтэй төлөөлөгч байсан. Бид нэгдээд 2014 онд эмэгтэй төлөөлөгчдийн лобби бүлэг байгуулж эмэгтэйчүүд, залуучуудын чиглэлээр хэд хэдэн асуудлыг шийдвэрлэхийг зорьж, аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргад эмэгтэйчүүд, залуучуудад зориулсан сургалт, сурталчилгаа хийх, жендэрийн тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, хүчирхийллийн хохирогчид зориулсан хамгаалах байр ажиллуулах, эмэгтэйчүүдийн манлайллыг дээшлүүлэх, төрийн чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх журмыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах саналаа танилцуулсан. Эдгээр асуудлаас хамгаалах байрны асуудлыг аймгийн хурлаар хэлэлцэж, тогтмол зардлыг төсөвт тусгуулсан. Мөн аймгийн Цагдаагийн газар байр гаргасан ба уг байрны засварын санхүүжилтийг төсвөөс гаргуулсан.

Би аймгийн ИТХ-ын Нийгмийн бодлогын хорооны гишүүн байсан нь жендэр, эмэгтэйчүүд, залуучуудын асуудлаар санал оруулж, нөлөөлөхөд нэмэр болсон. Мөн бид 2014 онд “Манлайлагч эмэгтэйчүүдийн чуулган” зохион байгуулсан. Үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулж буй Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ, Монголын Эмэгтэйчүүдийн сан зэрэг ТББ-ууд, Хүний Эрхийн Үндэсний Комисс, Жендэрийн Үндэсний Хороо зэрэг төрийн байгууллагуудаар туршлага судлах аялал зохион байгуулсан.

Мөн УИХ дахь эмэгтэй гишүүдийн бүлэг, аймгийн эмэгтэй төлөөлөгчдийн лобби бүлэг, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг орон даяар цахим хэлбэрээр хийсэн нь УИХ-аар хуулийг батлуулахад түлхэц өгсөн.

Д.Чимгээ, Булган аймгийн Хурлын төлөөлөгч (2012–2016)

Мөн хууль, бодлогод өөрчлөлт оруулахаар нөлөөллийн ажил хийхийн тулд намын эмэгтэй гишүүд, иргэний нийгмийн байгууллагууд, түүний дотор эмэгтэйчүүдийн байгууллагуудтай түншлэн ажиллаж болно. Иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл, судалгааны байгууллагатай хамтран эмэгтэй нэр дэвшигчдийн чадавх бэхжүүлэх, улс төр дэх эмэгтэйчүүдийн эсрэг чиглэсэн жендэрээс үүдэлтэй хэвшмэл ойлголтыг няцаах, жендэрийн тэгш байдлын талаарх бодлого, эрх зүйн өөрчлөлт хийхэд хэрэг болох баримт нотолгоо бүрдүүлэх зэрэг арга замаар эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой юм.

■ **Нам доторх эмэгтэйчүүдийн (мөн эрэгтэйчүүдийн) талаар илүү зүйл мэдэж авах**

Нэгэнт намын эмэгтэй гишүүн болохын хувьд намын бусад эмэгтэй (эрэгтэй) гишүүдийн талаар, өөрөөр хэлбэл, тэд хэр идэвхтэй ажилладаг, ямар албан тушаал хашдаг, ямар ур чадвартай зэргийг мэдэж авах нь чухал. Нэг намын гишүүд үзэл суртал, улс төрийн хувьд тодорхой хэмжээгээр холбоотнууд боловч тухайн эмэгтэйн хувьд намын албан тушаал, ялангуяа шийдвэр гаргах албан тушаал, нэр дэвшилтийн хувьд өрсөлдөгчид юм. Эмэгтэйчүүд өөрийн холбоотон ба өрсөлдөгчөө тодорхойлохын улд намын бусад эмэгтэй (эрэгтэй) гишүүдийг, мөн тэд хэр идэвхтэйг зураглан үзэж болох юм. Үүнд: тэдгээр эмэгтэйчүүд орон нутаг, бүс, үндэсний гэх мэт намын аль шатанд ажилладаг, шийдвэр гаргах ямар албан тушаал хашдаг (жишээлбэл, гүйцэтгэх хороо, удирдах зөвлөлийн гишүүн, намын их хурлын төлөөлөгч, сурталчилгааны менежер, намын фракц, эмэгтэйчүүдийн бүлгийн ахлагч гэх мэт), мөн ямар сонгуульт албан тушаал хашдаг (орон нутаг, хотын зөвлөлийн гишүүн, Засаг дарга, УИХ-ын гишүүн) зэрэг мэдээллийг цуглуулж болно.

Намын албан тушаал сулрах, нэр дэвших ажиллагаа эхлэхэд эдгээр эмэгтэй дахин томилогдох эсвэл сонгогдохыг эрмэлзэх магадлал хэр вэ? Тэд нам дотроо, намын удирдлага, мөн сонгогчдын дунд хэр танигдсан бэ? Эцэст нь, тэдгээр эмэгтэйн боловсрол, мэргэжил, ур чадвар, мэргэшлийн талаар мэдэж авах нь зүйтэй. Ингээд уг мэдээллээ эмэгтэйчүүдийн дунд эвсэл, сүлжээ, эв санааны нэгдэл бий болгоход, тухайлбал, намын эмэгтэйчүүдийн бүлэг зэргийг байгуулахад ашиглаж болно. Түүнчлэн нам дотор зарим асуудлаар байр сууриа ахиулахад тэд холбоотон болж, шийдвэр гаргах түвшний албан тушаалд очиход дэмжих, сонгуульд өрсөлдөхөд дэмжих боломжтой.

■ Нийгмийн сүлжээг ашиглах

Нийгмийн сүлжээний шинэ хэлбэрүүд нь сонгуулийн сурталчилгаа хийх, ер нь улс төр хийх аргыг өөрчилж байна. Цахимд суурилсан хэрэгслүүд нь улс төрчид, улс төрийн байгууллагууд, сонгогчдын хоорондын харилцааны шинэ сувгууд бий болгоход тусалж байна. Нийгмийн сүлжээний арга хэрэгслүүдээс дурдвал:

- o Facebook
- o Твиттер
- o Блог
- o Нийгмийн сүлжээний цахим хуудсууд
- o Гар утасны мессэж үйлчилгээ.

Эмэгтэйчүүд улс төрийн харилцаа үүсгэх эдгээр шинэ хэлбэрийг ашиглах боломжийг алдаж болохгүй. Эдгээр нь:

- Нэгдүгээрт: сонгогчидтой холбогдох зардал багатай арга юм.
- Хоёрдугаарт: нийгмийн сүлжээ нь нэр дэвшигч, сонгогч хоёр шууд харилцах боломж олгодог бөгөөд нам, хэвлэл мэдээллийн байгууллагаас нэр дэвшигчдэд олгох нэвтрүүлгийн цаг, сурталчилгааны ажлын санхүүжилтээс хамааралгүй байдаг.
- Гуравдугаарт: нийгмийн сүлжээгээр дамжуулан сонгогчидтой шууд холбогдох боломжийг ашиглан эмэгтэй нэр дэвшигчид залуу сонгогчдыг хэрхэн ойлгож, хүндэтгэж байгаагаа илэрхийлж болно. Учир нь цахимд суурилсан нийгмийн сүлжээг ашиглагч нь голдуу залуучууд байдаг.

Орон нутгийн хурлын төлөөлөгчид, тэр тусмаа эмэгтэй төлөөлөгчдийн хувьд тухайн аймаг, дүүргийнхээ хурлын нэгдсэн цахим хуудаст өөрсдийн мэдээллийг тогтмол оруулж, хийж буй ажлаа тайлагнаж, мэдээлж байх хэрэгтэй.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нэгдсэн цахим хуудас буюу <http://www.khural.mn> хаяг дээр төлөөлөгчийн хувьд хийсэн ажил, хамтын ажиллагаагаа сурталчлах хэрэгтэй. Энэ цахим хуудас дээр “Сайн туршлага, хамтын ажиллагаа” гэсэн цонх байдгийг Та бүхэн мэднэ.

Шигтгээ 26. Сум хөгжүүлэх сангийн хэрэгжилтэд хяналт тавьсан туршлага

Сум бүрт байдаг сум хөгжүүлэх сангийн Хяналтын зөвлөлийг ахлан ажиллалаа. Энэ санд тавих хяналтын ажлыг бодлогын болон хэрэгжилтийн түвшинд хийхийг зорьсон. Сумын нийгэм, эдийн хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө болон сум хөгжүүлэх сангийн зээлийн олголт хоёрт харьцуулсан мониторинг хийж, дүгнэлт, зөвлөмж гарган сумын Засаг дарга, түүний Тамгын газарт ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын хамт хүргүүлсэн.

Тус төлөвлөгөөг боловсруулахад иргэд, бизнесийн төлөөлөл болон төрийн байгууллагын салбар бүрийн оролцоог хангасан эсэх, Арвайхээр суманд хэрэгжих эн тэргүүний бизнесийн чиглэлүүдийг тодорхойлсон эсэх, мөн сумын хөгжлийн сангийн зээл нь энэ чиглэлүүдэд хэрхэн нийцэж байна гэдэг дээр мониторинг хийгдсэн гэсэн үг юм.

**Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ИТХ-ын төлөөлөгч
Н.Эрдэнэсүвдтай хийсэн ярилцлагаас, 2016**

Шигтгээ 27. Бодлого, шийдвэрт иргэдийн оролцоог хангасан туршлага

Говь-Алтай аймгийн Алтай сумын ИТХ нь төрийн байгууллагуудаас гарч байгаа бодлого, шийдвэрт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сард хоёр удаа иргэдийн дунд “236”, “336” гэсэн уулзалт, хэлэлцүүлгийн арга хэмжээг зохион байгуулдаг ажээ.

“236”: Сар бүрийн 2 дахь долоо хоногийн 3 дахь өдрийн 6 цагаас төрийн байгууллагууд иргэдэд зориулан ажлын тайлангаа хэлэлцүүлэх уулзалтыг зохион байгуулдаг.

“336”: Сар бүрийн 3 дахь долоо хоногийн 3 дахь өдрийн 6 цагт ИТХ-аас иргэдэд шинээр гарсан дүрэм, журам, хууль эрх зүйн, болон шинэ мэдээ мэдээллийг өгдөг.

ИТХ-аас 2012-2015 онд Тэргүүлэгчдийн 37 удаагийн хурлаар 80 тогтоол, ИТХ-ын 11 удаагийн хурлаар 68 тогтоол шийдвэр гаргасан бөгөөд тэдгээрийг иргэдэд танилцуулах аяныг зохион байгуулж, тогтоол, шийдвэрийн эмхэтгэлийг сумын бүх өрхүүдэд хүргүүлж, танилцсан хүмүүсийн саналыг бичгээр авч, хурлаас гарч байгаа шийдвэртээ тусган ажилладаг байна.

■ Жендэрийн тэгш байдлыг дэмжсэн намын хөтөлбөр боловсруулах, сургалт хийх асуудлыг лоббидох

Эмэгтэйчүүд дангаараа эсвэл хамтдаа намын шинэ гишүүдэд зориулсан сургалт бүрт жендэрийн тэгш байдлыг нэг сэдэв болгон оруулж байхаар нам дотроо нөлөөллийн ажил хийж болно. Энэ сэдвийг эмэгтэйчүүдийн байгууллагын гишүүд (хэрэв байдаг бол), нам

доторх жендэрийн нэр хүнд бүхий тэмцэгч эсвэл гаднаас жендэрийн эсвэл улс төрийн мэргэжилтэн урьж авчран заалгаж болно. Намын удирдлага, шийдвэр гаргагчид мөн уг сургалтад ядаж нэг удаа суух хэрэгтэй бөгөөд жендэрийн асуудлыг тусгаж чадах эсэх нь намын удирдлагаас ирэх дэмжлэгээс ихээхэн хамааралтай.

Намаас гишүүддээ зориулан чадавх бэхжүүлэх, сургалтын хөтөлбөр гаргасан бол эмэгтэйчүүд жендэрийн тэгш байдал, жендэрийн асуудлыг тусгах гэсэн сэдвийг заавал үзэх сэдэв болгохын төлөө нөлөөллийн ажил хийж болно. Түүнчлэн намаас зохион байгуулж буй сургалтад эмэгтэй, эрэгтэй гишүүд хамрагдах тэгш боломжтой байх үүднээс сургалтад хэн хамрагдах талаар шалгуур байгаа эсэхийг олж мэдэх хэрэгтэй. Эмэгтэйчүүд намын удирдлагадаа нөлөөлөн, намын гишүүдээс жендэрийн асуудлыг намын бүх үйл явц, журам, практикт тусган авч үзэх мэдлэг туршлага бий болгож, хөгжүүлэхийн тулд жендэрийн тэгш байдал, жендэрийн төсвийн ахисан шатны сургалтад суух сонирхолтой намын гишүүдэд санхүүжилт олгуулахаар хөөцөлдөж болно. Энэ нь жендэрийн тэгш байдлын талаарх тухайн сэдвээр дотоод чадавх бүрдүүлэхэд ач холбогдолтой.

■ *Нам үл харгалзан эмэгтэйчүүдтэй хамтран ажиллах*

Нам дотроо эмэгтэйчүүдтэй эв санааны нэгдэлтэй байж, хамтрахаас гадна нийтлэг эрх ашиг хөндөгдөж байгаа асуудлаар нам үл харгалзан хамтран ажиллаж болно. Тухайлбал, нийгэмд буй жендэрийн ялгаварлан гадуурхлын талаар ойлголт нэмэгдүүлэх ажлыг нам үл харгалзан хийж болно.

Шигтгээ 28. *“Тэгш төлөөлөлтэй Парламент” аян*

Португалд хэрэгжүүлсэн “тэгш төлөөлөлтэй Парламент” аяныг 3 эмэгтэй гишүүний санаачилгаар Европын парламентын 1994 оны сонгуулийн өмнөхөн өрнүүлсэн.

Тэд нийт 115 эмэгтэй, 115 эрэгтэй улс төрчийг парламентын нэг өдрийн хуралд урьж, ардчиллын асуудал, төрийн үйл хэрэгт эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг, төлөөлөл, тэгш боломж зэрэг асуудлыг хэлэлцсэн. Уг арга хэмжээ нь парламентын суудлын 50 хувийг эмэгтэй, 50 хувийг эрэгтэйчүүд эзэлж буй тохиолдолд бодлого боловсруулах үйл явц ямар байхыг харуулахыг эрмэлзсэн.

■ *Нам дотроо эвсэл, эв нэгдэл бий болгох*

Эмэгтэйчүүдийг хүнтэй харилцахдаа сайн, зөвшилцөл бий болгож, бас холбож чаддаг гэж үздэг. Гэвч эрэгтэйчүүд ч улс төрийн сүлжээг

(ялангуяа албан бус аргаар) сайн бүрдүүлж чаддаг. Улс төрд сүлжээ, эвсэл бий болгох аргуудаас дурдвал:

- Бизнес эрхлэгчидтэй холбоо үүсгэх;
- Эрхэлж буй ажлынхаа холбоог ашиглах, мөн уг холбоог ашиглан танилын сүлжээгээ өргөжүүлэх;
- Клуб, паб, фитнес, бусад газар албан бусаар уулзах;
- Хандивлагч, ивээн тэтгэгчид цугларч буй арга хэмжээнд очих;
- Хэн хэнд нь хэрэгтэй албан бус “хэлэлцээ”хийх;
- Санаа, амжилтаа сурталчлахын тулд хэвлэл мэдээллийг бүрэн ашиглах.

Хувийн, эсвэл албан ажилтай холбоотой ч бай ялгаагүй уулзалт бүрийг өөрийн дүр төрх, ололт амжилт, улс төрийн байр сууриа танилцуулах боломж гэж харах хэрэгтэй. Тиймээс улс төрийн карьераа ахиулахыг сонирхож буй эмэгтэйчүүд дор бүрнээ уулзалт, арга хэмжээ бүрийг өөрийн санаа, хувь нэмрийг хүргэх боломж гэж харж, нөлөө бүхий шийдвэр гаргагч, олон нийтийн санаа бодолд нөлөөлөгч талуудтай холбоо тогтоон, дэмжигчдийн сүлжээг бий болгож эхлэх нь зүйтэй.

Үүний зэрэгцээ хамтдаа дэмжлэг үзүүлэх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн албан ба албан бус сүлжээ байгуулан, нам дотроо карьераа ахиулахад бэлэн чадвартай олон тооны эмэгтэй байгаа талаар сурталчилж, намын эмэгтэй гишүүдийн санаа зовж буй асуудлаар хамтран ажиллаж, тэдэнд тулгамдаж буй асуудал, бэрхшээлээ илэрхийлэх эерэг, аюулгүй орон зай бий болгоход дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Шигтгээ 29. Эмэгтэй төлөөлөгчид хамтран ажилласан туршлага

Би аймгийн 4-р багийг төлөөлж сумын хуралд төлөөлөгчөөр сонгогдсон, мөн багийнхаа Иргэдийн Нийтийн Хурлын даргын үүргийг гүйцэтгэдэг. Манай багийг зээлийн хороо гэж нэрлэдэг бөгөөд дийлэнх оршин суугчид нь зах дээр мах, сүү борлуулдаг хүмүүс байдаг. Гэр хороолол зонхилсон, ажилгүйдэл ихтэй баг. Манай багаас сумын Хуралд гурван эмэгтэй төлөөлөгч сонгогдсон. Бид ажилгүй иргэдийг хувийн хэвшил, компанид ажилд оруулахаар зуучилж өгдөг бөгөөд одоогоор 8 хүнийг ажилтай болгож өгсөн.

Сумын хуралд байгаа эмэгтэй төлөөлөгчид бид нэг намаас сонгогдсон тул бүлэг байгуулан ажиллах шаардлага гараагүй. Харин тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд хамтран ажиллаж байгаа ба эрэгтэй төлөөлөгчдөд нөлөөлөл үзүүлж чадсан. Тухайлбал, манай 4-р багт хүүхдийн тоглоомын талбай байдаггүй. Аймгийн

төвийн бусад бүх багт тоглоомын талбай байдаг юм. Тиймээс энэ багаас сонгогдсон гурван эмэгтэй төлөөлөгч бид сумын хуралд санал оруулж, Орон нутгийн хөгжлийн сангаас тоглоомын төв байгуулахад зарцуулах 30 сая төгрөгийг төсөвт тусгуулж батлуулсан.

Мөн сумын хурлын эмэгтэй төлөөлөгчид заавал төсвийн мөнгө гэж хүлээлгүйгээр өөрсдөө хандив цуглуулан хөгжлийн бэрхшээлтэй, өрхийн орлого багатай айлуудад тусламж дэмжлэг үзүүлдэг.

Ц.Эрдэнэчимэг, Архангай аймгийн Эрдэнэбулган сумын ИТХ-ын төлөөлөгч (2008-одоо хүртэл)

■ **Улс төр дэх эмэгтэйчүүдийн талаар нотолгоонд суурилсан судалгаа хийх**

Иргэний нийгмийн байгууллага дангаараа эсвэл судалгааны байгууллагатай хамтран улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар сонгогчдын байр суурь, хандлагыг харуулсан судалгаа хийх хэрэгтэй. Энэ нь сонгуулийн өмнө эмэгтэй нэр дэвшигчдэд хэрэгтэй мэдээлэл болох төдийгүй сонгогдсон эмэгтэй төлөөлөгчдийн талаарх иргэд, сонгогчдын хандлагыг мэдэхэд тустай байдаг.

Шигтгээ 30. Нотолгоонд суурилсан нөлөөлөл

... УИХ-ын болон орон нутгийн сонгуульд өрсөлдөж буй эмэгтэй нэр дэвшигчдийн талаарх олон нийтийн санал бодлыг тандах судалгааг 2008 онд МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ, IRIM судалгааны хүрээлэнгээс хамтран хийсэн. Энэ судалгаагаар нийт оролцогчийн талаас илүү хувь нь (59 хувь) нэр дэвшигчийн хүйс сонгуульд санал өгөхөд шийдвэрлэх хүчин зүйл болно гэж хариулсан бол 38 хувь нь нэр дэвшигчийн хүйс гол асуудал биш гэж хариулжээ.

... Орон нутагт сонгогдох болон томилогдох албан тушаалд байгаа эмэгтэйчүүдэд нөлөөлсөн гол хүчин зүйлийг судлахаар Монголын эмэгтэйчүүдийн сангаас эрхлэн судалгаа хийсэн. Уг судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 48 хувь нь тэдний нэр хүнд, олонд танигдсан байдал нь сонгуульд ялахад чухал хүчин зүйл болсон гэж хариулжээ. Эмэгтэй нэр дэвшигч сонгуульд ялалт байгуулахад нөлөөлөх хоёрдогч шалтгаан бол тухайн нэр дэвшигчийн харьяалагддаг улс төрийн намын нэр хүнд гэж нийт судалгаанд оролцогчдын 23.1 хувь нь хариулжээ. Бусад хүчин зүйлст боловсролын байдал, нэр дэвшигчийн үзэл бодол, (13.8 хувь), нэр дэвшигчийн үнэнч, тууштай байдал (15.4 хувь) зэрэг багтсан байна...

Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: (Нөхцөл байдлын товч үнэлгээ, Баримт бичгийн судалгаа, 2014)

Улс төрд, ялангуяа шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байгаа тул улс төрд орох эмэгтэйчүүд, эмэгтэй манлайлагчдыг тодорхойлж, дэмжих нь нэн чухал. Эмэгтэйчүүд намынхаа бусад эмэгтэйчүүдтэй уг мэдээллийн сангаа хуваалцаж, улс төр хөөх боломжтой эмэгтэйчүүдийн сан бүрдүүлж болно. Мөн янз бүрийн тохиолдлоор уулзаж, өндөр сэтгэгдэлтэй үлдсэн эмэгтэйчүүдийнхээ талаар тэмдэглэл хийж, тэднийг ирээдүйд хэрхэн татан оролцуулахаа бодож болно. Энэ нь орон нутгийн сонгуульд өрсөлдөхийг хүсч буй тухайн орон нутгийнхаа намын үүрт идэвхтэй ажилладаг эмэгтэйчүүдийн хувьд бас чухал арга юм.

Шигтгээ 31. Чадвартай эмэгтэйчүүдийн талаарх мэдээллийн сан

Шведийн парламентын гишүүн Анита Градин янз бүрийн уулзалт, нийтийн сонсгол, арга хэмжээн дээр уулзсан эмэгтэйчүүдийнхээ талаар тэмдэглэж авдаг жижиг хар тэмдэглэлийн дэвтэр байнга авч явдаг байв. Сонирхолтой танилцуулга, дүн шинжилгээ хийж, түүнд сэтгэгдэл төрүүлсэн эмэгтэйчүүдийг тэрээр уг дэвтэртээ бичиж авдаг байв. Ингээд намаас нь аль нэг албан тушаалд нэр дэвшүүлэх хэрэгтэй болоход тэр дэвтрээ харна. Түүний дэвтэр бол чадвартай, мэргэжлийн эмэгтэйчүүдийн талаарх мэдээллийн сан байсан тул тохирох эмэгтэй нэр дэвшигчийг намдаа олж өгч чаддаг байснаас гадна улс төр сонирхдог эмэгтэйчүүд алга гэх намын ажилтнуудын үгийг няцааж чаддаг байв.

Хожим Градин Шведийн Засгийн газарт сайд болж, жендэрийн тэгш байдлын үндэсний комисс байгуулсан.

6.3. ЭМЭГТЭЙ ТӨЛӨӨЛӨГЧИД ӨӨР ХООРОНДОО ХАМТРАН АЖИЛЛАХ, ХАМТЫН СОНИРХЛЫГ ХӨНДСӨН АСУУДЛААР НЭГДЭЖ АЖИЛЛАХ АРГА, ТУРШЛАГА

 Дэмжих сүлжээг бий болгож, өргөжүүлэх

Улс төрд амжилт гаргах эсэх нь тухайн оронд улс төрийн намууд яаж ажилладаг, мөн улс төрчдийн авчрах ур чадвар, туршлагаас ихээхэн хамаардаг. Гэвч эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх сүлжээ байхгүй бол, ялангуяа гэр бүлийн ойрын гишүүдээс дэмжлэг үгүй бол улс төрийн карьераа ахиулах маш хэцүү. Эмэгтэйчүүд улс төрийн нэлээд өндөр түвшинд гарч чадсан ч тухайн туулж өнгөрүүлсэн үе нь таатай, урамтай байж чадахгүй юм. Ийм дэмжих сүлжээ нь өөр хоорондоо өрсөлдөгч тэргүүлэх чиглэлийг тэнцвэртэй авч үзэх, улс

төрийн ажилд суралцахад туслахын зэрэгцээ эмэгтэй нэр дэвшигчдэд заавар, удирдамж, дэмжлэг үзүүлж чадна.

Карьераа ахиулах төлөвлөгөө гаргахдаа эмэгтэйчүүд одоо байгаа болон ашиглах боломжтой нөөцөөс гадна дэмжих сүлжээгээ хөгжүүлэхэд анхаарах ёстой. Тийм дэмжих сүлжээг гурван аргаар хөгжүүлж болно. Үүнд:

- *Одоо байгаа хувийн сүлжээ:* гэр бүл (хүүхэд, эхнэр, нөхөр, эцэг эх, ах, эгч, дүү, хамаатнууд), найз нөхөд, нийгмийн сүлжээ, хөршүүд;
- *Мэргэжлийн сүлжээ:* мэргэжлийн холбоод (ажлын байр, мөн тухайн чиглэлийн мэргэжилтнүүдийг нэгтгэсэн холбоод), буяны байгууллагууд, нутгийн холбоо, оюутны сүлжээ, багш-эцэг эхийн холбоо зэрэг багтана. Үүнд: эмэгтэйчүүдийн үнэлэмж, зарчмыг тусгасан үзэл санааны болон шашны сүлжээ ч багтаж болно. Мөн эмэгтэйчүүдтэй холбоотой чиглэлээр бизнес эрхлэгч буюу хандивлагч болж болзошгүй хүмүүс байж болно. Эцэст нь, улс төрийн ментор буюу дагуулан сургагч нь мэргэжлийн сүлжээдийн нэг хэсэг байж болох бөгөөд сонгуульд өрсөлдөх, нам дотроо албан тушаал ахих сонирхолтой эмэгтэйчүүдэд тусалж болно.
- *Бусад сүлжээ:* тухайн орон нутгийн бизнесийн зөвлөл, нутгийн удирдлагын байгууллага, сайн дурын эсвэл буяны нийгэмлэг, намтай холбоотой бүлгүүд, мэргэжлийн холбоод, хэвлэл мэдээлэл ба харилцааны бүлгүүд, мөн эмэгтэйчүүдийн үнэлэмж ба итгэл үнэмшлийг тусгасан бусад холбоод, эмэгтэйчүүдийг дэмждэг хандивлагч, санхүүжүүлэгчид, кампанит ажилд дэмжлэг үзүүлэгчид үүнд багтана.

Шигтгээ 32. Эмэгтэй төлөөлөгчдөөс бусад байгууллагатай хамтран ажилласан туршлага

Би аймгийн ИТХ-д 3 удаа дараалан сонгогдсон. Аймгийн хуралд хамгийн ихдээ л 6 эмэгтэй төлөөлөгч байдаг байсан бөгөөд бүгдээрээ ИТХ-ын Нийгмийн бодлогын хороонд ажилладаг байлаа. Бид сургалт, сурталчилгааны чиглэлээр голдуу үйл ажиллагаа явуулж байсан. Жишээ нь, аймгийн хэмжээнд нэн тулгамдсан асуудал болох өсвөр насны охидын жирэмслэлт, үр хөндөлтийн асуудлаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, бүх шатны эрүүл мэндийн болон хүүхдийн байгууллагатай хамтран хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэ асуудал далд хэлбэрээр явагддаг тул тохиолдол бүрт хэлэлцүүлэг хийж, асуудлыг шийдвэрлэж байлаа. Мөн аймаг, сумын түвшинд хавдраар өвдсөн

хүмүүст “Амьдралын хэв маяг” сургалтыг тогтмол зохион байгуулсан.

2006 оноос эмэгтэй төлөөлөгчид хамтран аймаг, сумын түвшинд урьдчилан сэргийлэх үзлэг хийх зорилгоор явуулын амбулаторийг ажиллуулах санал гаргаж, уг үйл ажиллагааны зардлыг жил бүрийн аймгийн төсөвт тусгадаг болсон юм. Энэ үйл ажиллагааг зуны улирлаас эхлэн намар хүртэл сумдын бүх багт зохион байгуулдаг бөгөөд жилд дунджаар 40-60 сая төгрөгийг уг үйл ажиллагаанд зарцуулдаг. 2006 оноос хойш аймгийн ИТХ-д аль нам нь олонх болсон ялгаагүй явуулын амбулаторийн үйл ажиллагааг дэмжиж, тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд энэ жил гэхэд 69 сая төгрөгийг төсөвт тусгасан байгаа.

Ц.Алимаа, Увс аймгийн ИТХ-ын төлөөлөгч (2004–2016)

Шигтгээ 33. Эмэгтэй төлөөлөгчид хамтран цэцэрлэг байгуулах зардлыг олон талт эх үүсвэрээс босгосон туршлага

2012-2016 онд төлөөлөгчөөр сонгогдон ажилласан 6 эмэгтэй хамтран цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хамгийн их хүүхэдтэй гэр хорооллыг сонгож, цэцэрлэг барих аяныг санаачилсан юм. Нийт 390 сая төгрөгийн санхүүжилт хэрэгтэй гэсэн тооцоо гарсан. Үүнээс 120 сая төгрөгийг иргэд, байгууллагын хандиваар цуглуулж чадсан. Үлдэгдэл 270 сая төгрөгийн санхүүжилтийг жил, жилийн Орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт суулгуулж, 2014 онд 100 сая төгрөг, 2015 онд 80 сая төгрөг, 2016 онд 90 сая төгрөгийг батлуулж, гурван жилийн хугацаанд цэцэрлэгийг барьж ашиглалтад оруулсан. Одоо 125 хүүхэд энэ цэцэрлэгт явж байна.

Энэ сонгуульт жилийн хугацаанд 50 ортой хүүхдийн эмнэлэг барих ажлыг эхлүүлэх зорилготой тооцоо, зураглалыг гаргасан байгаа.

Ж.Дулмаа, Баянхонгор аймгийн ИТХ-ын төлөөлөгч (2004–одоо хүртэл)

✿ Нам дотроо эмэгтэйчүүдийн бүлэгт нэгдэх, эсвэл тийм бүлэг байгуулах

Эмэгтэйчүүдийн бүлэг, жигүүр гэх мэтээр нэрлэгддэг намын эмэгтэйчүүдийн байгууллагууд нь намын эмэгтэй гишүүдээс бүрдсэн намын дотоод нэгж юм. Тэдгээр нь эмэгтэйчүүдэд бодлогын тэргүүлэх чиглэлээ илэрхийлэх, тодорхой асуудлаар хамтарсан нөлөөллийн ажил хийх, эмэгтэйчүүд карьераа ахиулах чадавх бэхжүүлэхэд нь туслах, жендэрийн тэгш бус байдал, жендэрээс үүдэлтэй ялгаварлан гадуурхлын талаар ойлголт мэдлэгийг дээшлүүлэх зэрэг янз бүрийн ажил хийх зорилго тавьдаг. Эмэгтэйчүүдийн зарим байгууллага

жендэрийн аудит зэрэг судалгаа, үнэлгээний ажил хийж, намын дүрэм, бодлого, хөтөлбөрт жендэрийн тэгш байдал, тэнцвэрийн талаар тусгуулах нөлөөллийн ажил хийн, намын мөрийн хөтөлбөр боловсруулахад хувь нэмэр оруулдаг.

🌸 *Эрэгтэйчүүдийг улс төрийн түнш, жендэрийн асуудлаар тэмцэгч болгон хамтран ажиллах*

Улс төрийн оролцооны асуудлаар тууштай тэмцэгч олон эмэгтэй байдгийн адил эрэгтэйчүүд дотор ч бас тийм хүмүүс бий. Гэвч жендэрийн тэгш байдлыг хангах үйлсэд харагдахуйц хувь нэмэр авчрах эрэгтэйчүүдийг татан оролцуулахад бэрхшээл байсаар байгаа. Эрэгтэйчүүдийн хөрөнгө нөөц, дэмжлэгийг авснаар эмэгтэйчүүдийн бүлгийн ажлын үр дүн дээшлэх бөгөөд эмэгтэй улс төрчдийн дэвшүүлж буй асуудал илүү өргөн хүрээний дэмжлэг авч чадна. Түүний зэрэгцээ эмэгтэй улс төрч жендэрийн тэгш байдлын асуудлаар эрэгтэйчүүдээс дэмжлэг авч чадвал энэ нь тэднийг зөвхөн эмэгтэйчүүдийн асуудлаар л хөөцөлддөг гэх шүүмжлэлийг сулруулна. Үнэндээ жендэрийн тэгш байдлыг тогтоох нь эрэгтэйчүүдэд ч адил тэгш хамаатай бөгөөд эрэгтэй улс төрчдөд ч ашиг тустай байдаг. Энэ эвслийг амжилттай бий болгохын тулд эмэгтэй, эрэгтэй хүмүүс харилцан зөвшилцөлд хүрч чадахуйц жендэрийн тэгш байдал хөндөгдсөн асуудлыг олж тогтоох нь чухал.

6.4. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Эмэгтэйчүүд сонгогдох үедээ төдийгүй сонгогдсоны дараа ч олон тооны саад тогторуудтай тулгарч байна. Тэдний боломж, давуу тал нь хувь хүний түвшинд түлхүү байгаа бол саад тогтор, сорилт нь бүтэц, тогтолцооны түвшинд байна.

Улс төрийн шийдвэр гаргах түвшинд оролцох, нэр дэвшихийн тулд эмэгтэйчүүд өөрсдийгөө хөгжүүлэх, танигдах, хүлээн зөвшөөрөгдөх зэрэг хувийн хөгжил, хувийн манлайлал дээр анхаарах нь дангаараа хангалтгүй. Үүнээс гадна нийгэмд эмэгтэйчүүдийн дүр төрх, үнэлэмж, үүрэг хариуцлага, байр суурийн талаар тогтсон хэвшмэл хандлага, эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлаж байгаа сонгуулийн тогтолцоо, улс төрийн намын санхүүжилт зэрэг нийтлэг эрх ашгийг хөндөж байгаа тогтолцооны саад, бэрхшээлийг өөрчлөхөд хамтын хүчин чармайлтаа нэгтгэх зайлшгүй шаардлагатай.

Энэ нь эмэгтэйчүүд нийтлэг эрх ашгийнхаа төлөө нам үл харгалзан нэгдэх, хамтын манлайллыг хэрэгжүүлэх шаардлага байгааг харуулж байна.

Ашигласан материал

- Ардчилал, сонгуулийн туслалцааны олон улсын хүрээлэн. Парламент дахь эмэгтэйчүүд: Тоо ба агуулга, 1998 он.
 - International Institute for Democracy and Electoral Assistance (IDEA), Women in Parliament: Beyond Numbers, 1998
- Европын зөвлөл, Чадавхи бэхжүүлэх багц материал, 2005
 - Council of Europe, Capacity Building Toolkit, 2005
- Жексон, Парри, Манлайллын талаарх товч, сонирхолтой, хямд ном, 2008.
 - Brad Jackson and Ken Parry, Very Short, Fairly Interesting and Reasonably Cheap Book about Leadership, London: Sage Publications Ltd., 2008
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Азийн сан, “Хамтдаа оролцъё!” Иргэдийн оролцооны гарын авлага, Улаанбаатар, 2015 он.
- НҮБХХ, Ази, Номхон далайн бүс нутгийн сонгуульд албан тушаал дахь жендэрийн тэгш байдал, Бангкок, 2012.
 - UNDP, Gender Equality in Elected Office in Asia Pacific: Six Actions to Expand Women’s Empowerment, 2012
- НҮБХХ, Ази, Номхон далайн орнуудын орон нутгийн захиргаанд эмэгтэйчүүдийн төлөөлөл: Нөхцөл байдлын тайлан, 2010 он.
 - UNDP, Women’s Representation in Local Government in Asia-Pacific: Status Report, 2010
- НҮБХХ, Жендэрийн тэгш байдал: Орон нутгийн түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо ба манлайлал, 2013 он.
 - UNDP, Gender Equality: Women’s Participation and Leadership in Governments at the Local Level, Asia and the Pacific
- НҮБХХ, УИХ-ын Тамгын газар, Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх төсөл, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Увс, Өмнөговь аймагт явагдсан ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн манлайллын сургалтын тайлан, 2015 он.
- Нутгийн удирдлага сэтгүүл, ИТХ, Иргэдийн нийтийн хурлын үйл ажиллагаанд иргэдийг оролцуулах арга зам, Улаанбаатар, 2011 он.
- МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ, “Эмэгтэйчүүдийн улс төрийн нөлөөлөл, манлайллын чадварыг бэхжүүлэх” сургалтын гарын авлага, Улаанбаатар, 2010 он.
- Чанцалдулам, Ж, Иргэний танхимын хөтөч, Улаанбаатар, 2013 он.
- Нийгмийг хувьсган өөрчлөх манлайлал: Ээдрээтэй ойлголтуудыг тодорхой болгох нь, КРИА, 2011
- Нийгмийг хувьсган өөрчлөх манлайлал, КРИА, 2014

ХАВСРАЛТ

1. Иргэдийн оролцоог баталгаажуулсан хуулиудын харьцуулалт
2. Дөрвөн хуулиар баталгаажуулсан ИТХ-аас зохион байгуулах боломжтой 6 төрлийн сонсох ажиллагааг хэрхэн хэрэглэх тухай харьцуулсан ойлголт
3. Нийтийн сонсгол зохион байгуулах журам
4. Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу орон нутгийн сонсгол явуулах ИТХ-ын хүсэлтийн жишээ

ИРГЭДИЙН ОРОЛЦООГ БАТАЛГААЖУУЛСАН ХУУЛИУДЫН ХАРЬЦУУЛАЛТ

ИТХ-ын төлөөлөгч нь ИРГЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ МЭДЛИЙГ БАРИХ эрхийг ТӨЛӨӨЛСӨН ТӨЛӨӨЛЛИЙН хувьд хөгжлийг өргөн хүрээнд авч үзэж буй өнөөгийн нөхцөл байдлыг, нөгөө талаас хөгжилд оролцогч өөр ашиг сонирхол бүхий олон талууд бий болсныг мэдэрч сонгогчид, иргэдийнхээ хүсэл санаа, эрэлт хэрэгцээг мэдэхгүйгээр, оролцуулахгүйгээр тэдний өмнөөс шийдвэр гаргах ямар ч боломжгүй бөгөөд шийдвэр гаргалаа ч асуудлыг шийдэх үр нөлөөтэй бодлого, шийдвэр гаргаж чадахгүй юм.

Ийм л учраас иргэдийн оролцоог баталгаажуулсан хууль тогтоомжууд бий боллоо. Хэрэв эдгээр хууль тогтоомжийг мөрдөөгүй, хэрэгжүүлээгүй бол ИТХ-аас гаргасан аливаа бодлого шийдвэр нь өөрөө илт хууль болохыг ч мөн эдгээр хуулиар зааж өгсөн байна.

Иймд ИТХ-аар тогтмол хэлэлцэн батлаж, хэрэгжилтийг тогтмол үнэлдэг дараах бодлогын баримт бичгүүдээ боловсруулах, хэрэгжилтийг үнэлэхэд иргэдийн оролцоог хангах хуулийг хэрэглэх асуудал чухлаар тавигдаж байгаа юм. Энэ нь

1. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр үнэлж дүгнэхэд
2. “Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих Дэд хөтөлбөр”-ийн төсөлд санал дүгнэлт гаргах, батлах, хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгөх
3. Жил бүрийн “Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төсөлд санал дүгнэлт гаргах, батлах, хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгөхөд энд дурьдах арга, аргачлалыг боломж болгон ашиглахыг санал болгох юм.

Иргэдээ сонсох ажиллагааны үндсэн зорилго нь тухайн хэлэлцэн шийдвэрлэх бодлогын асуудлаар иргэд, байгууллагаас санал, шүүмжлэл, зөвлөмж хүлээн авч, тэдгээрийг нэгтгэн бодлого, шийдвэрийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах, асуудал шийдвэрлэхэд ашиглах явдал юм. Сонсгол нь иргэдийн нээлттэй цуглаан, хурал, хэлэлцүүлэг биш, ялгаатай зохион байгуулалт шаарддаг. Сонсох ажиллагаанд оролцогчид тодорхой журам, дэгийн дагуу ихэвчлэн хуралдаан даргалагчийн зүгээс оролцох хүмүүсийн тоог харгалзаж тогтоосон хугацаанд эрэмбэ дараалал, эмх цэгцтэйгээр байр сууриа илэрхийлэх хэлбэрээр явагддаг.

Иргэдийн оролцооны хуулиудын ИТХ-тай холбогдох гол заалтууд:

- А. “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-ийн (ХБТТХ) 19-р зүйл. 19.2.1 болон 19.2.4 дэх хэсэг; 15-р зүйл. 15.4 болон 15.7 дахь хэсэг; 16-р зүйл. 16.2; 16.3; 16.5 дахь хэсэг.
- В. “Нийтийн сонсголын тухай хууль”-ийн (НСТХ) 5-р зүйл. 5.1.1 дэх хэсэг. 6-р зүйл. 6.3.2; 6.2.3; 6.2.5; 6.2.6 дахь хэсэг
- С. “Захиргааны ерөнхий хууль”-ийн (ЗЕХ) 26-р зүйл. 26.1 болон 26.2 дахь хэсэг.

D. “Нийтийн санал асуулгын тухай хууль”-ийн (HCAIX) 3-р зүйл. 3.1.1 дэх хэсэг. 6-р зүйл. 6.1.2 болон 6.1.3 дахь хэсэг.

Эдгээр 4 хуулиудын зорилгыг харьцуулан тайлбарлъя.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль. 2016.01.01	Нийтийн сонсголын тухай хууль. 2016.01.01
Зорилт: Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино. Хүрээ: Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, мэдээлэх, хөгжлийн бодлого төлөвлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.	Зорилт: Төрийн байгууллага, албан тушаалтан энэ хуульд заасан асуудлаар нийтийн сонсголыг зохион байгуулж төрийг удирдах хэрэгт иргэдийн оролцоог хангахад оршино. Хүрээ: Эрх бүхий этгээдээс боловсруулах хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт; энэ хуульд заасан нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал; хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд тавих хяналт; татварын хууль тогтоомж болон төсөв батлах, төсвийн орлого ба зарцуулалтад тавих хяналт;
Захиргааны ерөнхий хууль. 2017.07.01	Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль. 2017.03.12
Зорилт: Нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэх. Хүрээ: Захиргааны байгууллагын үйл ажиллагааг тухайлсан хуулиар зохицуулаагүйгээс бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.	Зорилт: Нийтийн эрх зүйн хүрээнд зөвлөлдөх санал асуулгыг энэ хуульд заасан асуудлаар зохион байгуулж төрийн үйл хэрэгт зөвлөлдөх арга хэлбэрээр иргэдийн оролцоог хангахад оршино. Хүрээ: Нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатай олж илрүүлэх; тухайн асуудлын эрэмбэ, түүнийг шийдвэрлэх арга зам, гаргах шийдвэрийн талаар иргэдтэй зөвлөлдөх; иргэд, олон нийтэд тулгамдсан асуудлын талаар мэдлэг, мэдээлэл өгөх; Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд заасан төрийн үйл хэрэгт оролцох иргэдийн оролцоог хангах.

Дөрвөн хуулиар иргэдийн оролцооны арга хэрэгслийг тодорхойлсон байдал

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль. 2016.01.01	Нийтийн сонсголын тухай хууль. 2016.01.01
Хэлэлцүүлэг: 19.2.Энэ хуулийн 19.1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага дараах хэлбэрээр ХЭЛЭЛЦҮҮЛЭГ зохион байгуулжболно: 19.2.1.хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд;19.2.2.эрдэмтэн судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд; 19.2.3.тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд; 19.2.4.төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд.19.2-т заасан хэлэлцүүлгийн үр дүнд гарсан саналыг хөгжлийн бодлогын баримт бичигт тусган боловсруулж, төслийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ.	5.1.1.“Нийтийн сонсгол” /цаашид “сонсгол” гэх/ гэж хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг тогтоох, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, түүнчлэн хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэх, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахын өмнө төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээчээс санал сонсох, мэдээлэл авах үйл ажиллагааг;
Захиргааны ерөнхий хууль. 2017.07.01	Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль. 2017.03.12
Сонсох ажиллагаа: 26.1.Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно. 26.2.Энэ хуулийн 26.1-д заасан оролцогчоос тайлбар, санал авах ажиллагааг СОНСОХ АЖИЛЛАГАА гэнэ.	3.1.1.“Зөвлөлдөх санал асуулга” гэж нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар энэ хуулийн 3.1.3-т заасан этгээд шийдвэр гаргахын өмнө болон түүнийг хэрэгжүүлж, сахин мөрдөж байгаа байдлын талаар тохиолдлын зарчмаар түүвэрлэн сонгосон иргэдээс тусгай бэлтгэсэн асуултаар санал авах замаар иргэдийг төрийн үйл хэрэгт оролцуулах цогц үйл ажиллагааг;

Дээрх хуулиар заасан иргэдийн оролцооны арга хэрэгсэлүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль. 2016.01.01	Нийтийн сонсголын тухай хууль. 2016.01.01
19.2.Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа нутгийн захиргааны байгууллага дараах хэлбэрээр хэлэлцүүлэг зохион байгуулж болно: • хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд • эрдэмтэн судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн хүрээнд • тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд • төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд.	6.2.Сонсгол нь дараах төрөлтэй байна: 6.2.1.хууль тогтоох;- УИХ, хууль санаачлагч 6.2.2.ерөнхий хяналтын;- НӨУБ 6.2.3.төсвийн хяналтын;- НӨУБ 6.2.4.томилгооны; УИХ 6.2.5.захиргааны хэм хэмжээний болон төлөвлөлтийн; 6.2.6.орон нутгийн. ИТХ-ын хүсэлтээр УИХ
Захиргааны ерөнхий хууль. 2017.07.01	Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль. 2017.03.12
11 дүгээр зүйл. Захиргааны үйл ажиллагааны хэлбэр 11.1.Захиргааны үйл ажиллагаа дараах хэлбэртэй байна: 11.1.1.захиргааны акт; 11.1.2.захиргааны гэрээ; 11.1.3.захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд боломж олгоно.	6.1.Зөвлөлдөх санал асуулгыг дараахь асуудлыг шийдвэрлэхэд заавал явуулна: 6.1.1.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5.3.3-т заасан асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх үндэслэл, шаардлагыг тодорхойлох; - УИХ, 6.1.2.орон нутгийг хөгжүүлэх сангаас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ; -ИТХ, 6.1.3.хот, суурин газрын хэсэгчилсэн төлөвлөлт /нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж/. - Хот байгуулалтын тухай хуульд заасан эрх бүхий этгээд зөвлөлдөх санал асуулгыг санаачлан явуулна.

ДӨРВӨН ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛСАН ИТХ-ААС ЗОХИОН БАЙГУУЛАХ БОЛОМЖТОЙ 6 ТӨРЛИЙН СОНСОХ АЖИЛЛАГААГ ХЭРХЭН ХЭРЭГЛЭХ ТУХАЙ ХАРЬЦУУЛСАН ОЙЛГОЛТ

- I. ХТБТХ. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
 - a. Нээлттэй хэлэлцүүлэг
- II. НСТХ. Нийтийн сонсголын тухай хууль
 - a. Ерөнхий хяналтын сонсгол
 - b. Төсвийн хяналтын сонсгол
 - c. Орон нутгийн сонсгол
- III. ЗЕХ. Захиргааны ерөнхий хууль
 - a. Сонсох ажиллагаа
- IV. ЗСАТХ. Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль
 - a. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтаар санал асуулга
 - b. Зөвлөлдөх санал асуулга

Аливаа сонсголыг зохион байгуулах сонсгол даргалагчид өөр өөр олон эрх ашиг бүхий талуудын ашиг сонирхолыг зохицуулахад хүндрэл үүсч болох бөгөөд түүнийг тогтоосон зарчимд нийцүүлэн зохицуулна.

Эдгээр сонсголуудыг зохион байгуулахад баримтлах зарчмыг хууль тус бүрт хэрхэн заасан байгааг дараах хүснэгтэд харууллаа.

	ХБТТХ¹	НСТХ²	ЗЕХ³ тусгай зарчим	ЗСАТХ⁴
1	үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;	хууль дээдлэх,	хуульд үндэслэх;	хууль дээдлэх;
2	нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;	ардчилсан ёс,	шуурхай, тасралтгүй байх;	иргэний бодитой, шууд оролцоог хангах;
3	төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх	үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах,	ил тод, нээлттэй байх;	иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах;
4	судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх	иргэний мэдэх эрх, эрх чөлөөг хангах,	үр нөлөөтэй байх;	олон талт мэдээллээр тэгш хангах;
5	нөөц бололцоонд үндэслэсэн байх;	талуудын оролцоог тэгш хангах,	зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх;	ил тод, нээлттэй байх;
6	ил тод, нээлттэй байх;	үр нөлөөтэй байх	бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах;	хараат бус байх;

7	олон нийтийн оролцоог хангасан байх.		ашиг сонирхлын зөрчилтэй захиргааны үйл ажиллагаанаас татгалзан гарах, татгалзан гаргах боломжийг хангах;	харилцан зөвлөлдөх;
8			хууль ёсны итгэлийг хамгаалах.	үр нөлөөтэй байх.

Монгол Улсын Их Хурлын 2017
оны 12 дугаар тогтоолын хавсралт

НИЙТИЙН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ журмын зорилт нь ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах үндэслэл, нарийвчилсан журам, сонсголын дэгийг тогтооход оршино.

2. Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага Нийтийн сонсголын тухай хуулийн 8.3, 9.3-т заасан ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулахдаа энэ журмыг баримтална.

Хоёр. Нийтийн сонсгол зохион байгуулах үндэслэл

1. Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд хүсэлтэд сонсгол зохион байгуулах үндэслэл, шаардлагыг тодорхой заасан байх ба сэдэв, зорилго, товын талаархи саналаа тусгаж болно.

2. Хүсэлтийн дагуу сонсгол зохион байгуулах үндэслэл, шаардлагыг зохион байгуулагч, түүний ажлын алба хянан үзээд зохион байгуулах нь зүйтэй гэж үзвэл хариу мэдэгдэн сонсголд бэлтгэнэ.

3. Иргэн, хуулийн этгээд ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ирүүлсэн бол хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын таван өдөрт багтаан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Нийтийн сонсголын тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тухайн асуудлаар сонсгол зохион байгуулах эсэхийг хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв сонсгол зохион байгуулах шаардлагагүй гэж үзсэн бол үндэслэл бүхий хариуг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын гурван өдөрт багтаан бичгээр өгнө.

4. Засгийн газар, төрийн захиргааны төв, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага төсвийн хяналтын сонсголыг жилд нэг удаа өөрийн эрхлэх асуудал, хамаарах төсвийн хүрээнд зохион байгуулна.

5. Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах хугацааг товлон зарламагц тухайн асуудлаар төрийн аудитын байгууллагад дүгнэлт гаргуулахаар холбогдох баримт бичгийг хүргүүлнэ. Төрийн аудитын байгууллага гаргасан дүгнэлтээ сонсгол зохион байгуулахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө ирүүлнэ.

6. Ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах тов, сэдэв, сонсгол даргалагчийг томилох асуудлыг Засгийн газар хуралдаанаараа, төрийн захиргааны төв байгууллагын хувьд сайд, нутгийн өөрөө удирдах байгууллагын хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, нутгийн захиргааны байгууллагын хувьд Засаг дарга тус тус шийдвэрлэнэ.

7. Сонсгол даргалагчийг томилохдоо сонсгол зохион байгуулах сэдвийг харгалзан тухайн асуудлаар мэргэшсэн, эсхүл туршлагатай, ашиг сонирхлын зөрчилгүй албан тушаалтныг сонгоно.

Гурав. Нийтийн сонсголын бэлтгэл хангах

1. Сонсгол зохион байгуулагчаас сонсголын товыг тогтоосон бол товлосон өдрөөс хойш долоо хоногийн дотор Нийтийн сонсголын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан арга хэрэгслээр сонсгол явуулах огноо, цаг, сэдэв, байр, ажиглагчаар оролцох хүний тоо, оролцогчдыг хэрхэн бүртгэх, бүртгэл дуусах хугацааны талаар нийтэд мэдээнэ.

2. Сонсголын товыг хойшлуулсан бол Нийтийн сонсголын тухай хуулийн 20.4-д зааснаар дахин зарлана.

3. Сонсгол зохион байгуулах танхимыг бэлтгэх, техникийн бэлтгэлийг хангах, сонсголын тэмдэглэл хөтлөх, сонсгол даргалагчийн даалгаснаар сонсголын дэг зөрчигчийг танхимаас гаргах, сонсголыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг урьж оролцуулах ажлыг Нийтийн сонсголын тухайн хуулийн 16.1-д заасан этгээд /цаашид “ажлын алба” гэх/ хариуцна.

4. Хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөллийг оролцуулахдаа урилгыг олон нийтэд мэдээлэх ба хэвлэл мэдээллийн байгууллага төлөөллөө оролцуулах хүсэлтээ сонсгол зохион байгуулахаас ажлын зургаагаас доошгүй өдрийн өмнө бичгээр ирүүлнэ.

5. Сонсголд оролцогч, ажиглагч, шинжээч, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийн тооны дээд хязгаарыг сонсгол болох танхимын багтаамж, тухайн асуудлын хүрээнээс хамааран сонсгол зохион байгуулагч тогтооно.

6. Тухайн сонсголд оролцож санал хэлэх, тайлбар, мэдээлэл өгөх, эсхүл ажиглах иргэн, хуулийн этгээд нь сонсгол болохоос ажлын арваас доошгүй өдрийн өмнө сонсгол зохион байгуулагчид мэдэгдэж, оролцогч, эсхүл ажиглагчаар оролцохоо бүртгүүлнэ. Шаардлагатай бол санал, тайлбар, мэдээллээ урьдчилан бичгээр ирүүлэх ба ажлын алба оролцогчид хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл, сонсголд оролцох зааварчилгаа өгнө.

7. Бүртгүүлэхдээ бичгээр, харилцах утсаар, эсхүл зохион байгуулагч байгууллагын цахим шууданд захидал илгээн бүртгүүлж болох ба бүртгэлийг ажлын алба хянан үзээд оролцогчийн тооны дээд хязгаараас хамаарч бүртгүүлсэн цаг хугацааны дарааллаар нь бүртгэлийг баталгаажуулна.

8. Сонсгол зохион байгуулагч шаардлагатай гэж үзвэл шинжээч томилж, сонсголд оролцуулж болох бөгөөд шинжээчийн үйл ажиллагааны зардлыг сонсгол зохион байгуулах байгууллагын төсвөөс гаргана.

9. Ажлын алба энэ журмын 3.4, 3.6, 3.7-д заасны дагуу бүртгэсэн нэрсийг сонсгол даргалагчид хэлэлцүүлэг эхлэхээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө танилцуулж, сонсгол даргалагчийн урилгаар оролцох хүмүүсийн нэрсийг авна. Бүртгүүлсэн болон урилгаар оролцох оролцогч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийн нэрсийг бүртгүүлсэн дарааллын дагуу холбогдох байгууллагын цахим хуудсанд хэлэлцүүлэг эхлэхээс гурваас доошгүй хоногийн өмнө байршуулна.

10. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын болон олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, тухайн асуудлаар мэргэшсэн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллийг сонгол даргалагчийн урилгаар оролцуулна.

11. Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллийг урьж оролцуулахдаа сонгол хийх сэдэв, асуудлаар мэргэшсэн байгууллагуудын нэгдэл буюу холбоодоос албан бичгээр санал авна. Саналд сонголын сэдэв, тов болон төлөөллийн тоог тусгана. Ирүүлсэн саналтай нь холбогдуулан зохион байгуулагч урилга явуулан тухайн холбоо, байгууллагын төлөөллийг сонголд заавал оролцох нөхцөлөөр хангана.

12. Сонголд заавал оролцож, тодорхой асуудлаар тайлбар, мэдээлэл хийх төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээч нарт сонгол болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө сонголд оролцох талаар мэдэгдэх бөгөөд тэдний нэрсийг нийтэд мэдээлнэ.

13. Эрхэлж байгаа албан тушаалын хувьд сонголд заавал оролцох үүрэг хүлээсэн төрийн албан хаагч сонголд оролцох, мэдээлэл, тайлбар өгөхөөс татгалзсан бол Төрийн албаны тухай хуулийн 15.1.16-д заасан *нийтийн сонголыг зохион байгуулах, сонголд оролцох журмыг зөрчсөн гэж үзнэ*.

Дөрөв. Нийтийн сонгол зохион байгуулах

1. Сонгол даргалагч сонголын сэдэв, хүсэлт, сонгол зарласан огноо, сонголд дуудагдсан албан тушаалтан, холбогдох этгээд, шинжээч, тайлбар хийх хүний нэр, сонголд оролцогчдын тоо, сонголын дэг зэргийг 10 минутад багтаан танилцуулна.

2. Сонгол зохион байгуулах хүсэлт гаргасан этгээд, эсхүл тэдгээрийн төлөөлөгч хүсэлтийнхээ үндэслэл, шаардлагын талаар 10 минутад багтаан танилцуулна.

3. Сонголд оролцогч санал хэлэх, тайлбар, дүгнэлт гаргах дарааллыг сонгол даргалагч тогтоох ба оролцогчид сонголын танхимд ирсэн хугацааны дагуу санал хэлэх эрхийг олгож болно. Дарааллыг тогтоохдоо эерэг болон эсрэг саналтай, олонхи болон цөөнхийн төлөөллийг оролцуулах зарчим баримтална.

4. Ажиглагч нь сонголын үед асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй.

5. Сонголд оролцогчийн үг хэлэх хугацааг 3-10 минутаар тогтооно.

6. Хөгжлийн бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст үг хэлэх хугацааг шаардлагатай хэмжээгээр сунгаж олгоно.

7. Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл сонголд оролцохдоо бусад оролцогчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

8. Санал, тайлбар, дүгнэлттэй холбогдуулан оролцогчоос асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байна.

9. Асуулт, хариулт дууссаны дараа сонголд оролцогчид болон хүсэлт гаргасан төлөөлөл санал, дүгнэлтээ оролцогчдын тооноос хамааран 1-3 минутын хугацаанд хэлнэ.

10. Асуулт асуух, үг хэлэхдээ сонсголын сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сонсгол даргалагч асуулт асуух, үг хэлэхийг хязгаарлаж болно.

11. Сонголд оролцогч бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, бусдын яриаг таслах, зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хашгирах, шүгэлдэх зэргээр бусдад үгээ чөлөөтэй хэлэхэд саад учруулсан болон сонсгол зохион байгуулагч, сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзвал сонсгол даргалагч дэг баримтлахыг шаардаж, шаардлагыг үл биелүүлбэл ажлын алба оролцогчийг танхимаас гаргаж болно.

12. Сонсгол даргалагч сонсголыг хааж үг хэлнэ.

13. Ажлын алба сонсголын тэмдэглэлийг аудио болон бичгэн /товч/ хэлбэрээр хийж тухайн байгууллагын албан ёсны цахим хуудсанд ажлын таван өдрийн дотор байршуулна.

14. Сонсгол дууссаны дараа сонсголын үйл ажиллагаа болон сонсголын үед хэлэлцэгдсэн асуудал, асуулт, хариулт, мэдээлэл, дүгнэлт зэрэгтэй холбогдуулан ямар нэгэн зарга, гомдол үүсгэхгүй ба ямар нэгэн арга хэмжээ авагдахгүй.

НИЙТИЙН СОНГОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ДАГУУ ОРОН НУТГИЙН СОНГОЛ ЯВУУЛАХ ИТХ-ЫН ХҮСЭЛТИЙН ЖИШЭЭ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИД

213318 Бат-Өлзийт, Заамар сум

Утас: (01-27-5) Факс: (01-27-5)

2017.05.10 № 16

танай -ны № -т

Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт
1993 оноос хойш хэрэгжсэн Алт 1 хөтөлбөрийн
үр нөлөө, Алт 2 хөтөлбөрийг хэрэгжүүлэх
бодлогын асуудлаар орон нутгийн сонгогч
зохион байгуулах хүсэлт гаргах нь

Төв аймгийн Заамар сум нь 1980, 1990-ээд онуудад улсын тэргүүний газар тариалангийн бүс нутаг байлаа. Малын тоо 2011 оны байдлаар 181178 толгойд хүрч нэг өрхөд ногдох малын тоогоор аймагтаа тэргүүлж, улсад 9-т бичигдэж байсан сум. Манай сумын нийт газар нутгийн хэмжээ 281.207 га, үүнээс малчдын гол бэлчээр нутаг болох Хайлааст багийн нутаг дахь Туул голын сав газарт 1993 оноос Алт хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд яг өнөөдрийн байдлаар алтны 22 компани, түүнийг дагасан 20 гаруй жижиг уурхай үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр компаниуд бүгд шороон ордын алт олборлох үйл ажиллагаа явуулдаг. Мөн зарим компаниуд нь Монгол улсын хэмжээнд байдаг 5-н драгын голын голдирол дээр ажиллуулах байдлаар олборлолтоо хийж ирсэн. 1993-2010 онд Эрэл ХХК, Монполимет ХХК, Алтандорнод ХХК, Шижиер алт ХХК зэрэг томоохон уул уурхайн компаниуд бүгд энд ажиллаж олборлолт явуулсан байдаг. Энэ хугацаанд Заамар сумын алтны бүлэг ордоос нийт 120 тонн алт олборлосон мэдээ бий. Энэ нутагт алт олборлох уул уурхайн үйл ажиллагаа өнөөг хүртэл тасралтгүй 24 жил явагдсаар байгаа боловч ямар ч компани уул уурхайн эдэлбэрт өртсөн газраасаа нэг ч га газрыг бэлчээрийн ангилалд шилжүүлэх хэмжээнд нөхөн сэргээгээгүй байсаар байна.

Туул гол нь Заамарын хөндийгөөр 110 км үргэлжлэн урсдаг. Энэ л голоосоо үеийн үед нутгийн ард түмэн хүн малгүй ундаалж байгалийнхаа сайхнаар бахархаж өвөлдөө өнтэй сайхан өвөлжиж газар нутгаа “Зуд болдоггүй тосон Заамар” хэмээн шүтэж ирсэн ирсэн түүхтэй. Гэтэл алт олборлолтын үйл ажиллагааны сөрөг нөлөөнд өртсөн Хайлааст багийн малчид Туулынхаа усыг уух аргагүй болж ундны усаа 5-10 км зайтай газраас зөөж хэрэглэдэг болсон. Мөн малаа бэлчээх газар нутаггүй болж уулын оройг бараадан нүүдэллэж, өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн газар ч үгүй болсон.

Энэ 24 жилийн хугацаанд “Гол мөрний эхийг хамгаалах, ойн сан болон усан сан бүхий газар нутагт алт олборлох үйл ажиллагааг хориглох тухай хууль” гарсан ч энэ нутагт буюу Туул голын сав газарт, Заамар сумын уул уурхайн компаниудад энэ хууль үйлчлэхгүй байсаар өдий хүрлээ. Энэ газар нутагт мөн нөхөн сэргээлт хийгээгүй бол дараа жилийн олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэхгүй байх эрх бүхий төрийн байгууллагууд хяналт шалгалт хийж үүргээ хэрэгжүүлж ажиллаж байгаагүй гэж хэлж болно. Иймд Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлсэн 1993 оны Алт 1 хөтөлбөрийн хар ул мөр болж үлдсэн овоолго шороо, отвал дунд 2000 гаруй иргэд амьдарч байгаа бол Хайлааст багийн 10-аад малчид уул уурхайгаас дайжин

Төмстий багтаа төвлөрөн өнөөдөр амьдралаа залгуулж байна. Гэтэл Төмстий багийн угаас хүн ам шигүү, төвлөрч буй газар нутагт нь Монгол Улсын Засгийн газар 2017 оны Алт 2 хөтөлбөрийн хүрээнд тус сумын газар нутагт 21000 га газар нутгийг уул уурхайн үйл ажиллагаа явуулах зорилгоор сонгон шалгаруулалтын талбайд оруулан зарлаад байна.

Үндсэндээ Заамар сумын нийт газар нутгийн 52.000 га-д уул уурхай, 12.597 га-д газар тариалангийн бүс нутаг, үлдсэн хэсэгт иргэд төвлөрөн амьдардаг ба үүнээс үүдэлтэй бэлчээрийн даац хэтрэх, хүн амын төвлөрөл үүссэнээр байгаль орчин бохирдох зэрэг хүнд нөхцөлд амьдарч байгаа бидний газар нутгаас Засгийн газар өөрийн санаачлагаар дахин авч уул уурхайн үйл ажиллагаа явуулах гэж байгаа нь нутгийн иргэдийг гар хумхиад суухгүй, тэмцэхэд хүргээд байгаа болно.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, уул уурхай бүхий багийн иргэд, ИТХ-ын төлөөлөгчид нь Монгол Улсын Засгийн газрыг энэ байдалд дүгнэлт хийж “АЛТ 1” хөтөлбөрийн сөрөг үр дагаврыг арилгах, Байгаль Орчны Нөлөөлөх Байдлын Үнэлгээний тухай хуулийн дагуу стратегийн болон эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх, үндэсний эрх ашгийн төлөө засаг захиргааны анхан шатны нэгжийн эрх ашгийг золиослох үйлдэл гаргахгүй байхыг тэмцлийн олон хэлбэрээр илэрхийлж байгаа болно.

Иймд дээр дурьдсан нутаг дэвсгэрт стратегийн болон эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийхийн зэрэгцээ, нутгийн иргэд, Байгаль орчин хүний эрхийн чиглэлийн ТББ-уудын хүсэлтийн дагуу МУ-ын Нийтийн сонголын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх хэсэгт заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Монгол Улсын Засгийн газарт хандан Заамар сумын Хайлааст багийн Туул голын сав газар дахь уул уурхайн эдэлбэрт өртсөн газар нутагт орон нутгийн сонголыг зохион байгуулах хүсэлтийг гаргаж байна.

Бидний хүсэлтийг Нийтийн сонголын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт зааснаар хүлээн авч, бидэнд тулгамдаад байгаа олон асуудлыг хамтдаа ярилцаж, шийдэх боломж олгоно гэдэгт найдаж байна.

Бидэнтэй дараах хаяг болон утсаар холбогдох боломжтой. Төв аймгийн Заамар сум 4-р баг ЗДТГ-ын байр сумын ИТХурал. Утас: 70275801, 99064146, 88724869



Захиргааны ерөнхий хуулийн дагуу явуулах Сонсох ажиллагаа
явуулах зарын жишээ

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ СОНСОХ АЖИЛЛАГААНД УРЬЖ БАЙНА

2018 оны 01 сарын 25

Сонсох ажиллагааны сэдэв: Өмнөговь аймаг, Гурвантэс сумын захиргааны байгууллага болон Жавхлант орд ХХК хооронд байгуулах Хамтын ажиллагааны гэрээний төсөл

Сонсох ажиллагааны зорилго: Талуудын хооронд байгуулагдах Хамтын ажиллагааны гэрээни төсөлд эрх ашиг нь хөндөгдөх талуудын саналыг авах, мэдээлэл өгөх, Хамтын ажиллагааны гэрээний хороонд ажиллах иргэдийг сонгох үйл явцын ил тод нээлттэй байдлыг хангах явдал.

Хэзээ, хаана болох: Гурвантэс сумын төв. Соёлын төвд 2018 оны 02 сарын 08 ны өдрийн 14:00 цагт болно.

Оролцогчид: Баясах багийн иргэд заавал оролцох бөгөөд бусад иргэд, ИНБ, БИНХ-ын тэргүүлэгчид, ИТХ-ын төлөөлөгчид

Хамтын ажиллагааны гэрээ байгуулах эрхзүйн үндэслэл:

- Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйл. 42.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана. 42.2. дахь хэсэг. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээ байгуулах асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.
- Захиргааны ерөнхий хуулийн 52-р зүйл. 52.1 дэх хэсэг. Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, эсхүл дуусгавар болгохоор захиргааны гэрээг эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгуулж болно. 26-р зүйлийн 26.1 дэх хэсэг Захиргааны акт, захиргааны гэрээг байгуулахад эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно.

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Баясах багийн Зангат уул-1 нутагт байрлах коксжих нүүрсний MV-016952 тоот тусгай зөвшөөрөлтэй “Жавхлант орд” ХХК-ны байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар аймаг, сумын захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулсан гэрээ байгуулна.

Хамтын ажиллагааны гэрээний төсөл боловсруулахад ЗГ-ын 2017 оны 179-р тогтоолоор батлагдсан загвар гэрээнд үндэслэн 2017 оны 12 сард Гурвантэс сумын төвд талуудын оролцоотой хийгдсэн сургалт хэлэлцүүлгээс гарсан

санал, аймгийн уул уурхайн асуудал хариуцсан хэлтсийн боловсруулсан гэрээний төслийн саналуудыг тусган боловсруулж, Жавхлант орд ХХК-д илгээн саналыг аваад байна.

Хамтын ажиллагааны гэрээний төслийгцахим хуудаснууд, Сумын Урт багийн төв дэх Уул уурхайн мэдээллийн төвөөс авч танилцаж болох бөгөөд Баясах багийн нийт өрхөд хэвлэн тараасан болно.

Сонсох ажиллагаа явуулах дараалал:

Цаг	Сонсох ажиллагааны дараалал
14:00-14:10	Оролцогчдын бүртгэл
14:10-14:20	Хамтын ажиллагааны гэрээний тухай ерөнхий ойлголт өгөх
14:20-15:00	Хамтын ажиллагааны гэрээний төслийг танилцуулах
15:00-15:30	Асуулт хариулт
15:30-17:30	Хамтын ажиллагааны гэрээнд санал авах ажиллагаа
17:30-17:50	Хамтын ажиллагааны гэрээ батлах хүртэлх төлөвлөгөө танилцуулах
17:50-18:00	Хаалт

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН ЗДТГ
ОУИТБС-ЫН ДЭД ЗӨВЛӨЛ

СОНСОХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАХ ЗАГВАРУУД

А.Бодлого, шийдвэр гаргахын өмнө:

1. Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтаар санал асуулга зохион байгуулах тухай Сангийн яамны сайдын тушаалаар батлагдсан бие даасан журам байгааг ашиглаарай.
2. Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 6-р зүйлийн 6.4 дэх хэсэгт нийслэлийн хэмжээнд 500-аас дээш, дүүрэгт 300- аас дээш, аймагт 100-аас дээш, суманд 50-аас дээш тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугч иргэний гаргасан санал, хүсэлтийг шийдвэр гаргах эрх бүхий этгээд¹ хэлэлцэн шийдвэрлэх үүрэгтэй. Энэ тохиолдолд ИТХ, Засаг дарга заавал санал асуулга явуулна. Харин зөвлөлдөх санал асуулгад хамгийн сүүлийн удаа явагдсан УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулиар гаргасан сонгогчдын нэрийн жагсаалтаас тохиолдлын зарчмаар сонгож² оролцуулах тул шийдвэр яаж ч гарч болно гэдгийг сайтар ойлгоорой.

Загвар 1

.....аймаг/ нийслэлийн.....сум/дүүргийн
иргэдээс Хүнсний аюулгүй байдлын асуудлаар зөвлөлдөх санал асуулга
явуулах хүсэлт гаргах нь

Засаг дарга,
ИТХ-ын тэргүүлэгчдэд

Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4-р зорилгын 4.1.12-дахь зорилтод “Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулж, хэрэглэгчдийг баталгаат хүнсээр хангана.” гэжээ.

Энэхүү зорилтоо хэрэгжүүлэхээр 2017-2018 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн баримт бичгүүдэд мөрийн хөтөлбөрийн 4.1.12 дахь зорилтын үг өгүүлбэр тэр чигээр тусгагдсан байна. 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ тайланд тус зорилтыг 80%-тай хангалттай хэрэгжсэн гэжээ.

Гэтэл малчид, тариаланчдын өрх гэртээ үйлдвэрлэсэн мах, сүү сүүн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоог зах зээлд ченжийн дамжлагагүй хүргэх, дахин боловсруулах, зоорилох зэрэг үр дүнтэй арга хэмжээ авагдахгүй байна. Малчид, ногоочдын жилийн 4 улиралд ажиллаж нийлүүлж буй хүнс, хүнсний бүтээгдэхүүн аюулгүй баталгаатай байдал алдагдаж байна.

Иймд цаашид 2018-2019 онд сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн баримт бичигт малчид, тариаланчдын оролцоотой бодлого тодорхойлох шаардлага үүсч байгаа тул зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн дагуу санал асуулга зохион байгуулна уу

Малчид, тариаланчид, иргэдийн
төлөөлөл 50/100/300 хүний гарын үсэг

Загвар 2

3. Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 6-р зүйлийн 6.3 дах хэсэгт НӨУБ нь энэ хуулийн 6.1-д зааснаас бусад асуудлаар зөвлөлдөх санал асуулгыг санаачлан явуулж болно.

ИТХ өөрөө Засаг даргад эсвэл
ИТХ-ын хороо ИТХ-д гаргаж болно

Засаг даргад эсвэл
ИТХ-ын дарга танаа

Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай:

Аймаг, сумын засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлогын 3.3.1-т “Хог хаягдлыг бууруулах ангилан ялгах талаар иргэдийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх, дадал суулгах сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ” гэсэн томоохон зорилт арга хэмжээг тусгажээ.

Гэвч 2016-2017 онд дээрх зорилтын талаар Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд зорилт арга хэмжээ тусгагдаагүй тул огт арга хэмжээ аваагүй, 2018 оны Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд мөн ямар ч арга хэмжээ тусгагдаагүй байна.

Гэтэл аймаг/ сумын төвийн нийтийн эдэлбэр газарт хог ихээр үүсч байгаа төдийгүй хогийн цэгт хур хог улам хуримтлагдаж байна. Иргэдэд хог хаягдлаа ялган хаях, хогийн төлбөр төлөх, нийтийн эдэлбэр газар хог хаяхгүй байх зэрэг мэдлэг ойлголт байхгүй, амин хувиа хичээсэн хандлага улам бүр нэмэгдэж байна.

Иймд Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 6-р зүйлийн 6.3-т заасан эрхийн дагуу ИТХ-ын Байгаль орчин, хөдөөгийн бодлогын хороо санаачлан тус хуулийн 4-р зүйлийн 4.1.1.нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн туслалцаатай олж илрүүлэх, 4.1.3.иргэд, олон нийтэд тулгамдсан асуудлын талаар мэдлэг, мэдээлэл өгөх зорилгоор зөвлөлдөх санал асуулга зохион байгуулахаар хүсэлт гаргаж байна.

Иймд тус хуулийн 7-р зүйлийн дагуу шийдвэр гаргаж, 8-р зүйлийн дагуу Зөвлөлдөх зөвлөлийг байгуулан хамтран ажиллана уу.

Загвар 3

4. Захиргааны ерөнхий хуулийн Сонсох ажиллагаа явуулах хүсэлт гаргах нь

ИТХ-ын төлөөлөгч өөрийн бланкаар ИТХ-ын дарга, тэргүүлэгчдэд
ИТХ-ын хороод ИТХ-ын дарга, тэргүүлэгчдэд
ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчид хамтраад ИТХ-ын дарга, тэргүүлэгчдэд

2018 оны 10 сарын 10.

Сонсох ажиллагаа явуулах
хүсэлт гаргах нь

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.2 дахь хэсэгт заасны дагуу Нутгийн захиргааны байгууллага эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 10 дугаар сарын 05-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлжээ.

Тус 2018 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэхийн өмнө тус баримт бичгийн төслийн 2.3.3. "Өрх толгойлсон эх /эцэг/-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөжээ.

Иймд тус дэд хөтөлбөрт оролцож эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй өрх толгойлсон эцэг/эхчүүдийг оролцуулсан сонсох ажиллагаа явуулж тэдэнд шийдвэр гаргах ач холбогдол, нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгох хүсэлт гаргаж байна.

Захиргааны ерөнхий хуулийн 27-р зүйлд заасны дагуу сонсох ажиллагааг зохион байгуулна уу

Загвар 4

5. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу Нээлттэй хэлэлцүүлэг явуулах хүсэлт гаргах.

Энэ нээлттэй хэлэлцүүлэг нь Захиргааны ерөнхий хуулийн сонсох ажиллагаанаас юугаараа ялгаатай вэ? гэхээр ЗЕХ-ийн сонсох ажиллагаа зөвхөн тухайн бодлого, шийдвэрээс эрх ашиг нь хөндөгдөх иргэдийг сонсдог. Харин нээлттэй хэлэлцүүлэг нь олон нийтэд нээлттэй бөгөөд бодлого шийдвэрийг нийтэд танилцуулах, мэдээлэх, хэлэлцүүлэх, санал авах үйл ажиллагаа юм. Гэвч аль аль нь иргэдийн оролцоог шийдвэр гаргахын өмнө хангах зорилготой.

ИТХ-аас ЗД түүний ЗДТГ-т хүсэлт гаргана.

Нээлттэй хэлэлцүүлэг зохион
байгуулах хүсэлт гаргах нь

Аймаг сумын засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх “Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр” боловсруулж байгаад талархалтай байна.

Тус дэд хөтөлбөрийн үндэслэл, зорилго, агуулга, гарах үр дүн, нөлөөний талаар олон нийтэд нээлттэй мэдээлж, тэдний оролцоог хангах зорилгоор дэд хөтөлбөрийн төслийг олон нийтэд таницуулах, санал авах зорилготой нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Иймд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19-р зүйлд заасан дагуу иргэдийн оролцоог хангах нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулна уу

Хүсэлт гаргасан:

Б. Бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн явцад болон хэрэгжиж дууссаны дараа:

Загвар 5

1. Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу Ерөнхий хяналтын сонсгол явуулах хүсэлт гаргах нь

ИТХ-ын төлөөлөгчдийн $\frac{1}{4}$ саналаа ИТХ-ын дарга, тэргүүлэгчдэд ИТХ-ын 4 хороотой бол нэг хорооны төлөөлөгчид ИТХ-ын дарга, тэргүүлэгчдэд

2018 оны 10 сарын 10.

Сонсох ажиллагаа явуулах
хүсэлт гаргах нь

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.3 дахь хэсэгт заасны дагуу ИТХ 2018 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлахын өмнө тус баримт бичгийн 2.3.3. “Өрх толгойлсон эх /эцэг/-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ” зорилтын хэрэгжилтээр ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулна уу.

Тус ерөнхий хяналтын сонсголыг Нийтийн сонсголын тухай хуулийн 8-р зүйлийн 8.3.1 д заасны дагуу ИТХ-ын төлөөлөгчдийн бид хүсэлт гаргаж байгаа тул тус хуулийн 8-р зүйл, УИХ-ын 2017 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулуулахаар хүсэлт гаргаж байгааг шийдвэрлэнэ үү.

ХҮСЭЛТ ГАРГАСАН:

Загвар 6

2. Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу Төсвийн хяналтын сонсгол явуулах хүсэлт гаргах нь

ИТХ-ын төлөөлөгчдийн $\frac{1}{4}$ саналаа ИТХ-ын дарга, тэргүүлэгчдэд ИТХ-ын 4 хороотой бол нэг хорооны төлөөлөгчид ИТХ-ын дарга, тэргүүлэгчдэд

ИТХ-ын тэргүүлэгчдэд

Аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4-р зорилгын 4.1.12 дахь зорилтод “Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулж, хэрэглэгчдийг баталгаат хүнсээр хангана.” гэжээ.

Энэхүү зорилтоо хэрэгжүүлэхээр 2017-2018 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн баримт бичгүүдэд мөрийн хөтөлбөрийн 4.1.12 дахь зорилтын үг өгүүлбэр тэр чигээр тусгагдсан байна. 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ тайланд тус зорилтыг 80%-тай хангалттай хэрэгжсэн гэжээ.

Гэтэл малчид, тариаланчдын өрх гэртээ үйлдвэрлэсэн мах, сүү сүүн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоог зах зээлд ченжийн дамжлагагүй хүргэх, дахин боловсруулах, зоорилох зэрэг үр дүнтэй арга хэмжээ авагдахгүй байна. Малчид, ногоочдын жилийн 4 улиралд ажиллаж нийлүүлж буй хүнс, хүнсний бүтээгдэхүүн аюулгүй баталгаатай байдал алдагдаж байна.

Иймд 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4.1.12 дахь зорилт “Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулж, хэрэглэгчдийг баталгаат хүнсээр хангах зорилтын хэрэгжилт 80%-тай хэрэгжсэн гэж дүгнэсэн байх тул энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд төлөвлөж, зарцуулсан санхүүжилтийн асуудлаар Нийтийн Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу төсвийн хяналтын сонсголыг УИХ-ын 2017 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулуулахаар хүсэлт гаргаж байгааг шийдвэрлэнэ үү.

Нийтийн сонсголын тухай хуулийн 8-р зүйлийн 8.3.1-д заасны дагуу ИТХ-ын төлөөлөгчдийн $\frac{1}{4}$ бид хүсэлт гаргаж байгаа болно.

ХҮСЭЛТ ГАРГАСАН
ИТХ-ын төлөөлөгчид